



SHIIHIHUTUG UNIVERSITY

SHIIHIHUTUG

JOURNAL OF LAW AND MANAGEMENT

Ulaanbaatar
2024

© ШИХИХУТУГ сэтгүүл нь бүхэлдээ зохиогчийн эрхээр баталгаажсан болно.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:	Д.Лүндээжанцан
Зөвлөлийн гишүүд:	Ж.Бямбаа Н.Жалбажав Д.Оюунцэцэг А.Доржготов З.Батбаяр Б.Нармандах Т.Сүхбаатар Ж.Мөнхболд
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнх-Эрдэнэ
Хэвлэлийн хуудас:	7.0 х.х
Хэвлэсэн газар:	Mind book LLC

Хаяг:

СБД 5-р хороо Үндсэн хуулийн гудамж
Шихихутуг их сургууль.

Web site: www.shihihtug.edu.mn

Tel: 11+314977 Ulaanbaatar, Mongolia

ГАРЧИГ

1. 1992 оноос хойшхи Монгол улс дахь улс төр, эрх зүйн шинэтгэл /Д.Лүндээжанцан/	4
2. Аюулгүй байдлын орчны өөрчлөлт ба үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэтгэх шаардлагын тухайд /Н.Жалбажав/	22
3. Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд үндсэн хуулийн цэцийн үүрэг /В.Удвал/	35
4. Монгол улсын прокурорын байгууллагын хөгжилд БНМАУ-ын прокурор Ж.Авхиагийн гүйцэтгэсэн түүхэн үүрэг /Ц.Мөнхбат /	46
5. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа /А.Доржготов/	59
6. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал /Т.Сүхбаатар/	70
7. Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хүлээх үүрэг ба үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлага /М.Түвшинжаргал/	76
8. Өмгөөлөгчийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах арга зам /Б.Мөнх-Эрдэнэ/	91
9. Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо хуулийн тодорхой болон тодорхой бус байдалд нөлөөлөх нь /Х.Одонтуяа, Г.Гантөгс/	106
10. Эх сурвалжийн онолын хүрээнд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн зарим асуудлыг авч үзэх нь /Ё.Болормаа/	125
11. Хүний генийн инженерчлэл буюу генийн хувиргалтын талаарх зарим улсын хууль тогтоомжийн зохицуулалт /Ц.Амарсанаа/	139
12. Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлын зарчим, түүний хэрэгжилт, үр дагавар /Э.Анхбаяр/	148
13. Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтад соёлын капитал нөлөөлөх нь /Г.Гантөгс/	159
14. Иргэний хэргийн зарим төрлийн маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал /Б.Оюун-Эрдэнэ/	176
15. Ялын зорилго, түүний төрлийн харьцуулсан судалгаа /Б.Батаа/	184
16. Эрхзүйн антропологи /С.Номын баясгалан/	203
17. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудал, боловсронгуй болгох арга зам /Ё.Өсөхбаяр/	224
18. Бизнесийн ёс зүйн шалгуур бизнесийн гэрээний стандарт нөхцөлийн чухал хэсэг болох нь /Долгормаа/	244
19. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хамгаалах арга зам ба үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал /Б.Халиунаа/	251
20. Төрийн худалдан авах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд түүнийг шийдвэрлэх арга зам /Г.Батмөнх/	260 269
21. Компанийн хуулийн тайлбар /А.Доржготов/	281
22. Удирдахуйн ухааны илтгэл /Г.Гантөгс/	



ИЛТГЭЛ,
НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

**1992 ОНООС ХОЙШХИ МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨР,
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ**



Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, гавьяат хуульч Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Өнгөрсөн зууны 80, 90 ээд оноос нийгмийн өөрчлөлт шинэчлэлийн үзэл санаа дэлхий дахинаа газар авч, улам бүр хүчтэй болж байв. Энэ үйл явц Монгол орныг ч тойроогүй. 1990-ээд онд дэлхий нийтэд өрнөсөн ардчиллын шинэ давлагааны дор Монгол улс ч мөн улс төр, эрх зүй, нийгмийн байгууллын эрс шинэчлэлийг хийсэн билээ. Энэхүү илтгэлээр 1992 оноос Монгол Улсад өрнөсөн улс төр, эрхзүйн шинэтгэлийн үйл явцыг

1. Ардчилсан шинэ үндсэн хууль (1992) ба төрийн тогтолцооны шинэтгэл;
2. Эрх зүйн шинэтгэлийн үйл явц;
3. Улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын төлөвшил;
4. Сонгуулийн тогтолцооны шинэчлэл гэсэн 4 асуудлын хүрээнд тоймлон авч үзлээ.

Нэг. Ардчилсан шинэ үндсэн хууль (1992) ба төрийн тогтолцооны шинэтгэл

Монгол Улс 1990-ээд оны эхэн үеэс улс төрийн шинэчлэлийн хувьд нэг намын тогтолцооноос парламентын засаглалтай олон намын ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын тус бүр 8 удаагийн ардчилсан сонгуулийг явуулаад байна. 1992 онд баталсан Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулиар хүний үндсэн эрх, эрх чөлөө, тэр дундаа үг хэлэх, хэвлэн нийтлэх, цуглаан хийх, шашин шүтэх эрх чөлөөг баталгаажуулсан билээ.

1988 онд “БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийг шинэчлэн найруулах ажлыг эрхлэн гүйцэтгэх комисс”-ийг нам, төрийн тэргүүн Жамбын Батмөнхөөр ахлуулан байгуулжээ.¹ Үүний дараа Улсын Бага Хурал шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссыг БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбатаар ахлуулан байгуулжээ. Комиссоос боловсруулсан Үндсэн хуулийн төслийг ард нийтээр болон УБХ-аар хэлэлцэн “Их цааз”-ын төсөл нэртэйгээр АИХ-д 1991 оны 11 дүгээр сард өргөн барьжээ.

Ард нийтийн хэлэлцүүлэгт тухайн үеийн сонгуулийн эрх бүхий 1.1 сая хүний 900 гаруй мянга нь оролцсон

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Эмхэтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан. УБ., 2004. т

байдаг. Энэ бол шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах үйл явц Монголын нийт нийгмийг хамарч, төр улс, түмэн олон, шинэ, хуучин улс төрийн намууд гээд бүхий л түвшинд өндөр идэвх, чин сэтгэлээр асуудалд хандаж, эх орныхоо ирээдүйн сайн сайхны төлөөх эрмэлзэл тэмүүллээр Монгол Улс тэр чигээрээ оргилж байсны илэрхийлэл юм.

Үндсэн хуулийн төслийн хэлэлцүүлэг АИХ-ын танхимд 70 гаруй хоног үргэлжилж, 400 гаруй депутат оюун бодлоо мэтгэлцэн уралдуулж, улс төрийн зөвшилцлийг хангах, депутатуудын бүлгүүдийн байр суурийг нэгтгэн нэг мөр ойлголтод хүрэх ээдрээ, төвөгтэй замыг туулсны эцэст “ардчилсан” хэмээх нэрээр түүхэнд үлдсэн шинэ Үндсэн хуулиа 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр баталжээ.

Оршил, 6 бүлэг, 70 зүйл бүхий Шинэ Үндсэн хууль 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчлэв.

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон

Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж, улсын нэрийг Монгол Улс хэмээн нэрлэжээ².

Үндсэн хуулийн гол зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах, эх орноо хөгжүүлэх, иргэдийнхээ эрх, эрх чөлөө, сайн, сайхан аж төрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Ардчилсан шинэ Үндсэн хуулийн нэг ололт бол хүний эрхийг хамгаалах хүрээн дэх олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнүүд болох хүний эрхийн түгээмэл тунхаг³ (1948 он), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁴ (1966), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт⁵ (1966 он)-уудад заасан хүний эрх, эрх чөлөө, тэдгээрийг хэрэгжүүлэх баталгаа, механизмыг үндсэнд нь заан бэхжүүлж чадсанд оршино.

Шинэ Үндсэн хуулиар төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчмын дагуу төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн тогтолцоогоор хуваарилжээ. Монгол Улсын засаг захиргаа,

² Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

³ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail/1271> (2023.05.01)

⁴ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail/1257> (2023.05.01)

⁵ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail/1284> (2023.05.01)

нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагынасуудлыг хуульчлан бэхжүүлсэн байна. Монгол Улс нь нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдаж байхаар заан бэхжүүлжээ.

Шинэ Үндсэн хуулийн бас нэг онцлог бол Үндсэн хуулийн хяналтын механизмыг бий болгосон явдал мөн. Үндсэн хуулийн 5 дугаар бүлэгт Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий Үндсэн хуулийн Цэцийн бүтэц, үйл ажиллагааны зарчим, эрх хэмжээг хуульчлан бэхжүүлжээ.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль нь орчин цагийн либералуудын томъёолсноор урьд өмнөх тунхаг буюу хөтөлбөр Үндсэн хуулиудаасаа хууль-Үндсэн хууль болсноороо, өөрөөр хэлбэл, Монголын ард түмний нийгмийн зөвшилцлийн гэрээ болж нийгмийн ардчилсан улс төрийн тогтолцооны бодит байдал (“байх ёстой” болон “байгаагийн” зөрүү)-ын эх бичвэр, үзэл санаа нь болж нийт иргэнийхээ эрх, эрх чөлөөг баталгаажуулснаараа монголчуудын төр, хууль цаазын сэтгэлгээнд нэн содон үзэгдэл болсон билээ.

Үндсэн хууль бүхэлдээ, Улсад тусгаар тогтнол, Иргэнд эрх чөлөө, Хүн амд эрх тэгш байдал, Эх оронд зах зээлийн эдийн засаг, Төрд

ардчилсан дэглэм, Орон нутагт өөрөө удирдах ёс, Үндсэн хуульд шүүхийн хяналт ба тогтвортой байдлыг олгож Монгол Улсын олон улсын нэр хүндийг бүрнээ сэргээн тогтоосон⁶.

Монгол Улсын Үндсэн хуульд 1999 болон 2000 онд 2 удаагийн оролдлогоор 7 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт хожмоо “дордуулсан 7 өөрчлөлт” хэмээн нэрлэгдэж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт, тэнцэл алдагдаж, парламентат ёсыг сулруулахад хүргэсэн гэх шүүмжлэл дагуулсан⁷. Харин зарим судлаачдын хувьд Үндсэн хуулийн 2000 оны нэмэлт, өөрчлөлт нь ардчилсан хариуцлагын тогтолцоог бэхжүүлсэн гэж үздэг. “Засгийн газрын гишүүд тогтмол бус, онцгой тохиолдол гарсан үед гаднын хүн шиг ирж чуулганд оролцдог байсан. Иймд дэмжигчид эдгээр нэмэлт, өөрчлөлт нь Засгийн газрын гүйцэтгэх чадварыг сайжруулсан хэмээн үзжээ⁸.

Чикагогийн их сургуулийн профессор Том Гинсбург “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” хамтын бүтээлдээ: Олон улсын түвшинд харьцуулахад Монгол Улсын Үндсэн хууль харьцангуй

⁶ Б.Чимид. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм. УБ., 2019. т. 24

⁷ Б.Чимэд. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006. т. 146

⁸ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Хамтын бүтээл. УБ., 2016.т.196

сайн хэрэгжсэн гэхдээ үүнийг ямар ч утгаар Үндсэн хуулийг эс өөрчлөх дархлаа хэмээн ойлгож болохгүй. Жефферсоны хэлснээр бүх үндсэн хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн өөрчилж байх хэрэгтэй.” гэсэн байна⁹.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь ард түмний засаглах эрхийг ханган, парламентат ёсоо бататган бэхжүүлэх, хөгжлийн бодлого төлөвлөлт, байгалийн баялгийг ашиглахад баримтлах зарчмыг тодорхойлж, УИХ-ын хариуцлага, хяналтыг сайжруулах, улс төрийн нам, түүний санхүүжилт, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, гүйцэтгэх эрх мэдлийн тогтвортой байдлыг хангах, шүүх эрх мэдлийн хараат бус, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэжээ.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил өрнөхийн зэрэгцээ нэмэлт, өөрчлөлтийн зарим асуудлыг эргэн авч үзэж өөрчлөх талаар “ХҮН” намын зүгээс улс төрийн хүрээнд маргаан, мэтгэлцээн өрнүүлж ирэв. Улмаар 2022 онд иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх, Ш.Адъяаа, Н.Ганибал нарын гаргасан мэдээллээр 2019 онд Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийг өөрчлөн найруулж “Ерөнхий

⁹ Монгол Улсын Үндсэн хууль-25 жил эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017. т. 40

сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн Цэц маргаан үүсгэжээ. Үүний дагуу 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн Цэц Их суудлын хуралдаанаараа уг маргааныг авч хэлэлцэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар тогтоолыг¹⁰ гаргажээ.

Уг тогтоолд үндэслэн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр УИХ-ын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаас Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэснийг хүчингүй болсонд тооцсон байна. Ийнхүү УИХ-ын гишүүн нь ямар нэг хязгаарлалтгүйгээр Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч болох эрх зүйн боломж нээгдэж, улмаар Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар үндсэндээ /дөрвөөс бусад нь/ УИХ-ын гишүүдээс бүрдэх болов.¹¹

Улмаар 2019 оны нэмэлт

¹⁰ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941> (2023.05.01)

¹¹ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 33 дугаарт нийтлэгдсэн.

өөрчлөлтийн үед хэлэлцэгдсэн боловч Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн саналын босгыг давж чадаагүй үлдсэн УИХ-ын гишүүдийн тоог болон сонгуулийн холимог тогтолцоог бэхжүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг УИХ 2023 оны V сарын 31-ний өдөр батлав. Ийнхүү УИХ-ын гишүүд эрх мэдэлтэн, дарга бус, харин ард түмнийхээ элч төлөөлөгч байх тогтолцоог бэхжүүлэх зорилгоор УИХ-ын гишүүдийн тоог 126 болгон нэмэгдүүлж, сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульдаа тусгаж өгчээ.

Шинэ Үндсэн хуулийн дагуу, төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх бүрдлийн тухай хуулиуд батлагдаж, тэдгээрийн дагуу уг бүтцүүдийг шинээр буй болгож зохион байгуулж ажиллуулав. Түүнчлэн нийслэл, орон нутаг, хот тосгоны эрх зүйн байдлыг хуульчлан тогтоосноор нутгийн удирдлагыг шинээр зохион байгуулсан билээ.

Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь Улсын Их Хурал

«Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална» гэж Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд заасан билээ. УИХ нь Үндсэн Хуулийн 25 дугаар зүйлд заасан онцгой бүрэн эрх, хуулиар тогтоосон бусад бүрэн эрх эдэлж,

хэрэгжүүлж байна. УИХ, Хууль тогтоох бүрэн эрхийн хүрээнд хууль санаачлах эрх бүхий субъектүүд болох Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн газрын өргөн барьсан хуулийн төсөл, тус улсын нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалтын ямар ч асуудлыг хянан хэлэлцэж шийдвэрлэж байна. Мөн гаргасан хууль, шийдвэрийнхээ биелэлтийг хянан шалгах, УИХ-аас байгуулагдаж, түүнд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын тайлан, мэдээллийг сонсож, үйл ажиллагааг нь чиглүүлэн ажиллаж байна. 1992-1996 онд байнгын ажиллагаатай анхны УИХ бүрдэн ажилласнаас хойш 8 удаагийн Улсын Их Хуралд нийтдээ 383 хүн УИХ-ын гишүүнээр сонгогдон ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч

Монгол Улсын Төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ. Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн

хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг дээдэлж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг, улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилд хүрэхэд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгодог байсныг Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр насны хязгаарыг 50, бүрэн эрхийн хугацааг 6 жил болгож, зөвхөн нэг удаа сонгодог байхаар өөрчилсөн¹². УИХ-д суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх эрхтэй байхаар Үндсэн хуульд заажээ. Шинэ Үндсэн хууль үйлчилж эхэлснээс хойш Ерөнхийлөгчийн сонгууль 8 удаа явагдаж 5 Ерөнхийлөгч сонгогдсон байна.

Монгол Улсын Засгийн газар

Ардчилсан шинэ Үндсэн хуулиар Засгийн газрын байрыг тодорхойлж, түүний бүрэлдэхүүн болон бүрэн эрхийн үндсийг баталгаажуулж өгчээ. Энэ тухай Үндсэн хуульд *«Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн»* гэж заажээ¹³.

Засгийн газар бүрэлдэхүүний

¹² Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 45 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

хувьд Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн, УИХ-д өргөн мэдүүлдэг. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр УИХ хүн нэг бүрээр хэлэлцэн томилдог байсныг Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрын гишүүдийг УИХ, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд өөрөө томилж, чөлөөлж, огцруулж байх, Ерөнхий сайдын томилсон Засгийн газрын гишүүд УИХ-д тангараг өргөж байхаар заасан бөгөөд 2020 онд Засгийн газар энэ зарчмаар байгуулагджээ. 1992 оноос хойш Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайдаар П.Жасрайгаас Л.Оюун-Эрдэнэ хүртэл нийтдээ 15 Ерөнхий сайд ажиллажээ.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд: «Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн байгууллагын бусад албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчдээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй» гэж заасан нь аливаа нөлөөнд үл автах шударга шүүхийг бүрэлдүүлэх эрх зүйн баталгаа болсон байна.

Монгол Улсын шүүхийн Үндсэн

тогтолцоо нь Монгол Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэж байна. Түүнчлэн эрүү, иргэний, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх байгуулж болохыг хуулиар зөвшөөрсөн. Ингэхдээ шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд Шүүхийн хяналтаас гадуур байж үл болно. Шүүх нь: а) *анхан шатны*, б) *давж заалдах шатны*, в) *хяналтын шатны* гэсэн 3 шаттай байхаар зохион байгуулагдав. Түүнчлэн захиргааны хэргийн шүүхийг аймаг, нийслэлд, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг тус тус байгуулан ажиллаж байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүхийн хараат бус байх зарчмыг хангах үүднээс ажилладаг, шүүх болон шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульдаас шүүгчийг шилж сонгох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллах нөхцөлийг хангахтай холбогдсон үүргийг биелүүлэх зорилготой ажээ.

Өнөөдөр манай улсад 21 аймаг, нийслэл хотод бүгд 117 шүүх, нийт 511 шүүгч ажиллаж байна.

Прокурорын байгууллага

Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд зааснаар: прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж оролцдог бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг

хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

Үндсэн хуулийн Цэц

Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн. 1992 оноос тус институци бүрдэн Үндсэн хуулийг сахин хамгаалах ажлаа эхэлсэн билээ. Үндсэн хуулийн Цэц 9 гишүүнтэй ажилладаг бөгөөд УИХ-аас 3, Ерөнхийлөгч 3, УДШ 3 гишүүнийг тус тус нэр дэвшүүлж, УИХ-аас 6 жилийн хугацаагаар томилдог.

Цэцийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын нэг онцлог нь түүний шийдвэрийг УИХ нэг удаа буцааж болдог явдал юм. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг нь УИХ хүлээн зөвшөөрөөгүй бол Цэц их суудлаараа дахин хянан үзэж эцсийн шийдвэр болох тогтоол гаргана. Цэцийн тогтоолыг бүх холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Үүгээр нь Цэцийг Үндсэн хуулийн шүүхийн шинжийг агуулдаг гэж үзэж болох юм. Судлаач О.Мөнхсайханы тэмдэглэснээр: Цэц 1992-2016 оны хоорондох 24 жилийн хугацаанд нийт 2067 өргөдөл, мэдээлэл, хүсэлт хүлээж авчээ. Цэц 182 маргаан үүсгэснээс 16 маргаантай холбогдуулан магадлал гаргасан

байна. Түүнчлэн 176 дүгнэлт гаргасны 99 нь буюу 57,2 хувь нь Үндсэн хууль зөрчсөнийг тогтоожээ. Цэц 59 маргаанаар тогтоол гаргаж эцэслэсэн шийдвэрлэсэн байна¹⁴

Төрийн алба

Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг төрийн алба хэмээх ойлголтод хамааруулан авч үздэг билээ. Төрийн албыг 1/ улс төрийн алба, 2/ захиргааны алба, 3/ тусгай алба, 4/ үйлчилгээний алба гэж ангилж байна.

Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх болон чадахуйн зарчим алдагдаж ирсэн нь УИХ-ын сонгууль бүрийн дараа эсвэл сайд, дарга нар солигдох бүр төрийн албан хаагчдыг улс төрийн болон бусад элдэв шалтгаанаар олноор нь халах практик 1996 оноос эхлэн тогтож, улмаар энэ нь зуршмал зүйл болон хувирсан байна. Оросын эрдэмтэн В.А.Родионов “Монголын улс төрийн орон зайд бизнесийн, ажил хэргийн, нутаг нугын, төрөл садны, эсхүл ашиг сонирхлын үндсэн дээр бүрэлдсэн найз нөхдийн бүлэглэлийн төлөөлөл

төрийн албанд ноёрхсон” гэж тэмдэглэжээ.¹⁵

Нутгийн удирдлага

1992 оноос Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдах болов. Аймаг нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор юм.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болох иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болоод Засаг дарга нь Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна.

Шинэ Үндсэн хуулиас хойш хуучин байсан 18 аймаг дээр Дархан, Эрдэнэт хот болон Сүмбэр сум гурвыг аймаг болгон Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгийг тус тус байгуулжээ.

¹⁴ О.Мөнхсайхан. Үндсэн хуулийн хяналт. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. 2016. т. 179

¹⁵ В.А.Родионов. Политический процесс в Монголии в условиях постсоциалистической трансформации. Улан-Удэ., 2018. т. 173

ХОЁР. ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

Монгол Улсад ардчилсан шинэ Үндсэн хуулийн дагуу эрх зүйн цоо шинэ тогтолцоог бүрдүүлэх буюу хууль засагладаг байхад чиглэсэн эрх зүйн тогтолцоог шинэчлэх нь анхны УИХ-ын үндсэн гол зорилт байв. Зөвхөн 1992-1996 оны хооронд УИХ 9 удаагийн чуулган хийж, 369 хууль, 374 тогтоол баталжээ. Үүнээс 117 нь шинээр гаргасан хууль байв.¹⁶

Эрх зүйн бүрэн шинэтгэлийг нэрт хуульч Б.Чимидийн тэмдэглэснээр: "... Нэгдүгээрт, хууль тогтоомжийг шинэтгэх...

Хоёрдугаарт, хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх...

Гуравдугаарт, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх...

Дөрөвдүгээрт, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх ...

Тавдугаарт: нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлж, сайн эрх зүйг үгүйсгэхтэй тэмцэх. Энэ бол өгүүлэн буй шинэтгэлийн хамгийн төвөгтэй "үл үзэгдэх" урт хугацааны зорилт бөгөөд бодитой үнэлж, зөв тайлж, онож хийвэл зохих үзэл онол, мэдрэмж шаардсан ажил юм."¹⁷ хэмээн тодорхойлжээ.

¹⁶ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021. т. 398

¹⁷ ШУА-ФСЭХ. Монголын нийгмийн өөрчлөлт УБ., 2013. т. 323

Зөвхөн батлагдсан хуулиудын тоо бус, нийгмийн амьдралын бүхий л хүрээний үндсэн харилцаа шинэ хуулиудаар зохицуулагдах болсон нь энэ дүгнэлтийг хийх бололцоог олгосон билээ¹⁸.

1998 оны эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт «Эрх зүйн шинэтгэлийн зорилт нь тус улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчныг бүрдүүлэхэд оршино» гэж заажээ.

Энэ зорилтын доор

1. Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх;
2. Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
3. Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах;
4. Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
5. Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх;
6. Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох;
7. Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын

¹⁸ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021. т. 398

оролцоог өргөтгөх гэсэн 7 үндсэн чиглэлийг тодорхойлжээ.¹⁹

УИХ эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөртэй зэрэгцүүлэн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг батлан мөрдүүлсэн нь эрх зүйн шинэтгэлийн үйл ажиллагааг тодорхой зорилттой төлөвлөж хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан байна. Улмаар 2015 онд батлан мөрдүүлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулиар “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг Засгийн газар боловсруулж, төслийг УИХ-д мэдүүлснээр УИХ хэлэлцэн батлах журмыг тогтоосон нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагааны төлөвлөлтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улс орны хөгжлийн бодлогод нийцүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон юм.

Монгол УИХ 1998, 2001, 2005, 2009, 2017 онуудад хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл баталж байсан бөгөөд сүүлд 2021 онд 12 дугаар тогтоолоороо 2024 он хүртэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан юм.

Үндсэн хуулийн дагуу нэгэнт бүрдсэн **төрийн байгууллын эрх зүйн үндсийг тогтоон зохицуулж буй** гол гол хуулиудад улс орны хөгжлийн шаардлага, тулгамдсан

асуудлыг шийдвэрлэх үүднээс шинэчлэл хийж, Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгыг бүрэн зөв тусган нарийвчлах, зохицуулалтын чадавхыг сайжруулах зорилготой шинэчлэл хийгдэж ирэв.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1994, 2010 он) улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний чөлөөт хөгжил, нийгмийн дэвшлийг хангах талаар ойрын ирээдүйд төрөөс баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон чухал баримт бичиг болох Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого, улмаар 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрх зүйн шинэтгэл нь тусгалаа олсон юм. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталж, Монгол УИХ-ын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтыг баталсан.

¹⁹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. УИХ-ын тогтоол 1998 он. №18 “Монгол улсын эрх шинэтгэлийн хөтөлбөр” <https://old.legalinfo.mn/annex/details/3140?lawid=6881> (2023.05.01)

**ГУРАВ. УЛС ТӨРИЙН НАМ,
ИРГЭНИЙ НИЙГМИЙН
БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВШИЛ**
Улс төрийн намын төлөвшил

1989 оны 12 дугаар сарын 10-нд болсон Нийгмийг ардчилахыг шаардсан анхны жагсаалд оролцогчид “Эрх зүйт төрийн төлөө”, “Олон намын систем хэрэгтэй”, “Хүний эрхийг дээдэлъе”, “Хэвлэлийн эрх чөлөө” зэрэг уриа лоозон барьсан байсан бөгөөд энэ үеэр Монголын Ардчилсан Холбоо байгуулагдсаныг зарлаж, МАХН-ын Төв хорооны 7 дугаар бүгд хурал, БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганд өргөн барих бичиг илгээв. Уг өргөн барих бичигт олон намын систем тогтоох, хүний эрхийг дээдлэх, улс төрийн намаас төр засгийн үйл ажиллагааг шууд удирдан чиглүүлж нөлөөлөхийг зогсоох, төрийн сонгуулийн системийг өөрчилж, бүх нийтийн сонгуулийг явуулах зэрэг улс төрийн шаардлага тавьснаар Монгол оронд ардчиллын төлөө хөдөлгөөн эхэлснийг тунхагласан юм. 1989 оны 12 дугаар сарын 28-нд Ардчилсан социалист хөдөлгөөн, 1990 оны 2 дугаар сарын 17-нд Шинэ дэвшилт холбоо зэрэг шинэ хөдөлгөөн, холбоонууд байгуулагдаж, ардчиллын төлөөх тэмцэл улам хүчтэй болж, ардчилсан хүчнүүдийн зүгээс зохион байгуулсан жагсаал цуглаанууд дараалан хийгдэж, тавих шаардлага нь улам бүр хүчтэй болж байлаа. 1990 оны 2 дугаар

сарын 18-нд Монголын Ардчилсан Холбооны анхдугаар Их хурал хуралдаж Монголын Ардчилсан Нам байгуулагдсан тухай албан ёсоор зарлав. 1990 оны 3 дугаар сарын 2-нд Монголын Социал-Демократ Нам, 3 дугаар сарын 9-нд Монголын Ногоон нам, 3 дугаар сарын 11-нд Монголын Үндэсний Дэвшлийн Нам болон Монголын Чөлөөт Хөдөлмөрийн Нам байгуулагдав.

3 дугаар сарын 10-нд МАХН, МоАН, МСДН, МоАХ, АСХ, ШДХ, МОХ хамтран “Монголын ард түмний сонорт хүргэх улс төрийн тунхаглал” гаргав. Ардчилсан өөрчлөлт, шинэчлэл хийх явцад улс төрийн хүчнүүдийн үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг тодорхойлсон бөгөөд энэхүү зарчмаа улс төрийн хүчнүүд хэлбэрэлтгүй дагасан нь Монгол оронд ардчилсан хувьсгал тайван замаар, амжилттай, хурдтай хэрэгжих үндсэн нөхцөл болсон юм.

БНМАУ-ын АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн IX чуулган хуралдаж 1990 оны 5 дугаар сарын 10-нд “Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль” болон “Улс төрийн намуудын тухай хууль”-ийг батлав. Ийнхүү улс төрийн намууд хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндэс бүрэлдэж, Монгол Улсад олон намын тогтолцоо бий болов.

2023 оны эхний байдлаар Монгол Улсад бүртгэлтэй улс төрийн нам 36 байна. Гэвч эдгээр намын дийлэнх нь үндэсний хэмжээнд танигдаагүй,

идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй, парламентын болон иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцдоггүй юм уу ор нэрийн төдий оролцсон нэр зүүдэг, сонгуульд орох зохион байгуулалтын бүтэц, гишүүдгүй, сонгуулийн санхүүжилт гаргах чадавхгүй байна.

Монгол Улсад олон намын оролцоотой сонгуулийн систем бий болсон 30 гаруй жилд ердөө хоёр нам ээлжлэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд богино хугацаанд бусад намын төлөөлөл энэ хоёр намын аль нэгтэй нь эвсэх, хамтрах байдлаар УИХ, Засгийн газарт төлөөллөө оруулсан байдаг. Гэвч Монголын хоёр том намын нэг нь дотоод зөрчлөө даван туулж чадахгүй удаж байна.

Энэ учраас зөвшилцлийн ардчилалд шилжих шаардлагын улмаас УИХ-ын гишүүдийн тоог нэмэгдүүлж, сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульдаа суулгаж өгсөн юм. 2012 онд ХБНГУ-ын монголч эрдэмтэн Удо Баркманн: Парламентын засаглал, нийт ард түмнээс сонгогддог ч хязгаарлагдмал эрхтэй ерөнхийлөгч, парламентын шийдвэрт түүний хориг тавих эрх, парламентаас бүх түвшинд нөлөө үзүүлэх боломжтой гүйцэтгэх засаглалын шийдвэр гаргах механизм, тэр бүү хэл янз бүрийн санаа бодлыг уралдуулах баталгаа болсон олон ургалч үзэл ч бас гадны нөлөөнөөс хамгаалах боломжийг ерөнхийлөгчийн засаглалтай

ардчиллаас илүү олгож байна. Энэхүү зөвшилцлийн тогтолцооны төвд улс төрийн намууд байсан нь эргэлзээгүй. Намууд хөгжлийн хөдөлгүүр нь ч, зохицуулагч нь ч болж байлаа²⁰ хэмээн тэмдэглэжээ

Судлаачид Монгол Улсад өдгөө үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд санхүүжилтийн ил тод байдал хязгаарлагдмал, улс төрийн нам бодлогын институци болон төлөвшиж чадаагүй, хэн нэгэн лидер буюу үүсгэн байгуулагчийн удирдлагаас шууд хараат нэг хүний юм уу лидер тойрсон бүлэглэл маягийн хэлбэртэй байгаа хэмээн дүгнэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр 2023 оны хаврын чуулганаар шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуулиар “Намд төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, түүний шалгуур, хуваарилалт, гишүүний татвар, хандив, санхүүжилтийн ил тод байдал, тайлагнал, хуулиар намыг идэвхгүйд тооцох, өөрчлөн байгуулах, татан буулгах, тараах, үйл ажиллагааг нь зогсоох хүртэл асуудлыг нарийвчлан зохицуулсан.”²¹

²⁰ Удо Б.Баркманн. Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд. УБ., 2013. т. 250

²¹ Веб хуудас. Parliament.MN. 2023.07.07

Иргэний нийгмийн байгууллага /ИНБ/-ын төлөвшил

Иргэний нийгмийн онцлог шинж чанарыг “төр ба зах зээлээс тусдаа, нийтлэг хэрэгцээ, ашиг сонирхолтой, харилцан ойлголцол, оролцоо, хамтын ажиллагаа, тэгш байдал зэрэг үнэт зүйлсийг баримжаалдаг хүмүүсээс бүрдсэн, аливаа гадны нөлөөллөөс хараат бус үйл ажиллагааны үндсэн дээр хөгждөгт оршино хэмээн тодорхойлох нийтлэг хандлага байна²².

Орчин үеийн ардчилсан төр засгийн хөгжил, иргэний нийгмийн төлөвшлийн нэг чиг хандлага бол төрийн зарим үүрэг, тухайлбал, социал бодлого, социал соёлын бодлого зорилтуудыг иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх замаар төр, нийгмийн удирдлагад олон нийтийн оролцоог идэвхжүүлэх зэрэг юм. Ер нь төр олон нийтийн оролцоогүйгээр шийддэг асуудал байх учиргүй юм.

Иргэний нийгмийн холбоотой хуулиудын дотор Үндсэн хуульд заасан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх, Иргэний нийгмийн эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хууль чухал байр эзэлдэг бөгөөд нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагуудын харилцааг энэ хуулиар зохицуулж ирэв. Монгол Улсад 1998 онд 1075,

2005 онд 3492, 2010 онд 6915, 2015 онд 11879, 2020 онд 25388 ТББ бүртгэлтэй байна.²³

ДӨРӨВ. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

Ардчилсан шинэ Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 9-д хүний сонгох, сонгогдох эрх насны хязгаарыг тогтоон заасан бол Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, 4 жилийн хугацаагаар сонгоно.” Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “УИХ-ын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн үндсийг тогтоожээ. Мөн Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт орон нутгийн сонгуулийн журмыг хуулиар тогтоохоор заажээ. Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж” гэсний талаар одоог хүртэл улс төрчид ч, эрдэмтэн судлаачид ч, иргэд ч нэг мөр нэгдмэл ойлголтод хүрч чадаагүй байна. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд

²³ Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. Танилцуулга. <https://forum.parliament.mn/projects/11200> (2023.05.01)

²² Д.Лүндээжанцан. Эрх мэдэл ба ардчилал. УБ., 2015. т. 68

УИХ-ын сонгуулийн тогтолцоог 5 удаа өөрчилж, Үндсэн хуулийн Цэц сонгуулийн холимог тогтолцоо Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж 2012 онд 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоол гаргасан байтлаа, сонгуулийн холимог тогтолцоо Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж 2016 онд 05 дугаар дүгнэлт гаргаж, хоорондоо зөрчилтэй эдгээр шийдвэрүүдийг Үндсэн хуулийн Цэцийн 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгох хүртэл зэрэгцэн үйлчилсээр байв. Үүнээс улс төрчид, эрдэмтэн судлаачид ч сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчинө, зөрчихгүй гэж марган хуваагдаж, сонгогчдоо ч мөн хоёр талд хуваасаар өдийг хүрсэн гэж дүгнэж болох юм.

2023 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр УИХ-ын 78 гишүүнийг сонгуулийн тойргоос олныг төлөөлөх (мажоритари) аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх (пропорциональ) аргаар сонгоно. Энэ дагуу Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг УИХ-аар хэлэлцэж 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталжээ.²⁴

УИХ-ын гишүүнийг намын жагсаалтаар (пропорциональ) сонгох сонгуульд Монгол Улсын нутаг

дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна. Энэ дагуу УИХ-ын пропорциональ сонгуульд Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа манай улсын сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй болсон. Гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байх юм.

Сонгуулийн дүнг гаргахдаа улс төрийн нам тойрогт ногдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлсэн байх, намын тухайд нам эвсэлд өгсөн нийт саналын 4 буюу түүнээс дээш хувьд санал авсан байх, хоёр нам бүхий эвслийн тухайд 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх, 3 буюу түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 7 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх зэрэг шаардлагуудыг тусгажээ.

Сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсаны дараа УИХ-ын чуулганы хуралдаан дээр УИХ-ын дарга Г.Занданшатар хэлэхдээ: Эрх баригч нам бүр өөрсдийн эрх ашгийн төлөө сонгуулийн хуулийг өөрчилдөг байдал үүгээр дуусгавар болж байна. УИХ-ын Сонгуулийн тухай хууль 30 жил тогтвортой мөрдөгдөх ёстой гэдгийг онцлон тэмдэглэе хэмээн мэдэгджээ²⁵.

²⁴ Legalinfo.mn

²⁵ УИХ-ын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар тус улсад улс төр, эрх зүйн иж бүрэн шинэтгэл хийх үзэл баримтлалын үндэс суурь зарчмуудыг тогтоож өгчээ.

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль (1992) нь улс төр, эрх зүйн зөвшилцлийн баримт бичиг, төр, иргэдийн хооронд байгуулсан нийгмийн гэрээ болж чадсаныг улс төр, эрх зүйн тогтолцооны түүх харуулж байна.

Төрийн эрх мэдэл тус бүрийн бүрэн эрхийг Үндсэн хууль болоод органик хуулиудаар харилцан хяналт, тэнцвэртэйгээр хуваарилж, нэг бүрчлэн тогтоож, хязгаарлаж өгснөөр үндсэн хуульт ёс төлөвших, хүний эрх хангагдах эрх зүйн баталгаа бүрдсэн болох нь харагдаж байна.

Эрх зүйн хуучин тогтолцоог халж өөрчлөн, нийгмийн шинэ харилцааг хуулиар зохицуулах нөр их ажил хийгдэн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлж ирэв. Эрх зүйн шинэтгэлийн үйл явц улс орны хөгжил, хүний эрхэд суурилан цаашид ч улам гүнзгийрэх учиртай. Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 850 гаруй хууль улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн бүхий л харилцааг зохицуулж байна. Парламентаас Үндсэн хуульд нийцсэн, урт хугацаанд тогтвортой үйлчлэх хүчин чадалтай хуулийг батлахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлэх, гажуудуулахгүй

байх нь өнөөдөр ард иргэдийн хүсэн хүлээж буй хүний эрх, шударга ёсыг хангахад хамгийн чухал, тулгамдаж байгаа асуудал юм.

Ардчилсан засаглалын тогтолцооны эх үндэс нь болсон улс төрийн намууд ардчилсан үндсэн дээр зөв төлөвшихгүйгээр, эрх зүйн орчныг нь сайжруулахгүйгээр улс орны хөгжил дэвшил, авлига, хүнд суртлаас ангид байх, төрийн байгуулал, иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулах нөхцөл бүрдэхгүй гэдэг нь сүүлийн 30 жилийн хугацааны сорилт сургамж харуулав.

Сургамж, шүүмжлэлтэй хандах олон асуудал дагуулж буй боловч сонгуулийн тогтолцоо өмнөх тогтолцооны үеийн шагналын болон томилолтын сонгуультай харьцуулахад үндсээрээ өөрчлөгдсөн болой.

Өнгөрсөн жилүүдэд нэг талаас парламентыг дээд, доод гэсэн хоёр танхимтай болгох, улмаар Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга хийж, Ерөнхийлөгчийн засаглалд шилжих, нөгөө талаас Ерөнхийлөгчийг нийт ард түмнээс сонгодгийг болиулж, парламентаас сонгодог болох, парламентыг хугацаанаас нь өмнө тараах эрхийг Ерөнхий сайдад өгөх зэрэг санал бодол улс төрчид, судлаачид, улс төрийн зарим хүчний зүгээс удаа дараа гарч, үүнийгээ тогтолцооны хямралаас гарах арга зам гэж нотлохыг оролдож ирэв. Үүнтэй хувь судлаачийн хувьд санал нийлэхгүй.

Хэрэв Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөө амилуулах хуулиудыг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлэн баталж, түүнийгээ хэрэгжүүлээд явахад үр дүн нь ойрын жилүүдэд гарч, Үндсэн хууль чиг үүргээ урт удаан хугацаанд гүйцэтгэсээр байх болно гэдэгт итгэлтэй байна. Монгол Улс ардчилсан тогтолцоо, түүний дотор парламентын ардчилсан тогтолцооноос ухрах ёсгүй.

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль. Эмхэтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан. УБ., 2004;
- Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаар;

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

<https://legalinfo.mn>; Б.Чимид. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм. УБ., 2019. т. 24;

Б.Чимэд. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006. т. 146;

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Хамтын бүтээл. УБ., 2016. т. 196;

Монгол Улсын Үндсэн хууль-25 жил эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017. т. 40;

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941> (2023.05.01);

О.Мөнхсайхан. Үндсэн хуулийн хяналт. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн

шинжилгээ. 2016. т. 179;

В.А.Родионов. Политический процесс в Монголии в условиях постсоциалистической трансформации.

Улан-Удэ., 2018. т. 173;

Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021. т. 398;

ШУА-ФСЭХ. Монголын нийгмийн өөрчлөлт УБ., 2013. т. 323;

Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021. т. 398;

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. УИХ-ын тогтоол 1998 он. №18 “Монгол улсын эрх шинэтгэлийн хөтөлбөр” <https://old.legalinfo.mn/annex/details/3140?lawid=6881> (2023.05.01);

Удо Б.Баркманн. Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүлүүд. УБ., 2013. т. 250;

УИХ-ын Тамгын газрын вэб сайт, parliament.mn.

Д.Лүндээжанцан. Эрх мэдэл ба ардчилал. УБ., 2015. т. 68;

Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. Танилцуулга. <https://forum.parliament.mn/projects/11200> (2023.05.01);

УИХ-ын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.

**АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГЫН ТУХАЙД**



Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн захирал, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн. Доктор (Ph.D), профессор Н.ЖАЛБАЖАВ

**Аюулгүй байдлын тодорхойлолт,
томъёоллын тухайд**

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д аюулыг аливаа юмс үзэгдэлд “гамшиг зовлон учруулж мэдэх хор хөнөөлтэй юм” гэжээ.

В.И.Даль: Нэвтэрхий толь бичиг /М.Наука.1955 он.Т.4, 170 дах талд/-тээ “аюулгүй байдал бол найдвартай байдал” гэсэн бол, С.И.Ожегов: “Словарь русского языка” /М.Русский язык.1990 он, 844 дэх талд/-тольд “Аюулгүй байдал гэдэг нь хэн нэгэн, ямар нэгэн зүйлд аюул занал учрахааргүй нөхцөл байдал, аюулаас хамгаалагдсан төлөв байдал” гэж томъёолжээ, Аюулгүй байдал /англ. safety, security; ор. безопасность/-ын тухай С.Нарангэрэл академичийн тодорхойлолт сонирхол татаж буй.

Тэрбээр “Эрх зүйн эх тайлбар толь” /2007 он/-д АБ-ыг “тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс **бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал.** Монгол Улсын аюулгүй байдлын үндсэн объект нь дараах ашиг сонирхол юм: бие хүний аюулгүй байдал, үндсэн хуулийн эрх ба эрх чөлөө, хувийн аюулгүй байдлыг нь хамгаалах, амьдралын чанар ба түвшинг нь өөд татах, бие махбодь, оюун санаа ба оюунлаг байдлыг хөгжүүлэх; нийгмийн аюулгүй байдал, ардчиллыг бэхжүүлэх, нийгм-ийн зөвшилцөлд хүрэх, хүн амын бүтээн байгуулах идэвхжилийг нь өрнүүлж, оюун санааг нь сэргээх; төрийн аюулгүй байдал, түүний үндсэн хуулийн байгуулал, улс орны бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах” гэж тодорхойлжээ. Академич мөн энд аюулгүй байдлын ойлголтын хүрээнд “аюул”, “эрсдэл” гэсэн нэр томъёог тодорхойлсон нь бий.

Тухайлбал, эрсдэл гэдэг /англи.risk, ор. риск/ нь эрх зүйд ямар нэг сөрөг нөлөө учруулж болохуйц үр дагаврын хэмжээ нэмэгдэх, ихсэх магадлал, иргэний эрх зүйд хүний хүсэл зоригоос шалтгаалан байгалийн ба гэнэтийн аюул тохиолдоход хүлээх хохирол. Эрсдэлийг хоёр хэсэгт ангилна: Объектив эрсдэл: ихэвчлэн эрсдэл ба таамаглагдаж буй эрсдэлийн өөрчлөлт, элдэв гамшигт нэрвэгдэлтээс үүсэх хохирол хамаарна. Субъектив эрсдэл өгөгдсөн үйл баримтын дүнд сэтгэл зовох, эргэлзээ төрөх, өөрөөр хэлбэл хувь хүний сэтгэл санаа, оюун ухаантай холбогдож гарах эрсдэлүүд хамаарна.” гэж тодорхойлжээ.

“Монгол хэлний их тайлбар толь”-д Аюулыг “1.Гамшиг зовлон учруулж болох хор хөнөөл, гай-Чамд одоо айх аюул, зовох зовлон үгүй болсон. дэлгэрэнгүй ... аюул тулгарах (гай зовлон нүүрлэх), аюул дайрах (хор хөнөөл ихтэй гамшиг болоод өнгөрөх), аюул ёрлох (гай ёрлох), аюул нөмрөх (гай нөмрөх, гай учрах), аюул тарих (гамшиг зовлон үүсгэх), аюул тээх (хөнөөл тээх, хөнөөл болох), байнгын аюул (байнга учирч болох аюул), галын аюул (түймэр), гэнэтийн аюул (гэнэтийн осол), дайны аюул (дайны хор уршиг), зудын аюул (их цас унаж мал бэлчээргүйдэх аюул), усны аюул (үер усны осол), үхлийн аюул (амь насанд заналхийлсэн аюул), аюул гамшиг [хоршоо] (нийтийг хамарсан томоохон аюул), аюул занал [хоршоо]

(болзошгүй хор хөнөөл), аюул зовлон [хоршоо] (гай түйтгэр, зовлон гамшиг)-Нийтийн аюул зовлонгийн өөдөөс амь холбон нэгдсэн билээ. Аюул осол [хоршоо] (гэнэт тохиолдох амь насанд халтай хэрэг явдал)-Тийн алс холын аян аюул осол бүхий байв. Ж.Верн. Арван таван наст капитан., аюул сүйрэл [хоршоо] (гамшиг зовлон тохиолдож хохирох нь), аюул тохиол [хоршоо] (гай тохиол)-Зайлшгүй аюул тохиол учирсан нь магад гэж сэтгэл түвдэхгүй байжээ. Ж.Верн. Арван таван наст капитан., аюул түгшил [хоршоо] (а. Учирч болзошгүй аюул; б. Сэтгэлийн айдас, хямрал)-Мянган түмэн аюул харь цэрэгт гишгэгдэх аюул түгшил үгүй аюул түгшүүр [хоршоо] (айж эмээх, аюул осол болох зэргээс үүдэх сэтгэлийн зовнил)-Аюул түгшүүрээс айхгүй юу? В.Инжаннаши. Хөх судар.” аюул түйтгэр [хоршоо] (а.Хор хөнөөл; б.Гай барцад)-Амь насны аюул түйтгэрийг арилгалцахыг бодож үзье дээ. А.Дашням. Өлзийнарангийн өчил., аюул хөнөөл [хоршоо] (ямар нэг муу явдлаас гарах хор уршиг), аюул эмээл [хоршоо] (айж эмээх нь), хор аюул [хоршоо] (гэм уршиг болох зүйл) гэж тодорхойлж томьёолсон байна.

Б.Чадраа, Л.Болд нарын “Монгол хэлний дэлгэрэнгүй толь” /УБ.2008 он, 160-т, 176 дах талд/-д “айх эмээх, сандрах, түгшүүргүй, тайван байдал” гэжээ. Эдгээр болон бусад томьёоллуудад юмс, үзэгдлийн аюулгүй байдал гэж тэдгээрийн аливаа аюул, занал, эрсдэлээс

хамгаалагдсан, ангид байхыг хэлсэн нийтлэг санаа байна.

Арга зүйн ийм хандлага улс үндэстэн, нийгмийн аюулгүй байдлыг тодорхойлж томъёолоход нэгэн адил хамааралтай гэж үзэж байна. Чингэхдээ тухайн юмс үзэгдлийн амин чухал, мөн чанар, оршихуй, эс оршихуйн нь үндэс болсон зүйлд учрах аюул эрсдэлийг олж харах нь чухал. Улс үндэстний тухайд ийм амин чухал зүйл нь хүн, тухайн улс орны иргэний аюулгүй байдал гэж үзэх бүрэн үндэстэй байна. Эдүгээ их, бага улс, үндэстний аюулгүй байдлын үзэл баримтлал, номлол зэрэгт хүний аюулгүй байдалд голлох ач холбогдол өгч байгаа хандлагыг ч анхаарах учиртай бөгөөд ҮАБҮБ нь улсын иргэн, хүн ам, удмын сангийн АБ-д онцгой ач холбогдол өгсөн, хүний эрх, эрх чөлөө, тэдгээрийн баталгаажилт, хүний хөгжил, амьдрах орчны аюулгүй байдал нь төрийн бодлого үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт болох үзэл санааг тусгасан баримт бичиг байх нийтлэг жишиг тогтож байна.

Улс, үндэстний аюулгүй байдлыг тухайн улс орны иргэдийн эрх эрх чөлөөний баталгаажилттай тэгэхдээ хүний амьдралын анхдагч орчин болох экологи, байгаль орчны аюулгүй байдал, мөн нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, хөгжилтэй нь, улс орны төрийн тогтолцоо, засаглалын шинж шинж чанартай нь, өөрөөр хэлбэл иргэн, байгаль, нийгэм, төр гэсэн уялдаа

холбоонд авч үздэг, тайлбарладаг хандлага давамгайлах болсон байна. Эдгээр санаа бодлогыг илүү оновчтой, логик уялдаа холбоонд нь шинэлэг байдлаар томъёолох, тодорхойлох хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Монгол Улсад улс орны аюулгүй байдалд хандах ийм төлөв байдал ажиглагдаж байна гэх үндэстэй байна. Эдүгээ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” зэрэг стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд Монгол Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдлын хувь заяаг монгол хүн, Монгол Улсын иргэний аюулгүй байдал хөгжилтэй холбосон, уялдуулсан “Хүн амаа эх оронч, эрүүл чийрэг, дэлхийд өрсөлдөх чадвартай болгох цогц бодлого хэрэгжүүлэх ...Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг засаглал тогтоох ... хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх...” зэрэг шинэ утга агуулга, өнгө аястай, тодорхой зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлдог чиг хандлага бий болжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын хэлсэн үг, илтгэлүүд, монголын улс төр, иргэний нийгмийн байгууллагуудын удирдлагын баримт бичгүүдэд улс үндэсний аюулгүй байдлыг иргэний эрүүл мэнд, боловсрол, хүмүүжил, төлөвшилтэй, мөн монгол хүн, улс

үндэсний, төр ёсны үнэт зүйлстэй холбон тайлбарласан цөөнгүй байна. Үүнийг нийгмийн ухамсар сэтгэлгээний шинэ хандлага гэх бүрэн үндэстэй юм. Тухайлбал, “Алсын хараа 2050”-д хүний хөгжил, амьдралын чанар, үндэсний бахархал, эв нэгдлийг үндэсний нэгдмэл үнэт зүйлст багтаан “Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл эв нэгдлийг нягтруулна” гэсэн зорилт /баримт бичгийн 1.1/ дэвшүүлжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх: “Монгол хүн, Монгол оюун ухаан, Монголын түүх, Монгол өв соёл, Монгол урлаг, Монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой. Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болсон Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй Монгол хүнийг хүмүүжүүлэх эх үйлсийг бид цалгардуулах учиргүй” гэсэн нь төрийн бодлогын энэ чиг хандлагыг онцолсон хэрэг юм. Бид үүнийг үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх шинэ зорилт гэж үзэж байгаа болно.

Энэ бүхнээс үзэхэд **үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, зорилтыг монгол хүн, Монгол Улсын иргэний аюулгүй байдал, амьдралын чанар, хөгжил ба ҮАБ, монголын ард түмэн, улс үндэсний үнэт зүйлс ба үндэсний аюулгүй байдал гэсэн уялдаа холбоонд тодорхойлох нь Үндэсний аюулгүй**

байдлын үзэл баримтлалыг шинэчлэх нэг үндэслэл болно гэж үзэж байна. Ийм хандлага байр суурь нь дэлхий нийтийн чиг хандлагад нийцэж уялдаж байна гэх үндэс байна.

Гадаад дотоодын олон судлаачид хүний аюулгүй байдлын гол зүйл болсон эрх, эрх чөлөөг аливаа хүн эдийн засгийн, нийгмийн, улс төрийн, соёлын сонголтоо чөлөөтэй хийх боломжийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх үйл явц, үр дүн нь болсон хүний хөгжилтэй холбон үздэг байна /мөн тэнд. 199 дэх талд/. Энэ бол хүний өөрийнх нь дотоод нөөцийг хөгжүүлэх замаар чадвар боломжийг нь төгөлдөржүүлэх /сайжруулах/, чингэснээр амьдралд нь ач холбогдолтой, үр өгөөжтэйгөөр нөлөөлөх хэрэг бөгөөд хүний нийгмийн харилцаанд оролцох үйл ажиллагааны цогц, нэг ёсны үр дүн нь юм. Судалгаанаас үзэхэд нийгмийн шинэтгэлд саад болж буй гол хүчин зүйл нь бfy I хүний хүчин зүйлтэй холбоотой гэх үндэстэй байна. /Б.Хэрлэн, Г.Хулан, Б.Даш-Ёндон, Г.Чулуунбаатар нарын судалгаа, Монголын нийгмийн өөрчлөлт /Монгол Улсын ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн хамтын бүтээл. 2008 он, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн жил бүрийн статистик мэдээллүүд г.м/. Эдгээрт юуны өмнө: Нийгмийн сошиал ялгарлын лавширлаас үүдэлтэй ашиг сонирхлын бүлгүүдийн зөрчил,

ажилгүйдэл ядуурал, олигархи бүлгүүдийн нөлөө, үндэсний хэмжээнд хүрсэн туйлширсан улс төржилт, нутгархах үзэл, хандлага зэрэг үндэсний эв нэгдэлд харшлах үзэгдлүүд, бэлэнчлэх сэтгэлгээ, шунахайрал, авлига зэргийг нэрлэж болох байна. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлд: цаг уурын дулаарлын уршиг, нөлөө, цар тахал, дэлхийн зах зээлийн конъюктурын өөрчлөлт, нийтийг хамарсан хямралт үйл явц зэргийг нэрлэж байна.

Улс орны хөгжил, дэвшил, аюулгүй байдалд нөлөөтэй эдгээр аюул,эрсдэл, хүндрэл бэрхшээлээс сэргийлэх, хамгаалах, уршиг нөлөөг нь арилгах, саармагжуулах арга замын үндсийг тодорхойлох нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шинэчлэлийн гол агуулга нь болох учиртай гэж үзэж байна.Энд улс төрч С.Баярын арга зүйн зөвлөмж болгосон зүйл сонирхол татаж буй.” ...аливаа ойлголт, бодол, таамаглал зэрэг нь мөнхүү “концепцын” хэмжээнд хүрэхийн тулд наанадаж гурван нийтлэг шинжийг нийтлэг шинжийг өөртөө агуулсан байх учиртай ажээ. Нэгдүгээрт, үзэл баримтлал нь аливаа эд юм, асуудал, үзэгдлийн тал , нэг хэсгийг бус бүхэл цогцолбороор нь авч үзсэн байх ёстой. Хоёрдугаарт, үзэл баримтлал нь олон янзын үзэл бодлын цуглуулга бус, хоорондоо логик уялдаа холбоо бүхий ойлголт төсөөллийн цогц

нийлбэр,тогтолцоо болж бүрэлдсэн байх ёстой. Гуравдугаарт, үзэл баримтлан тулгуур ойлголт, гол дүгнэлт, ач холбогдлыг өргөн олон нийт биш юмаа гэхэд нийгмийн тодорхой хэсэг хүлээн зөвшөөрсөн байх ёстой ажээ”. /С.Баяр. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын талаарх санал, дүгнэлт, зөвлөмж” Стратегийн судалгаа. 2022 он. Дугаар 84.8 дахь талд/.

Дүгнэлт болгон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын агуулгыг дараах байдлаар өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд: Бүхэлдээ ҮАБҮБ нь:

- 1.Нийтлэг үндэслэл
2. Монгол Улсын иргэн/хүний/-ний аюулгүй байдал,
- 3.Нийгмийн аюулгүй байдал
- 4.Монгол Улсын төрийн аюулгүй байдал
- 5.ҮАБ-ын гадаад, дотоод орчин.
- 6.ҮАБҮБ-ыг хэрэгжүүлэх удирдлага, зохицуулалт гэсэн бүтэцтэй, авсаархан боловч агуулга төгс баримт бичиг байх ёстой гэж үзэж байна.Бид ҮАБҮЗБ-ын агуулгад дараах зүйлсийг багтаан тодорхойлох ёстой гэж үзэж байна. Үүнд:

Нэг.

ҮАБ-ын өнөөгийн тодорхойлолт нь аюулгүй байдлын мөн чанарыг нь гэхээсээ үр дүнг нь ерөнхийлөн томъёолсон шинжтэй болсон гэж үзэж байна.

Тиймээс ҮАБ-ын тодорхойлолтыг “ҮАБ гэж Монгол Улсад хүн, улсын иргэн, нийгмийн ардчилсан тогтолцоо, ардчилсан төрийн бүрэн эрхт байдал гадаад дотоод аливаа аюул эрсдэлээс харилцан уялдаа холбоотой хамгаалагдсан байдал мөн. ҮАБ хангагдсанаар Монгол Улсын оршин тогтнохуй, хөгжил дэвшлийн язгуур эрх ашгийн зүйлүүд хадгалагдах, хамгаалагдах таатай орчин бүрдэнэ. Ийм язгуур эрх ашгийн зүйлд:

- Монгол Улсын иргэний нэр төр, эрх, эрх чөлөө, тэдгээрийн баталгаажилт;
- Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт, аюулгүй байдал, олон улсын нэр хүнд, байр суурь;
- Монгол Улс, үндэстний эв нэгдэл;
- Монгол Улсын төр, нийгмийн ардчилсан байгуулал,
- Төр, хууль цааз, цэргийн байгуулалтын өв уламжлал;
- Монголын нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц шинж, өнгө төрх, аж ахуйгаа эрхлэн хөтлөх, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах арга ухаан, технологи;
- Монголын үндэсний соёл урлаг, хэл бичиг, утга зохиол, дуу хөгжим, яруу найраг, уран барилга, монгол зураг г.м соёлын үнэт зүйлс.
- Монгол Улсын иргэдийн эх оронч үндэсний үзэл, хүмүүжил, үндэсний бахархал, ой санамж;
- Байгаль эхээ хайрлан хамгаалах монгол арга ухаан, өв

уламжлал;

- Монгол Улсын төр, нийгмийн үндэс нь болсон өрх гэр бүл, тэдгээрийн өмч хөрөнгө бат бэх байдал, гэр бүлийн гишүүдийн өмч, нэр төр, эрх, эрх чөлөө, эрхэмлэх бусад үнэт зүйлс” гэж томъёолох,

Нэгэн зүйлийг онцлоход **Монгол Улс бол суут богд Чингис хааны гал голомт болох тухай** Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэгтээ тунхаглан баталгаажуулах нь үндэстний бахархал омогшил, эв нэгдлийн үзэл санаа, ухамсар, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. **Унгар** улсын Үндсэн хуулинд “**Бидний хаан Гэгээн Иштван мянган жилийн түүхт Унгарын төрийг бат бэх суурилуулж, эх орныг маань христийн шашинт Европын нэг хэсэг болгон хөгжүүлсэнд бид Бахархаж байна**” гэжээ. Үндсэн хууль болон ҮАБҮБ, холбогдох бусад хууль тогтоомж, төрийн удирдлагын баримт бичигт уламжлалт шашин /бурхны шашин/-ны байр суурийг оновчтой тодорхойлох, иргэдийн бусад шашин шүтлэгт хүндэтгэлтэй хандах зарчмыг хуульчлан баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна. Мөнөөх Унгар улсын үндсэн хуулинд “Бид христийн шашны үндэстнийг нэгтгэх, авч үлдэх үүргийг хүлээн зөвшөөрч байна. Улс орныхоо олон төрлийн шашны өв уламжлалыг хүндэтгэж байна” гэж томъёолсныг энд жишээ болгох байна.

Үзэл баримтлалд Монгол Улсын төрөөс бурхны шашны хүмүүнлэг, энэрэнгүй, нигүүлсэхүйн үзэл санааг дэмжин дэлгэрүүлэх бодлого баримтлахын зэрэгцээ иргэдийнхээ шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэн дагана гэсэн санааг тусгаж болно гэж үзэж байна.

ХОЁР.

Хүний аюулгүй байдал гэж “Монгол Улсад хүн аюул, эрсдэлээс хамгаалагдсан, Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө баталгаажсан, хүний хөгжлийн орчин бүрдсэн нөхцөл байдал мөн” гэх. Хүний аюулгүй байдлыг хангах нэг үндэс нь байгаль, нийгмийн хүчин зүйлээс гадна хүмүүний өөрийнх нь дотоод ертөнц нь болсон итгэл, үнэмшил, ертөнцийг үзэхүйн зүйлүүд болох эх оронч үзэл, ухамсар, бахархал, ой санамжийг нь төлөвшүүлэн хөгжүүлж монгол хүн, Монгол Улсын иргэний оюун санааны дархлааг бүрдүүлэх хэрэг гэж үзэж байна.

НҮБ-ын Хүний аюулгүй байдлын зөвлөлөөс “Хүний амьдралын утга учрыг хүний эрх, эрх чөлөө, сэтгэл хангалуун байдлаар тодорхойлно. Хүний аюулгүй байдал гэдэг нь хүмүүний амьдралын гол утга учир болох үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахыг хэлнэ. Энэ нь улс төр, нийгэм, хүрээлэн буй орчин эдийн засаг, батлан хамгаалах, соёлын системийг цогцлон бүтээж, улмаар нэр төртэй аж төрөх нөхцөл, бий

болгохыг хэлнэ” гэсэн нь хэлснийг нотлох баримт юм. /Г.Хулан. Хүний АБ-ын талаарх онол, арга зүйн зарим үзэл санаа. УБ.,2020 он 203 дах тал/

Түүнчлэн НҮБ-ын 1994-онд боловсрогдсон хүний хөгжлийн илтгэлд хүний аюулгүй байдлыг “Аливаа хүн айх аюулгүй ,нэн шаардлагатай хэрэгцээгээр дутагдах гачигдах юмгүй, эрх чөлөөтэй байх...” гэж тодорхойлоод “хүний аюулгүй байдлын долоон хэмжүүр”- ийг:

- 1.Хүний эрүүл мэндийн аюулгүй байдал/өвчнөөс ангид байх/,
- 2.Хүний эдийн засгийн аюулгүй байдал /Ядуурлаас ангид байх/,
- 3.Хүний хүнсний аюулгүй байдал /Өлсгөлөнгөөс ангид байх/,
- 4.Хүнийг хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал /Цэвэр ус агаараар дутагдахгүй байх/,
- 5.Хүний хувийн аюулгүй байдал /Гэмт хэрэг, мансууруулах бодис, хүчирхийллээс ангид байх/,
- 6.Олон нийтийн аюулгүй байдал/ Гэр бүлийн, гарал язгуурын бүлгийн амьдралд оролцох эрх/,
- 7.Хүний улс төрийн аюулгүй байдал /Хүн үндсэн эрхүүдээ эдлэх эрх чөлөө/ гэж тодорхойлсон нь Монгол Улсад хүний аюулгүй байдлыг хангах чухал үндэслэл болох учиртай. Ардчилал түгж, зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшихийн хэрээр төрөөс Монгол Улсын иргэний өмчлөх эрх, өмчийн халдашгүй байдлыг баталгаажуулах, хамгаалах зорилт хэзээ хэзээнээс

илүү чухал болохыг үзэл баримтлалд тодорхой тусгах ёстой. Төрийн хүн ам зүй, хүний аюулгүй байдлыг хангах бодлого үйл ажиллагааны хамгийн чухал зорилтод хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах бодлого, үйл ажиллагаа байх нь тодорхой биз ээ. Дэлхийн хоёр их үндэстний хооронд оршин буй монгол туургатан бид тун цөөхүүл билээ. Тал нутгийн эрэлхэг дайчин, эрх дурыг /чөлөөг/ эрхэмлэгч, нүүдэлчин удмын сониуч, гэнэн цайлган гэмээр монгол хүн /Ц.Дамдинсүрэн, Гумилёв.Л.Н/-д бас сайны хажуугаар саар гэгчээр цагийн болон үйлдвэрлэл технологийн сахилга горимд дургүй, залхуу, омгорхог, сониуч зэрэг базаахгүй зан чанар ч чамгүйг Майский.И г.м гадаад дотоодын судлаачид тэмдэглэсэн нь цөөнгүй бөгөөд эдгээр сайн, саар талууд нь монгол хүн даяаршлын нөлөөнд хамгаас түрүүн өртөх шалтаг, шалтгаан болж буй гэх үндэстэй юм. Хүн амын хэт төвлөрөл, хотжилт, хүрээлэн буй орчны /байгаль орчны/ бохирдол, амьдралын зорилго, хэв маягийн, үнэт зүйлсийн чиг баримжааны хувьсал өөрчлөлт, мөн Монгол руу болон Монголоос гадагш чиглэсэн хүн, ажиллах хүчний урсгал, хүмүүнлэгийн харилцааны өргөжилт, даяаршихуйн нөлөөлөл, нийгмийн зарим таагүй үзэгдэл, тухайлбал: биеэ үнэлэх, архидан согтуурах, мансуурах бодист донтох /статистик мэдээ сэлтээр бол монгол хүн хар тамхи зэргийг хэрэглэгч

төдийгүй тээгч бас үйлдвэрлэгч болох аюул бодитой нүүрлэж буй ажээ/ зэрэг нь хүн амын дунд цус ойртолт, эрлийзжилт, эрүүл мэндийн хавтгайрсан доройтол, улмаар удмын сангийн аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэлийг дагуулж байна /статистик мэдээ сэлтээр бол монгол хүн хар тамхи зэргийг хэрэглэгч төдийгүй тээгч бас үйлдвэрлэгч болох аюул бодитой нүүрлэж буй ажээ. Үүний зэрэгцээ **Монгол Улсад одоогоор хүний аюулгүй байдлыг хангах тогтолцоо төлөвшөөгүй** байна гэхэд хэтрүүлэг болохооргүй төвшинд байна. **Ийм цаг үед чухамдаа хүний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын үндсийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын гол агуулга зорилт нь болох учиртай** гэж үзэж байна.

ГУРАВ.

Монгол Улсын нийгмийн аюулгүй байдлыг “Монгол Улсын нийгэм, эдийн засаг, экологийн тогтвортой хөгжил, тэнцвэрт байдал, үндэсний эв нэгдэл хадгалагдсан, хамгаалагдсан байдал” гэж томьёолох.

Монгол Улс, монголын ард түмэн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмчид суурилсан зах зээлийн эдийн засаг зэрэг хүн төрөлхтний хөгжлийн үнэт зүйлсийг эргэлт буцалтгүй сонгож хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулах эрхэм зорилгыг тунхагласан ардчилсан

Үндсэн хуулиа батлаад 30 гаруй жил өнгөрчээ. Энэ түүхэн ахархан хугацаанд нийгмийн шинэтгэл объектив /давагдашгүй, хүнээс үл хамаарах болон субъектив/ хүнээс өөрөөс нь, хүний хүчин зүйлээс хамааралтай/ хүчин зүйлийн дор хүндрэл бэрхшээл алдаа, оноог дагуулан удаашралтай ч урагшилсаар байна. Энэ бол монголын ард түмний олонхын бодол, хандлага гэж үзэж байна.

Төрийн удирдлагын баримт бичгүүд, эрдэмтэн судлаачид, улс төрчдийн үнэлгээ дүгнэлтээс үзэхэд монголын нийгмийн шинэтгэлийн гол үр дүнд:

- Ардчилал, үндсэн хуульт ёс, бүгд найрамдах засаглалд суурилсан ардчилсан төрийн тогтолцоо төлөвшин төрийн эрх мэдлийн хуваарилалт хэрэгжин, иргэний нийгэм төлөвшин байна,

- Монгол Улсын иргэн өмчтэй болж түүнд суурилсан зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшин байна,

- Монгол улсын иргэний эрх, эрх чөлөөний улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн баталгааны үндэс, суурь бүрдэж байгаа

- Монгол Улсын олон улсын тавцан дахь байр суурь, нэр хүнд бэхжин байгаа зэргийг хэлж болно гэж үзэж байна. Эдүгээ төр улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахад эдийн засгийн хүчин зүйл шийдвэрлэх ач холбогдолтой юм. Иймд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төр, нийгмийн

ардчилсан тогтолцоог хөгжүүлэх бодлого, зорилтын зэрэгцээ улс орны эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг бэхжүүлэх, үүний тулд уул уурхай, байгалийн баялгийн олборлолт, боловсруулалт, эрчим хүч дэд бүтцийг хөгжүүлэн түлш, эрчим хүчний хараат бус байдлыг хангах, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, нийгмийн үйлчилгээ зэрэг эдийн засгийн үндсэн салбаруудын зохист харьцааг бүрдүүлэх, **хүн амыг хүнсний чанартай бүтээгдэхүүнээр баталгаатай хангах чадавхыг бүрдүүлэх**, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, **экспортын бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс бүх талаар дэмжин хөгжүүлэх**, гадаад зах зээлээ өргөтгөх, бэхжүүлэх бодлого зорилт шингэсэн байх учиртай гэж үзэж байна. Товчоор илэрхийлэхэд улс орныхоо олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурь нэр хүндийг бэхжүүлэх, ялангуяа олон улсын зах зээлд эзлэх орон зайгаа өрсөлдөн хамгаалах үндэсний чадавхаа бүрдүүлэх, бэхжүүлэх, хамгаас чухал **нь эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлаа хангах нь үндэсний аюулгүй байдлаа хангах гол арга зам** гэж үзэж байна.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн алхам бүрийг экологийн тэнцвэрт байдлыг хангах, онгон дагшин байгаль эхээ хайрлан хамгаалах, орчны нөхөн сэргээлтийн үр нөлөө бүхий бодлого үйл

ажиллагаа салшгүй дагалдах, уул уурхайн “хаалтын менежмент”-ийг тууштай хэрэгжүүлэх учиртай гэж үзэж байна. Байгаль эхээ “амилуулан” хайрлаж хамгаалах, халдах, хандах ёс жудаг, хорио цээрийг тогтоож чандлан мөрддөг монгол аж төрөх хосгүй арга ухаан, соёлыг үр хойчдоо өвлүүлэх, хууль тогтоомжоо тэгшитгэх үзэл санаа ҮАБҮБ-д шингэсэн байх учиртай. **Нийгмийн аюулгүй байдал хэсэгт** эрүүл мэнд, боловсролын тогтвортой хөгжлийг хангаж иргэндээ, ялангуяа залуу үедээ эх орондоо чанартай боловсрол эзэмших, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авч хүсэл зорилгоороо эзэмшсэн мэргэжлээрээ өөрөө өөрийгөө илэрхийлж сэтгэл хангалуун аж төрөх нөхцөл бүрдүүлэх, нийгмийн хэсэг бүлгүүд, угсаатан ястны ашиг сонирхлын зохицол /гармони/-ыг хангах, хүн амын дундаж давхаргыг бэхжүүлэх, ажилгүйдэл, ядууралтай тууштай тэмцэх, хууль боловсруулах, баталгаажуулах шүүлтүүрийг эрс сайжруулах, гэмт хэрэг халдлага, хүчирхийллээс хамгаалах бодлогыг үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдлыг хангах бодлого зорилттой уялдуулан тодорхойлох зэрэг нь чухал байр суурь эзлэх ёстойг онцолж байна.

ДӨРӨВ

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг ханган, ажлын байрыг нэмэгдүүлэх, гамшиг, өвчин тахал

нүүрлэсэн үед ажлын байрыг хадгалах хамгаалах замаар **ажилгүйдэл, ядууралтай тэмцэх нь** төрийн нийгэм-эдийн засгийн бодлогын нэг гол зорилт, улс орны аюулгүй байдлыг хангах чухал нөхцөл нь юм. Энэ цаг үед иргэдийн чанартай амьдралын баталгааг бүрдүүлж эдийн засгийн эрх, эрх чөлөөг нь, юуны өмнө өмчлөх эрх, өмчийнх нь халдашгүй байдлыг хангах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх замаар амьжиргааны найдвартай эх үүсвэртэй болгоход чиглэсэн нийгмийн хамгааллын ухаалаг бодлого хэрэгжүүлэх, хүн амын дундаж орлоготой иргэдийг дэмжих нь нийгмийн тогтвортой байдал, хөгжлийг хангах, аюулгүй байдлыг хангах нэг гол арга зам мөн.

Нийгмийн шинэчлэлийн үр нөлөөгөөр ардчилал, олон ургалч үзэл түгж, нийгэмд шинэ бүтэц, давхаргажилт бий болж иргэдийн амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн баримжаа өөрчлөгдөн, нийгэмд хэсэг бүлгүүдийн эд хөрөнгө /баян, ядуугийн/, эзлэх байр ялгаа зөрүү, ашиг сонирхлын зөрчил бодитой болж лавширч байгаа нь нийгмийн амьдралын өнөөгийн хэв маяг, онцлог шинж нь болж байна. Нийгмийн ухамсар сэтгэлгээнд гарч буй өөрчлөлтүүд: нийгмийн ухамсар сэтгэлгээнд амиа хичээх /эгоист/ үзэл давамгайлах болж “эзэн хичээвэл заяа хичээх” философи, эд хөрөнгө, мөнгөний сэтгэлгээ түгж байгаа; олон ургалч үзэл бодол, ертөнцийг үзэхүй,

олон шашин дэлгэрч байгаа зэргийг хэлж болно.Тухайлбал 2020 оны байдлаар Монгол Улсад бүрэн бус тооцоо, судалгаагаар 410 гаруй сүм хийд үйл ажиллагаа явуулж тэдгээрт 1740 гаруй санваартан хуврагуудтай байгаа тоо байна. Тэдгээрийн 222 нь христийн /320 гаруй ламтай/, бурхан шашны 150 хийд /1380 гаруй/, загалмайтны 27 сүм /30 гаруй/ мөн бусад төрлийн 10 гаруй сүм хийд байна. Тэдгээрийн тоонд зарим улс оронд хориглож хаасан шашны төрөл зүйлийн байгууллага ч байх магадлалтай ажээ. Бие биедээ дайсагнагч олон шашин түгсэн улс орныг “Торхтой дарин дээр сандайлагч”-тай зүйрлэсэн нь байдаг.

Монгол Улс дэлхийд бас улс төрийн намуудын тоогоор “толгой цохиж” буй улс. Бүр иргэний нийгэм, гэр бүлд хүртэл нэвчин иргэн аль нэгэн нам, эсхүл аль нэг эрх мэдэлт бүлгийн “асрал ивээлгүй” бол өөрөө өөрийнхөөрөө байж чадахгүйд хүртэл нөлөөлж буй улс төржсөн талцал үндэсний эв нэгдэлд хор хүргэх нигууртай зүйл. Нэг үгээр илэрхийлэхэд эх оронч үндэсний үзэл хүмүүжил, эе эвийн үзэл санаа, үндэсний ой санамж зэрэг нийт нийгэм, үндэстэн улс орны нийтлэг ашиг сонирхол нэгэн санаа зорилгод нэгтгэх, нягтруулах оюун санааны хүчин зүйлүүд бөгөөд зах зээлийн эдийн засгийн харилцаа, чөлөөт өрсөлдөөний нөхцөлд үндэсний эв нэгдлийн оюуны дархлаа нь болж нийгмийн ухамсар дахь нэгдэх,

нийлэхийн эсрэг “төвөөс зугтах” хүчийг саармагжуулах учиртай. Энэ бол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын гол зорилтын нэгэн хэвээр байх ёстой гэж үзэж байна. Бас нэгэн зүйлийг онцлоход угсаатан ястны нийтлэг болон онцгой /онцлог/ эрх ашгийг оновчтой тунгаасан, угсаатны цөөнхийн хэл, соёлыг хамгаалах, хөгжүүлэх зорилгод нийцсэн хүн ам зүйн ухаалаг бодлого зохицуулалт төрийн эдийн засаг / бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт г.м/, боловсрол, эрүүл мэнд соёлын бодлогын ёстой л нэг салшгүй / атрибут / зорилго байх учиртай. Ийм учраас **үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх нь төрийн бодлогын нэн чухал зорилт бөгөөд түүний үндсэн чиглэлд:**

1.Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлын зүйлүүд, эрхэмлэх нийтлэг үнэт зүйлүүдээ, үндэсний бахархалт зүйлүүдээ оновчтой тодорхойлох үндсэн дээр, үндэсний эв нэгдлийн оюуны үндсийг бэхжүүлэх, нийт иргэнээ соён гэгээрүүлж эх оронч үндэсний үзэл бахархлаа хөгжүүлэх.

2.Нийгмийн баялгийн хуваарилалтын шударга ёсыг тогтоох, хүн амын дундаж давхаргыг бэхжүүлэх,

3.Төр, нийгмийн удирдлагын бүх салбар, шатанд иргэдээ угсаа гарвал, яс үндэс, нас хүйс, хөрөнгө чинээ, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нийгэмд талцал, зөрчилд хүргэж буй улс төржилт, явцуурхан бүлгэрхэх,

онцгойрох, нутгархах аливаа оролдлого явууллагатай тууштай тэмцэх тогтолцоо, механизм/ арга, хэрэгсэл/-ыг төлөвшүүлэх,

4. Угсаатан ястны эрхийн тэгш байдлыг бодитой хангах,

Түүнчлэн монгол хэлнээ нэлээд өргөн хэрэглээ бүхий улс төр, эрх зүйн зарим ойлголтын томъёолол, тухайлбал үндэсний, үндэстний, үндэстэн, угсаатан ястны, үндэстний олонх, цөөнх г.м ойлголтуудын томъёоллыг нэг мөр болгон цэгцлэх ч шаардлага байна..

ТАВ

Монгол Улсын төрийн аюулгүй байдлыг “Монгол Улсын ардчилсан төрийн байгуулал, төрийн бүрэн эрхт байдал дотоод, гадаадын аливаа халдлага, аюулаас хамгаалагдсан байдал” гэсэн утгаар томъёолох.

Монгол Улсад бүгд найрамдах засаглал, ардчилсан төрийн байгууллыг бэхжүүлж аюулгүй байдлыг нь хангах үндсэн чиглэл:

1. Үндсэн хуульт ёс, бүгд найрамдах засаглал, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тууштай хэрэгжүүлэх, төрийн эрх мэдлийн салаа мөчир хоорондын болон төрийн төв, нутгийн удирдлагын байгууллагуудын харилцаа, уялдаа холбооны тогтолцоо арга хэрэгсэл, хэлбэрийг боловсронгуй болгож төр, нийгмийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах
2. Төрийн албанд мэдлэг, боловсрол, ур чадварт суурилсан

удирдлагын тогтолцоо /мерит тогтолцоо/-г хэвшүүлэх

3. Шүүх, шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг бодитой хангаж шударга шүүхийг төлөвшүүлэх
4. Төрийн байгууллагад тавих иргэний нийгмийн хяналт, оролцооны тогтолцоо, арга хэрэгсэл, хэлбэрийг боловсронгуй болгох
5. Иргэдийн /сонгогчдын/ шууд, тэгш, нууцаар саналаа өгч шударгаар сонгох, сонгогдох эрхийг бодитой хангах
6. Монгол Улсын төрийн бодлого, үйл ажиллагааны үнэт зүйлсийг төрийн удирдлагын бүх түвшин, төрийн албан хаагч бүрийн үйл ажиллагаанд хэлбэрэлтгүй сахих зэрэг болно.

Нийгэмд шударга ёс тогтоохын тулд:

- Монгол хүн, улсын иргэн хууль, шүүхийн өмнө үндэс угсаа, гарал үүсэл, нас хүйс эрдэм боловсрол, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь зэргээс үл хамааран тэгш байх зарчмыг тууштай баримтлах;
- Аливаа бодлого, шийдвэрт улс үндэстнийхээ нийтлэг ашиг сонирхол, үнэт зүйлсийг эрхэмлэх;
- Нийгмийн баялгийн хуваарилалтын шударга ёсыг тогтоох;
- Авлига, нутгархах, танил тал харах, улс төржих ашиг сонирхлоороо талцан явцуурхан бүлгэрхэх, онцгойрох гэсэн аливаа илрэлтэй тууштай тэмцэх;

- Төрийн хууль, тогтоомжийг дээр доргүй нэг мөр даган биелүүлэх, нийгэмд хууль дээдлэх зарчмыг тууштай хэвшүүлэн тогтоох ,
- Бодлого, үйл ажиллагааны алсын хараатай байх,
- Эе эвийн сэтгэлгээг эрхэмлэх
- Туршлага сургамж, түүх, өв уламжлал, шинэчлэлийн нэгдлийг сахих
- Эрх, үүрэг, хариуцлагын нэгдлийг хангах

7. Төрийн хууль тогтоох үйл ажиллагааны бүх шатанд /боловсруулах, санаачлах, батлах, хэрэгжүүлэх / хэрэглэх/ г.м/-д олон нийтийн болон мэргэжлийн хяналт, “шүүлтүүр”-ийн тогтолцоог бүрдүүлэх,

8. Нийгэм төрийн удирдлагын бүх шат, нийт иргэнд хууль дээдлэн сахих ухамсар, сэтгэлгээ төлөвшүүлэх.

9. Төрийн удирдлагын мэдээлл-ийн системийн найдвартай, тасралтгүй байдлыг хангах, төрийн нууцлалыг хадгалах, хамгаалах, чандлан сахих, түүний төлөө хүлээх хариуцлагыг чангатгах зэрэг болно.

Төрийн аюулгүй байдлын бодлогын нэн чухал зорилтод иргэний улс төр, эрх зүйн мөн чанар /хүн нийгмийн аль нэг бүлэг давхаргад харьяалагдах, улс орны иргэн нь байж удирдлага, зохион байгуулалт, хууль цааз, төрийн эрх мэдэлд эрхшээгдэх, үзэл бодол, ертөнцийг үзэхүй, ашиг сонирхолтой байх г.м/ илрэх, хэрэгжих орчин нь болсон төр улсын аюулгүй байдал, хөгжлийн асуудал зүй ёсоор орно.

Зургаа

”ҮАБ-ын дотоод, гадаад орчин” гэсэн бие даасан бүлгийг боловсруулж **дотоод орчны асуудалд** улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрэх, нийгмийн бүлэг давхарга, үндэстэн, угсаатан, ястны ашиг сонирхлын зохицол /гармони/-ыг хангах бодлогыг тууштай хэрэгжүүлэхийн хамт аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, нийгмийн дэг журмыг сахиулах хүч хэрэгслийг бэхжүүлэх,иргэдээ гэмт хэрэг, халдлага хүчирхийллээс хамгаалах тогтолцоог бэхжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, **гадаад орчны асуудалд** Монгол Улсын олон улсын нэр хүнд байр суурийг бэхжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн зорилго чиглэлийг тодорхойлох, тухайлбал: энхийг эрхэмлэгч гадаад бодлогоо тууштай баримтлах, хоёр хөрштэйгөө харилцах, гуравдах хөршийн бодлогоо баримтлах, НҮБ болон олон улсын хамтын ажиллагааны тогтолцоо, механизмыг бэхжүүлэхэд идэвхтэй оролцох, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавх, боломж, оролцоогоо нэмэгдүүлэх зэрэг бодлого зорилтоо тодорхойлж томьёолох.

Товчоор хэлэхэд улс, **үндэстний аюулгүй байдлын дотоод орчин нь нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, гадаад орчин нь улс түмний энх амгалан байдал** гэдгийг иш үндэс болгох ёстой гэж үзэж байна.

ҮНДСЭН ХУУЛЫТ ЁСЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ҮҮРЭГ



Хууль зүйн доктор (PhD), Дэд
профессор, гавьяат хуульч
В.УДВАЛ

Түлхүүр үг: Үндсэн хуульт ёс, Үндсэн хуулийн үнэт зүйлс, Үндсэн хуулийн баталгаа, Үндсэн хуулийн цэц, төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдэл.

Хураангуй: Үндсэн хуульт ёс ба эрх зүйт төр, хууль дээдлэх үзэл санаа, зарчим, үнэт зүйлсийн онолын үндэслэлийг эртний сэтгэгчдээс анхны бичмэл Үндсэн хууль баталсан үе болон түүнээс хойших үе, орчин үеийн үзэл баримтлал, үнэт зүйлс, зарчмыг үечлэн судалж үзэхэд нийгмийн доторх аливаа үйл ажиллагаа, тогтоосон хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг үнэлэх шалгуур, түүний хэрэгжилт Үндсэн хуулийн шүүх /Үндсэн хуулийн цэц/-ийн төлөвшилтэй салшгүй холбоотой байна. Үндсэн хуулийн эрх зүйн зарчмууд нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн үзэл санааны

чухал шалгуур бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг хангах асуудал тулгамдаж байгааг Үндсэн хуулийн цэцийн өнгөрсөн 30 гаруй жилийн практик харуулж байна.

Үндсэн хуульт ёсны үндсэн зарчим болох төрийн эрх мэдлийг хязгаарлах, эрх зүйн хэм хэмжээгээр нийгмийн харилцааг зохицуулах, хууль дээдлэх, шударга ёсны үр дүн нь тэгш байдлыг бий болгох, шударга шүүхийн хяналт, төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг зогсоох зэрэг үзэл санаа, зарчмууд нийгмийн амьдралд хэрхэн төлөвшиж байгааг тодорхойлох нь чухал юм.

Мөн хүний үндсэн эрхийг баталгаажуулахын тулд төрийн эрх мэдлийг хуваарилж, харилцан хяналт тавих механизмыг бүрдүүлэн хэрэгжилтийг шүүхийн журмаар Үндсэн хуулийн цэц хянах нь төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг зогсоох онцгой үүргийг бий болгож байгаа билээ. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг таслан зогсоох үүрэгтэй Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг гаргаж, шийдлийг судалгааны үр дүнд тулгуурлан дэвшүүлж байгаа болно.

Агуулга:

- × Удиртгал
- × Үндсэн хуульт ёсны онол, хөгжлийн хандлага
- × Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн үүрэг
- × Үндсэн хуулийн цэцээс төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг зогсооход тулгамдаж буй асуудал, шийдэл
- × Дүгнэлт
- × Ном зүй

Удиртгал

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хууль хэрэгжиж эхэлснээс хойших өнгөрсөн хугацаанд үндсэн хуулийг хамгаалах, үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэхэд үндсэн хуульт ёсны үзэл санаа, онолын үндэслэл олон сорилт бэрхшээлтэй тулсаар байна.

Аль хэдий нь өнгө төрхөө олчих байсан иргэний нийгэм, бодит ардчиллын ойлголт Үндсэн хуулиар тодорхойлсон үнэт зүйл, үзэл баримтлал, чиг баримжаанаас алсран холдсоор байгаа энэ үед үндсэн хуульт ёсны онол, хөгжлийн хандлагыг судалгааны төвд оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд эрх мэдлийн төвлөрлийг хязгаарлах, төрийн үйл хэрэгт оролцох хувь хүний эрхийг хангах, хууль дээдлэх зарчмыг сахиулах үүрэгтэй Монгол Улсын үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг шүүхийн журмаар хамгаалах,

үндсэн хуулийн баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн онцолж болох юм. Гэвч Үндсэн хуулийн цэц эрх зүйн хүрээний асуудлыг шийдвэрлэх явцдаа улс төрийн нөлөөллийг мэдэрсээр ирсэн бөгөөд энэ нь Цэцийн гаргаж буй шийдвэр болох дүгнэлт, тогтоол, тэдгээрийн үндэслэл, гишүүдийн байр суурь зэрэгт тусгалаа олсон байдаг.

Цэцийн хянаж буй хууль эрх зүйн актуудын улс төрийн шинж агуулгаар уг нөлөөллийг тайлбарлаж болох ч эдгээр хэм хэмжээ нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг үнэлэх шалгуур хамгийн чухал үүрэгтэй байна. Үүнтэй холбоотойгоор үндсэн хуульт ёсны зарчмууд нь чухал шалгуур мөн бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг хангах асуудал тулгамдсан асуудал болж байгааг Үндсэн хуулийн цэцийн практик үйл ажиллагаанаас харж болно.

Дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарц нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг шинэчлэх, үйл ажиллагааных нь эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, гаргаж буй шийдвэрийн үндэслэлийг сайжруулах, үндсэн хуульт ёс хэлбэрэлтгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх, Цэц шийдвэрээрээ Үндсэн хуулийг тайлбарлах, Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангуулах эрх хэмжээг өргөтгөх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг хийх хэрэгцээ шаардлага ч бий болж байна.

Манай улсын эрдэмтэн судлаачдын туурвисан Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа, шинжилгээний бүтээлүүдийг судалж үзвэл Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэц ямар үүрэгтэй болох талаас нь бичиж тэмдэглэсэн бүтээл ховор байна. Энэ чиглэлээр академич Ж.Амарсанаа, хууль зүйн шинжлэх ухааны доктор Ч.Энхбаатар, хууль зүйн доктор Ч.Өнөрбаяр нарын судалгааны өгүүллэг, нэг сэдэвт бүтээл гарсан байгаа билээ. Харин Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэц ямар үүрэгтэй болох асуудал доктор, профессор. Б.Чимид, доктор, профессор. Г.Совд нарын бүтээлд агуулгаараа суусан байдаг.

Үндсэн хуульт ёсны онол, хөгжлийн хандлага

Орчин үед төрийн ардчилсан тогтолцоотой орнуудад үндсэн хуульт ёсны үзэл санаа дэлхий нийтийн нийтлэг жишгээр боловсронгуй болон хөгжиж байна.

Үндсэн хуульт ёсны үзэл санаа олон шинжлэх ухааны уулзвар дээр хөгжиж байгаа ч Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны онолын үүднээс задлан шинжилж, түүний үндсэн шинж, зарчмуудыг шинээр тодорхойлсоор байна. Эртний Эллада болон Римийн “ардчилал”-ын тухай үзэл санааны дотор үндсэн хуульт ёсны үзэл санаа бүрэлдэн бий болсон гэж тэмдэглэсэн байдаг.²⁶

²⁶ *Московский государственный институт международных отношений (Университет) МИД России. Конституционное право*

Түүнчлэн хувь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид дээд эрх ашиг, үнэт зүйлд захирагдах, иргэн төрийн харилцаа тодорхой зарчимд суурилах зэрэг үзэл санаа үндсэн хуульт ёсны үзэл санаанд мөн багтаж байжээ. Их Британий Магна Харти, Хабеас корпус акт (Habeas Corpus Act), XVIII зууны Францын хувьсгалын үзэл санаа, 1776 онд батлагдсан Эрхийн Тунхаглал, 1789 оны Иргэний болон хүний эрхийн Тунхаглал зэрэг баримт бичгүүд нь үндсэн хуульт ёсны үзэл санаа үнэт зүйл, зарчмуудыг агуулж байсан гэж үздэг. Эдгээр баримт бичгүүдэд нийтийн засаглал нь хүний эрхийг хүндэтгэн төрийн үйл ажиллагаанд болон нийгэмд хувь хүний гүйцэтгэх үүрэг ролийг хамгаалан баталгаажуулж, засаглалыг хэрэгжүүлэгч байгууллага гаргаж байгаа шийдвэрээ хувь хүн, улс нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэх, засаглалын эрх мэдлийг хязгаарлах, хууль дээдлэх (rule of law) буюу тогтсон үзэл санаа, хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулах зарчмыг тунхагласан байна. 1776 оны Америкийн Виржиний эрхийн Тунхагт эрх зүйн хэм хэмжээний хүрээнд засгийн эрх мэдэл зөвхөн ард түмнээс эхтэй гэдгийг баталгаажуулсан байна. Өөрөөр хэлбэл, тухайн төр, засгийн оршин байх үндэс нь хүмүүст, иргэддээ үйлчилж, тэдний ашиг

сонирхлыг хамгаалахад оршино гэж үзжээ.

Дээрх түүхэн баримт бичгүүдээс гадна эртний Грек, Ромын гүн ухаантнууд, сэтгэгчдийн бүтээл туурвилд улс нийгмийн ашиг сонирхол, нийтийн эрх ашигт нийцсэн төрийн харилцаа юу байх талаар олон олон үзэл санааг боловсруулан нийтийн хүртээл болгож байжээ. Тухайлбал, Францын алдарт философич, соён гэгээрлийн хөдөлгөөний төлөөлөгч, түүхч, социологич, хуульч зохиолч Барон де Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлдээ эртний Грек-Ромын үеэс XVIII зуун хүртэлх улс төр, нийгэм, эрх зүйн түүхэн хөгжлийг судалж, метафизик, этнологи, соёлын антропологиогийг хүртэл тусгасан байна. Тэрээр “Хэрэв хууль тогтоох эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгдвэл эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд хууль тогтоогчид дарангуйлагч хуулийг тогтоож, дарангуйлал үүснэ. Харин шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд мөн л эрх чөлөө үл оршино”²⁷ гэжээ.

Үндсэн хуульт ёсны үзэл санаа, зарчим, үнэт зүйлс нь дэлхийн бараг бүх орны Үндсэн хуульд сууж, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай байлгахын тулд төрийн эрх мэдлийг задлан тодорхой чиг үүргээр дамжиж хэрэгжих эрх мэдлүүдэд

²⁷ Барон де Монтескье. Хуулийн амин сүнс. МОНСУДАР нийгмийн ухаан №5. 2009. 14 дэх тал.

хуваарилан, нэг эрх мэдлийг нөгөө эрх мэдлээр хянуулж, төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрт, нэгдмэл байдлыг бий болгох зарчим болон хөгжсөөр байна. Хэн уг зарчмыг зөрчиж алдаа гаргана тэнд дарангуйлал буцаж сэргэх зүй тогтол байгааг дэлхийн улсуудын төрийн түүх батлан харуулж байна.

Үндсэн хуульт ёс гэдэг нь үндсэн хуулийн гадна орших үнэт зүйлсийг хамгаалдаг үндсэн хуультай байхыг хэлнэ²⁸ гэж Кембрижийн их сургуулийн эрдэмтэн Марлин Вайнд тодорхойлжээ. Хүн төрөлхтөн Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хууль ёсны байх зарчим, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаа, үнэт зүйлийг үндсэн хуулиараа хамгаалах ёсыг өнө эртнээс боловсруулж мөрдсөөр иржээ. Энэхүү “үндсэн хуульт ёс” хэмээх ойлголт нь үндсэн хуулиар урьдчилан тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, нийгмийн харилцааг зохицуулж байгаа үндсэн хуулийн зүйл заалт гэхээс илүү нийтээр дагаж мөрдөхөөр тогтсон үзэл санаа, үнэт зүйлсийг дагах ёс гэж үздэг байна.

“Орчин үед **Үндсэн хуульт ёс** гэдэгт: хууль (эрх зүй) бол эцсийн бөгөөд дээд хүчинтэй, төр засгийн эрх мэдэл ард түмнээс эхтэй, засгийн үйл ажиллагаа нь хуулиар хязгаарлагдсан, хууль нь хүний эрхэд

²⁸ Marlene Wind, *European Constitutionalism Beyond the State* (Cambridge University Press, 2003), P.1-3.

үндэслэгдсэн байхыг ойлгодог”²⁹ хэмээн Ч.Өнөрбаяр өөрийн бүтээлдээ дурджээ.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн үндсэн сэдэвтэй холбоотойгоор **“Үндсэн хуульт ёс гэдэг нь эрх зүйн онол, зарчимд суурилж, Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсийн баталгаа болох Үндсэн хуулийн шүүх (цэц) төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг хязгаарлах үзэл санаа, зохицуулалт юм”** хэмээн тодорхойлж болно. Учир нь улс төрийн институциуд өөр хоорондоо зөрчилдөж, учраа олохоо больсноос улс төрийн гүн хямрал үүсэх, энэ нь нийгэмд нөлөөлж гудамжинд гарах аюул занал нүүрлэх тохиолдолд энэхүү сөргөлдөөнийг эрх зүйн маргааны хүрээнд Үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэж, нийгэмд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг.³⁰

Нөгөөтээгүүр ямар ч сайн боловсруулсан Үндсэн хууль сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлж чадахгүй³¹ хэмээн үздэг. Энэ бүхнээс харвал, зөрчил маргааныг шийдвэрлэх үндсэн аргын нэг нь тухайн асуудлыг шүүхээр хэлэлцэж, шийдвэрлэх арга болно. Манай улсын хууль зүйн нэр томъёонд

“Үндсэн хуульт ёс” хэмээх нэр томъёог төлөвшүүлэхдээ: Үндсэн хуульт ёсны ойлголтод Үндсэн хуулийн үндсэн бүтцийн дархлаа, хамгаалалт хэмээх ойлголтуудыг багтаан, тэдгээр нь хүний жам ёсны эрхэд суурилсан байх учиртай гэдэг талаас нь авч үзэх нь чухал юм. Энэ нь Үндсэн хуульт ёсыг Үндсэн хуулиар тогтоосон зарчим, хүний эрхэд суурилсан хуулиар төрийн эрх мэдэл хязгаарлагдана гэсэн ерөнхий үзэл санаанд үндэслэж байгаа билээ.

Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн үүрэг

Өнөөдөр ардчилсан шударга сонгуулийн тогтолцоо, парламент дахь олонх, цөөнхийн харилцаа, улс төрийн намын төлөвшлийн асуудал зэрэг суурь үзэл онолын төлөвшлийн асуудлаас гадна үндсэн хуулийн хяналтын механизм, Үндсэн хуулийн шүүхийн асуудал онолын хувьд ч, арга зүйн хувьд ч анхаарал татсан хэвээр байна.

Тиймээс ч эрдэмтэд “Төрийн эрх, мэдлийг хуваарилахуй нь төрийн засаглалын институуд харилцан бие биеэсээ үл хамаарч, бие биеэ хянан барьж байхын зэрэгцээ харилцан тэнцвэртэй байхад оршино”³² хэмээн үзэж байна.

Дэлхийн улсууд төрийн эрх мэдлийн хуваарилалтын сорилтыг өөр өөрийн онцлогт тохирсон үзэл баримтлал, үнэт зүйлээр баяжуулан

²⁹ Ч.Өнөрбаяр. Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага (Түүх, Улс төр, Эрх зүй). УБ., 2021. 23 дахь тал

³⁰ Адомэйт, Хэньшэн. Эрх зүйн онол. УБ., 2017. 96 дахь тал.

³¹ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн шүүх ба улс төр. Хууль дээдлэх ёс. УБ., 2012. №4. 41 дэх тал

³² Д.Лүндээцанцан. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014. 9 дэх тал.

хөгжүүлж, саад бэрхшээлийг даван туулсаар байна. Тэдгээрийн нэг нь ардчиллын тухай ойлголт мэдлэг юм.

Ардчиллын тухай онол сургаал олон хүнд, бэрхшээлтэй асуудлыг дагуулдаг болохыг Францын сэтгэгч А.Токвиль өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

Тэрээр “Америк дахь ардчилал” номдоо “урлагийн эрх чөлөө гайхамшгийг бүтээх боломжтой, гэвч эрх чөлөөтэй амьдралд суралцах нь энэ гайхамшгийг бүтээхээс хүнд”³³ хэмээн тэмдэглэсэн байна. Энэ хүндрэл өнөөдөр манай оронд эдийн засгийн уналт сэргэлт, инфляцын өсөлт, үнийн хөөргөдөл, ядуурал зэрэг тулгамдсан асуудлыг төрүүлж, ардчилал хүнд сорилтыг дагуулсаар байна. Тухайн ойлголтууд эсрэг тэсрэг боловч ардчилал ядууралтай зэрэгцэн оршсоор байна.

А.Токвиль “Ядуу хүн эрх чөлөөтэй байж чадахгүйтэй адил, ядуу улс орон ардчилсан байх боломжгүй”³⁴ гэсэн нь улам бүр тод харагдах боллоо. Бүх нийтийг хамарсан ядуу зүдүү байдал дарангуйлал уруу халтирах аюултай болохыг тухайн үедээ А.Токвил сургаж байжээ.

Монгол Улсад нийгмийн ардчилсан тогтолцоо, эдийн засгийн олон хэвшил бүхий улсад байж болох бүхий л институци бий болж, төрийн эрх мэдлийг хуваарилан, хуулиар тэдгээрийн харилцан тэнцлийг хангах, эрх мэдлийг

хэрэгжүүлэгчид нэг нь нөгөөгөөсөө үл хамааран бие даасан байдалтай үйл ажиллагаа явуулж байгаа боловч батлагдсан хуулийг мөрдүүлэх, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, гэм буруутай этгээдийг цээрлүүлэх, улсын хөгжлийг дэмжих харилцан хамааралтай, иж бүрэн тогтолцоо хараахан бүрэлдэж чадаагүй байна. Эрх зүйн ухамсрын доголдлоос шалтгаалан төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд харилцан хяналттай байж эрх мэдлийн тэнцвэрийг хангах соёл ч төлөвшин тогтохгүй, төрийн эрх мэдэл хязгаартай хүрээнд хэрэгжих ёстойг хүлээн зөвшөөрөх хандлага ч одоохондоо алга байна.

Монголын нийгэмд тохиолдож байгаа эдгээр сорилт бэрхшээлийн нөгөө талд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч институциуд хэрхэн төлөвшиж, Үндсэн хууль түүний баталгаа болж чадаж буй эсэх нь асуудал дагуулсаар байна. Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа “...төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын Үндсэн санааг **хязгаарлах** гэсэн агуулгаар үзэж болно. Учир нь төрийн эрх мэдлийг төрийн аль нэг байгууллага дээр төвлөрүүлэхийг хязгаарлах, эрх мэдлийг хяналтгүйгээр хэтрүүлэн ашиглахаас сэргийлэх утга үүнд агуулагдаж байна...”³⁵ гэж дүгнэсэн байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм.

³³ А.Токвиль. *Демократия в Америке*. М., Прогресс, 1992. С. 189.

³⁴ Мөн тэнд

³⁵ Ц.Сарантуяа. *Төрийн эрх мэдэл хуваарилах зарчим. Үндсэн хуулийн хяналт.* // “Монголын төр эрх зүй”. 1995. №2. 16-17 дахь тал.

Үүнээс улбаалан шүүх эрх мэдлийн байгууллагын бие даасан байдал нь “үндсэн хуульт ёс” болон “хууль дээдлэх ёс” оршихуйн баталгаа болж байгаа эсэх асуудалд судлаач анхаарлаа хандуулж байгаа болно.

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийн цоо шинэ зохицуулалтын нэг нь яах аргагүй Үндсэн хуулийн цэц буюу Үндсэн хуулийн шүүхийг бий болгож эрх зүйн үндсийг хуульчилсан явдал юм. Энэ нь хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтын нэгээхэн хэсгийг бид өөрийн орны өвөрмөц онцлогт тохируулан хэрэглэж, энэ асуудлаарх дэлхийн хөгжлийн үндсэн зарчмыг хүлээн зөвшөөрч, төрт ёсны уламжлалдаа шинэ хуудас нээсэн түүхэн ач холбогдолтой үйл явц, шинжлэх ухааны цогц шийдэл болсон юм.

Аливаа улсын Үндсэн хуулиар тогтоосон үнэт зүйл, үзэл баримтлал, зарчим зохицуулалтыг хэрхэн яаж хамгаалж, Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах баталгаа нь юу болохыг, хүн төрөлхтөн судлан боловсруулж, шинжлэх ухааны суурь зарчмыг бүтээсэн байдаг билээ. Хэдийгээр дэлхий ертөнцөд оршин тогтнож байгаа улсууд улс төрийн тэмцлийн хүнд хүчирт нэрвэгдсээр байгаа ч шинжлэх ухаанаар бүтээгдсэн зарчмыг хүлээн зөвшөөрдөг болсон.

Шүүх эрх мэдлийн хүрээнд үндсэн хуулийн маргааныг шүүж шийдвэрлэх боломжийг 1992 оны Үндсэн хуулийн

Тавдугаар бүлэгт нээж, үндсэн хуулийн зөрчлийг шүүхийн журмаар шийдэх эрхийг Үндсэн хуулийн цэцэд олгосон. Эндээс Үндсэн хуулийн цэц төрийн байгуулалд онцгой үүрэгтэй болохыг харж болно.

Тухайлбал, Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” хэмээн тодорхойлсон.

Үндсэн хуулийн цэц нь үндсэн хуулийн хяналтыг Европ загвараар хэрэгжүүлдэг бөгөөд хэд хэдэн онцгой шинжийг агуулсан байдаг. Тухайлбал,

1. Инститuciones хувьд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч ердийн шүүхүүдээс ангид бие даасан шүүх /цэц/ үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг.

2. Үндсэн хуулийн гомдолд үндэслэсэн хянан шийдвэрлэх ажиллагаа нь Үндсэн хуулийн хяналтыг ердийн шүүхээс тусгаарласны үндсэн дээр үүсдэг.

3. Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдал захиргааны болон санхүүгийн хувьд бие даасан байх нь шүүхийн бие даасан байдлын урьдчилсан нөхцөл болдог.

4. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр парламентын баталсан хуулийг хүчингүй болгох эрх

мэдэлтэй бөгөөд хэлэлцэх асуудлын ихэнх нь Үндсэн хуульд аливаа хууль, бусад шийдвэр нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэх асуудал эзэлдэг.

5. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид болох Цэцийн гишүүд улс төрийн эрх мэдэл бүхий парламентаас томилогддог байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц нь төрийн байгууллын тогтолцоонд онцгой үүрэгтэй бөгөөд Үндсэн хуулиас бусад хуулийн хэрэгжилтийг түүнд нийцүүлэн хянан шийдвэрлэж, үндсэн хуульт ёс болон хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэн, Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах байгууллага юм.

Үндсэн хуулийн суурь зарчмын баталгааг хангаснаараа Үндсэн хуулийн цэц нь ардчиллын, хүний эрхийн төдийгүй үндсэн хуульт ёс бүрэлдэж бэхжих баталгаа болдог билээ. Сүүлийн 10 жилд буюу 2012-2021 оны байдлаар Үндсэн хуулийн цэцээс маргаан хянан шийдвэрлэж гаргасан нийт дүгнэлтийн 98 хувь нь иргэдийн өргөдөл, мэдээллээр үүссэн маргаан байна.

Энэ хугацаанд эрх бүхий байгууллагын хүсэлтээр үүссэн маргаан хоёрхон хувьтай байна³⁶. Түүнчлэн Цэц байгуулагдсан 1992 оноос 2022 он хүртэлх 30 жилийн хугацаанд Үндсэн хуулийн цэц нийт

296 дүгнэлт, тогтоол гаргасны 225 нь хууль, хоёр нь зарлиг, 18 нь Улсын Их Хурлын тогтоол, 13 нь Засгийн газрын тогтоол, гурав нь Сонгуулийн ерөнхий хорооны тогтоол Үндсэн хуульд нийцээгүй гэсэн шийдвэр гарчээ. Нийт ирсэн өргөгдлийг авч үзвэл 62 хууль, УИХ-ын хоёр тогтоол, Засгийн газрын хоёр тогтоол, СЕХ-ны нэг тогтоол Үндсэн хуульд нийцсэн байна. Мөн УИХ-ын хоёр дарга, УИХ-ын хоёр гишүүн, 4 Ерөнхий сайд, нэг Ерөнхий прокурорыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн тогтоожээ³⁷. Эндээс харвал Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэгдсэн 10 хууль тутмын 8 нь Үндсэн хуульд нийцээгүй байсан байна. Төрийн өндөр албан тушаалтныг огцруулах эгүүлэн татах үндэслэл бий эсэх асуудлаар УИХ-ын даргыг нэг удаа огцруулах үндэслэлтэй хэмээн шийдвэрлэж байжээ.

Үндсэн хуулийн цэцээс төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг зогсооход тулгамдаж буй асуудал, шийдэл

Дээр дурдсан төрийн байгуулалтын тогтолцоонд онцгой үүрэгтэйгээр Үндсэн хууль амьдралд бодитой хэрэгжих боломжийг бүрдүүлж, түүний баталгаа болдог Үндсэн хуулийн цэцийг УИХ-тай маргаж байгаа тал мэт ойлгож, ярьсаар өнөөдрийг хүрч байна. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг УИХ-аас хамааралтай

³⁶ Монголын Хуульчдын Холбоо. Иргэдээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийн төлөв байдал ба Үндсэн хуулийн эрх зүйн хэрэглээ, шинжилгээний гарын авлага. УБ., 2022. 11 дэх тал.

³⁷ Мөн тэнд 16 дахь тал

байлгах гэж зүтгэдэг байдал ч ажиглагддаг.

Үндсэн хуулийн цэцийн гишүүд хэр зэрэг бие даасан хараат бус ажиллана, тэр хэмжээгээр Үндсэн хуулийн суурь зарчим болох төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцвэртэй байдал баталгаажиж, Үндсэн хууль амьдралд бодитой хэрэгжих боломж бүрдэх билээ. Нийгмийн ухамсарт Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны суурь зарчмыг зөв төлөвшүүлэх нь сайн хууль батлахаас илүү хүнд гэдгийг өнгөрсөн 30 жилийн түүхээс бэлхнээ харж болно.

Өөрөөр хэлбэл, сайн Үндсэн хууль баталж, түүнд нэмэлт өөрчлөлт хийгээд ч, сайн хууль гаргаад ч, туршлагатай чадварлаг парламентыг сонгосон ч, Үндсэн хуулийн зарчим, үнэт зүйл, хэм хэмжээнд өөрсдийн амьдралын хэв маягаа нийцүүлэхгүй бол хүний эрх, эрх чөлөө баталгаагүй болж, ард түмний засаглалын механизм доройтож мэдэх юм.

Үүнийг бид 2016 онд Үндсэн хуулийн цэцийн даргыг огцруулж, Цэцийн тухай хуульд парламент дур зоргоор нэмэлт, өөрчлөлт оруулсан түүхээс харж болох юм.

Мөн Үндсэн хуульд оруулсан “дордохын долоон өөрчлөлт”, 2019 онд хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан өөрчлөлтийг Үндсэн хуульдаа оруулсан, нийтийн биш ашиг сонирхлыг Үндсэн хуульд оруулахаар хүч түрдэг зэрэг дур зоргын үйлдлүүд ч байсаар байна.

Ард түмний төлөөлөгчдийн байгууллагын хууль тогтоох үйл ажиллагаа Үндсэн хуульдаа захирагдах ёстой гэсэн үзэл онолоор Үндсэн хуульд ёс илэрлээ олох зүй тогтол байгааг хүлээн зөвшөөрөх нь чухал юм.

Үндсэн хуулиар дархлагдах ёстой зүйлс нь хэлбэр талаасаа бус агуулга-сууриараа институтчилэгдэх нь нэн чухал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үр дагавар нь Монгол Улсын үндсэн хуулийн агуулга, мөн чанарыг тайлбарлаж, түүнийг биелүүлэх баталгаа болно. Үндсэн хуулийн цэц өөрийн гаргасан шийдвэрээр Үндсэн хуулийг тайлбарлах, Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн бүтцийн онол, үнэт зүйл, тогтоосон зарчмыг дэлхийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн улам бүр хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Эдгээрийн шийдэл нь дараах асуудлуудад хамаарч байна. Үүнд:

1. Үндсэн хуульд ёсыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэц онцгой үүрэгтэй байгааг харгалзан Цэцийн гишүүнийг сонгож томилох шалгуурт тухайн нэр дэвшигчийн онолын мэдлэг бэлтгэлийг харгалзан үзэх зохицуулалт оруулах хэрэгцээ бий болж байна. Цэцэд нэгэнт маргаан хянан шийдвэрлэх процесс явагддаг агуулгаар эрх зүйн боловсролтой хуульчдыг, улс төрийн зохих мэдлэг, энэ чиглэлээр мэргэшсэн байдлыг

харгалзан Цэцийн гишүүн-шүүгчийг томилох шаардлагатай.

2.Цэцийн гишүүнийг дахин томилж, хэн нэгний барьцаа болгодог зохицуулалтыг өөрчилж нэг удаа томилдог зохицуулалтыг Цэцийн тухай хуульд оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Өмнө дурдсан барьцааны даалгавраа сайн хийх тусам дахин томилогддог буруу практикийг тасалж байж, Цэцийн гишүүдээс хамааралтайгаар зарим үед улс төрчдөд зориулж шийдвэр гаргадаг байдлыг өөрчилж чадах юм.

3.Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийг боловсронгуй болгон эрх зүйн зохицуулалтад оруулж, Үндсэн хуулийн процессын эрх зүйн хэм хэмжээнд шинэчлэл хийх шаардлагатай байна.

4.Үндсэн хуулийн шүүх (цэц) дэлхий нийтэд тогтсон соёлоор иргэдийнхээ Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг хамгаалагч, манаач нь байх ёстой байтал манайд улс төрийн маргаан, улс төрчдийн эрх ашгийн хэрүүл дунд хайч нь болж зогсдог буруу жишиг тогтож байгаа нь нууц биш юм.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх зүйн байдлынхаа хүрээнд иргэдээс гаргасан үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

1992 оноос Монгол Улсад Үндсэн хуулийн үзэл санаа, үнэт зүйл, зарчим олон зүйл дээр өөрчлөгдөн шинэчлэгдэж, Үндсэн хуульт ёсны дэлхий нийтийн нийтлэг жишигт нийцэн хөгжиж байна.

Эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг эрх зүйн шинэ нөхцөл байдалд зүгширч төлөвшихөд Үндсэн хуулийн шүүх (цэц) онцгой үүрэг гүйцэтгэсээр байна.

Үндсэн хуульд хууль, эрх бүхий байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэдийн үйл ажиллагаа нийцэж байх, хуульд захирагдах ёс (the rule of law)-ны тогтоосон жишгийг харгалзан Үндсэн хуулийн цэц улс төрийн дарамт шахалтаас ангид байх шаардлага зүй ёсоор үүсэж байна. Үндсэн хуулийн шүүх (цэц) нь Үндсэн хуульд захирагдсан, бие даасан шийдвэрээрээ дамжуулан аливаа эрсдэлээс ангид байх боломжтой.

Цаашид төрийн эрх мэдлийн хуваарилалтын харилцаанд Үндсэн хуулийн цэцийн статусыг зөв тодорхойлох, Цэцийн магадлан шийдвэрлэх үйл ажиллагааны цар хүрээ, мөн чанар, Цэцийн шийдвэрийн үндэслэлийг Үндсэн хуульт ёсны зарчимтай уялдуулан эрх зүйн зохицуулалтад хамруулах шаардлага ч бий болж байна.

Ном зүй

1. Адомэйт, Хэньшэн. Эрх зүйн онол. Уб., 2017.
2. Барон де Монтескье. Хуулийн амин сүнс. МОНСУДАР нийгмийн ухаан №5. 2009.
3. Московский государственный институт международных отношений (Университет) МИД России. Конституционное право зарубежных стран. М., Изд. НОРМА, 2005.\
4. Монголын Хуульчдын Холбоо. Иргэдээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийн төлөв байдал ба Үндсэн хуулийн эрх зүйн хэрэглээ, шинжилгээний гарын авлага. Уб., 2022.
5. Marlene Wind, European Constitutionalism Beyond the State (Cambridge University Press, 2003)
6. Д.Лүндээцанцан. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. Уб., 2014.
7. Ч.Өнөрбаяр. Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага (Түүх, Улс төр, Эрх зүй). Уб., 2021.
8. А.Токвиль. Демократия в Америке. М., Прогресс, 1992.
9. Ц.Сарантуяа. Төрийн эрх мэдэл хуваарилах зарчим. Үндсэн хуулийн хяналт.// "Монголын төр эрх зүй". 1995. №2.
10. Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн шүүх ба улс төр. Хууль дээдлэх ёс. Уб., 2012. №4.

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛД БНМАУ-ЫН ПРОКУРОР Ж.АВХИАГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ТҮҮХЭН ҮҮРЭГ



Монголын хуульчдын холбооны
хууль зүйн шинжлэх ухаан,
боловсролын хөгжлийг дэмжих
хорооны дарга, Хууль зүйн ухааны
доктор, дэд профессор,

Судлаач Ц.МӨНХБАТ

Нэг. Оршил

Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ж.Авхиа нь 1969 оны 02 дугаар сарын 06-ны өдөр БНМАУ-ын прокуророор томилогдож, 1978 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 9 жил гаруй хугацаанд энэхүү төрийн өндөр хариуцлагатай албыг нэр төртэй хашсан байна. 1983 оноос Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан,³⁸ Улсын Ерөнхий прокурорын газрын Ахмадын хорооны даргаар³⁹ ажиллаж байв. Улсын прокуророор ажиллах хугацаандаа прокурорын байгууллагын үйл ажиллагааны хууль зүйн эрх зүйн үндсийг боловсруулахад биечлэн оролцож, хууль ёсыг нэг бүрчлэн сахиулахад үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм хүндтэй хүний нэг билээ.⁴⁰ Прокурорын байгууллагыг бэхжүүлэх, түүний улс орны амьдралд гүйцэтгэх үүргийг нь улам өндөржүүлэх, хууль ёсыг сахиулахад хяналтын

Товч утга. Монгол Улсын гавьяат хуульч, Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Авхиагийн мэндэлсний 100 жилд зориулан прокурорын байгууллагын түүхэн хөгжилд түүний оруулсан гавьяа зүтгэлийг судалгааны үндсэн дээр гаргасан өгүүлэл болно.

Түлхүүр үг. Прокурорын хууль тогтоомж, хяналт, хүний нөөц, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, шинэчлэл, үр дүн.

³⁸ Прокурорын байгууллагын түүхэн товчоон. 1930-2020. УБ. 2020. 142 дахь тал

³⁹ Ш.Сүхбаатар. Монгол Улсын прокурорын байгууллага нэвтэрхий толь. УБ.2022. 14 дэх тал

⁴⁰ Ц.Бямбацогт. Ж.Авхиа-прокурорын байгууллагад ажилласан он жилүүд. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн хурандаа генерал Жарантайн Авхиа 90 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2013. 34 дэх тал

үйл ажиллагааг өргөтгөх зайлшгүй шаардлага үүссэн үед Улсын прокуророор томилогдсон байдаг. Түүний дайчин шуурхай зохион байгуулах чадвар ноёлсон он жилүүдэд прокурорын байгууллага сэвхийн боссон гэж ахмад прокурорууд ам нэгтэй хэлдэг.⁴¹

**Хоёр. Прокурорын
байгууллагын хууль тогтоомжийг
боловсронгуй болгоход
санаачилгатай оролцсон**

Урьд үйлчилж байсан прокурорын байгууллагын үйл ажиллагааны дүрмийг шинэчлэн хуулийн хэлбэршилд оруулан, төрийн эрх барих дээд байгууллага Ардын Их Хурлын чуулганаар “БНМАУ-ын прокурорын хяналтын хууль”-ийг хэлэлцүүлэн, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1976 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 253 дугаар зарлигаар батлуулсан нь эрх зүйн зохицуулалтын хувьд үлэмж ач холбогдолтой үйл явдал болсон. Энэхүү 6 бүлэг 65 зүйлтэй хууль батлагдан гарсан нь тухайн үеийн прокурорын байгууллагын дээд удирдлага тухайлбал, Ж.Авхиа прокурорын санаачилга, идэвх зүтгэлтэй шууд холбоотой байв. Гэтэл адил тэгш эрхтэй шүүхийн байгууллагын хууль сураггүй байсан юм.⁴²

Энэ тухай Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат хуульч, доктор, профессор Н.Жанцан: Өнөөгийн шүүх эрх мэдлийн концепсоос харвал Дээд шүүхийнх түрүүлж гарах ёстой шүү дээ. Нэг үгээр хэлбэл түрүүлж сэтгэж, түрүүлж боловсруулж, түрүүлж өрсөж, концепцийг ойлгуулж чадсантай холбоотой⁴³ гэж тэмдэглэсэн байна.

1960 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд 1978 оны 12 дугаар сарын 26-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын прокурор хууль санаачлах эрхтэй” болсон нь Ж.Авхиа прокурорын хөөцөлдлөгөө санаачилгатай холбоотой гэж үздэг.

Хуульд зааснаар прокурор төрийн хуулийн биелэлтэд тавих хяналтыг прокурорын ерөнхий хяналт, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт, шүүхийн хяналт, тусгай хяналт гэсэн үндсэн 4 чиглэлээр хэрэгжүүлж байсан нь улс орны хэмжээнд хууль хэрэгжүүлэхэд тавих хяналтыг голлон гүйцэтгэж байснаар тодорхойлогдож байжээ.⁴⁴ Хуульд орсон шинэлэг зүйлийн талаар Ж.Авхиа прокурор өөрийн дурсамждаа “Хуулийг улс орон даяар хүн бүр нэг бүрчлэн биелүүлэх, хууль зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан арга

⁴³ Мөн тэнд. 175 дахь тал

⁴⁴ Ц.Бямбацогт. Ж.Авхиа-прокурорын байгууллагад ажилласан он жилүүд. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн хурандаа генерал Жарантайн Авхиа 90 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.2013. 34 дэх тал

⁴¹ Ш.Сүхбаатар. Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш. УБ. 2017. 49 дэх тал

⁴² Ш.Сүхбаатар. Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш. УБ. 2017. 52 дахь тал

хэмжээ авах, хүний эрх эрх чөлөөг хамгаалах, хохирсон эрхийг сэргээх, прокурорын байгууллагын ажилтнууд албан тушаалын зэрэгт тохирсон цол, формын хувцас хэрэглэх, цалин хөлсний нэмэгдэл цалин авах” гэж дурдсан байна.⁴⁵ Түүнчлэн прокурорын байгууллагын зохион байгуулалт, боловсон хүчин томилох журам, түүнд баримтлах шалгуур, ажил хэргийн байдлыг аттестатчлах, ажилтнуудыг урамшуулах, сахилгын арга хэмжээ авах, эрдэм шинжилгээний хүрээлэн, хэвлэлтэй байхыг хуульчилсан байна.⁴⁶

Тухайн үеийн прокурорын байгууллагын үндсэн чиг үүргийн нэг бол гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг судлан илрүүлж, цаг тухайд нь арилгуулах талаар хууль хамгаалах байгууллагуудаас зохиож байгаа ажлыг зохицуулах зөвлөлийг Улсын прокурор удирдаж байв.

Энэ үүргээ хэрэгжүүлэх эрх хэмжээг дээрх хуульд тусгуулж чадсанаар прокурорын байгууллагын нэр хүнд хуулийн бусад байгууллага дундаас тэргүүлэх болсон байна.

Гурав. Прокурорын байгууллагад бүтэц, зохион байгуулалтыг оновчтой хийсэн

Ж.Авхиа прокурор хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын прокурорын газарт Иргэний хэргийн шүүн таслах ажиллагаанд хяналт тавих тасаг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Тоо бүртгэл мэдээллийн тасаг, “Социалист хууль ёс” сэтгүүлийн газар, Чухал хэргийг мөрдөн байцаах групп байгуулж, Улсын Дээд шүүхийн цэргийн коллегийн хуралдаанд оролцох үүрэг бүхий прокурор шинээр ажиллуулжээ.

Прокурорын орон тоог 30 гаруй хувиар нэмэгдүүлсний үр дүнд Ардын цэргийн прокурорын газрыг Цэргийн Ерөнхий прокурорын газар болгон өргөтгөн, Хязгаарын ба дотоодын цэргийн прокурорын газрыг тусгайд нь байгуулсан байна.

Аймаг хот, сумдад ажиллах хэсгийн прокурор, мөрдөн байцаагчдын орон тоо үлэмж нэмэгдсэн байна. Тухайлбал, Эрдэнэт хот, Дорнод аймгийн Халх гол сум, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Дорноговь аймгийн Сүмбэр суманд хэсгийн прокурор ажиллах болжээ.⁴⁷

Төв аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагч нэг байсныг хоёр болгож, гурав хэсгийн прокурорыг

⁴⁵ Ж.Авхиа. *Хос морьтой холын замд*. УБ.2003. 67 дахь тал

⁴⁶ Ш.Сүхбаатар. *Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш*. УБ. 2017. 52 дахь тал

⁴⁷ Ц.Бямбацогт. *Ж.Авхиа-прокурорын байгууллагад ажилласан он жилүүд. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн хурандаа генерал Жарантайн Авхиа 90 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. УБ. 2013. 34 дэх тал

зургаа болгож, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.

Дөрөв. Түүний ажиллах хугацаанд гарсан хяналтын ажлын зарим үр дүн

Прокурорын байгууллагын үйл ажиллагааны гол цөм болсон мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахад онцгой анхаарч 1969, 1972, 1977 онд Мөрдөн байцаах албаны улсын нэг, хоёр, гурав дугаар зөвлөгөөнийг зохион байгуулан, өөрийн биеэр илтгэл тавьж, мөрдөн байцаах ажиллагааг шуурхай явуулах, энэ ажилд оршиж байсан алдаа дутагдлыг арилгах талаар үүрэг, амлалт авхуулах, сайн ажиллаж байсан прокурор, мөрдөн байцаагч нарыг шагнаж урамшуулах, тэргүүний арга барилыг дэмжин дэлгэрүүлэх зэрэг олон ажлыг зохион байгуулсан байна.⁴⁸

1977 оныг 1969 онтой харьцуулахад прокурорын мөрдөн байцаалтын хуулийн анхны хугацаанд хэрэг барагдуулах ажиллагаа 66.6 байсан бол 86.1 хувь болж, 19.5 хувиар, хэрэг мөрдөж барагдуулах ажиллагаа 78.2 хувь байснаа 89.7 хувь болж, 11.5 хувиар өсөж, шүүхэд шилжүүлсэн хэрэг гологдол болж буцах явдал 13.8 хувь байсан бол 7.2 хувь болж, хэрэг бараг 1 дахин буурах зэргээр гол үзүүлэлтүүд дээшилсэн байв.

1968 онд эрүүгийн хэргийн 43.1, иргэний хэргийн 11.2 хувьд прокурор оролцож, иргэний нэхэмжлэл 52-ыг гаргаж байсан бол 1977 онд эрүүгийн хэргийн 83.1 хувьд улсын яллагчаар, иргэний хэргийн 49.3 хувьд нь прокурор оролцож, 592 удаа иргэний нэхэмжлэл гаргасан нь 11.4 дахин өсжээ.⁴⁹

Мөн 1968-1977 онд улсын хэмжээнд ерөнхий хяналтын ажлын үзүүлэлт өс дахин өссөн⁵⁰ байна.

ЗХУ-д криминалистикийн чиглэлээр 3 удаа төлөөлөгч явуулж, туршлага судлуулсан нь үр дүнтэй болжээ. Прокурорын болон хуулийн байгууллагуудын ажилтны онол практикийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч, хуульчдад зориулсан “Социалист хууль ёс” мэргэжлийн сэтгүүлийн анхны дугаар 1973 онд хэвлэгдэж, 1990 он хүртэл улирал тутам нийтийн хүртээл болж байсан ба захиалагч уншигчийн тоо 20000-д хүрч эрэлт хэрэгцээтэй байжээ.

Үндэсний телевизийн “Хууль зүй”, радиогийн “Иргэн ба хууль”, “Залуучууд-хууль ёс” нэвтрүүлгийг сард 2 удаа тогтмол явуулдаг байв.⁵¹

1960-1980 онд гэмт хэргийн нөхцөл байдал хүндрээгүй, хэргийн гаралт 5-6 мянга болсон⁵² нь Ж.Авхиа прокурорын хичээл зүтгэлтэй холбоотой гэж судлаачид, ахмад үеийнхэн үзэж байгаа нь

⁴⁹ Ж.Авхиа. *Хос морьтой холын замд*.

УБ.2003. 67-68 дахь тал

⁵⁰ Мөн тэнд. 34 дэх тал

⁵¹ Мөн тэнд. 75 дахь тал

⁵² Мөн тэнд. 71-72 дахь тал

⁴⁸ Мөн тэнд.

эх сурвалжид тодорхой бичигдсэн байна.

1976 онд ЗХУ-ын Ерөнхий прокурорын орлогч А.С.Панкратов,

Буриад Улсын прокурор
Б.Ц.Цеденжапов,

БНАГУ-ын Ерөнхий прокурорын
орлогч А.Ландбнер,

БНБАУ-ын Ерөнхий прокурор
И.Вачков,

1977 онд БНУАУ-ын Дээд прокурор С.Карой нарыг урьж айлчлуулсан⁵³ нь харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаанд чухал нөлөө үзүүлж, өнөөгийн прокурорын байгууллагын шинжлэх ухаан, судалгааны чиглэлийн ажлын эхлэлийг баттай тавьсан, бодитой дэмжлэг болсон байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнд Зөвлөлт Холбоот Улсаас В.Б.Ястребов, Г.В.Дашков, В.П.Рябцеб нарын эрдэмтдийг зөвлөх мэргэжилтнээр урьж ажиллуулж байжээ.

Тав. Хүний эрхийг хангах, шударга үнэнийг тогтооход оруулсан хувь нэмрээс товчхон

Ж.Авхиа прокурор 1971 онд Улаанбаатар хотын Ажилчны дүүргийн худалдааны нэг касснаас 25000 төгрөг хулгайд алдагдсан хэрэгт эхнэр, нөхөр хоёр эрүүгийн хариуцлагад татагдаж, анхан шатны шүүхээс 3-5 жилийн хорих ял шийтгүүлж, уг шийдвэрийг бүх шатны шүүхээр хэвээр үлдээсэн

⁵³ Мөн тэнд. 70 дахь тал

асуудлыг хянаад эргэлзээтэй гэж үзэж холбогдох шалгалтыг хийлгэсний эцэст Улсын Дээд шүүхийн бүгд хуралд прокурорын эсэргүүцэл бичиж, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаалгасан ба 22 хоногийн дараа гэм буруутай этгээдийг олж тогтоон, улмаар шүүхэд шилжүүлэн 7 жилийн хорих оногдуулан шийдвэрлүүлсэн байна. Энэ тухай ахмад прокурор Ч.Шийрэвдорж сонинд тодорхой ярилцлага өгсөн байдаг.⁵⁴

Зургаа. Прокурорын байгууллагад эрдэм судлал, шинжлэх ухааныг хөгжүүлсэн нь

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж уг ажлыг санаан зоргоор бус шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, шинжилгээний ажлыг чухалчилж, эрдэм шинжилгээний байгууллага байгуулахыг чухал ач холбогдолтой гэж үзэж МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1972 оны 96 дугаар тогтоолоор БНМАУ-ын прокурорын газрын дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг байгуулах тухай шийдвэр гаргажээ.

Уг шийдвэрийн дагуу БНМАУ-ын прокурор Ж.Авхиагийн 1973 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар тушаалаар Гэмт хэргийн шалтгаан

⁵⁴ Ч.Шийрэвдорж. 1970-аад онд үйлдэгдсэн 25 мянган хэргийн учир зангилаа. Зиндаа сонин. УБ.2017.05.10

нөхцөл судлах хүрээлэнг 1973 оны 3 дугаар сарын 1-ний өдөр байгуулж, түүний дагаж мөрдөх түр дүрмийг батлан мөрдүүлжээ.

Тус хүрээлэн нь БНМАУ-ын прокурорын газрын системд багтаж, гэмт хэрэгтэй тэмцэх талаар тавьж байгаа төрийн бодлогыг хэрэгжүүлэн биелүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад туслах зорилгыг дэвшүүлж, Монгол Улсад гарч байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах эрдэм шинжилгээний байгууллага байв.

Тус хүрээлэн нь 1973-1983 оны хооронд БНМАУ-д гарч байсан гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах асуудлыг шийдвэрлэх зорилгын үндсэн дээр,

1. Гэмт хэрэгтэй тэмцэх онол арга зүйн үндсэн асуудал;

2. Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах;

3. Хуулийн байгууллагуудаас зохиож буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг судлан боловсронгуй болгох гэсэн 3 үндсэн сэдвийн хүрээнд 12-15 дэд сэдвээр судалгааг явуулсан байна.

Судалгаа шинжилгээний ажлын үр дүнд “БНМАУ-ын прокурорын хяналт” сурах бичиг, Зөвлөлтийн эрдэмтэдтэй хамтран “Уголовный процесс МНР”, “Уголовное право МНР” сурах бичгийг

орос хэл дээр хэвлүүлсэн байна. Түүнчлэн,

1. “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье”,

2. “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эцэг эхийн роль”,

3. “ХАА-н нэгдлийн мал ашиглан шамшигдуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал”,

4. “Худалдааны байгууллага дахь социалист өмчийн эсрэг гэмт хэрэг, тэмцэх арга зам”,

5. “Согтуурал социалист аж төрөх ёсонд харш үзэгдэл”,

6. “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил ба прокурорын байгууллага” зэрэг нэг сэдэвт эрдэм шинжилгээний 10 гаруй ном, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээний 50 гаруй зөвлөмж, эрдэм шинжилгээний 80 гаруй өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна. Үүнээс 6 өгүүлэл орос хэлээр, 1 өгүүлэл польш хэлээр гарчээ.

Улсын прокурорын газрын дэргэд эрдэм шинжилгээний хүрээлэнтэй болсноор прокурорын байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хуультай болох, энэ чиглэлээр олон улсын прокурорын байгууллагуудын туршлагаас судалгаа хийх боломж нэмэгджээ.

Тус хүрээлэн нь “БНМАУ-д гарч байгаа гэмт хэргийн шалтгаан

нөхцөл”, “Хүч хэрэглэсэн болон өмчийн эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх зарим асуудал”, “Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал” зэрэг сэдвийг голлон судалсан байна.

Гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлсэн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд ихээхэн анхаарал хандуулж судалгаа хийж байжээ. Гэмт хэрэгтэн бие хүний судлал, хохирогчийн судлалын асуудлаар тухайн үед судалгаа хийсэн баримт байна.

Тус хүрээлэн 1974 оноос эхлэн “Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” гэсэн эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг жил тутам гаргаж, нийт 8 дугаарыг хэвлүүлсэн байна. Түүнчлэн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт хэрэгжүүлэх зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил, прокурорын хяналтыг боловсронгуй болгох зэрэг тодорхой асуудлаар зургаан удаа эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохиосноос гадна социалист орнуудын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй нягт харилцаа холбоотой байж, олон улсын хурал, зөвлөгөөн, коллеквизм, симпозиум, криминологичдийн их хуралд удаа дараа идэвхтэй оролцдог байв.

Монгол Улсад 1983 оноос өмнөх 20 гаруй жилийн хугацаанд гарсан гэмт явдлын статистик,

тоо бүртгэлийн материалд боловсруулалт хийгээд зогсохгүй, гэмт явдлын гаралтын байдал, бүтэц, хөдөлгөөн, хандлагад дүгнэлт хийж байжээ.

Өдгөө дээрх хүрээлэн нь 51 дэх жилдээ Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн болон өргөжиж, Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 118 дугаар тогтоолоор баталгаажиж Сургалтын алба, Судалгааны алба, Тамгын хэлтэстэйгээр салбарын зохих эрдэмтэд, туршлагатай прокурор, судлаачдаар бэхжигдэн, прокурор, ажилтнуудаа сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, прокурорын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж байна.

Долоо. Прокурорын байгууллагын хүний нөөцийг чанаржуулах, прокурор, ажилтнуудыг сургах, урамшуулан дэмжихэд анхаарсан

Аливаа байгууллагын үйл ажиллагаа ямар байх эсэх нь тэнд ажиллагсдын хүний нөөцийн хүрэлцээ хангамж, боловсрол, мэдлэг, мэргэшлийн түшингээс ихээхэн хамаардаг билээ.

Ж.Авхиа прокурор мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх 5 жилийн хэтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр 10 жилийн хугацаанд гадаад, дотоодын хуулийн дээд сургуульд 60, дунд сургуульд 79, мэргэжил дээшлүүлэх курсээр 208 нийт 347 хүнийг сургаж бэлтгэсэн байна. 1978 оны байдлаар ЗХУ-д 38 хүн суралцаж байжээ. Улсын прокурорын газрын нэр дээр жил бүр 2 хүнийг ЗХУ-ын хуулийн их сургуульд явуулж байсныг 1977 оноос 10 хүн болгож нэмэгдүүлжээ.

Монгол Улсын Их Сургуульд мөрдөн байцаагчийн анги нээлгэсэн байна. 1969 онд прокурор, мөрдөн байцаагч нарын 28 хувь нь дээд боловсролтой байсан бол 1978 онд 42 хувь болж, нийт ажилтнуудын 98.4 хувь нь дээд, дунд боловсролтой болжээ.

Прокурор Н.Жанцан, К.Тажебакет, Л.Рэнчин, Ц.Бүжинлхам нарыг ЗХУ-д аспирантурт суралцуулснаар тэд хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэрэг амжилттай хамгаалсан байна.

Гавьяат хуульч, ахмад прокурор Н.Сосорбарам: Прокурор, ажилтнуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах ажилд оролцуулах, мэргэжил чадварыг нь дээшлүүлэхэд онцгой анхаарч, Улсын прокурорын 01 дугаар албан даалгавар гаргаж, прокурор бүр жил бүр эрх зүйн сэдвээр 10-аас доошгүй лекц, яриа хийх, лекцийн сэдэв 1, ярианы сэдэв 2-г боловсруулах, хэвлэл, радиод 3-аас доошгүй материал бичих, хэрэг зөрчилд орж болзошгүй хүнийг даан авч хүмүүжүүлэх, улсын яллагчаар 3-аас доошгүй оролцох зэрэг олон ажлыг хийж байсан нь прокурор бүрийн боловсрол мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх хариуцлага сахилгыг бэхжүүлэхэд бодит нөлөө үзүүлж байлаа⁵⁵ гэсэн байна. Прокурорын байгууллагад ажиллаж гавьяа байгуулж зүтгэл гаргасан тэргүүний хүмүүсийг урамшуулан шагнаж байх “Гавьяат хуульч” цол буй болгох талаар Намын Төв Хороо, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд санал тавьж, дэмжигдэн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 69 дүгээр зарлигаар “БНМАУ-ын гавьяат хуульч” цол бий болсон түүхтэй. Ийнхүү БНМАУ-ын анхны гавьяат хуульч цолоор Улсын прокурорын газрын Шалган зааварлах хэлтсийн прокурор Г.Дамдинсүрэн, Ерөнхий хяналтын хэлтсийн прокурор С.Батсүх нар шагнагдсан байна.

⁵⁵ Ж.Авхиа. *Хос морьтой холын замд*. УБ. 2003. 75 дахь тал, Ш.Сүхбаатар. *Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш*. УБ. 2017. 126 дахь тал

Гавьяат хуульч С.Батсүх: 1970 онд прокурорын байгууллага 40 жилийн ойгоо тэмдэглэх гээд хөл ихтэй жил боллоо. Ж.Авхиа, Г.Иш нар ч ойгоороо улсын гавьяат хуульч цолтонтой болж, хүмүүсээ шагнуулах төсөл барьчихсан төрийн ордон руу байсхийгээд явчихна. Их ч хөөцөлдсөн.

Тэд гавьяат хуульч цолтонтой болгосон гавьяатай улс. Энэ нь прокурор төдийгүй Монголын хуульчдын дотроос анхны хүндтэй цол байв.⁵⁶ Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат хуульч, доктор, профессор Н.Жанцан: Ж.Авхиа гуай ажиллаж буй салбартаа ээлтэй.

Бусад салбартай тиймхэн ханддаг байсан. Гавьяат хуульч бий болголоо гэхэд прокуророос эхний улс шагнагдсан. Яагаад шүүхээс нэг ч хүн оруулчихаагүй юм.⁵⁷ гэж бичжээ. Прокурорын байгууллагын боловсон хүчний тогтвор суурьшлыг сайжруулах, нэр хүндийг дээшлүүлэх зорилгоор “Хуульчаас төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх” хүртэл 7 зэрэг бүхий цол, цолны нэмэгдэлтэй болгов.

Цолны нэмэгдэлтэй болсноор прокурорын цалин 25 хувь, мөрдөн байцаагчийн цалин 40 гаруй хувиар нэмэгдсэн⁵⁸ ажээ. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны

02 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр зарлигаар Ж.Авхиа прокурорт албан тушаал болон гавьяа зүтгэлийг үнэлэн “Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх” цол олгосон байна.

Найм. Прокурорын ажиллах орчин, нөхцөлийг бэхжүүлсэн

1974 онд шинээр Улсын прокурорын газрын дөрвөн давхар албан конторын барилга, Хөвсгөл, Өвөрхангай, Булган, Хэнтий аймагт 2 давхар конторын барилгатай болж, бусад нь тусдаа байртай болсон. Бүх харьяа 15 нэгж газруудын автомашиныг шинэчлэн, шуурхай албаны автомашинтай болгож, бие даасан төсөвтэй автограшийг шинээр байгуулжээ. Улсаас тодорхой төсөв шийдвэрлүүлж, 100000 төгрөгийн дэмжлэгээр, орон нутгийн прокурорын газруудыг мөрдөн байцаалт явуулах тоног төхөөрөмжөөр хангасан. Тухайн үед Намын Төв хорооны 1977 оны 345 дугаар тогтоолд техник хэрэгсэл худалдаж авахад зориулж, 300 мянган төгрөг улсаас олгохоор заасан байлаа.⁵⁹

Мөрдөн байцаах ажиллагаанд шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглах асуудалд анхаарч ЗХУ-аас криминалистикийн багаж худалдан авах ажлыг 2 удаа зохион байгуулж, Улсын прокурорын газар, Улаанбаатар хотын прокурорын газарт криминалистикийн кабинет,

⁵⁶ Ш.Сүхбаатар. Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш. УБ. 2017. 57 дахь тал

⁵⁷ Мөн тэнд. 62 дахь тал

⁵⁸ Ж.Авхиа. Хос морьтой холын замд. УБ.2003. 70 дахь тал

⁵⁹ Ж.Авхиа. Хос морьтой холын замд. УБ.2003. 70 дахь тал

орон нутагт криминалистикийн булан, лаборатори, Төв аппаратад тусгай төхөөрөмжлөгдсөн автомашинтай болжээ. Яргайтын аманд прокурор, ажилтнуудын зуслангийн 20-иод модон байртай болсон. Улсын ерөнхий прокурор асан Г.Бахдал: Улсын Ерөнхий прокурорын өндөр албан тушаалыг хэн олон жил хашсанаар биш харин юу амжуулсан, юу үлдээснээр нь үе үеийн ерөнхий прокуроруудыг үнэлэн дурсдаг. Жишээ нь Ж.Авхиа гуайг прокурорын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд хамгийн их зүйл бүтээсэн гэж үнэлдэг⁶⁰ гэсэн бий.

Ес. Ажилсаг хөдөлмөрч дайчин прокурор, жинхэнэ эр хүн байв

Ж.Авхиа прокурор Улсын прокуророор томилогдсон даруйдаа ажил хэргээ яаравчлан судалж, өөрөө бие даан шийдэхийгээ шийдэж, дээшээ танилцуулж шийдвэрлэж болох асуудлаа Улс төрийн товчоо, Ю.Цэдэнбал, Ж.Батмөнх, С.Жалаж-Аажав нарын нөлөө бүхий удирдлагатай нэг бүрчлэн уулзаж ойлгуулсан нь ажил хэрэг нь бүтэмжтэй болоход ихэд нөлөөлсөн байна.

Ю.Цэдэнбал дарга тэр үед прокурорын ажилд өөриймсөг хандаж, олон зүйлийг шийдэж өгчээ.⁶¹ Ахмад үеийн дурсамжаас үзэхэд, тухайлбал, Монгол Улсын

⁶⁰ Г.Бахдал. Хууль яагаад гууль болов. Өдрийн сонин. 2006.11.28. №284. 2418

⁶¹ Ш.Сүхбаатар. Эр хүн. УБ.2013.14 дэх тал

Хөдөлмөрийн баатар, Гавьяат хуульч, доктор, профессор Н.Жанцан: “Ямар ч асуудал байхгүй, прокурорын нэр хүнд Ж.Авхиа... нарын үед их өсчихсөн юм.

Үүнтэй маргах хүн байхгүй.⁶² Хүний төлөө ажилладаг байсан юм даа. Эрдэм судлалын ажилд их анхаарна. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг Улсын прокурорын газрын дэргэд байх ёстой гэдгийг анх гаргаж тавьж, Улс төрийн товчоогоор хүлээн зөвшөөрүүлээд тогтоол гаргуулсан. Хорих байгууллагаас суллагдсан хүүхдийг заавал ажилтай болгодог байсан.⁶³

Улсын Ерөнхий прокурорын орлогч асан, хурандаа Ж.Чойжанцан: Ж.Авхиа прокурор нь хөдөлмөрч, ямар ч ажилд бүтээлчээр ханддаг, хүнийг дээр доор гэж ялгадаггүй, үг сонсдог, хэрэгтэй зүйлийг авч чаддаг, гүндүүгүй, хүнд тусархаг, ажилд хатуу шаардлагатай, амьдралд уян зөөлөн ханддаг, эрдэм номтой, эрхэлсэн ажилдаа махруу, ажилсаг, хамт ажиллахад тулхтай, түшигтэй, жинхэнэ эр хүн байсан.⁶⁴

Улсын прокурорын орлогч, Цэргийн ерөнхий прокурор асан хошууч генерал Б.Даваасамбуу: Ер нь Ж.Авхиа гуайд олон сайхан онцлог чанар бий дээ, түүний гол нь зорьсондоо заавал хүрэх дайчин

⁶² Мөн тэнд.

⁶³ Ш.Сүхбаатар. Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш. УБ. 2017. 172-174 дэх тал

⁶⁴ Н.Сосорбарам. Дурсамж. Ж.Авхиа. Хос морьтой холын замд. УБ. 2003.75 дахь тал

давшингүй байдаг, тэрээр цагдаа, цэрэг, прокурор, армид ажиллаж байхдаа байгууллагын хөгжлийн ирээдүйг харсан томоохон зорилтыг тавьж, түүндээ хүрэхийн тулд бүхнийг тэр зүгт чиглүүлэн зохион байгуулж, ямагт уйгагүй шаргуу ажиллаж санасандаа хүрдэг байлаа. Ж.Авхиа гуай нэгэнт шийдээд эхэлсэн ажлаа дутуу орхиж байсныг би үзээгүй.⁶⁵

Гавьяат хуульч, ахмад прокурор С.Батсүх: Ер нь Ж.Авхиа Улсын прокуророор ажилласан арав шахам жилийг тод мөртэй, прокурорууддаа үеийн үед дурсах дурсамж үлдээсэн хүн. Ж.Авхиа ажлын өвөрмөц арга барилтай хүн.

Удирдлагын арга барилын хувьд хүн нэг бүртэй тулж ажиллана. Өглөө бүр шуурхай зөвлөгөөн хийж, өмнөх өдрийн ажлаа болсон болоогүйг дүгнэж, дараачийн ажлаа төлөвлөнө. Бидний санаа оноог их сонсоно.

Зөв юман дээр зарчимч чанга шаардлага сайтай. Аливаа асуудалд өнөөдрийг бодож ажиллаж байгаагүй, алсын бодлоготой ханддаг. Хэрэг танилцах нь гайхалтай.⁶⁶

Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, хэлтсийн дарга асан, ахмад прокурор Т.Сүхбаатар: Тэр үед хуулийн байгууллага дээд боловсролтой мэргэжлийг боловсон хүчин их дутагдаж байсан.

⁶⁵ Ц.Бямбацогт. Ж.Авхиа-прокурорын байгууллагад ажилласан он жилүүд. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн хурандаа генерал Жарантайн Авхиа 90 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2013. 38 дахь тал.

⁶⁶ Ш.Сүхбаатар. Эр хүн. УБ. 2013. 44 дэх тал

Энэ бэрхшээлээс гарахын тулд Ж.Авхиа прокурор их зүйл хийсэн хүн. Үүний жишээ бол энэ хүний оролцоотойгоор Монголын хуульчид ЗХУ-ын нэлээд хэдэн хотуудад суралцах болсон төдийгүй зөвхөн прокурорын олон ажилтнууд Москва, Ленинград, Харьковт мэргэжил дээшлүүлсэн. Хэрэв Улсын прокурор Ж.Авхиа Зөвлөлтийн прокурорын байгууллага, түүний дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн, сургуулиудтай харилцаа холбоо муутай, бас дотооддоо мөнгө санхүүгийн талаас нь шийдэж өгөөгүй бол ийм боломж гарахгүй байлаа.⁶⁷ гэсэн нь олонтоо байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1998 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр 193 дугаар зарлиг гаргаж “Хуулийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, прокурор, цагдаагийн байгууллагыг материаллаг бааз, боловсон хүчнээр бэхжүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж, Улсын Ерөнхий прокурорын газрын Ахмадын Зөвлөлийн дарга Жарантайн Авхиад “Монгол Улсын гавьяат хуульч” цол хүртээсүгэй” гэсэн нь энэхүү түүхэн нэр хүндтэй хүний ажил үйлсийг Монгол Улсын төр, засаг өндрөөр үнэлсний нотолгоо билээ.

⁶⁷ Мөн тэнд. 42 дахь тал

Арав. ДҮГНЭЛТ

Ж.Авхиа прокурорын үед прокурорын байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үндсэн хяналтуудын үр нөлөөг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлэх чиглэлд урьд өмнө байгаагүй хөгжил дэвшил, өөрчлөлт шинэчлэл сэргэн мандалт авчирсан онцлог цаг үе байлаа. Тухайлбал, Прокурорын байгууллага бие даасан хуультай болсон, прокуроруудыг цол хэрэглэж, цолны нэмэгдэлтэй болгосон, Улсын Дээд шүүх, Улсын прокурорын газрын 4 давхар албаны конторын байртай болсон, “Гавьяат хуульч” цол анх удаа бий болгуулсан, Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулсан, мэргэжлийн “Социалист хууль ёс” сэтгүүлтэй болсон, жил бүр байгууллагын нэр дээр 10 оюутан гадаадад суралцдаг болсон, МУИС дээр мөрдөн байцаагчийн анги нээлгэсэн, прокурор, ажилтнуудын орон сууцны хангамж, цалин нэмэгдсэн болон тухайн үед прокурорын байгууллагын нэр хүнд урьд хожид байгаагүйгээр өссөн, прокурорын өгсөн үүрэг даалгавар тухай бүр ёсчлон биелэгддэг, зохион байгуулсан нэвтрүүлэг, яриа лекц бүхэн олон түмэнд хүрсэн, төр засгийн удирдлагууд прокурорын байгууллагын үгийг сонсдог

болсон зэргээр удирдлага зохион байгуулалтын томоохон ажил хийж, прокурорын байгууллагын түүхэнд нэрээ мөнхлөн үлдээсэн болохыг бахархалтайгаар тэмдэглэж байна.

Ялангуяа түүний санаачлан байгуулсан Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэн нь анх байгуулагдсан цагаас эхлэн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, уг асуудлыг шинжлэх ухааны үндэслэл, судалгаатайгаар боловсруулах үйл ажиллагаа явуулж эхэлснээр Монгол Улсад криминологийн шинжлэх ухааныг илүү нарийн, шат дараалалтайгаар хөгжүүлж, түүний ач холбогдол, үр өгөөжийг нэвтрүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн болохыг дурдах нь зүйтэй.

Арван нэг. САНАЛ

Энэхүү илтгэлийг боловсруулах явцад дараах саналыг дэвшүүлж, цаашид ажил хэрэг болгох боломжтой гэж үзсэн болно. Үүнд,

1. Прокурорын байгууллагын түүхийн музейд Ж.Авхиа прокурорын үзмэрийн хэсэг байгуулах;
2. Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнг түүний нэрэмжит болгож алдаршуулах;
3. Ж.Авхиа прокурорын эрдэм шинжилгээний сонгомол бүтээлийг боть болгон хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4. Жил бүр эрүүгийн эрх зүйн чиглэлээр эрдэмтэн Ж.Авхиагийн нэрэмжит оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулах г.м.
5. Ийнхүү илтгэлийн төгсгөлд Жарантайн Авхиа прокурор Монгол төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, бие хүч тэгш, ухаан саруул, оюунлаг, сод хүмүүн байсныг тэмдэглэж байна.
6. Түүний хууль хамгаалах байгууллагын ажилтнуудад хандаж "...юуны урьд би төрийн хуулийг хэрэгжүүлэгч, ард түмний эрх ашгийг хамгаалагч, төр улсын төлөөлөгч гэдгээ хатуу ухамсарлах нь чухал. Эрх мэдэл, албан тушаалдаа эрсдэлгүй гагцхүү хуулийн хүрээнд ажиллах хэрэгтэй"⁶⁸ гэсэн одоо ч үнэ цэнтэй хэлж үлдээжээ.

⁶⁸ *tsoodol@montsame.mn*

ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА



Шихихутуг их сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш
А.ДОРЖГОТОВ

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа⁶⁹

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох асуудал зайлшгүй шаардлагатай болно.

Хуульд зааснаар “Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ” гэжээ.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ: Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах

⁶⁹ Тухайн бүлгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосон.

бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтан болон ажиллагч /цаашид “ажилтан” гэх/-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаарыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэнэ⁷⁰.

Хуульд үндэслэн 2024 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн улсын хэмжээнд мөрдөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг цагт 3,929 төгрөг буюу сард 660,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосноор⁷¹ тооцвол **13200000** төгрөг хүртэлх иргэний эрх зүйн маргааныг тусгайлсан журмаар хянан Хуульд зааснаар “Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ” шийдвэрлэнэ. Хуулиар зохицуулсан “тодорхой боловсрол, тусгай мэргэжил, ур чадвар шаардах ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж

⁷⁰ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай /Шинэчилсэн найруулга/ Монгол Улсын хууль, 2021 оны 4 дүгээр сарын 16.

⁷¹ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай “Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны тогтоол. 2023.10. 13 №12.

байгаа ажилтны цагийн үндсэн цалин /хөлс/-г хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоохыг хориглосны гадна” уг заалт нь ажилтан цалин /хөлс/-гаа хөдөлмөрийн хөлсний доод Хуульд зааснаар “Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ” хэмжээнээс өндөр тогтоолгох, ажил олгогч болон ажиллуулагч /цаашид “ажил олгогч” гэх/ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүү тогтоосон цалин /хөлс/ олгоход саад болохгүй байхаар зохицуулсан байдаг⁷²

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хүн амын амьжиргааны доод түшинг тодорхойлох тухай хуульд заасны дагуу тогтоосон түвшингээс багагүй байх бөгөөд хэрвээ хүн амын амьжиргааны доод түвшинг⁷³ мөн хуулийн 5.3-т заасны дагуу тогтоосон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хамгийн өндөр тогтоосон бүсийн түвшингээс багагүй байх ёстой.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэрэглэхтэй холбогдсон бусад хуулийн заалтыг хэрэгжүүлэхдээ Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээг мөрдлөг болгох эрх зүйн зохицуулалт бий.

Хэмжээг дагаж мөрдөх. Ажилтныг хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллуулж байгаа ажил олгогч нь түүнд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй үндсэн цалин /хөлс/-г олгох үүрэг хүлээх бөгөөд ажил олгогч нь хуулийн заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд **хамаарах** бол түүнээс багагүй үндсэн цалин /хөлс/-г өмчийн төрөл, хэлбэр болон тухайн салбарын ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах салбарын байгууллагад гишүүнчлэлтэй эсэхээс үл хамааран олгоно. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосон тохиолдолд түүнийг дагаж мөрдүүлэх хугацаа нь дараагийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр байх ба тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш шинэчлэн тогтоосон бол дараагийн төсвийн жилээс эхлэн дагаж мөрдүүлэхээр хуулиар тогтоосон.

Шүүх хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг дээр дурдсан хуулийн зохицуулалтыг харгалзах шаардлагатай болно.

Улсын хэмжээнд мөрдөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд үндэслэн дараах төрлийн хэргүүдийг од түвшин тодорхойлох тухай хууль, 1998 -01-08, “Төрийн мэдээлэл эмхэтгэл” 1998 он №2-т нийтлэгдсэн.

⁷² Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай /Шинэчилсэн найруулга/ Монгол Улсын хууль, 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь заалтыг үзнэ үү.

⁷³ Хүн амын амьжиргааны до

шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхээр хуульчлан тогтоосон байна. Үүнд:

1. Бүх төрлийн гэрээ.

Бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулахаар заажээ. Энд дараах ойлголтуудыг тодорхойлох шаардлагатай болно.

а/ Бүх төрлийн гэрээ.

Монгол Улсын иргэний хуулийн арван тавдугаар бүлэгт “Гэрээний эрх зүй”-г тодорхойлон зохицуулсан. Түүнд гэрээний талуудын чөлөөт байдал, зөвшөөрлийн үндсэн дээр байгуулах гэрээ, ирээдүйд бий болох хийгээд бэлэн эд хөрөнгийн талаар хийх гэрээ, өвлөгдөх эд хөрөнгийн гэрээ байгуулах, эд хөрөнгийн дагалдах зүйлийн хамаарал, үүргийн гүйцэтгэлийг тодорхойлох, гэрээ байгуулах санал, гэрээ байгуулсанд тооцох, үнэ хаялцуулах ажиллагаа хийгээд гэрээг тайлбарлах, гэрээ хүчин төгөлдөр болох, стандарт гэрээний нөхцөл, гуравдагч этгээдэд ашигтай гэрээ, гэрээнээс татгалзах, түүний эрх зүйн үр дагавар зэрэг гэрээний эрх зүйн ерөнхий зохицуулалтуудыг тодорхойлсон байдаг.

Эдгээр ойлголтод үндэслэн *иргэний эрх зүйн гэрээг* “хоёр буюу түүнээс дээш этгээд иргэний эрх ба үүрэг тогтоох, өөрчлөх дуусгавар болгох алаар хийсэн хэлцээр” тодорхойлсон байдаг.

б/ Гэрээний эрх зүйд иргэний эрх зүйн гэрээг *бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээ, бусдын эзэмшил*

ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээ, ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ гэсэн гурван бүлэгт хуваан эдгээр гэрээний үүргийг иргэний хуулиар журамлан зохицуулдаг.

Иргэний эрх зүйн эдгээр гэрээг бүх төрлийн гэрээ гэж ойлгож хуулийг хэрэгжүүлэх нь зүйтэй санагдана.

2. Мөнгөн хөрөнгө.

Мөнгөн хөрөнгө гэх ойлголт **бэлэн мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгө** хамаарна.

Бэлэн мөнгө нь кассад болон харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламжаас бүрддэг байна. Мөнгөтэй адилтгах хөрөнгө гэдэг нь үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага байна.

“Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах”-тай холбогдсон маргаан Тусгайлсан журмаар шүүхэд хянан шийдвэрлэх хэрэгт хамаарна. Монгол Улсын иргэний эрх зүйн ойлголтоор “Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна. *Нийтийн өмч* нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэрээр нь ангилдаг. *Хувийн өмч* нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй. Нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно⁷⁴

Өмчлөгч.

Хуульд өөрөөр заагаагүй бол төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэн болон хуулийн этгээд өмчлөгч байна.

⁷⁴ Эх сурвалж: Монгол Улсын Иргэний хууль, 99 дүгээр зүйл.

/ИХ,101/. Эдгээр нь дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулахтай хэрэг маргаанд хамааралтай байх боломжтой.

Учир нь “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” байхаас гадна өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ зохих ёсоор ашиглаж, арчлан хамгаалж, хадгалахгүй байгаа нь нийтийн ашиг сонирхолд харшлахаар бол өмчлөлийн зүйлээ зохих ёсоор ашиглах, арчлан хамгаалах, хадгалах үүргийг өөрт нь даалгах буюу бусдаар зохих хөлс, шан харамжтайгаар гүйцэтгүүлэх үүргийг шүүх өмчлөгчид хүлээлгэж болно гэж иргэний хуулиар тодорхойлон тогтоосон.

“Гэр бүлийн хөрөнгийн эрх” түүний дотор гэр бүлийн гишүүдийн ,хамтран өмчлөх дундын хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой иргэний хэрэг хамаарч болох юм.

Иргэний хуулийн 128.1-д “Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, **ашиглах**, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна”.

Хуулийн эдгээр заалтаас зөвхөн хамтран өмчлөх дундын өмчийн **ашиглалт, засвар үйлчилгээтэй** холбоотой хэрэг маргааныг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэж болох юм.

Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх эрхтэй бас холбогдоо. Иргэний хуульд зааснаар “Нийтийн зориулалттай орон сууцны барилгын доторх сууц /өрөө/ болон дундын өмчлөлийн зүйлд хамаарахгүй сууцны бус зориулалттай талбайн хэсгийг дангаар өмчилж болохоор, дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд хамаарахгүй орон сууцны барилга, байгууламж, төхөөрөмжийн хэсэг нь орон сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд байхаар, дундын өмчлөлийн эд хөрөнгөөс орон сууц өмчлөгчид ногдох хэсэг нь тэдгээрийн тус тусын өмчлөлд байгаа орон сууцны талбайн хэмжээ, нийт талбайн харьцаагаар тодорхойлогдохоор тус тус тогтоон зохицуулсан байдаг.

Иргэний хуулийн 147 дугаар зүйлд “Сууц өмчлөгч нь өөрийн өмчлөлд байгаа сууц болон сууцны бус зориулалттай хэсгийн халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг ашиглалтын төлбөрийг эрх бүхий байгууллагад, дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг сууц өмчлөгчдийн холбоонд тус тус төлнө” гэж заасан. Түүнчлэн орон сууцны цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц хоорондын

талбай болон тагт, сууцны доторх дундын ашиглалтын талбай, орцны хаалга, довжоо, цонх, хог зайлуулах хоолойн засвар үйлчилгээтэй холбогдсон, түүнчлэн өөр нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчдийн оролцох хэмжээг тодорхойлохдоо уг зардлыг тухайн орон сууцны нийт сууцны тоонд хуваан хариуцахаар тогтоосон.

Улмаар орон сууцны дээвэр, доод хонгил, халаалт болон халуун, хүйтэн усны удирдах зангилааны анхны хаалт хүртэл, цахилгаан оролтын самбар хүртэл холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэл, шалны +0.00 тэмдэгтээс дээших бохир усны шугам сүлжээ, тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээ, даатгал болон холбогдох бусад зайлшгүй зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлохдоо сууц эзэмшигчийн дангаар өмчлөх талбайг, тухайн орон сууцны байшингийн дангаар өмчлөх өмчлөлд байгаа нийт талбайд харьцуулан гаргана.

Маргаан иргэний хэрэг үүсгэж болох бас нэгэн асуудал бол “орон сууцны ашиглалтын хэвийн, аюулгүй байдлыг хангах, урсгал засвар хийлгэхээс бусад асуудлаар санал өгөөгүй өмчлөгч уг асуудлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй бөгөөд

энэ тохиолдолд тухайн этгээд уг арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд бий болсон зүйлийг ашиглахаар шаардах эрхгүй”. Амьдралд энэ асуудлаар иргэний хэрэг маргаан гардаг.

Орон сууц өмчлөгчдийн холбоо

нь дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гэрээний үүрэгтэй холбоотой бусдад учруулсан гэм хорыг холбооны дүрэм, сууц өмчлөгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон эдгээр журмын дагуу арилгана. Эдгээртэй холбогдох ашиглалт, түүний засвар үйлчилгээтэй холбоотой хэргийг шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх бололцоотой юм.

Хамтран ажиллах гэрээгээр

хоёр буюу түүнээс дээш этгээд хуулийн этгээд байгуулахгүйгээр, ашиг олох болон бусад тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах үүрэг хүлээдэг. Гэрээнд өөрөөр заагаагүй бол талуудын төлсөн хураамж нь тэдгээрийн дундаа өмчлөх хөрөнгө байхаар тогтоож, дундаа өмчлөх хөрөнгийн үр шим, түүнийг нэгтгэсэн, нийлүүлснээс бий болсон хөрөнгө талуудын дундаа өмчлөх хөрөнгө байхаар хуульчилсан. Уг хөрөнгийн засвар үйлчилгээний ашиглалт, засвар үйлчилгээний зардлын талаар маргаантай хэргийг шүүхэд тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх болох юм.

Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлж болдог.⁷⁵

Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл нь иргэний эрх зүйн харилцаанд бүрэн эрх бүхий төлөөлөгч буюу гишүүдээр дамжин оролцоно. Холбооны гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагааныхаа орлогоор олж авсан хөрөнгө нь гишүүдийн дундын хөрөнгө болно.

Нэхэмжлэгчдийн шаардлагыг гишүүдийн дундын хөрөнгөөр хангах бөгөөд орон сууцны дундын өмчлөлийн зүйл үүнд хамаардаггүй. Гишүүд өөрөөр тохиролцоогүй бол дундын хөрөнгө шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд холбоо, нөхөрлөлийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бүрэн эрх бүхий этгээдүүд ижил хэмжээгээр нөхөх хариуцлага хүлээнэ.

Эрх зүйн эдгээр зохицуулалттай холбоотойгоор тэдний дундын өмчлөлийн хөрөнгийн ашиглалт, түүний засвар үйлчилгээний зардал, төлбөрийн талаар маргаан гарах магадлалтай.

Дундаа хэсгээр өмчлөх. Иргэний хуулийн тавин нэгдүгээр бүлэгт, дундаа хэсгээр өмчлөгчид

⁷⁵ Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд “бүртгэгдээгүй холбоон нөхөрлөл”-ийн тухай зохицуулсан байдаг.

харилцан өөрөөр тохиролцоогүй бол өмчлөгч бүр тэнцүү хэмжээгээр өмчлөх эрхтэй бөгөөд өөрт оногдох хэсэгт ногдох үр шимийг өмчлөх эрхтэй. Хуульд өөрөөр заагаагүй бол тодорхой эрхийг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байвал энэ бүлэгт заасан журмыг баримтлахаар зохицуулдаг. Дундаа хэсгээр өмчлөгчдийн олонхын саналаар дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, удирдлагын талаар шийдвэр гаргах бөгөөд саналыг өөрт оногдох хэсэгт хувь тэнцүүлэн тооцно гэж хуулиар тогтоосон. Энд өмчлөгчдийн дунд өмчийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлын талаар гарсан маргаантай иргэний хэргийг шүүхэд тусгайлсан журмаар хянан шийдвэрлэж болно.

Цалин хөлс⁷⁶. хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах хэрэг тусгайлсан журмаар хянан ажиллагаанд хамаарч байна. Цалин хөлсний тухай хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулиар тодорхойлсноор “Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ” Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх цалин хөлс гаргуулах хэргийг энд тодорхойлсон хүрээнд ойлгож хэрэглэх нь зүйтэй.

Гэм хорыг арилгуулах эрх.

Бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн

⁷⁶ Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль / шинэчилсэн найруулга /101 дүгээр зүйлд тодорхойлсон.

хөрөнгө гаргуулах нэхэмжлэлтэй хэрэг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарна. Хуулийн энэ зохицуулалтыг гэрээний болон гэрээний бус үүрэгт аль алинд нь хамааруулан ойлгох зохистой.

Иргэний хууль тогтоомжид зааснаар “Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй байдаг бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцдог. Түүнчлэн үүрэг гүйцэтгэгч тодорхой эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд шилжүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь уг эд хөрөнгийг өөртөө шилжүүлэх, учирсан хохирлоо арилгахыг шаардах эрхтэй. Мөн үүрэг гүйцэтгэгч тодорхой ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгээгүй, хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч уг үүргийг өөрөө гүйцэтгэх буюу гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж, учирсан хохирлыг арилгахыг шаардах эрхтэй байдаг. Эдгээрээс уламжлан иргэний эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх эрхийг тодорхойлдог. Иргэний хуульд “Гэм хорыг арилгуулах эрх” гэдгийг гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн

эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэг, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг хамааруулдаг. Хохирсон этгээд эрхээ сэргээлгэхээр гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээдэд тодорхой хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол мөнгөөр гүйцэтгэхийг шаардаж бодог.

Эрүүл мэндийг хохироосноос хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсан буюу хөдөлмөрийн чадвар нь буурсан, эсхүл хэрэглээ зардал нь нэмэгдсэн бол гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд хохирогчид сар тутам мөнгө /тэжээн тэтгэхтэй холбогдсон тэтгэлэг/ төлөх замаар гэм хорыг арилгах үүрэгтэй. Хохирсон этгээд эмчилгээний зайлшгүй зардлыг урьдчилан төлүүлэхээр гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээдээс шаардах эрхтэй. Мэргэжлийн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд дахин мэргэжил эзэмших зайлшгүй шаардлагатай бол үүнтэй холбогдсон зардлыг нөхөн төлөхөд энэ журам нэгэн адил хэрэгждэг. Хүндэтгэн үзэх шалтгаан байвал иргэний хуульд заасан сар тутмын мөнгөн төлбөрийн оронд нэг удаагийн нөхөн төлбөр авахаар шаардаж болохоор зохицуулсан байдаг.

Гэм хорыг арилгуулах эрхтэй холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлсан журамд хамааруулсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр дээр дурдсан маргаантай холбоотой хэрэг үнийн дүнгээр хязгаарлагдана.

Үнийн дүн үл хамаарах

Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхээр хуульчилсан. Үүнд:

* Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

* Бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулахаар заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

* Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл тус тус үнийн дүнгээс үл хамаарч тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэгдэнэ.

Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглосон бөгөөд гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

Зарчим, хугацаа. Тусгайлсан журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх зарчим хугацааг

тодорхойлохдоо

× Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

× Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

× Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

× Хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тогтоосон зарим заалт ойлгомжгүй, зохицуулалтын хувьд өрөөсгөл болсон гэж үзэх үндэслэлтэй.

Тухайлбал “хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ” гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зарчимд “*Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах*” зарчимд “Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй” гэж хуульчлан баталгаажуулсан байдаг. Бодоход “Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно” гэх заалтад холбогдуулан томъёолсон байх магадлалтай.

Энэ тохиолдолд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах ойлголтод үндэслэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой атал “Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх”⁷⁷, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй” гэх заалт хэргийн оролцогч, түүнчлэн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлэх эрхийг хязгаарласан агуулгыг илэрхийлж байна.

Нотлох баримт

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд “Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ” гэж тодорхойлдог. Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

Нотлох баримт гаргах цуглуулах, бүрүүлэх гэдэгт: Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй ба бусад оролцогч нотлох баримт гаргаж болохоор, улмаар шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг албадан гаргуулж болохоор зохицуулсан байдаг. Түүнчлэн хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлага-тай нотлох

⁷⁷ ИХШХШТХуулийн 68 дугаар зүйлд нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах тухай зохицуулсан байх бөгөөд “хэргийг нэгтгэх” ойлголт байхгүй. Энд хэргийг нэгтгэх тусгаарлах гэж заасан байна.

баримт нь төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлэх үүрэгтэй.

Цахим баримт бичмэл нотлох баримт бөгөөд хэрэгт авагдсанаар бичмэл нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх ёстой.

Гэрч энэ хуулийн 43.3-т заасан⁷⁸ эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг⁷⁹ шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

Мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75⁶.2-т “Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно” гэжээ.

⁷⁸ ИХШХШТХуулийн 43 дугаар зүйлийн 43.3 заалт. “Гэрчээр дуудагдсан этгээд шүүхэд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй. Мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, зориуд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэжээ.

⁷⁹ Нотариатын үйлдэлд гэрчийн мэдүүлгийг гэрчлэх заалт үгүй. “Баримт бичигт зурсан гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх” үйлдэл байдаг. “Хуульд заасан бусад” гэсэн заалтад хамааруулан гэрчийн мэдүүлгийг гэрчилж болох ч гэрчийн мэдүүлэг худал гэх ойлголтоор эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй гэж үзнэ.

Дуу, дүрс бичлэг хуулийн 37 дугаар зүйлд зааснаар нотолгооны хэрэгсэл байх бөгөөд нотлох баримтад хамаарна. Харин нотлох баримтыг үнэлэх талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд тодорхойлсон. Энэ зүйлд зааснаар

- Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

- Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.

- Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

- Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

Хуулийн эдгээр заалтаас ангид ойлгож болохгүй.

Дүгнэж хэлэхэд тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх иргэний эрх зүйн маргаанд хэрэгт хамааруулсан шалгуур оновчтой биш санагдав. Жишээ нь: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр шалгуур болгосон.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, эрх зүйн онол хууль хэрэглээний арга зүйн ойлголттой зарим талаар нийцээгүй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарсан, эрх зүйн зарчимд нийцээгүй зүйл заалтууд ажиглагдав.

Иймд хуулийн нэмэлт өөрчлөлтийг сайтар судлах, хууль хэрэглээний арга зүйн талаас нь сайтар нягталж эхнээс нь зөвөөр төлөвшүүлэх хэрэгтэй гэж үзнэ.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛД АНХААРАХ АСУУДАЛ



Шихихутуг ИС-ийн Клиник сургалтын
төвийн эрхлэгч Т.СҮХБААТАР

Оршил

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэл хүний эрхтэй хэрхэн холбогдож, практикт хэрхэн хэрэглэгдэж байгааг тодорхойлоход энэхүү өгүүллийн зорилго оршино

Түлхүүр үг

Гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэл, хэргийн зүйлчлэл

Гэр бүл – гэрлэлтээс үүдсэн эд хөрөнгийн бус болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хүмүүсийн хүрээ

Гэр бүлийн хүчирхийлэл гэж ураг төрөл, сэтгэл зүй, санхүүгийн холбоотой хүнтэй зүгээс гэр бүлийн бусад гишүүд, хамт амьдарч байгаа болон хамт амьдраагүй ч хамаарал

бүхий бусад хүмүүст хяналтаа тогтоож, эрх мэдлийн тэнцвэргүй байдалд оруулж буй үйлдэл эс үйлдлийг хэлнэ..

Хэргийн зүйлчлэл – Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинж нийгэмд аюултай, гэм буруутай үйлдлээс үйлдлийн шинжүүдийн харилцан хамаарлыг тогтоож хууль зүйн үнэлгээ өгч байгаа үйл ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуульд ..

Гэмт хэргийн нийгмийн хор аюул өсөн нэмэгдэж байгаа өнөө үед гэмт хэрэг зөрчлийг хууль зүйн талаас нь бүрэн задлах шинжилж гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх нь нийгэмд шударга ёс тогтооход нөлөөлөх нэг чухал хүчин зүйл болох нь олон баримтаар нотлогдож байгааг дурдах нь зүйтэй. Хүний эрхийн өнцгөөс авч үзвэл гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэргийн хохирогчийн асуудлыг ч энэ тэнцүү түвшинд авч үзэх ёстой асуудал юм.

Гэмт хэргийн зүйлчлэл нь хүний эрхийг хамгаалах асуудалтай олон талаар холбогдон яригдаж байгааг анхаарахгүй. Монгол улсын Эрүүгийн Хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэргийн бүрэлдэхүүнийг задлан шинжлэх, хэргийн зүйлчлэлийг зөв

хийх нь хууль зүйн олон үр дагаварт хүргэдэг.

Захиалагчийг нь олж тогтоогоогүй атлаа захиалгаар хүнийг алсан / ЭХ-ийн 10.1 дүгээр зүйлийн 2.3/ гэмт хэрэг үйлдсэн гэж зүйлчилж хоёр хүнд холбогдох хэргийг шүүхэд шилжүүлж ял шийтгэл оногдуулсан боловч тухайн 2 хүн нь дээрх гэмт хэргийг /ЭХ-ийн 10.1.2.3-д заасан хэргийг / үйлдээгүй, харин эрүүдэн шүүх үйл ажиллагааны хохирогч болсон байна гэж хэмээн үзэж суллагдсан нь Монголын нийгэмд ихээхэн дуулиан шуугиан болж байгааг хүн бүхэн янз бүрээр хүлээн авч байна.

Үүний учир шалтгаан олон байгаа хэмээн үзэж ойлгож болох боловч Монгол Улсын Эрүүгийн Хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэргийн объектив талын шинжийг учир ойлгомжгүй байдлаар хуульчилж заасан нь практикт янз бүрээр хэрэглэгдэхэд хүргэж байна. Гэмт хэргийн статистик мэдээ судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өсөн нэмэгдэж байна.

Прокурорын байгууллагаас 2023 онд Гэр бүлийн хамаарал бүхий харьцаатай хүнийг байнга зодох, харгис хэрцгий хандах зэргээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 773 хэрэгт хяналт тавьж 501 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн дийлэнх нь

31- 44 насныхан байна. Хүйсийн хувьд 94.6 хувь нь эрэгтэй. 63.2 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2022 оныхоос **22.3 хувиар** өссөн байна.

Нийт гарсан гэмт хэргийн 55.1 хувь нь Улаанбаатар хотод, 44.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдахаас өмнө гэр бүлийн хүчирхийллийн нэг төрөл болох тарчлаах үйлдлийг Эрүүгийн хуулийн 100.1 дүгээр зүйлд хуульчилсан бөгөөд УДШ-ээс 2010 оны 5 дугаар сард 13 дугаар тогтоол гаргаж **Байнга** гэдгийг 3 удаагийн тохиолдол гэж тайлбарласан.

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг зөрчилд тооцохдоо **байнга** гэсэн шинжийг заагаагүй тул гэр бүлийн хүчирхийллийн дийлэн хувь нь Зөрчлийн хуулиар шийтгэгдэж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд **сэтгэл санааны, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийлэл** нь гэр бүлийн хүчирхийлэлд хамаарна гэж тодорхойлсон.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэл Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл болдог учир хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, зөрчил хянан шалгах ажиллагаа явуулахдаа мөрдөгч нотлох баримтыг бүрэн гүйцэд мэргэжлийн өндөр түвшинд цуглуулж

шалгах нь зүйлчлэлийг зөв хийхэд нөлөөлөх чухал нөхцөл болдгийг анхаарах нь зүйтэй

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн хүчиндэх гэмт хэрэгт гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэж үзэж ял оногдуулахаар заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүчирхийлэлд хамаарна гэж заасан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т **бие махбодын хүчирхийлэлд** амь нас эрүүл мэндэд гэм хор учруулсан эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдлийг,

Хуулийн 6.3-т **сэтгэл санааны хүчирхийллийг** хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харьцахыг хязгаарлах гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэх үйлдэл багтахыг,

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т **эдийн засгийн хүчирхийлэлд** цалин хөлс тэтгэвэр тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, эдийн засгийн

хараат байдалд оруулсан эсхүл санхүүгийн хохирол учруулах үйлдэл хамаарахыг,

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д **бэлгийн хүчирхийлэлд** эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг ойлгоно гэж тус тус заасан нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг зөв зүйлчлэхэд чухал ач холбогдолтой.

Судалж үзэхэд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн үйлдлийн шинж байдлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд дээрх байдлаар тодорхойлж хуульчилсан хэдий ч Эрүүгийн хуульд байнга зодох, харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах гэсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн бие махбод, сэтгэл санааны, эдийн засгийн хэлбэрийг хуульчилсныг хэргийг шалгах болон үйлдлийг зүйлчлэхэд анхаарах нь зүйтэй.

Зөрчлийн тухай хуульд харгис хэрцгий харьцах ,догшин авирлах, тарчлаах үйлдлийг хуульчилж заагаагүй бөгөөд зодох хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхэд халдах үйлдлийг заасны гадна хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харьцахыг хязгаарласан, гэсэн сэтгэл санааны хүчирхийллийн

хэлбэрийг хуульчилж заасан. Дээрх байдлаар гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг Эрүүгийн Хууль болон Зөрчлийн хуульд бүрэн гүйцэд тодорхойлоогүй, нэр томьёо тодорхой бус, зарим талаар учир дутагдалтай байгаа нь гэмт хэрэг зөрчлийг ялгаж салгаж зүйлчлэхэд бэрхшээл дагуулж байна.

Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан гэдэгт ямар үйлдэл хамаарах, хэрхэн ойлгох талаар хуулийн тайлбар, нэгдсэн ойлголт байхгүй байгаа нь гэмт үйлдлийг зүйлчлэх, төсөөтэй гэмт хэргээс ялгахад хүндрэл учруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зургаан сар байгаа нь үйлдлийг зүйлчлэхэд анхаарвал зохих асуудлын нэг бөгөөд хүний эрхийн өнцгөөс авч үзвэл хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгогдох магадлал их байгааг **анхаарахгүй байж болохгүй**.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэсэн гэмт хэргийг бүрэлдэхүүнийг задлан шинжилж үзэхэд гэр бүлийн хамааралтай хүнийг **байнга** хүчирхийлсэн бол гэж энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний онцлох шинж болгож заасан нь хүчирхийлэл үйлдсэн этгээдийн үйлдлийг зүйлчлэхэд маргаан дагуулсан

асуудал болж байна.

“**Байнга**” гэдгийг практикт 3 буюу түүнээс дээш удаа байхаар ойлгож хэрэглэж ирсэнтэй мөрдөгч прокурор шүүх санал зөрчилддөггүй бөгөөд нэг мөр ойлгож байгаа гэж үзэж болно.

Гэсэн хэдий ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэлтэй холбоотой дараах маргаан бүхий асуудал үүсэж байгааг анзаарахгүй байж болохгүй.

1. Хохирогч урьд нь хоёр удаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний дараа л Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдаж байна гэж үзэж үйлдлийг хуулийн энэ зүйл заалтаар зүйлчлэх нь тодорхой байна. Хуулийн энэ заалтыг хохирогчийн байр сууринаас буюу хүний эрх талаас нь авч үзвэл хохирогч гэр бүлийн хүчирхийлэлд урьд нь хоёр удаа өртсөн байхыг Эрүүгийн хууль шаардаад байгаа мэт өрөөсгөл байдлаар ойлгогдож байгаагийн зэрэгцээ гэмт этгээдийн үйлдэл өөр бусад үр дагаварт хүргээгүй бол Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр дангаараа зүйлчлэгдэхээр болж байна.
2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг зарим гэмт хэргийн хувьд ял хүндрүүлэх нөхцөл байдал болгон заасан тохиолдолд зүйлчлэл өөрчлөгдөнө. Тухайлбал: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь хэсэгт гэр бүлийн хүчирхийлэл

үйлдэж хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн энэ зүйл хэсгээр үйлдлийг зүйлчилнэ.

3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд хүний биед хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.3 дугаар зүйл, 11.4 дүгээр зүйл, 11.5 дугаар зүйлд зааснаар дангаар нь зүйлчлэх үү, аль эсвэл Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийг нэмж давхар зүйлчлэх үү гэдэг нь бас л маргаантай бөгөөд хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж байна гэж заагаад зүйлчлэлийг өөр өөрөөр хийж байна. Гэр бүлийн хүчирхийллийн үйлдсэний улмаас хохирогчид гэмтэл учирсан бол Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 11.4, 11.5 дугаар зүйлийн аль тохирох зүйлээр, гэмтэл учраагүй бол 11.7 дугаар зүйлээр зүйлчилж байна.

ДҮГНЭЛТ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгайлан зүйл болгож заасан нь хууль эрх зүйн хувьд ач холбогдолтой болсон хэдий ч энэ гэмт хэрэг ихэнх тохиолдолд нууц далд хэлбэрээр үйлдэгдэж, олон төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх суурь гэмт хэрэг болдог онцлогтой. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг / ЭХ-ийн 11.7 дугаар зүйл/, /Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл/ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийг хууль зүйн талаас ялгаж зүйлчлэх нь гэм буруутай этгээд шударгаар хариуцлага хүлээлгэх нөхцөл тул хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, зөрчил хянан шалгах ажиллагааны явцад нотлох баримтыг бүх талаас нь бүрэн гүйцэд цуглуулж шалгаж дүгнэх шаардлага тавигдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг зүйлчлэлд тухайн үйлдэл байнга давтагдаж үйлдэгддэг, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлдлийн объектив талын шинжүүдийг харгалзан үзэх нь онолын болон практик ач холбогдолтой.

Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн Хууль
2. Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
3. Монгол улсын Зөрчлийн тухай хууль
4. Гэр Бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2014 он

Бусад эх сурвалж

1. Швейцарын хөгжлийн агентлаг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх “төслийн хүрээнд Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв “Хохирогч хамгаалал цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт” мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. УБ хот. 2018 он.

2. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь 2021 он. 98-р тал

3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь” Судалгааны тайлан. УБ. 2021 он

4. Еремеева.ЕН. Гэмт хэргийн зүйлчлэл. ОХУ. Тула.2019 он

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БА ҮҮРГИЙН ЗӨРЧИЛД ХҮЛЭЭЛГЭХ
ХАРИУЦЛАГА



Хууль зүйн доктор (Ph.D),
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
эрдэмтэн нарийн бичгийн дарга
М.ТҮВШИНЖАРГАЛ

ТОВЧ УТГА :

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг тэгш, хүртээмжтэй хуваарилах, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үзэл санаа тусгалаа олсон билээ.

Энэ үзэл санааны хүрээнд төрийн өмчит компанийн (цаашид “ТӨК”) засаглалын ил тод байдал, сахилга бат, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдах болсон ба улмаар холбогдох хууль тогтоомжийн шинэчлэл явагдаж байгаа билээ. Тухайлбал, Монгол Улсын УИХ-аас батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “...төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн

этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх”⁸⁰ гэсэн бодлогыг тусгасны зэрэгцээ Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан өргүүлэн мэдүүлэхээр заажээ.⁸¹

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, түүнийг сайжруулахад компанийн удирдлага буюу төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн тогтолцоо, чиг үүргийг бэхжүүлэх, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Компанийн засаглалын хүрээнд ТУЗ-ийн тогтолцоо нь түүний бүтэц бүрэлдэхүүн, томилгоо зэрэг төрөл бүрийн дэд тогтолцооноос бүрдэх бөгөөд тэр дундаа ТУЗ-ийн гишүүний хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоо нь ТУЗ-ийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй.

Манай Улсын хувьд ТУЗ-ийн үйл ажиллагаа нь улс төрөөс хараат байдаг, ТУЗ-ийн гишүүнээр ⁸⁰Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020.08.28 №24 тогтоол 4.4.10.

⁸¹ Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, 2021.01.22 №12 тогтоол 1.8.52.

мэргэжлийн бус захиргааны албан хаагчийг томилдог зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагын тогтолцоо хангалттай бэхжээгүй байна.

Энэхүү судалгааны хүрээнд ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэн эрх буюу хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээ болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим, эрх зүйн орчин, мөн ТУЗ-ийн гишүүнд хариуцлага хүлээлгэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг судлахыг зорьсон болно.

ТҮЛХҮҮР ҮГС: Төрийн өмчит компани, Төлөөлөн удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг, хариуцлага

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БА ҮҮРГИЙН ЗӨРЧИЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

1. Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн хариуцлагын өнөөгийн нөхцөл байдал

ТУЗ нь компанийн удирдлагын шийдвэрийг гаргах, гүйцэтгэх удирдлага нь өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүний хариуд ТУЗ-д олгогдсон өргөн хүрээтэй эрх хэмжээг хянах зорилгоор компанийн өмнө итгэл даах үүргийг хүлээлгэдэг ба зөрчсөн тохиолдолд хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээлгэх механизм үйлчилдэг.

Сүүлийн үед ТӨК-ийг тойрсон (Эрдэнэс Тавантолгой ХК, Хөгжлийн банкны зэрэг) томоохон хэрэг маргаанууд гарах болсон. Дээрх хэрэг маргааны гол үндэслэл болсон компанийн голлох шийдвэрүүдийг тухайн компанийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ гаргасан байдаг. Өөрөөр хэлбэл компанийн эрх бүхий албан тушаалтан болох гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүн нь компанийн өмнө итгэл даах үүргийг хүлээх ба гаргасан шийдвэр нь тухайн үүргийг зөрчсөн нь нотлогдвол өөрийн хөрөнгөөр хариуцах учиртай.

Компанийн ТУЗ-ийн гишүүнд хариуцлага хүлээлгэх олон механизмаас(*эрүүгийн хариуцлага, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, гэм хор учруулснаас үүсэх хариуцлага*) итгэл даах үүргийн зөрчлийг тогтоож хариуцлага хүлээлгэх тогтолцоо нь Монгол Улсын хувьд онол болон хууль хэрэглээний хувьд шинэлэг төдийгүй шүүхийн практикт нэгдсэн ойлголт болж хөгжөөгүй байна.

Ялангуяа ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүний хувьд өөрийн гарсан шийдвэртэй холбоотойгоор итгэл даах үүргийн зөрчлийн улмаас хариуцлага хүлээсэн тохиолдол ховор байна. Учир нь ТӨК-ийн хувьд төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагын зүгээс төрийг төлөөлөн ТУЗ-д ажиллах этгээдийг томилж, түүнд удирдамж өгөх

байдлаар ажиллах чиглэлийг нь тодорхойлж өгдөг. Удирдамж, зааврыг зөрчсөн, эсрэг саналтай байгаад зохих ёсоор гүйцэтгээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болдог.

Төр компанийн хэлбэрийг сонгон үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд тухайн компанийн нэгдсэн бодлогыг тодорхойлж чиглэмж өгөх нь зүйн хэрэг боловч хуульд заасан эрх хэмжээнээс хэтрүүлсэн (*томилгоо хийхийг шаардах, бүрэн эрхэд хамаарах асуудлаар нь чиглэл өгөх, улс төр, ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргахыг шаардах зэрэг*) тохиолдолд тухайн удирдамжийг биелүүлээгүй ТУЗ-ийн гишүүнийг хамгаалах тогтолцоо, мөн хууль бус удирдамж чиглэл өгсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

ТӨК-ийн хувьд ТУЗ-ийн гишүүн нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд дараах хүндрэл тулгарах нь түгээмэл байдаг.⁸² Үүнд:

- Засгийн газар болон төрийн байгууллагын зүгээс компанийн эрх ашигт үл нийцэх бодлого гаргаж, хэрэгжүүлэхийг шаардах

- ТУЗ-ийн гишүүн нь төрийн албан хаагч байх тохиолдолд төрийн албан хаагчийн үүрэг нь ТУЗ-ийн гишүүний үүрэгтэй нь зөрчилдөх

- ТУЗ-ийн гишүүн хянамгай байх

үүргээ гүйцэтгэх мэдлэг, чадваргүй байх гэх мэт.

Монгол Улсын хувьд бусад улс оронд тулгардаг дээрх хүндрэлүүд ч мөн адил гардаг.

- ТӨК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч байх⁸³ тул ТУЗ-ийн гишүүний хувьд компанийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь тодорхой хүндрэл гардаг. Өөрөөр хэлбэл Засгийн газар, яамдаас ТӨК-ийн эрх ашигт харшлах бодлого хэрэгжүүлэх, улс төрийн нөлөөллөөр дамжуулан тодорхой шийдвэр гаргахыг шаардах нь нийтлэг бөгөөд энэ тохиолдолд ТУЗ-ийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч болохын хувьд ашиг сонирхлын зөрчилд ордог байна. Үүнийг шийдэх нэг арга бол ТУЗ-д ажиллах төрийн албан хаагчдын тоог багасгах эсвэл тодорхой тоон квот тогтоох юм.

- ТӨК-ийн ТУЗ-д хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн баталсан заавар, удирдамжийг баримтлан ажиллах үүрэг хүлээлгэсэн⁸⁴ нь ТУЗ-ийн компанийн өмнө хүлээх үүрэгтэй зөрчилдөх эрсдэлийг бүрдүүлж байна.

⁸³ Засгийн газрын тогтоол 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралт, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”.

⁸⁴ ТБОНӨмХ § 21.6 “Төрийн өмчийн төлөөлөгч болон ТУЗ-ийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно”.

⁸² World Bank, *Corporate Governance of State-Owned Enterprise: A Toolkit*, 161 (2014).

- ТУЗ-д төрийн албан хаагч нар голлон ажиллах, ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалт хангалтгүйгээс компанийн өмнө хүлээх үүргээ биелүүлэх мэдлэг, чадвар сул хүмүүс сонгогдон ажиллах нь түгээмэл байна.

- Компанийн тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүний шийдвэртэй холбогдуулан итгэл даах үүргийн зөрчлөөс үүдэх хариуцлага⁸⁵, хуульд заасан тусгай хариуцлагын⁸⁶ тухай зохицуулалтыг практикт зөв ойлгон хэрэглэсэн тохиолдол ховор байна.

Үүнээс дүгнэхэд ТӨК-ийн ТУЗ-ийн үүрэг хариуцлагын тогтолцоо холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд бүрэн бүрдээгүй гэж дүгнэж болох төдийгүй тэдгээрийн агуулга зарим талаараа компанийн засаглалын суурь зарчмаас гажих, бодит байдал дээр хэрэгжүүлэх боломжгүй байх зэрэг бэрхшээл тулгарч байна.

2. ТУЗ-ийн гишүүний компанийн өмнө хүлээх үүрэг

ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн хувийн хэвшлийн компанийн ТУЗ-ийн гишүүний нэгэн адил компанийн эрх ашгийг дээдлэн итгэл даах үүргийг хүлээх ба тус үүргийн

⁸⁵ КтХ 84.6. "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө."

⁸⁶ КтХ 85.2. "Компанийн эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө."

зөрчлөөс үүдэх хариуцлага хүлээх нь компанийн эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо юм.⁸⁷ Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй тогтвортой явуулахын тулд холбогдох эрх бүхий албан тушаалтныг (ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч) томилон ажиллуулдаг. Энэ нь ТУЗ болон компани хоёрын дунд итгэл дээр (*fiduciary relationship*) тулгуурласан харилцааг үүсгэдэг.

Үүний эсрэг ТУЗ нь өөрт олгогдсон өргөн хүрээтэй бүрэн эрхийг буруугаар ашиглах, хувьцаа эзэмшигчийн эрх ашигт үл нийцэх шийдвэр гаргах эрсдэл бий болдог. Иймд ТУЗ-ийн компани болон хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээх үүрэг болон зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг ч нарийн тодорхойлсон байх учиртай.

ТУЗ-ийн гишүүн нь итгэл даах үүргээс үүдэн үнэнч байх үүрэг (*duty of loyalty*), хянамгай байх үүрэг (*duty of care*)-ийг давхар хүлээнэ. Тэдгээрийг бүхэлд нь компанийн эрх бүхий албан тушаалтын хүлээх үүрэг (*director's duties, fiduciary duties*) гэж нэрлэдэг. Компанийн эрх зүйн хүрээнд дээрх үүргийг ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн ч нэгэн адил хүлээнэ.⁸⁸

Хянамгай байх үүрэг нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд

⁸⁷ OECD, *Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises*, OECD Publishing (2015)

⁸⁸ A Toolkit, *supra* note 37, at 161.

хохирол учруулж болзошгүй аливаа үйлдлийг хийхдээ шаардлагатай хэмжээнд болгоомжтой, няхуур хандах агуулгыг илэрхийлдэг. Энэ үүрэг нь ТУЗ-ийн гишүүдийн хувьд ТӨК-д хамаарах асуудлаар бүрэн мэдээлэлтэй байх, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргахыг шаардана. Мөн тус үүргийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдээс шийдвэр гаргахдаа хангалттай мэдээлэл олж авсан байх, мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулах, олон ТУЗ-д давхар ажиллахгүй байх, хангалттай мэдлэг чадвартай байх шаардлага үүснэ.

Харин үнэнч байх үүргийг компанид үнэнчээр ажиллах үүрэг гэж ойлгох бөгөөд компани болон хувьцаа эзэмшигчийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах, компанийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих гэх агуулгыг илэрхийлдэг.

Өөрөөр хэлбэл ТУЗ нь улс төрийн нөлөөлөл болон бусад этгээдийн ашиг сонирхлоос илүүтэйгээр компанийн эрх ашгийг тэргүүнд тавина гэсэн үг юм. ЭЗХАХБ-аас ТӨК-ийн ТУЗ-д дээрх үүргүүдийг хүлээлгэн холбогдох хууль тогтоомжид тусгахыг зөвлөсөн байдаг.⁸⁹

⁸⁹ OECD, *Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises*, OECD Publishing (2015)

(§7A) ТУЗ-ийн гишүүн нь үнэнч шударга ажиллах ба гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээх үүрэгтэй.

Хүснэгт 1. Итгэл даах үүргийн харилцааг зохицуулсан зарим орнуудын туршлага

Хянамгай байх үүрэг	Компанийн тухай хууль (2011)	Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам (2023)	ТБОНЕКТХ-ийн төсөл (2022) ⁹⁰	АНУ-ын Компанийн загвар хууль (2016) ⁹¹	ХБНГУ-ын Хувьцаат компанийн тухай хууль (1900) ⁹²	Индонез Улсын Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, үүсгэн байгуулах, татан буулгах журам (2003) ⁹³
	(§ 84.4.1) Хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх; (§ 84.4.3) Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;	(§ 6.1.2) Хувыцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцож, шийдвэр гаргахад санал өгөх; (§ 6.1.3.) Шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцсан байх, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;	(§32.4.1.) ТУЗ-ийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцож, шийдвэр гаргахад саналаа өгөх; (§ 32.4.3.) Шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцах, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;	(§ 8.30.b) ТУЗ-ийн гишүүд эсхүл ТУЗ-ийн хорооны гишүүд шийдвэр гаргах чиг үүрэг болон хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдээлэлд тулгуурлан, тухайн нөхцөл байдалд адил түвшний албан тушаалтан зохистой гэж итгэх түвшинд хянамгай байж өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлбэл зохино.	(§ 93/I,1) ТУЗ-ийн гишүүн нь шийдвэр гаргахдаа хуульд заасан үүргээ үнэнчээр биелүүлж, хянамгай хандаж ажиллана.	(§ 26. 2) ТУЗ нь аливаа шийдвэр гаргахдаа хянамгай байж, бүрэн мэдээлэлд тулгуурлан ТӨК-ийн чиг үүрэг, зорилгод нийцсэн шийдвэр гаргана.

⁹⁰ Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай” хуулийн төсөл, Дэлгэрэнгүй <https://lawforum.parliament.mn/project/170/>

⁹¹ Model Business Corporation Act (2003)

⁹² Aktiengesetz -1965

⁹³ The Establishment, Management, Supervision and Dissolution of State Owned Enterprises. Government Regulation No. 23/2022.

Үнэнч байх үүрэг	
(§ 84.4.4) Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх; (§ 84.4.5) Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх; Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх; Компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх;	
(§ 6.1.4.) ТУЗ-ын гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;	
(§ 32.4.6.) Өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх. (§ 32.4.1.) эрх, үүргээ үнэнч шударгаар, зөвхөн компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх; (§32.4.4.) ТУЗ-ын гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх (§32.4.5.) Өөрийн албаны чиг үүргээс ТУЗ-ийн гишүүний чиг үүрэг тусгаарлагдсан байх;	
(§ 8.30.а) ТУЗ-ийн гишүүн бүрэн эрх, чиг үүргийг биелүүлэхдээ үнэнч шударгаар, компанийн эрх ашигт нийцүүлэн ажиллах;	
(§ 93/1,3) ТУЗ-ийн гишүүн нь албан үүргийн хүрээнд олж авсан компанийн нууц, нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх;	
(§ 27. 1) ТУЗ-ийн гишүүн бүр ТӨК-ийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж, үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх;	

Дээрхээс дүгнэхэд Монгол Улсын холбогдох хууль, журамд ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүргийн нэг хэсэг болох хянамгай байх болон үнэнчээр ажиллах үүргүүд тусгагдсан байна. Итгэл даах үүргийн хамрах хүрээ нь өргөн бөгөөд улс орон бүр харилцан адилгүй байдлаар хуульчилсан байна.

Бусад улс орны эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд ТУЗ-ийн гишүүнд итгэл даах үүргээс нь үүдэн хариуцлага хүлээлгэх тогтолцоог ТӨК-ийн харилцааг тухайлан зохицуулсан хууль, журам⁹⁴ эсвэл компанийн харилцааг зохицуулсан ерөнхий хуулийн⁹⁵ аль нэгэнд тусгах байдлаар зохицуулсан байна.

Монгол Улсын хувьд Компанийн тухай хууль, Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, Төрийн болон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл зэрэг хууль тогтоомжид итгэл даах үүргийг давхардуулан, олон утга санаагаар хуульчилсан байгаа нь ерөнхий хууль ба тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан тусгай хуулийн хооронд эрх зүйн зөрчил үүсэх, улмаар хууль хэрэглээнд хүндрэл учруулах эрсдэлийг үүсгэж байна. Иймд ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүрэг түүнээс үүсэх хариуцлагын асуудал нь ТӨК болон хувийн хэвшлийн

компанийн аль альд хамаарах ерөнхий үүрэг учир ерөнхий хууль болох Компанийн тухай хуульд тодорхой системчлэн оруулах нь үр дүнтэй юм.

1. Итгэл даах үүргийн зөрчлийг тогтоох

ТУЗ-ийн гишүүд нь итгэл даах үүргээ зөрчин компанид хохирол учруулсан гэж үзвэл компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хувьцаа эзэмшигчийн зүгээс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг.

Хянамгай байх үүргийг зөрчсөн гэж үзвэл бизнесийн шийдвэр гаргах дүрэм (business judgment rule) гэж нэрлэгдэх шалгуурын дагуу үнэлэн үүргийн зөрчлийг тогтоодог. Харин үнэнчээр ажиллах үүргийн зөрчилд үндэслэн нэхэмжлэл гаргах тохиолдолд үнэнч шударгаар шийдвэр гаргасан (entire fairness) байдлыг нь үнэлэн тухайн үүргийн зөрчлийг тогтооно.

ТУЗ нь шийдвэр гаргахдаа итгэл даах үүргээ биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд нотлох үүргийг нэхэмжлэгч этгээд болох хувьцаа эзэмшигч хүлээх ба шүүхийн зүгээс ТУЗ-ийн шийдвэр нь итгэл даах үүргийг зөрчсөн эсэхийг үнэлэн тогтоох юм.

⁹⁴ Индонез улс нь 2022 онд ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн гаргасан шийдвэртэй холбоотойгоор хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг холбогдох журамдаа шинээр тусгасан байна.

⁹⁵ ХБНГУ, АНУ, Англи гэх мэт

3.1. Хянамгай байх үүргийн зөрчлийг тогтоох

ТУЗ-ийн гишүүнд олон төрлийн үүрэг хүлээлгэх нь тухайн этгээдийн ажиллах сэдлийг бууруулах эрсдэлтэй ба улмаар ТУЗ нь гаргасан шийдвэртэйгээ холбоотойгоор итгэл даах үүргийг зөрчлөөс үүдэх хариуцлагыг хүлээх тул ямар нэгэн эрсдэл бүхий үйл ажиллагаа явуулахаас зайлсхийж, аюулгүй, эрсдэл гаргахгүй байхад илүү ач холбогдол өгч эхэлдэг байна.⁹⁶ Мөн ТУЗ нь хуульд заасан үүргийн хүрээнд зохих ёсны шийдвэр гаргасан ч түүний үр дагаварт компани алдагдал хүлээх ч тохиолдол бас бий.

Энэ тохиолдолд ТУЗ шийдвэр гаргахдаа хянамгай байх үүргээ чандлан биелүүлсэн л бол хариуцлагаас чөлөөлөгдөх нь шударга ёсны зарчимд нийцэх юм.

Иймд хянамгай байх үүргээ зөрчсөн эсэхийг тогтоохдоо бизнесийн шийдвэр гаргах дүрмийн дагуу үнэлгээ хийх ба энэ ойлголт нь Англи-Америкийн эрх зүйгээс үүсэлтэй ба АНУ-ын улсын шүүхийн жишигт тулгуурлан хөгжсөн ойлголт юм.⁹⁷

Бизнесийн шийдвэр гаргах дүрэм нь тухайн нөхцөл байдалд бусад компанийн удирдлага ч авч хэрэгжүүлэх байсан мэдээллийг бүрэн цуглуулж, түүнд үндэслэн шийдвэр гаргахдаа хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьсан бол хожим нь тухайн шийдвэр оновчтой бус байсан нь тодорхой болсон ч түүнийг хянамгай байх үүргээ зөрчсөн гэж үзэхгүй юм⁹⁸.

Өөрөөр хэлбэл ТУЗ-ийн гишүүн нь шийдвэр гаргахдаа, шударга бас няхуур хянамгай байж, ижил төстэй бусад компанийн удирдлагатай адил хэмжээнд нухацтай хандсан бол ТУЗ-ийн гишүүн ямар нэг хариуцлага хүлээхгүй байх зарчим юм.

Ихэнх улс оронд ТУЗ-ийн гишүүн тухайн асуудалд судалгаатай хандсан, шийдвэр гаргахдаа бүх дүрэм журмыг баримталсан тохиолдолд тухайн шийдвэртэй холбоотойгоор хянамгай байх үүргээ зөрчсөн гэж үздэггүй байна.⁹⁹

Аливаа шийдвэр гаргахдаа бизнесийн шийдвэр гаргах дүрмийг баримталсан эсэхийг тогтооход харилцан адилгүй шалгуур хэрэглэдэг ч нийтлэг байдлаар дараах 5 үндсэн нөхцөлийг нийтлэг харгалздаг¹⁰⁰. Үүнд:

- Гаргасан шийдвэр нь тухайн нөхцөл байдалд хамгийн зөв шийдвэр гэж үзсэн байх (conscious

⁹⁶ 江頭憲治郎『株式会社法』434頁参照（有斐閣第7版 2017年）。

⁹⁷ Kürşat Göktürk, Amerikan, Alman, İsviçre ve Türk hukukunda işadami kararı ilkesi, İnönü Üniversitesi Hukuk Fakültesi Dergisi Cilt:2 Sayı:2, s.208 (2011)

⁹⁸ 江頭・前掲注（51）471頁参照。

⁹⁹ G20/OECD, Компанийн засаглалын зарчмууд, монгол хэл дээрх орчуулга, 53 тал (2015)

¹⁰⁰ Model Business Corporation Act 8.31 (a).

business decision)

- ТУЗ-ийн гишүүн нь сонирхлын зөрчилгүй, хараат бусаар бие даан шийдвэр гаргасан байх (disinterested an independent)

- Компанийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж, үнэнч шударгаар хандсан байх (good faith)

- Шийдвэр гаргахдаа хангалттай мэдээлэлд тулгуурласан байх (an informed decision)

- Хууль болон компанийн дүрмийг зөрчөөгүй байх (illegality)

Дээрх нөхцөлүүд хангагдсан тохиолдолд ТУЗ-ийн гишүүн нь гаргасан шийдвэртэйгээ холбоотойгоор ямар нэг хариуцлага хүлээх учиргүй.

Монгол Улсын хувьд бизнесийн шийдвэр гаргах дүрэм буюу мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах, ингэхдээ хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих зэрэг шалгуураар ТУЗ-ийн шийдвэрийг үнэлэх, улмаар хариуцлага хүлээлгэх, эсхүл хариуцлагаас чөлөөлөх агуулга бүхий зохицуулалт Компанийн тухай болон бусад холбогдох хуульд тусгагдаагүй байна.

Компанийн тухай хуулиар ТУЗ-ийн гишүүнд компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах (84.4.3) үүргийг хүлээлгэсэн хэдий ч ТУЗ-ийн шийдвэр компанийн эрх ашигт нийцсэн, мөн үндэслэлтэй эсэхийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй тул үүнийг зөвхөн шүүх л тогтоох боломжтой байна. Гэвч шүүх мөн адил ямар шалгуурын

хүрээнд ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг үнэлэн тогтоох нь тодорхойгүй байна.¹⁰¹

ТУЗ-ийн гишүүнийн хянамгай байх болон үнэнч байх үүргийн зөрчлийг тогтоож хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Улсын Их Дэлгүүр ХК-ийн хооронд үүссэн маргааныг дурдаж болно.

Хэргийн товч агуулга¹⁰²

СЗХ-оос Б нарын есөн хүнд холбогдуулан “УИД” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 7 болон 2017 оны 6 дугаар тогтоолуудыг хүчингүй болгож, уг тогтоолыг үндэслэж “УИД” ХК болон “НР” ХХК-ийн байгуулсан 2016 оны гэрээ, тус гэрээг 2017 онд сунгасан, 2018 оны үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг тус тус хүчин төгөлдөр бус хэлцэл болохыг тогтоолгох, компанид учруулсан 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаас гаргуулах нэхэмжлэлийг гаргасан байна.

Хэрэгт авагдсан баримтын хүрээнд “УИД” ХК-ний ТУЗ-ийн 2015 оны 7, 2017 оны 6 дугаар тогтоолоор “НР” ХХК-тай сонирхлын зөрчилтэй түрээсийн гэрээ байгуулж компанийг алдагдалд оруулж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон, мөн хараат бус гишүүн Д нь сонирхлын зөрчилтэй атлаа санал хураалтад оролцсон

¹⁰¹ Г.Давааням, *Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, 97 тал* (2021)

¹⁰² Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2023/07/04/, Дугаар 001/ХТ2023/00147

болох нь тогтоогдсон байна.

Тус гэрээний хүрээнд “УИД” ХК нь “НР” ХХК-тай 1 сарын 450,000,000 төгрөгийн үнэ бүхий түрээсийн гэрээ байгуулсан байна. “НР” ХХК нь “УИД” ХК-тай гэрээ байгуулсны дараа “НТ” ХХК-д 1 сарын 800,000,000 төгрөгөөр дамжуулан түрээсэлсэн ба улмаар “НТ” ХХК нь жижиглэнгийн түрээслэгч нартай 2016 онд 8,756,600,000 төгрөгийн, 2017 онд 8,868,900,000 төгрөгийн, 2018 онд 10,025,200,000 төгрөгийн түрээсийн гэрээг тус тус байгуулсан болох нь тогтоогдсон байна.

Шийдвэрийн товч агуулга¹⁰³

1. Түрээслэгч “НР” ХХК нь сарын 450,000,000 төгрөгийн үнэ бүхий түрээсийн гэрээ байгуулмагц “НТ” ХХК-д сарын 800,000,000 төгрөгийн төлбөртэйгөөр дамжуулан түрээслүүлсэн, “НТ” ХХК нь цааш жижиглэнгийн түрээслэгч нарт дамжуулан 2016 онд 8,756,600,000 төгрөгийн, 2017 онд 8,868,900,000 төгрөгийн, 2018 онд 10,025,200,000 төгрөгийн түрээсийн гэрээ байгуулсан нь үнийн хувьд илт зөрүүтэй, компанийн эрх ашигт нийцээгүй байна. Иймд ТУЗ-ийн гишүүд үүргээ шударгаар биелүүлсэн гэж үзэх боломжгүй.

2. ТУЗ-ийн дарга Э, Х, хараат бус гишүүн Ч, Д, Б нар нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх замаар Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах шийдвэр гаргаж,

түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцохдоо тус компанийг алдагдалд оруулж, компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 31.46%-ийг эзэмшиж буй 45,000 гаруй жижиг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг сонирхлыг бодит байдлаар хохироосон байна. “УИД” ХК-ний ТУЗ нь Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж бие даасан байдлаа хангаж ажиллаагүйн улмаас 2017 оны 04 дүгээр сараас 2018 оныг дуустал хугацаанд жилд дунджаар түрээсийн орлого 11,4 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардал 7,6 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 2,9 тэрбум төгрөг, мөн 2017 оны 4 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сарыг дуусталх хугацаанд татварын дараах цэвэр ашиг 4,416,400,000 төгрөгийг олох боломжийг алдагдуулсан болохыг тогтоосон байна.

3. Компани ашиг олох, засаглалаа бэхжүүлэх, зохистой ажиллах нөхцөлийг хангахын тулд компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх итгэлцлийн үүргийг хуулиар, мөн компани дүрмээрээ тогтоож болохыг зохицуулсан. “УИД” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 7, 2017 оны 6 дугаар тогтоолоор сонирхлын зөрчилтэй түрээсийн гэрээ байгуулж, компанийг алдагдалд оруулж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д зааснаар ТУЗ-ийн гишүүд нь компанийн эрх бүхий

¹⁰³ Хэсэгчлэн авав.

албан тушаалтан бөгөөд хариуцагч нар нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-д заасан “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, 84.4.4-д заасан “шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх” үүргээ биелүүлээгүй. Энэ үүрэг ТУЗ-ийн бүх гишүүдэд хамааралтай бөгөөд ТУЗ-ийн гишүүд болох хариуцагч нар энэ үүргээ биелүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Хариуцагч Б, Ш,С, Н, А, Х нар Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т заасан үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ **чанд биелүүлэх, үндэслэлтэй шийдвэр гаргах** үүргээ биелүүлээгүй тул, мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.6-д зааснаар, хараат бус гишүүд Д, Б нар Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2, 92 дугаар зүйлийн 92.2, 55 дугаар зүйлийн 55.3-т заасан үүргээ тус тус биелүүлээгүй тул хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д зааснаар тус тус хохирлыг хариуцах үндэслэлтэй байна.

5. Шийдвэр гаргасан ТУЗ-ийн хараат бус гишүүдээс гадна ТУЗ-ийн бусад гишүүд компанийн эрх ашигт нийцээгүй тогтоолыг дэмжсэн, үндэслэл бүхий шийдвэр гаргах үүргээ

биелүүлээгүй, бие даасан байдлаа хангаж ажиллаагүй тул хариуцлагыг хамтран хүлээх үндэслэлтэй болно.

Иймд нэхэмжлэлийн шаардлагад дурдсан “УИД” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолуудыг хүчингүй болгон, түрээсийн гэрээнүүдийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоож, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.6, 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсэгт **зааснаар буруутай албан тушаалтнууд болох хариуцагч тус бүрээс 440 сая төгрөгийг гаргуулж, “УИД” ХК-д олгохоор шийдвэрлэсэн** байна.

Бизнесийн шийдвэр гаргах дүрмийн агуулгыг улс орон бүр харилцан адилгүй байдлаар хуульчилсан байдаг ба дараах үндсэн шинжийг голчлон авч үзсэн байдаг.

**Индонез Улс: ТӨХЭ-ийн
удирдлага, хяналт, үүсгэн
байгуулах ба татан
буулгах журам**

§ 59. Дараах нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

59.1. Үнэнч шударга, хянамгай байж ТӨК-ийн зорилго чиглэлд нийцсэн, эрх ашгийг дээдэлсэн шийдвэр гаргасан;

59.2. Гаргасан шийдвэрийн үр дагавартай шууд болон шууд бусаар хувийн ашиг сонирхолгүй байх;

59.3. Шийдвэрийн үр дагавартай холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөгөө мэдээлэл авсан байх.

**ХБНГУ: Хувьцаат компанийн
тухай хууль**

§ 93/1,2. ТУЗ-ийн гишүүн нь бизнес-ийн шийдвэр гаргахдаа хангалттай мэдээлэлд тулгуурлан, компанийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж шийдвэр гаргасан тохиолдолд үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.

ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн эрх бүхий байгууллагын өгсөн удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулах үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн

төлөөлөл хэрэгжүүлэх журамд удирдамжийн дагуу шийдвэр гаргасан ТУЗ-ийн гишүүнийг хамгаалах зорилгоор хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн заавар, удирдамжийн дагуу гарсан аливаа шийдвэрийн үр дагаврыг ТУЗ-ийн гишүүн хариуцахгүй байх зохицуулалтыг оруулж өгсөн нь бизнесийн шийдвэр гаргах дүрмийн тодорхой төрлийг тусгаж өгсөн гэж үзэж болохоор байна.¹⁰⁴

Гэхдээ дээрх зохицуулалт нь хуульд нийцэж гаргасан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн шийдвэрийг ТУЗ хэрэгжүүлснээс үүсэж болох аливаа хохирлыг хариуцахгүй байх агуулгыг илэрхийлэх юм. Гэтэл илтэд компанийн эрх ашигт хохирол учруулж болохуйц эсвэл авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болохуйц шийдвэр гаргаж биелүүлэхийг шаардсан тохиолдолд ТУЗ дээрх шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй юу, хэрэв тухайн шийдвэрийг биелүүлсэн тохиолдолд ТУЗ-ийн гишүүд хариуцлагаас чөлөөлөгдөх үү гэх асуудал урган гардаг.

Зарим орны Компанийн тухай хууль тогтоомжид хувьцаа эзэмшигчдийн хурлын (ТӨК-ийн хувьд хувьцаа эзэмшигчийн

¹⁰⁴ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, (§ 8.3) Эрх бүхий этгээдээс баталсан удирдамжийн дагуу гарсан хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээс үүсэх үр дагаврыг энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээд хариуцахгүй.

эрхийг хэрэгжүүлэгч) шийдвэрийг хэрэгжүүлэх тохиолдолд ТУЗ-ийн гишүүн хувийн хариуцлага хүлээх нөхцөл бүрдэнэ гэж үзсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах мөн хүчин төгөлдөр бус тооцуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг ТУЗ-ийн гишүүнд олгосон байдаг¹⁰⁵.

Энэ зохицуулалт нь нэг талаараа хууль бус шийдвэрийг биелүүлэхгүй байх эрхийг ТУЗ-д олгож байгаа юм. Хэрэв ТУЗ компанийн эрх ашигт үл нийцэх шийдвэрийг биелүүлэхээс татгалзан шүүхэд гомдол гаргаагүй тохиолдолд хянамгай байх үүргээ зөрчсөн гэж боломжтой юм.

Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр нь компанийн эрх ашигт нийцэж буй эсэх, хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээг хэтрүүлсэн эсэхийг үнэлэн үзэх нь ТУЗ-ийн гишүүний компанийн өмнө хүлээсэн хянамгай байх үүрэг юм.

Монгол улсын хувьд ТУЗ-ийн зүгээс компанийн эрх ашигт үл нийцэх шийдвэрийг биелүүлэхээс татгалзах, хүчин төгөлдөр бус тооцуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг тодорхойлсон агуулга бүхий зохицуулалт Компанийн тухай болон бусад холбогдох хуульд тусгагдаагүй байна.

1.1 Үнэнч байх үүргийн зөрчлийг тогтоох

Хувьцаа эзэмшигчид компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох нь харьцангуй бага тул хөрөнгө оруулагчид болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад ТУЗ чухал үүрэгтэй. Иймд ТУЗ-ийн гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компанийн өмнө үнэнчээр ажиллах үүргийг хүлээдэг. Үнэнч байх үүргийн хамрах хүрээ өргөн тул шийдвэр гаргах, тодорхой үйлдэл хийх бүртээ компанийн эрх ашгийн эсрэг чиглэх боломжтой эсвэл хувийн ашиг сонирхолд хамаарах эсэхийг анхаарч, компанийн эрх ашгийг тэргүүнд тавих юм.¹⁰⁶

Үнэнч байх үүргийн зөрчилтэй холбоотой нэхэмжлэлийг шүүхийн зүгээс шударга байдлын стандартын (entire fairness) дагуу үнэлдэг. Шүүх ТУЗ-ийн шийдвэр нь хуульд нийцсэн эсэхийг тогтоохоос гадна шударга бөгөөд бодит нөхцөл байдалд нийцсэн эсэхийг тогтоодог. Ийм төрлийн маргаанд хариуцагч болох ТУЗ-ийн гишүүд гаргасан шийдвэрээ бодитой, шударга болохыг нотлох үүргийг хүлээдэг байна. Үнэнчээр ажиллах үүргийн зөрчлийг тогтоох шалгуур харилцан адилгүй байдаг хэдий ч дараах шалгуурыг харгалзан үзэх нь нийтлэг байна.

- Гаргасан шийдвэр нь шударга байх (fair dealing)

¹⁰⁵ Турк улс, Арлжааны тухай хууль, § 446 .1 (d); ХБНГУ, Хувьцаат компанийн тухай хууль § 245.5

¹⁰⁶ Hasan Pulaşlı, Şirketler Hukuku Şerhi, s.1159 (2017).

- Төлбөр тооцооны үнийн дүн бодит байх (fair price)

- Ашиг сонирхлын зөрчилгүй байх (conflict of interest transactions)

- Ажил хэргийн хүрээнд олж мэдсэн компанийн нууц, бизнесийн боломжийг өөрт ашиглахгүй байх (corporate opportunities)

Бусад улс орны хувьд үнэнч байх үүрэг ба түүний төрлүүдийг харилцан адилгүй байдлаар тогтоон хуульчилсан байдаг. Манай улсын хувьд Компанийн тухай хуулийн 84.4.2-т компанийн эрх ашгийг дээдлэх, 84.4.4-т сонирхлын зөрчлөөс зайлсхийх, 84.4.5-т хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх, 84.4.6-д нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх, 87-д их хэмжээний хэлцэл хийх, 89-д сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зэрэг үнэнч байх үүргийн төрлүүдийг тусгасан байна.

ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ



Хууль зүйн доктор (Ph.D), Шихихутуг
их сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч
Б.МӨНХ-ЭРДЭНЭ

УДИРТГАЛ

1. ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХИЙН
ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ
2. ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХИЙН
ХАМГААЛАЛТ БА ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН
ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ
3. ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН
ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

ДУГНЭЛТ /САНАЛ/

НОМ ЗҮЙ

Удиртгал

Өмгөөлөгчийн хувьд хүний эрхийн тухай Олон улсын гэрээ, Үндсэн хууль, ардчилсан нийгмийн үнэт зүйлсээр амьсгалахад шууд хувь нэмрээ оруулах нөлөөтэй гэдгээрээ чухал эрх, үүрэг хүлээдэг билээ. Өмгөөлөгчийн мэргэжил нь нэг талаараа ардчилсан тогтолцооны бэлгэ тэмдэг юм.

Сүүлийн жилүүдэд өмгөөлөгч нарыг доромжлох, гүтгэх, заналхийлэх болоод хувийн орон зайд нь халдах төдийгүй ажил мэргэжлийнх нь эрхэд нөлөөлөх гэж оролдсон хууль бус үйлдлүүд нэмэгдсэн. Өмгөөлөгч хүн үйлчлүүлэгчээ жинхэнэ утгаар нь хамгаалахын тулд шаардлагатай итгэл олж авахад мэргэжлийн нууц буюу хууль эрх зүйн хүрээнд олгогддог давуу эрх нь өнөө үед олон нийтийн хяналт шалгалтын улмаас сорилтод орж байна.

Өмгөөлөгчийн мэргэжил нь шударга ёсыг хэрэгжүүлэх, хүний эрх, ардчилал, хууль дээдлэх ёсыг хамгаалахад гол үүрэг гүйцэтгэдэг. Өмгөөлөл хийх нь өнөөдөр хувь хүн болон байгууллагын хувьд мэргэжлээ бие даан, аюулгүй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, тэр байтугай аюулд өртөх эрсдэл өндөртэй, халдлагын бай болох нөхцөл тодорхой хүрээнд үүсжээ. 2020 онд Европын Зөвлөлийн Хууль

зүйн хамтын ажиллагааны Европын хороо¹⁰⁷ өмгөөлөгч нарыг ажил мэргэжлээ хараат бусаар хийхэд нь зохих түвшний хамгаалалтыг хангах боломжит арга хэмжээний талаар судалжээ.

Судалгааны үр дүнд өмгөөлөгч нарын хамгаалалтыг сайжруулах боломжтой хувилбаруудыг харгалзан Европын шинэ эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх талаар авч үзсэн байна. Судалгаанд үндэслэн 2022 оны 1-р сарын байдлаар өмгөөлөгч нарыг хамгаалах шинжээчдийн хороог байгуулав.

Хууль зүйн хамтын ажиллагааны Европын хорооны дэргэд байгуулагдсан шинжээчдийн хороо нь гишүүн орнуудын 15 төлөөлөгч, түүнчлэн батлагдсан ажлын даалгаварт заасан оролцогч, ажиглагчдаас бүрдэнэ. Тус хороо нь Сайд нарын хороо, Европын Хууль зүйн хамтын ажиллагааны хорооны эрх мэдлийн дагуу өмгөөлөгчийн мэргэжлийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хор хөнөөлгүй, хязгаарлахгүйгээр бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах үүрэгтэй юм.

Шинжээчдийн хороо нь жилд гурван удаа хаалттай хуралддаг нь өмгөөлөгч, хуульч нарын эрх зүйн хамгаалалтад хэрхэн анхаарч байгаагийн нэг тод илэрхийлэл гэлтэй. Өмгөөлөгч нь шүүхийн ажилтан биш тул төрийн захиргааны

албанд шууд харьяалагддаггүй. Энэ бол түүний бие даасан байдлын сонгодог илэрхийлэл. Энэхүү хараат бус байдал нь хэд хэдэн үзүүлэлттэй байдаг.

Энэ нь оюуны хувьд нэгдүгээрт: Өмгөөлөгч хүн хууль зүйн үндэслэл, өгсөн зөвлөгөөг хариуцах ёстой бөгөөд өөрийн ухамсарт харшлах эсвэл хараат бус байдлыг алдагдуулах магадлалтай хэргүүдээс татгалзах чадвартай байх ёстой. Хоёрдугаарт: Эдийн засгийн хувьд гэнэтийн төлбөрийн гэрээг хориглох, хуульч бус хүмүүсийн удирддаг хууль зүйн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдэд гишүүн болохыг хориглох зэрэг болно. Тиймээс өмгөөлөгч үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хамгаалж, үйлчлүүлэгч, төр, шүүхээс хараат бус байдлаа хангах ёстой.

Өмгөөлөгч ямар ч албадлагагүй үг хэлэх, хүчтэй дархлаагаар баталгаажихгүй бол шударга ёс үнэгүй үлдэнэ. Өмгөөлөгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг мэргэжлийн нууц, мөрдөн байцаалтын нууцлалыг хангах үүднээс хязгаарлаж болох бөгөөд шүүхийн бүрэн эрх, шударга байдлын баталгаагаар өмгөөлөгчийн эрх чөлөөнд зүй бусаар хөндлөнгөөс оролцсон бол шийтгэл оногдуулах ёстой¹⁰⁸. Иймд олон нийтийн мэдээлэл авах эрхийг хамгаалахад чиглэсэн шударга ёсны үйл ажиллагаа, шүүхийн үйл

¹⁰⁷ European Committee on Legal Co-operation. (CDCJ)

¹⁰⁸ ECHR case MOR c. France of 15 December 2011; ECHR case Morice / France, April 2015.

ажиллагааны талаар олон нийтэд үг хэлэх, нийтийн эрх ашгийн төлөөх мэтгэлцээнд оролцох өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт сайн байх ёстой.

Хуульчдын үүргийн үндсэн зарчмуудад¹⁰⁹ “Өмгөөлөгч нь бичгээр болон амаар мэдүүлэг өгөх, шүүх болон бусад хуулийн байгууллагад мэргэжлийн хүрээнд асуудлыг үнэнч шударгаар мэдүүлсэн тохиолдолд иргэний болон эрүүгийн эрх зүйн хүрээнд дархлаатай байх ёстой”¹¹⁰ гэж заасан байдаг.

Төрөөс хараат бус байх Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны явцад өмгөөлөгч нар шүүгдэгчдийн эрх, нийгмийн хэв журмыг сахиулах эрхэм зорилгын тэнцвэрийг хангадаг. Тэд үйлчлүүлэгчээ хамгаалах, төлөөлөхийн тулд төрийн хууль хяналтын байгууллагуудын эсрэг тодорхой хамгаалалттай, эсэргүүцэх арга хэрэгсэлтэй байх ёстой.

Хэрэв өмгөөлөгч эрх зүйн хамгаалалт сайтай байгаа бол улс төрийн эрх мэдэлд захирагдахыг эрс эсэргүүцэж чадах болно. Нөгөө талаасаа өмгөөлөгчийн эрх зүйн хамгаалалт нь үйлчлүүлэгчийн өмгөөлөгчдөө итгэх итгэлийн нэг хэсэг юм. Өмгөөлөгч нь мэргэжлийн нууц, нууцлал, ашиг сонирхлын зөрчилдөө анхаарал хандуулах болон бусад ёс зүйн дүрмийг

хүндэтгэж, тодорхой эрх зүйн хамгаалалтаар эрх нь баталгаажсан тохиолдолд шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг учир энэхүү сэдвийг анхаарч судлах хэрэгцээ шаардлага бий гэж үзсэн болно.

1. Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалтын тухай ойлголт

Аливаа улс төр, эрх зүйн тогтолцооны нэгэн чухал амин сүнс нь үр ашигтай, хараат бус шүүхийн тогтолцоотой байх явдал юм. Шүүхийн тогтолцооны хараат бус, үр ашигтай байдал нь өмгөөлөгчийн эрх, үүрэггүйгээр хэрэгжихгүй.

Аливаа нийгэмд хууль дээдлэх ёсыг тогтоох, хүний эрхийг хамгаалахад өмгөөлөгч, өмгөөллийн байгууллагын байр суурь, үүрэг оролцоог албан ёсны болон материаллаг талаас нь авч үздэг хандлага бий. Өргөн хүрээний үүднээс авч үзвэл өмгөөлөгч нь хууль дээдлэх ёсыг тогтоох, түүнийг хөгжүүлэх, хуулийн төсөл боловсруулах, шүүх хуралдаан зэрэг үе шатанд чухал үүрэг гүйцэтгэж байдаг.

Хуулийн өмнө эрх тэгш байх, хууль дээдлэх, эрх зүйн тодорхой байдал, урьдчилан таамаглах боломжтой байдал, хуулийн бодитой байдал, хууль дээдлэх төрийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг хянан үзэхэд өмгөөлөгчийн оролцоо зайлшгүй шаардлагатай бөгөөд

¹⁰⁹ 1990 оны 9-р сарын 07. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнтэй харьцах тухай НҮБ-ын наймдугаар конгрессоос гаргасан болно. Куба улсын Гавана хотод батлагдсан.

¹¹⁰ In addition, Principle 20 of the Basic Principles on the Role of Lawyers states.

эдгээр ойлголтыг хэрэгжүүлэхэд өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт чухал ач холбогдолтой.

Өмгөөлөгч нь өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбогдуулан шүүгч, прокурортой адил хуульд заасны дагуу өргөн хүрээнд эрхийн хамгаалалт эдлэхээс илүүтэйгээр үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалахтай холбоотойгоор өргөн хүрээнд үүрэг хүлээсэн¹¹¹ байдгаараа эрхийн хамгаалалтын онцлог нь оршдог. Өмгөөллийн тухай хууль, Хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн хүрээнд үүрэгт ажилтайгаа холбогдуулан хүлээх үүрэг нь өргөн хүрээнд, нарийн зохицуулагдсан нь дэвшилттэй ч өмгөөлөгчдийн эрхийг үүрэгт ажилтай нь холбогдуулан хамгаалах талаарх зохицуулалт хангалттай биш байна.

Өмгөөлөгч¹¹² нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг хуульч юм.

Өмгөөлөгч нар үргэлж сайн боловсрол, өндөр чадвартай ажиллахыг хичээж, эрх зүйн асуудлыг шийдвэрлэх арга замыг сайн мэддэг байх ёстой.¹¹³ Өмгөөлөгч нь өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбогдуулан шүүгч, прокурортой адил хуульд заасны дагуу өргөн хүрээнд эрхийн хамгаалалт эдлэх нь нэн чухал бөгөөд ганцхан өмгөөлөгч

¹¹¹ Хуульчийн ёс зүйн хууль, дүрэм, журмын эмхэтгэл, УБ хот, 2016 он.

¹¹² Латин. *advocatus*; англи. *lawyer*; *advocate*.

¹¹³ 弁護士法. 第二条 弁護士は、常に、深い教養の保持と高い品性の陶や、に努め、法令及び法律事務に精通しなければならない。

хүний эрхийн гэхээсээ давхар үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалахтай холбогддог¹¹⁴ тул хэцүү, будлаантай, ээдрээтэй нөхцөл байдалд өмгөөлөгч нь эрх зүйн хувьд хамгаалалттай байснаараа үйлчлүүлэгчийн эрхийн хамгаалалтанд эерэг нөлөө үзүүлэх боломжоор хангагдана гэсэн үг.

Өмгөөлөгчид үйлчлүүлэгчийнхээ хуультай холбоотой хүнд хэцүү асуудлыг шийдвэрлэхэд нь туслах, хамгаалах, эсвэл санхүүгийн нөхөн олговор олгох зэргээр тэдний амьдралын хамгийн хэцүү үеүдэд өмгөөлдөг.

Америкийн хуульчдын холбоо¹¹⁵ өмгөөлөгч нарын дөрөвний нэг нь эхний долоон жилийн дотор мэргэжлээ орхидог болохыг тогтоожээ. Учир нь өмгөөлөгчийн ажилтай холбоотой аюулгүй байдлын баталгаа бага ажлын ихэнх хэсэг нь ерөнхий буюу үр дүнг шууд тодорхойлох боломж бага, сэтгэл зүйн болон ахуйн дарамт нь өмгөөлөгч мэргэжлээр ажиллахаас татгалзахад хүргэдэг байна.

Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт сайн байснаараа өөрсдийн үйлчлүүлэгчтэйгээ эрт бөгөөд тогтмол уулзах боломж гарах төдийгүй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг хангахын зэрэгцээ шударга шүүхийн ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

¹¹⁴ “Өмгөөлөл судлал” эмхэтгэл, I боть, УБ хот, 2015 он.

¹¹⁵ American Bar Foundation. (ABF)

Өөрийн үйлчлүүлэгчийг цагдан хоригдох эсэхийг хэлэлцэх шүүхийн хуралдаанд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч тухайн үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх баталгааг бий болгож чадна.

Түүнчлэн хууль зүй, өмгөөллийн үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн гүйцэд сайтар хангаж, хэргийн талаарх бүхий л холбогдох баримтыг судалсан хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч нь ял оногдуулахаас сэргийлэх эсхүл ялын хэмжээг бууруулах бүрэн боломжтой.

Эдгээр жишээнүүд болон хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрүүгийн хэргийн яллагдагчийн эрхтэй холбоотой олон улсын хэм хэмжээнээс харахад эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа нь тодорхой үйл ажиллагааг эрхлэхээс гадна тодорхой үр дагаварт хүрэх тухай ойлголт юм.

Өөрөөр хэлбэл өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт бол хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч нь хууль зүйн мэргэжлийн туслалцааны шилдэг жишигтэй нийцүүлэн өөрийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэн, улмаар шударга үр дагаврыг авчирч чанарын өндөр төвшинд хууль зүйн мэргэжлийн туслалцааг үйлчлүүлэгчдээ хүргэх чанарын баталгааг хангах нэгэн боломжийг бий болгоно.

2. Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт ба үйлчлүүлэгчийн эрх зүйн байдал

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийг баривчлагдах эсхүл баривчлагдсан, цагдан хоригдсон даруйд, аливаа байцаалтыг авахаас өмнө цаг алдалгүй уулзах, өмгөөлөгчөөр томилогдсоноос хойш 24 цагийн дотор үйлчлүүлэгчтэй уулзаж ярилцах нь чухал гэж үздэг. Энэ нь үйлчлүүлэгч төвтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчид бүрэн гүйцэд мэдээлэл зөвлөгөөг өгч, хэрэгт холбоотой чухал шийдвэрийг гаргахад туслалцаа үзүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг¹¹⁶.

Шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх эрхийг хангах. хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч шүүхийн өмнөх шатанд баривчлагдах, цагдан хоригдохоос сэргийлж, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан бол суллах арга хэмжээг аль болох цаг алдалгүйгээр авч ажиллах, хараат бус байдлаар үйл баримтыг судлан шинжих нөхцөлийг бүрдүүлэхэд оролцох, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч бие даасан хэлбэрээр үйл баримтыг судлан шинжлэх арга хэмжээг авах нь өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт хэр зэрэг хангагдсан эсэхээс ихээхэн хамаарна.

¹¹⁶ Япон улсын Хуульчдын Холбооны албан ёсны цахим хуудас: <https://www.nichibenren.or.jp/>

Хэрэв өмгөөлөгч нь тодорхой эрхийн хүрээнд хэргийн газар очиж танилцах, боломжит бүх гэрчүүдтэй уулзаж ярилцах, бэлтгэл ажлыг сайтар хангах цаг хугацаа өгөгдсөн тохиолдолд үйлчлүүлэгчтэйгээ уялдаа холбоотой иж бүрэн цогц хэргийн төлөвлөгөө, стратегийг боловсруулж, шүүх хуралдаан тус бүр оролцох бэлтгэл ажлыг сайтар хангах боломжоор хангагдана гэсэн үг. Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт тухайн улс оронд эрх зүйн зохицуулалтын хүрээнд болоод практикт хангагдаж чадсан тохиолдолд өмгөөлөгч нь өөртөө бүрэн итгэлтэйгээр тодорхой, оновчтой, хүчтэй үндэслэлүүдийг гаргаж, хууль болон үйл баримтуудыг зөв хэрэглэх, гэрчүүдэд зүй зохистой, оновчтой асуултыг тавих, ял оногдуулах бүх нөхцөл байдалд оролцох, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх, хамгийн бага эрүүгийн хариуцлагыг оногдуулах нөхцөлийг судлах, үйлчлүүлэгчийг хамгаалах, боломжтой бол эрүүгийн хариуцлага дундаас сонгох боломжийг шүүгчид бий болгож хамгийн бага ялыг оногдуулах боломжийг танилцуулахдаа бие даасан эрх хэмжээтэй байхаас гадна хэргийг цаг алдахгүйгээр давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн байж болзошгүй бүхий л асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хөндөж танилцуулах нөхцөл бололцоо бий болно.

Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт ба үйлчлүүлэгчийн эрх зүйн байдалд дараах гурван гол асуудал хөндөгдөж байна. Үүнд:

1. Эрт төлөөлөх
2. Үйлчлүүлэгч төвтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх
3. Шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх¹¹⁷

Өмгөөлөгч үйлчлүүлэгчийг баривчлагдсанаас хойш цаг алдалгүй төлөөлж, түүнтэй ганцаарчлан уулзаж, хэрэгт ач холбогдол бүхий зөвлөгөөг өгснөөр өөрийн үйлчлүүлэгчийн зорилго, амьдрал, гэр бүл, хувийн байдалтай илүү сайн танилцах боломж бүрддэг¹¹⁸.

Энэ нь эргээд үйлчлүүлэгчийн гэр бүл, хувийн ба нийгмийн байдал болон хэргийн нөхцөл байдалд тулгуурлан түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаас сэргийлэх эсхүл суллагдах нөхцөлийг бүрдүүлэх, үйлчлүүлэгчид эрхийг нь тайлбарлаж, цагдаагийн газар мэдүүлэг өгөх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр гарч болох эрхийн зөрчил, эрсдэлээс сэргийлж хамгаалах, үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд суллах арга хэмжээг хамгийн боломжит эрт ба хэргийн бүхий л хугацаанд авч ажиллах үүрэгтэй тул түүнийгээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангагдах зэрэг ач холбогдолтой.

¹¹⁷ Олон Улсын эрх зүйн сан. “Шударга ёсыг үнэлэх нь Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн тусалцаа үзүүлэгчийн чанарыг тодорхойлж, үнэлгээ өгөх нь” УБ., 2016 он. 22-р тал.

¹¹⁸ Мөн тэнд. 23-р тал.

Өмгөөлөгч материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг ур чадвар, туршлагадаа тулгуурлан зөв ба оновчтой хэрэглэх замаар үйлчлүүлэгчид ашигтай байж болохуйц бүхий л гомдол, хүсэлтийг цаг тухайд нь гаргах үүрэгтэй тул мөрдөн байцаалтын ажиллагаа дууссан бол үүнийгээ өмгөөлөгчид албан ёсоор мэдэгдэж, тэмдэглэл үйлдэж, хэргийн материалтай боломжтой хугацаа олгож танилцуулах нь өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт сайжрах үндэслэл юм.

Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалт үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд шүүн таслах ажиллагаа явагдахаас өмнө өмгөөлөх ажиллагаанд зориулж тодорхой хугацааны өмнө мэдэгдсэн байх ёстой.

Түүнчлэн өмгөөлөгчид улсын яллагчтай эрх тэгш байдлаар шүүх хуралдаанд оролцох боломжийг хууль эрх зүйн хүрээнд олгох, өмгөөлөгчид шүүгдэгчид чанартай хууль зүйн туслалцаа, өмгөөлөл үзүүлэхэд бэлтгэх хангалттай хугацаа олгодог болох, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, хугацааны талаарх мэдээлэл гаргаж өгөх¹¹⁹, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төлбөр төлөгчөөс төлбөр барагдуулах талаар удаашралтай хэргийн үндэслэл, шалтгаан,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан ямар ажиллагаа гүйцэтгэсэн болох, төлбөр төлөгчийн эд хөрөнгийг эрэн сурвалжилсан эсэх талаарх мэдээллүүд болон эд хөрөнгө үнэлж буй шинжээчийг ямар журмын дагуу томилдог талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгдөг болох нь өмгөөллийн эрхийн хамгаалалтыг сайжруулж үйлчлүүлэгч иргэдийн эрхийг нь хамгаалах бололцоог дээшлүүлэх нөхцөлөөр хангах юм.

Прокурорын даалгаварт ямар ажиллагаа гүйцэтгүүлэх талаар тусгагдсан мэдээллүүд, хэргийн материалд прокурорын даалгаврыг оруулдаг болох, тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх хугацааны талаарх мэдээллүүд, тухайн хэргийг шалгаж буй шүүгчийн хувийн байдлын талаарх мэдээллүүд ил байх¹²⁰, үйлчлүүлэгчийнхээ хэрэг дээр ажиллаж байгаа мөрдөн байцаагч, прокурор, шийдвэр гүйцэтгэлийн ажилтнуудтай утсаар холбогдон бие биеийнхээ ажилд хүндэтгэлтэй хандаж, уулзалтын цагийг товлон зэрэг асуудал дээр хүнд суртал гаргуулахгүй байх, өргөдөл гомдлын дугаар, хэргийн дугаар болоод мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа болон тус ажиллагаанд хяналт тавьж байгаа албан тушаалтны нэр, цол зэрэг албаны мэдээлэл, хэргийн

¹¹⁹ Өмгөөлөгч биечлэн цагдаагийн байгууллагад очиж лавлахаас бусад тохиолдолд мэдээлэл авахгүй байх тохиолдол их байна.

¹²⁰ Өмгөөлөгч нь шүүгчийг хэргийн оролцогчтой төрөл садангийн холбоотой гэдгийг мэдэх ямар ч боломжгүй байна. (Шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлт гаргахад ач холбогдолтой)

ажиллагааны дүр зургийн талаарх холбогдох бусад мэдээллийг цаг алдахгүй авдаг байхаас авахуулаад эсрэг тал нь өмгөөлөгчийг татгалзах санал хүсэлт гаргасан, өөр өмгөөлөгч авсан талаар цаг даруйд нь мэдээлдэг байх зэрэг асуудлуудыг шийдэх нь өмгөөлөгчийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулна. Түүнчлэн өмгөөлөгч нар олон улсын байгууллагууд, түүний дотор хүний эрх зөрчигдсөнтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, авч хэлэлцэх чадамж бүхий олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай саадгүй харилцаа холбоо тогтоох эрхээ эдлэх бололцоогоор хангагдах ёстой.

3. ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмгөөлөгч нь хэнээс ч хараат бус байх учиртай тул өмгөөлүүлж буй харилцаанаас өөр байдлаар үйлчлүүлэгчийн ажил хэргээс татгалзах нь нээлттэй. Түүнчлэн үйлчлүүлэгчийн тайлбар, бичиг баримт худал байсан нь илэрмэгц бусад нөхцөл байдлыг огт харгалзахгүйгээр үргэлжлүүлж үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хуулиар зөвшөөрөх ёстой. Үйлчлүүлэгч болон өмгөөлөгч хоорондын байгуулсан гэрээ нь төлбөрт итгэмжлэлийн гэрээ тул гэрээний урьдчилгааг өгөхгүйгээр гэрээг чөлөөтэй цуцлах

боломжтой байх ёстой. Япон улсын Өмгөөлөгчийн тухай хуулийн 73 дугаар зүйлд “хэн ч өөр хүний эрхийг шүүн таслах, эвлэрүүлэн зуучлах болон бусад аргаар эдэлж болохгүй” гэсэн заалт бий.

Мөн хуулийн 74 дүгээр зүйлийн

1-т “Өмгөөлөгч, хуулийн фирм нь өөрсдийн тэмдэглэгээ, тайлбартаа хариуцлага хүлээх ёсгүй,

2-т Өмгөөлөгч, хуулийн фирм биш бол ашиг олох зорилгоор хууль зүйн зөвлөгөө өгөх болон хууль эрх зүйн бусад ажил эрхэлж байгаа мэт мэдэгдэл хийх ёсгүй.

3-т Өмгөөлөгч биш хүн өөрийн нэр дээр хуулийн фирм эсвэл түүнтэй ижил төстэй нэрийг ашиглах ёсгүй” гэж заасан нь өмгөөлөгч нь дээрх хуульд заасан хангалттай шалтгаан бүхий этгээдээр үйлчлүүлэгчийг зуучлуулах, эдгээр этгээдийг хуульчийн нэр барихаас сэргийлэх болон нэр төрөө ашиглуулж болохгүй гэсэн хамгаалалт юм.

Өмгөөлөх эрхгүй хүнд өөрийн нэр болон эрхээ ашиглуулах асуудал гардаг. Түүнчлэн нэн төвөгтэй буюу өөрийн мэдлэг чадвараар өмгөөлөх боломжгүй хэрэг авч үйлчлүүлэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, олон хэргийг нэг дор авч хүндрэл бэрхшээл үүсгэж үйлчлүүлэгч нартаа худал баримт үзүүлэх байдлаар шүүх хуралдааныг хойшлуулах зэрэг асуудлууд нь өмгөөлөгчийн эрхийн хамгаалалтад сөргөөр нөлөөлдөг. Өмгөөлөгч нь мэргэжлийн бус үйл ажиллагаа явуулж буй

этгээдтэй хэлэлцээр хийх нь эрхийн хамгаалтанд нь сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр.

Учир нь эсрэг талаас нь өмгөөлөгч авахгүйгээр мэргэжлийн бус хүнээр хэлцэл хийлгэх нь асуудлыг үнэн зөвөөр шийдвэрлэх хугацааг удаашруулж өмгөөлөгчийн өөрийнх нь үйлчлүү-лэгч хохирох эрсдэл үүсдэг. Америкийн Нэгдсэн Улсын Хуульчдын нийгэмлэгийнх нь дүрэмд “өмгөөлөгч эсрэг талтай уулзах үедээ тэгш шударга харилцах ёстой ба зүй бус битүү сануулга, дохио өгч болохгүй. Эсрэг тал буруу ташаа ойлголттой байгааг мэдсэн, эсвэл мэдэж авах боломжтой тохиолдолд тухайн буруу ташаа ойлголтыг залруулахыг төлөө чармайн ажиллах хэрэгтэй”¹²¹ гэжээ. Энэ мөн л аль ч талд шударгаар ажиллах нь өмгөөлөгчийн эрхийн нэгэн хамгаалалт гэсэн агуулгаар хуульчлагдсан байна.

Өмгөөлөгчийн хэрэгт анхаарал тавих үүргийг хэт хатуу чанга болговол зохих этгээд нь хариуцлагаас чөлөөлөгдсөн ч гэлээ өмгөөлөгчид хариуцлага тооцох, өмгөөлөгчийн алдаа гэсэн ойлголт нийтэд түгэх, цаашлаад мөрдөн шалгах болон бусад төрлийн албаны ажилтнуудын зүй бус үйлдэл дээр үндэслэсэн өмгөөлөгчийн эсрэг мэдэгдлийг шүүхэд тэдний эсрэг ашиглах ёсгүй. Өмгөөлөгчдийг төрийн албан хаагч болон төрийн

бус байгууллагын дарамт шахалтаас сайтар хамгаалах хэрэгтэй. Шүүхээр шүүлгэж буй этгээд, өмгөөлөгч нарын хооронд солилцсон мэдээллийн нууцлалыг бүрэн баталгаажуулах ёстой. Нэг өмгөөлөгчид хэдэн хэрэг ногдож байна? хэргийн хүнд, ярвигтай байдал болон ажлын ачаалал нь хуульчийн туршлагатай нийцэж байгаа эсэх? хуульчийн үйл ажиллагааны улмаас ямар төрлийн үр дүн бий болж, үйлчлүүлэгчид ямар үр дагавар очиж байгаа вэ? зэрэг асуултуудад хариулт өгч, бид өмгөөлөгч нарын үйл ажиллагааг анхаарах нь эргээд эрхийн хамгаалалтыг сайжруулах үндэс болдог. Өмгөөлөгчийн эрхийн хамгаалалттай холбоотой дотоодын хууль эрх зүйн тогтолцоо, өөрсдийн үйл ажиллагааны хууль ёсны байдлыг олон улсын хүний эрхийн стандарттай жишиж хянах шаардлагатай байна.

Цаашлаад хүний эрх, хуульч нарын эрхийг өргөн хүрээнд, үр дүнтэй зөвлөлдөж, энэ талаар олон улсын дэмжлэг туслалцаа авах хэрэгтэй¹²². Олон улсын стандартын дагуу хамгаалагдсан үйл ажиллагааны төлөө шууд болон шууд бус замаар гэмт хэрэгт буруутгаж байгаа хуулийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгох нь зөв. Өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой өргөн агуулгатай, салаа утгатай тайлбар

¹²¹ Моригива Ясүтомо. Хуульчийн ёс зүй. УБ., 2007 он. 139-р тал.

¹²² New York City Bar Association Releases Statement of Pro Bono Principles.' Retrieved 2 June 11. 2007.

бүхий хуулийн заалтууд нь тэдний хүний эрхийн үйл ажиллагааных нь төлөө шүүхэд буруугаар ашиглагдаж болзошгүй учир тэдгээрт нэн даруй нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгох, хууль, шүүн таслах ажиллагааг өмгөөлөгч нарын эсрэг хэрэглэж айлган сүрдүүлэх, дарамтлах, мөрдөж хавчих эсвэл хариу арга хэмжээ авах зорилгоор ашиглах ёсгүй.

Япон улсад Гадаадын хуульчдын хууль эрх зүйн харилцааг зохицуулах тухай тусгай арга хэмжээний тухай хууль¹²³ гэж бий. Энэхүү хууль нь гадаадын хууль тогтоомжтой холбоотой хууль эрх зүйн харилцааг зохицуулах боломжийг нээж өгөхийн зэрэгцээ хуульчийн жишгээр хууль, эрх зүйн харилцааг зохицуулах, гадаад эрх зүйн харилцааг тогтворжуулах, эдийн засгийн харилцааг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилготой төдийгүй гадаад улсын болон дотоодын хуульч, өмгөөлөгч нарын эрх зүйн нэгэн хамгаалалт болж өгдөг. Түүний дээр өмгөөлөгч, гадаадын хуульчдыг ажилчин болгож, хуулийн үйл ажиллагаа явуулах зорилгоор хуульч, гадаадын хуульч хамтарсан корпорацын тогтолцоог байгуулах нөхцөлийг хангах боломж бүрддэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт жагсаасан дараах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр

бус шүүгчийн зөвшөөрлөөр явуулахаар өөрчлөх¹²⁴ хэрэгтэй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад яллах болон өмгөөлөх тал тэгш эрхтэй гэсэн эрүүгийн эрх зүйн чухал зарчим байдаг. Энэ зарчим зөвхөн тухайн хэрэг шүүхэд шилжсэний дараа хэрэгжих нөхцөл байдал үүссэн. Гэтэл хэрэг бүртгэх, мөрдөн шалгах үе шатанд ямар ч тэгш эрхийн баталгааг хуульчлаагүй. Тухайлбал ЭХХШТХ¹²⁵-аар мөрдөгч, прокурор нь яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй гэж заасан. Гэвч прокурор хэргээ шүүх дээр авч орж ирэхдээ улсын яллагч гэсэн байр суурин дээрээ хатуу зогсдог. Улсын яллагч хийх

¹²⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3-т Мөрдөгч үзлэгийг нууцаар хийх, нэгжлэг хийх, эд зүйл, баримт бичиг хураан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, оршуулсан цогцсыг гарган шинжлэх, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

¹²⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.

¹²³ 外国弁護士による法律事務の取扱いに関する特別措置法.

прокурор маань цагаатгах талын баримт цуглуулах нь практикт ховор төдийгүй прокуророос цагаатгах нотлох баримтыг шаардах нь бодитой биш юм. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой аливаа үйлдэл хийхэд өмгөөлөгч, прокурор хоёрын санал зөрөлдвөл шүүхэд очиж хагалуулдаг хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна. Аливаа хэрэг гарахад мөрдөгчид тухайн иргэнийг дуудаад гэрчээр мэдүүлэг авдаг. Мэдүүлэг авахдаа “Худал ярих юм бол эрүүгийн хариуцлага хүлээнэ”¹²⁶ гэж анхааруулаад авдаг. Тэгснээ дараа нь нөгөө хүнээ өөрийнх нь өгсөн мэдүүлгийг үндэслээд яллагдагчаар татчихдаг асуудал нь өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрхийн төлөө ажиллахад асуудал дагуулж байна. “Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхтэй” гэсэн заалт бий. Гэтэл 461-р хорих ангид уулзалтын үеэр үйлчлүүлэгчдээ дээрх эрхийн дагуу ганцаарчлан уулзах боломж хязгаарлагдмал гэж өмгөөлөгч нар хэлдэг. Ганцаарчлан уулзана гэдэг нь гадны ямар нэгэн хяналтгүйгээр уулзахыг хэлдэг тул байнгын хяналт дор уулзах ёсгүй. Тиймээс энэхүү буруу практикийг хориглосон хуулийн заалт оруулах шаардлагатай. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч болон прокурор нь шүүх танхимд эн тэнцүү байр сууринд суудаг болох хэрэгтэй. Шүүх танхимд

прокурор урд сууснаар өмгөөлөгчөөс ямар давуу эрх эдэлж байгаа вэ гэдэгтэй энэ асуудал холбогддог. Зарим тохиолдолд шүүх хуралдаанд шүүгч, прокурор хоёр нийлчхээд яллагдагч, түүний өмгөөлөгч рүү дайрах үзэгдэл гардаг. Нөгөө талаар энэ нь тэгш бус байдлыг илэрхийлэл гэж үзэх боломжтой.

Дүгнэлт

Өмгөөлөгч нарт учирч болзошгүй хуулийн дарамтыг хянах зорилгоор хууль сахиулах болон шүүхийн байгууллагын ажилтнуудын хяналтын тогтолцоог бий болгох асуудал цаашид яригдах цаг нь болсон. Түүнчлэн шүүх эрх мэдэл болон хууль сахиулахын салбарт эрх мэдлээ урвуулан ашиглах эсвэл хээл хахуульд автах бололцоог бүрдүүлж буй тогтолцоо, бүтцийн хийдлийг авч хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай. Хүний эрхийн зөрчлийг эсэргүүцэж үг хэлсэн, хуульч, өмгөөлөгчийг айлган сүрдүүлэх, дарамт үзүүлэх, сахилгын арга хэмжээ авах эсвэл тэдний ажлын байртай холбоотой бусад дарамж шахалт үүсэхээс хамгаалах ёстой. Ялангуяа шүүх болон сахилгын арга хэмжээ оногдуулах эрх бүхий байгууллага өмгөөлөгчийг хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулах эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэх хэмжээний шийтгэлийн арга хэмжээ авч болохгүй. Түүнчлэн шүүх хуралдааны танхимын гадна болон

¹²⁶ Эрүүгийн хууль. 2015 он. ЭХ-ийн 21.2 дугаар зүйл. Худал мэдүүлэх гэмт хэрэг.

дотор өмгөөлөгчийн бие махбод, хувь хүний халдашгүй байдлыг бүрэн хамгаалах ёстой. Хүний эрхийн хүрээнд ажилладаг өмгөөлөгчид хүний эрх хамгаалснаасаа эсвэл хүний эрхийг хамгаалагчдыг өмгөөлснөөсөө хуульчдын гишүүнчлэлээсээ хасагдах, айлган сүрдүүлэлтэй тулгарах эсвэл аливаа хариу арга хэмжээнд өртөх ёсгүй.

Дэлхий даяар өмгөөлөгчдийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах асуудал идэвхтэй яригдаж байгаа бөгөөд ажлаа хийх үедээ заналхийлэлд өртөх, шоронд хоригдож, гэмтэж бэртэж, амь насаа алддаг тохиолдол гарсаар байна.

Хятадад сүүлийн жилүүдэд хүний эрхийн олон зуун хуульч, өмгөөлөгч баривчлагдсан бөгөөд тэдний ихэнх нь одоог хүртэл нууцлагдмал газар хоригдож үлджээ. Курдын идэвхтнүүдийг өмгөөлөхөд оролцсон өмгөөлөгчдийг терроризмын эсрэг хуулийн дагуу шүүдэг Турк улс болон Саудын Арабд өмгөөлөгч иргэний эрх чөлөөг хамгаалсныхаа төлөө олон жил шоронд хоригдох эсвэл хамгийн хүнд шийтгэл хүлээдэг буруу тогтолцоо амь бөхтэй байна. Ардчилсан улсуудад хэдийгээр шууд хорьж цагдах нь бага ч эрх зүйн хүрээнд болоод практикт хамгаалалт хангалтгүй гэж үзэх олон үндэслэл бий. Өмгөөлөгч хүн нь эрх зүйт ёсны бодит хэрэгжилтийг хангагч гэдгийг чухалчилж эрх зүйн хамгаалалтыг хангаж өгөхийг ардчилсан улс болгон анхаардаг.

Санал

1. Эрүүгийн хэрэгт өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлэхэд өмгөөлөгч тодорхой төрлийн үйлдэл хийж, түүнийгээ баримтжуулж байх нь үйлчилгээний чанарт хяналт тавих, түүний ажлыг үнэлэхээс гадна эрх зүйн хамгаалалтын нэг хэсэг болох боломжтой

2. Аливаа хэрэг гарахад мөрдөгчид тухайн иргэнийг дуудаад гэрчээр мэдүүлэг авдаг. Мэдүүлэг авахдаа “Худал ярих юм бол эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэж анхааруулж байгаад өөрийнх нь эрхийг зөрчдөг. Дараа нь нөгөө хүнээ өөрийнх нь өгсөн мэдүүлгийг үндэслээд яллагдагчаар татчихдаг асуудлыг шийдэхгүйгээр өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрхийн төлөө ажиллахад бодит асуудал дагуулж байгаа төдийгүй өмгөөлөгчийн эрхийн хамгаалалтанд халдсан гэж үзэх боломжтой тул дээрх агуулгыг хууль зүйн талаас нь болон практик хэрэглээнд засаж залруулах

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт жагсаасан ажиллагаануудыг прокурорын зөвшөөрлөөр бус шүүгчийн зөвшөөрлөөр явуулахаар өөрчлөх

4. Америкийн Нэгдсэн Улсын Хуульчдын нийгэмлэгийнх нь дүрэмд “өмгөөлөгч эсрэг талтай уулзах үедээ тэгш шударга харилцах ёстой ба зүй бус битүү сануулга, дохио өгч болохгүй. Эсрэг тал буруу ташаа

ойлголттой байгааг мэдсэн, эсвэл мэдэж авах боломжтой тохиолдолд тухайн буруу ташаа ойлголтыг залруулахыг төлөө чармайн ажиллах хэрэгтэй” гэсэнтэй ижил заалтыг Өмгөөллийн тухай хуульд оруулах. Энэ нь аль ч талд шударгаар ажиллах нь өмгөөлөгчийн эрхийн нэгэн хамгаалалт гэсэн агуулгаар хуульчлагдах нөхцөлийг бүрдүүлнэ

5. Япон улсад өмгөөлөгч нь патентын итгэмжлэгдсэн төлөөлөгч, татварын мэргэшсэн төлөөлөгч хийх боломжтой. Түүнчлэн гадаадын хуульчдын хууль эрх зүйн харилцааг зохицуулах тухай тусгай арга хэмжээний тухай хууль гэж бий. Энэхүү хууль нь гадаадын хууль тогтоомжтой холбоотой хууль эрх зүйн харилцааг зохицуулах боломжийг нээж өгөхийн зэрэгцээ хуульчийн жишгээр хууль, эрх зүйн харилцааг зохицуулах, гадаад эрх зүйн харилцааг тогтворжуулах, эдийн засгийн харилцааг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилготой төдийгүй нөгөө талдаа дотоодын болон гадаадын өмгөөлөгч нарын эрх зүйн хамгаалалт болж өгдөг. Энэ жишгээр эрх зүйн зохицуулалтыг манай улс ч гэсэн боловсронгуй болгох боломжтой

6. Өмгөөлөгч практикт ямар төрлийн хэрэг, маргаан зонхилж байгааг өөрийн өмгөөллийн туршлага дээр үндэслэн тодорхойлж, тэдгээрийн гол шинж, иргэд хэргийн холбогдогч, гэрч, хохирогч болж байгаа байдал, ер нь иргэдийн эрх

зөрчигдөж байгаа ямар нуугдмал тохиолдлууд байж болох талаар зааж сургана. Ийм сургалт жилд 2 удаа хийдэг байх

7. Өмгөөлөгч, хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг хуульчдыг тохиолдсон хэргийг цаг тухайд нь шийдээгүй зэрэг ажил үүрэгтээ алдаа гаргасан тохиолдолд зохих хэмжээний хариуцлага хүлээлгэдэг байх. Тухайлбал Австрали, Англи зэрэг орнууд буруу зөвлөгөө өгснийх нь төлөө өмгөөлөгч, хуульчдыг тухайн хэргийн шүүхээс гадна өөр шүүхэд өгөх боломжтой байдаг. Энэ нь эргээд өмгөөлөгч нарыг хариуцлагатай ажиллах нөхцөлөөр хангахаас гадна нийт олонх өмгөөлөгч нарын нэр хүндийг хамгаалах зохицуулалт болж өгдөг давуу талтай тул дээрх жишгийг нэвтрүүлэх

8. Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхийг бүрэн хангаж өгөх. Ганцаарчлан уулзана гэдэг нь гадны ямар нэгэн хяналтгүйгээр уулзахыг хэлдэг тул байнгын хяналт дор уулзах ёсгүй. Тиймээс энэхүү буруу практикийг хориглосон хуулийн заалт оруулах шаардлагатай. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч болон прокурор нь шүүх танхимд эн тэнцүү байр сууринд суудаг болох хэрэгтэй. Нөгөө талаар энэ нь тэгш бус байдлыг илэрхийлэл гэж үзэх үндэслэлтэй тул дээрх байдлыг халах

9. Прокурорын даалгаварт ямар ажиллагаа гүйцэтгүүлэх талаар

тусгагдсан мэдээллүүд, хэргийн материалд прокурорын даалгаврыг оруулдаг болох, тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх хугацааны талаарх мэдээллүүд, тухайн хэргийг шалгаж буй шүүгчийн хувийн байдлын талаарх мэдээллүүд ил байх, үйлчлүүлэгчийнхээ хэрэг дээр ажиллаж байгаа мөрдөн байцаагч, прокурор, шийдвэр гүйцэтгэлийн ажилтнуудтай утсаар холбогдон бие биеийнхээ ажилд хүндэтгэлтэй хандаж, уулзалтын цагийг товлох зэрэг асуудал дээр хүнд суртал гаргуулахгүй байх, өргөдөл гомдлын дугаар, хэргийн дугаар болоод мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа болон тус ажиллагаанд хяналт тавьж байгаа албан тушаалтны нэр, цол зэрэг албаны мэдээлэл, хэргийн ажиллагааны дүр зургийн талаарх холбогдох бусад мэдээллийг цаг алдахгүй авдаг байхаас авхуулаад эсрэг тал нь өмгөөлөгчийг татгалзах санал хүсэлт гаргасан, өөр өмгөөлөгч авсан талаар цаг даруйд нь мэдээлдэг байх зэрэг асуудлуудыг шийдэх нь өмгөөлөгчийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах боломжийг бүрдүүлэх тул дээрх асуудлуудыг цаг алдалгүй хэрэгжүүлэх

10. Өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой өргөн агуулгатай, салаа утгатай тайлбар бүхий хуулийн заалтууд нь тэдний хүний эрхийн үйл ажиллагааных нь төлөө шүүхэд буруугаар ашиглагдаж

болзошгүй учир тэдгээрт нэн даруй нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгох, хууль, шүүн таслах ажиллагааг өмгөөлөгч нарын эсрэг хэрэглэж айлган сүрдүүлэх, дарамтлах, мөрдөж хавчих эсвэл хариу арга хэмжээ авах зорилгоор ашиглахгүй байх.

НОМ ЗҮЙ

I. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Эрүүгийн хууль. 2015 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012 он
5. Өмгөөллийн тухай хууль. 2019 он

II. Ном, сурах бичиг

1. Хуульчийн ёс зүйн хууль, дүрэм, журмын эмхэтгэл, УБ хот, 2016 он
2. “Өмгөөлөл судлал” эмхэтгэл, I боть, УБ хот, 2015 он
3. Олон Улсын эрх зүйн сан. “Шударга ёсыг үнэлэх нь Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн чанарыг тодорхойлж, үнэлгээ өгөх нь” УБ., 2016 он
4. Моригива Ясутомо. Хуульчийн ёс зүй. УБ., 2007 он

III. Гадаад эх сурвалж

1. ECHR case MOR c. France of 15 December 2011; ECHR case Morice / France, April 2015
2. ABA Model Rule 6.1 Voluntary Pro Bono Service.’ Pro Bono and Public Service. Retrieved 2 10. June 2007

3. New York City Bar Association
Releases Statement of Pro Bono Principles.’
Retrieved 2 June 11. 2007

4. 弁護士法. 1933年.

5. 外国弁護士による法律事務の取扱いに関する特別措置法. 1986年.

6. なぜ弁護士会の会費は世界一高いのか？
(黒猫のつぶやき)

7. 弁護士はどんな仕事をしているの？”. 日
弁連子どもページ. 2021年7月30日閲覧。

8. Цахим эх сурвалж

Япон улсын Хуульчдын Холбооны албан
ёсны цахим хуудас:[https://www.nichibenren.
or.jp/](https://www.nichibenren.or.jp/)

Америкийн Нэгдсэн улсын Хуульчдын
Холбооны албан ёсны цахим хуудас: [https://
www.americanbarfoundation.org/index.html](https://www.americanbarfoundation.org/index.html)

**ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ХУУЛИЙН
ТОДОРХОЙ БОЛОН ТОДОРХОЙ БУС БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ**



Хууль зүйн докторант, Шихихутуг
их сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн ахлах багш
Х.ОДОНТУЯА



Бизнесийн удирдлагын докторант,
Шихихутуг их сургуулийн Удирдахуйн
ухааны тэнхимийн эрхлэгч
Г.ГАНТӨГС

Оршил

**Үндсэн хуулийн хяналтын
тогтолцоо хуулийн тодорхой
болон тодорхойгүй байдалд
нөлөөлөх нь**

1.1. Үндсэн хуулийн хяналтын загвар, тогтолцоо ба харьцуулалт, онцлог, чиг хандлага

1.2. Үндсэн хуулийн тогтолцооны төрөл нь хуулийн тодорхой болон тодорхойгүй байдалд нөлөөлөх нь, тэдгээрийг даван туулах арга зам

Дүгнэлт

Хураангуй:

Энэхүү сэдвийн хүрээнд үндсэн хуулийн процессын эрх зүйн үндсэн хуулийн хяналтын тогтолцооны төрөл болох төвлөрсөн болон төвлөрсөн бус хяналтыг харьцуулан

судалснаар улс орнуудын үндсэн хуулийн хяналтын тогтолцоо, түүний хяналтын хэлбэр болох загварын сонголтын үндэслэл, шалгуур, тогтолцооны төрлийн давуу болон сул талыг авч үзэхээс гадна үндсэн хууль хэрэглээний ойлгомжгүй болгож болзошгүй болох хууль зүйн тодорхой болон тодорхойгүй бус байдал нь тогтолцооны төрөл сонголтоос хамаардаг мөн хэрхэн нөлөөлдөг эсэхийг үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжлийн чиг хандлагаар, харьцуулан судлан, цаашилбал, хуулийн тодорхой бус байдлыг түүнийг даван туулах арга замыг тодорхойлон, дүгнэн авч үзэв.

Түлхүүр үг:

Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо буюу систем, *Үндсэн хуулийн төвлөрсөн ба төвлөрсөн*

бус хяналт, Үндсэн хуулийн хяналтын хэлбэр буюу загвар / модель/, хуулийн тодорхойгүй байдал (legal uncertainty), хуулийн тодорхой байдал, өмнөх шийдвэрээр тогтоосон хууль ёсны жишгийг дагахыг шүүхийг үүрэг болгосон хууль зүйн сургаал (stare decisis), *Үндсэн хуулийн өөрчлөлт, хувьсал, Шүүгчийн тусгай санал / Dissenting opinion/*

Оршил

Үндсэн хуулийн хяналтын тогтолцооны талаар харьцуулсан судалгааны чиглэлээр сонгон судлахдаа түүний хяналтын тогтолцооны асуудал нь эрх зүйн бүл, тэдгээрийн ямар эрх зүйг чухал гэж тооцож буйгаасаа хамаарах, хамаарахгүй үр дагаврыг эрх зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх, цаашилбал үндсэн хуулийн хяналтын тогтолцооны хэлбэрийн загвар нь ямар хяналтын тогтолцоонд хамаарах, тэдгээрийн онцлог, ялгаа нь орчин үеийн үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжлийн чиг хандлагаар үндсэн хуулийн хяналтын тогтолцооноос нь хамааран тухайн улсын хуулийн тодорхой бус байдалд нөлөөлдөг, нөлөөлдөггүйн учир шалтгааныг тайлбарлан, түүнийг даван туулах шийдэл эрэлхийлэх нь энэхүү илтгэлийн зорилго билээ.

1.1 Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо ба харьцуулалт, онцлог, чиг хандлага

Үндсэн хуулийг заавал дагаж мөрдөх ёстой гэж байгаа бол түүнийг нь хамгаалах ямар нэг арга хэрэгсэл байх ёстой. Үндсэн хуульд харшилсан үйлдэл, шийдвэр гарсан тохиолдолд Үндсэн хуулийн хяналтаар дамжин хэрэгжих нь ойлгомжтой юм.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн хяналт нь Үндсэн хуульд ёс болон хууль ёсны эрх хамгаалалтын арга хэмжээний дээд төрөл юм. Онолын түвшинд Үндсэн хуулийн хяналтыг өргөн утгаараа шүүхийн журмаар Үндсэн хуулийг хамгаалах зорилгоор Үндсэн хуулийн хэрэг, маргааныг шийдвэрлэх асуудал хэмээн ойлгож болно. Явцуу утгаараа Үндсэн хуулийн хяналт нь Үндсэн хуульд ердийн хууль, эрх зүйн акт нийцэж байгаа эсэхийг үнэлж хянахыг ойлгодог.¹²⁷ (Цогтоо., 2019)

Дэлхийн улс орнуудын үндсэн хуулиудад үндсэн хуулийн дагнасан шүүх эсвэл ердийн шүүхийн харьяаллын шүүхээр хянах гэсэн хоёр төрлийн хувилбарыг боловсруулсан байдаг.

Мөн эдгээр хоёр хувилбарыг хольсон загвар ч бий болсон бөгөөд түүнийг “эрлийз” буюу “hybrid” гэж нэрлэх болжээ. Үндсэн хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн эрин үед үндсэн хуулийн хяналтын асуудлыг

¹²⁷ Ш.Цогтоо. Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй. УБ..2019.89 дэх тал.

загварынх нь мөн чанар, эрх зүйн тогтолцооноос нь эхлэн зөв тодорхойлон гаргаж ирснээр эрх зүйн болон үндсэн хуулийн соёлын өөр өөр түвшний хүрээнд тухайн салбар эрх зүйн хөгжлийн хандлага, эрх зүйн тогтолцооны үзэл баримтлалын чиг хандлагыг зөв тодорхойлох боломжтой болно гэж дүгнэн энэхүү илтгэлээ бичлээ.

Мөн үндсэн хуулийн маргааныг аль шүүхийн хяналтад хамаарч байгаагаас хамааран тэрхүү хяналтаа төвлөрсөн ба төвлөрсөн бус гэж нэрлэдэг тухай өгүүлэх болно.

Үндсэн хуулийн хяналтын эрх мэдлийг шүүх нь хэрэгжүүлдэг системийг төвлөрсөн бус тогтолцоо гэж нэрлэсэн байдаг бөгөөд энэ нь АНУ-д хөгжсөн бөгөөд “төвлөрсөн бус” буюу “Америкийн” систем гэж нэрлэгддэг. Энэхүү загварын хувилбар байдаг улс орныг нэрлэвэл Аргентин, Австрали, Канад, Энэтхэг, Япон, Филипин.

Үндсэн хууль боловсруулагчид “төвлөрсөн бус” тогтолцооноос илүү төвлөрсөн тогтолцоог илүүд үздэг юм байна. 1990-ээд онд төвлөрсөн тогтолцоо аль хэдийн бий болсон бөгөөд баруун Европт сайн хөгжсөн нь цаашдаа Зүүн болон Төв Европт хурдацтай тархсан байдаг.

Үндсэн хуулийн хяналтын загварын сонголт нь чухам ямар шалгуур, юуг чухалчилж авч үздэг вэ гэдгийг тайлбарлая. Үүнээс энэхүү сэдвийн гол зорилго урган гарч ирнэ.

- Үндсэн хуулийн хяналтын загвар, тогтолцоо хоорондын функциональ ялгааг тодорхойлон тайлбарлах;

- Эдгээр үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд шинжилгээ хийж, хамаарлыг тайлбарлах;

- Холимог буюу “эрлийз” / hybrid гэж нэрлэх хоёр соёлт үзлээс үүдэлтэй үндсэн хуулийн хяналтын онцлог, яагаад элементүүдийг хольсон тухай асуудлыг тодруулах зэрэг юм.

Юуны өмнө эрх зүйн бүл буюу аймаг ¹²⁸ (Хууль зүйн яам, 2013) нь улс орнуудын үндсэн хуулийн хяналтын загвар, тогтолцоонд хамааралтай эсэхийг хүснэгтлэн харъя.

¹²⁸ Хууль зүйн яам. Дэлхийн банк. Харьцуулсан эрх зүй. УБ., 2013. 7 дахь тал.

д/д	Эрх зүйн аймаг	Улс орнууд	Онцлог:
1	Ром -Германы эрх зүйн аймаг	Эх газрын орнуудаас улсуудаас гадна Латин Америкийн ихэнх улсууд, Африкийн зарим улс орон, Япон, Индонез, Шотланд, ӨАБНУ, Израйль	Ром-Германы эрх зүйн бүлтэй улс орнууд эрх зүйгээ хувийн ба нийтийн эрх зүйн гэсэн салбарт хуваадаг. Тэдгээр улсыг Иргэний эрх зүйг чухалчилдаг гэж бас үздэг байна. Иргэний эрх зүйн улс орнууд/ Civil Law Countries/: (https://onlinelaw.wustl.edu/blog/common-law-vs-civil-law) Үндсэн хуулийн төвлөрсөн болон төвлөрсөн бус тогтолцоотой. • БНХАУ /China/ • Япон /Japan/эрх зүйн холимог тогтолцоотой • ХБНГУ /Germany/ • Франц /France/ • Испани /Spain/
2	Англи-Америкийн эрх зүйн аймаг Нийтлэг эрх зүйн аймаг	Энэхүү аймагт Английн эрх зүйн тогтолцоо болон англи хэлтэй улс орнууд бүгд хамаарна. Энэхүү аймгийг английн эрх зүй, америкийн эрх зүй гэсэн 2 хэсэгт хувааж авч үздэг. Английн эрх зүйн хэсэгт Англи, Хойд Ирланд, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнууд хамаарна.	Тэд эрх зүйг нийтийн ба хувийн эрх зүй гэж ангилдаггүй. Нийтлэг эрх зүйн улс орнууд/ Common Law Countries/: Үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн бус тогтолцоотой. • Америкийн Нэгдсэн Улс /The United States/ • Англи /England/ • Энэтхэг /India/ • Канад /Canada/
3	Холимог эрх зүйн бүл	Өмнөд Африкийн хууль нь иргэний хууль болон нийтлэг эрх зүйн аль алиных нь элементүүдийг агуулсан эрлийз системтэй.	IDEA-ийн Баруун Африкийн төсөлд¹²⁹ хэлэлцсэн 16 улсын зарим нь АНУ-тай тун төстэй Дээд шүүхийн загварыг ашигладаг. Бусад нь (ихэвчлэн Францын иргэний хуулийн уламжлалыг баримталдаг хүмүүс) үндсэн хуулийн зөвлөлийг ашигладаг. Бусад нь Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг ашигладаг.
Эрх зүйн аймаг болгон ангилах шалгуур: /Эрдэмтдийн тодорхойлолт/			
д/д	Эрдэмтэн	Шалгуур	
1	Даннел Бернал	Эрх зүйн бүтэц, эрх зүйн эх сурвалжуудыг тодорхойлох онол, практикийн өвөрмөц онцлогууд, нийгэм ба төрийн амьдралд эрх зүйн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх бодол, төсөөлөл, эрх зүйн аль нэг тогтолцооны хүрээнд хэрэглэгдэж байгаа хууль зүйн техник, эрх зүйн философи, улс төр болон бусад үндэс, зарчим байна гэжээ.	
2	Эсмен	Янз бүрийн ард түмний бүрэлдэн бий болсон түүхэн онцлог, тухайн нийгмийн ерөнхий бүтэц, онцлох бусад шинж	
3	Леви-Ульман	Эрх зүйн эх сурвалжийг шалгуур болгосон	
4	Армижон-Нольде-Вольф	Эрх зүйн үүсэл хийгээд ижил, ялгаатай талыг	

¹²⁹ Types of Constitutional Review | William & Mary Law School (wm.edu) /mamсан. 2024.05.03/

5	<i>Шницер</i>	Соёлын онцлог, түүний хамрах хүрээг
6	<i>Цвайгерт</i>	Хууль зүйн арга барилыг буюу эрх зүйн тухайн системийн түүхэн хөгжил, сэтгэлгээний онцлог, эрх зүйн эх сурвалж, түүнийг тайлбарлах арга, үзэл суртлын хүчин зүйлсийг үндэслэн ангилгах нь зүйтэй гэж үзсэн.
7	<i>Рене Давид</i>	Үзэл суртлын болон хууль зүйн арга, ажиллагааны шалгуурыг голлон ангилж байна.

Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоо нь нийтлэг эрх зүйн (common law) тогтолцоо, иргэний эрх зүйн (civil law) тогтолцоо гэсэн хоёр үндсэн ангиллын аль нэгэнд багтдаг. Иргэний эрх зүйн үндсэн тогтолцоотой 150 орчим улс байдаг бол нийтлэг эрх зүйн 80 орчим улс байдаг. Энэ хоёр тогтолцооны гол ялгаа нь нийтлэг эрх зүйн улс орнуудад шүүхийн дүгнэлтийн хэлбэрээр хэвлэгдсэн шүүхийн практикийн эрх зүй үндсэн ач холбогдолтой байдаг бол иргэний эрх зүйн тогтолцоонд кодчилогдсон хууль давамгайлдаг.¹³⁰ (<https://law.wustl.edu/>, 2024)

Хүснэгт-1 ээс дүгнэхэд дэлхийн улсуудын эрх зүйг эрх зүйн бүл болгосон шалгуур болон онцлог нь Үндсэн хуулийн хяналтын загвар, тогтолцоонд харгалзан үзэх чухал асуудал гэдэг нь харагдаж байна. Тухайлбал: Эрх зүйн бүлийн онцлог болох эрх зүйг ангилах ангилалтаас хамааран улс орнуудын аль үндсэн хуулийн хяналтын тогтолцоог ашигладаг болохыг нь ойлгомжтой, үндэслэлтэйгээр тайлбарлаж болох хэдий ч шууд эрх зүйн ангилалт, аль эрх зүйг чухалчилсан зэргээс

улбаалсан сонголтыг хийгээгүй улс орон байгааг анхаарах ёстой.

Б.Чимид багшийн хэлсэн хуульд хандах зарчим, арга, хэлбэр, арга барил эв дүйд тулгуурлан үндсэн хууль болон үндсэн хуульчилсан хуулийг бодитой үнэлж, зөв тайлж, онож хэрэглэх үзэл, онол, мэдрэмж рүү чиглэгдэх болно. Гэхдээ эрх зүйн бүлийн ялгаатай талын онцлогийг харгалзан тухайн асуудалд хандах нь зайлшгүй юм.

Үндсэн хуулийн шүүх нь нийтлэг эрх зүй гэхээсээ илүү иргэний эрх зүйтэй улс орнуудад буюу Европын болон Азийн ихэнх орнууд төвлөрсөн системийг ашигласан, харин нийтлэг эрх зүйн орнуудаас бүрддэг Британийн хамтын нөхөрлөлийн ихэнх орон төвлөрсөн бус тогтолцоог ашигладаг байна. Харин Баруун Африк, Ойрх Дорнодын орнууд төвлөрсөн тогтолцоог ашигладаг байна.. Иргэний эрх зүйн зарим улс орнууд (жишээ нь Япон) төвлөрсөн бус системийг, зарим нийтлэг эрх зүйтэй улс орнууд (жишээ нь, Мьянмар) төвлөрсөн системийг ашигласан байдаг байна.

Тодруулбал: Өмнөх хүснэгтээс харвал Япон улс иргэний эрх зүйг чухалчилдаг, үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн тогтолцоог

¹³⁰ <https://onlinelaw.wustl.edu/blog/common-law-vs-civil-law/mamсан.2024.05.03/>

ашигладаг гэсэн шууд дүгнэлт хийж болохгүй, Япон улс төвлөрсөн бус тогтолцоог ашигладаг бөгөөд үндсэн хуулийн хяналтыг “Дээд шүүх” нь хэрэгжүүлдэг болохыг дурдахад дээрх ангилалт хийсэн аргачлал нь үндсэн хуулийн хяналтын тогтолцоог шууд тодорхойлох нь боломжгүй нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн ба төвлөрсөн бус системийг нийтлэг эрх зүй / common law/ ба иргэний эрх зүйгээс/ civil law/ хамааран ашигладаг гэж дүгнэх нь өрөөсгөл мөн үндсэн хуулийн хяналтын холимог загвартай улс орнууд аль үндсэн хуулийн хяналтын аль системийг сонгосон байгаа нь сонирхол татахуйц юм.

Энэхүү “төвлөрсөн” тогтолцоо гэж нэрлэсэн үндсэн хуулийн хяналтыг Австрид эрдэмтэн Ханс Келсений нэртэй холбоотой үүссэн тул “Европ” систем гэж бас нэрлэдэг бөгөөд Австри, Герман, Итали, Испани, Колумб, Оросын Холбооны улс, Бүгд Найрамдах Солонгос улс, Турк, Тайвань мөн Европын улсуудын мужуудад ашигладаг байна. Төвлөрсөн хэмээх энэхүү тогтолцоо нь доорх эрдэмтдийн нэрлэсэн Австрийн буюу Австри-Германы, Европын, Австрийн буюу үндсэн хуулийн эх газрын хяналтын загвар гэж янз бүрээр нэрлэгдэж буй хяналт юм. Үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн загвар нь дэлхийн 1-р дайны дараа Европт үүссэн. 1920 онд хуучнаар

Чехословак, Австри, 1921 онд Лихтенштейн, 1931 онд Испани зэрэг улсууд анхлан нэвтрүүлсэн. Х.Келсен бол энэ загварыг хөгжүүлж, сурталчлах, Америкийн хувилбараас хамгаалахад хамгийн их хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Келсений загвар - Үндсэн хуулийн бус хууль тогтоох үйлдлээс “үндсэн хуулийн хамгаалалт” үзүүлэх зорилгоор ердийн шүүхээс гадуур тусгай шүүх байгуулах нь илүү гэж үзсэн хувилбар юм. Энэ байгууллага нь Дэлхийн 2-р дайны дараа Австри улс 1945 онд дайны өмнөх Үндсэн хуулийн шүүхээ сэргээн байгуулснаар үлгэр дуурайлал болжээ. Мөн Герман улс Үндсэн хуульдаа (1949) Үндсэн хуулийн хяналтыг бий болгон хамгийн нөлөө бүхий улс болсон юм. Италид 1947 онд Америкийн загварын дагуу шүүхийн хяналтыг бий болгосон тодорхой нөхцөл байдал үүссэн. Энэ нь тийм ч амжилттай байгаагүй тул Итали ерөнхий утгаараа Европын загварыг авчээ. Грек, Испани, Португал, Бельги, Франц болон бусад улсууд удалгүй мөн энэхүү загварыг бэхжүүлсэн. Хуучин коммунист орнууд шүүхийн хяналтыг зохицуулах гэж оролдсон. Югослав 1963 онд Үндсэн хуулийн шүүхийг байгуулж, Польш улс 1986-1997 онд ажиллаж байсан Үндсэн хуулийн шүүхийг (1982) байгуулжээ. Өнөөдөр энэ нь Европт, ялангуяа Европын Холбооны гишүүн орнуудын дунд зонхилох загвар болсон байна.

Үлдсэн орнуудаас Дани, Швед, Финлянд зэрэг улсууд “Америкийн” загварыг баримталдаг боловч эдгээр улсын шүүхүүд хууль, хууль тогтоомжийг үндсэн хууль зөрчсөн гэж үзэх нь ховор байдаг. Бусад улс Ирланд, Грект үндсэн хуулийн хяналтын “холимог” гэх хяналтын загварыг хэрэглэдэг, Нидерланд, Их Британид үндсэн хуулийн хяналтын тогтолцоо байдаггүй.

Европын загварын бүтцийн онцлог нь төвлөрсөн, хийсвэр хяналт юм. Төвлөрөл гэдэг нь аливаа хууль, жирийн хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх эрх зөвхөн Үндсэн хуулийн шүүхэд л байна гэсэн үг. Португалийн Үндсэн хуульд жирийн шүүхүүд өөрсдийн эрх мэдлийн үндсэн дээр хууль тогтоомжийг хүчингүй болгохыг зөвшөөрдөг. Хийсвэр хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу шүүх хууль тогтоомж, ердийн хууль тогтоомжийг хийсвэрээр хянан үзэж, үндсэн хуульд харшилсан тохиолдолд хүчингүй болгож болно.

Арабын орнууд Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийн шүүхийн хяналтын зарим хэлбэрийг нэвтрүүлэхдээ гол төлөв төвлөрсөн системийг дагасан байдаг. /Египет, Хуучин Ирак, Ливан, Сири гэх мэт/

Үндсэн хуулийн биелэлтэд тавих мэргэжлийн хяналтыг уг асуудлыг тусгайлан эрхлэх үүрэг бүхий мэргэжлийн байгууллага эрхлэн гүйцэтгэдэг. Орчин үед дэлхий нийтэд үйлчилж байгаа Үндсэн хуулийн

мэргэжлийн хяналтын Америкийн, Австрийн, Францын гэсэн гурван загвар /модель/ байдаг.¹³¹ (бүтээл, 2000) гэж бичжээ. Эдгээр нь бол хяналтын тогтолцооны хэлбэр юм.

Үндсэн хуулийн хяналт хэрэгжүүлж ирсэн гадаад зарим орны Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрдэмтэн судлаачдын зохиол бүтээл судалж үзсэний үндсэн дээр Үндсэн хуулийн хяналтын дэлхий нийтээр тогтсон гурван үндсэн загвар-модель Англи-Саксоны, Америкийн, Европын гэсэн гурван гол загвар (модель)¹³² (Өнөрбаяр.Ч. А.Бямбажаргал. “Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа, 2019) үйлчилж байна.

Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих байгууллага, түүний ангилал; Үндсэн хуулийн хяналтын загвар¹³³ (Ц.Сарантуяа., 2005)

Үндсэн хуулийн биелэлтийг шүүхийн байгууллагаас хянах нь

- Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих америк загвар

- Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих европ загвар:

- Үндсэн хуулийн бие даасан шүүх байгуулах

- Цөөн тохиолдолд үндсэн хуулийн зөвлөлийг бий болгох замыг тус бүр сонгож авсан байдаг.

Үндсэн хуулийн хяналт буюу

¹³¹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000. 248 дах тал.

¹³² Ч.Өнөрбаяр. А.Бямбажаргал. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа. УБ., 2019. 181 дэх тал.

¹³³ Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ., 2005.23-24 дэх тал.

үндсэн хуулийн шүүхийн хяналтын загвар хэмээх сэдвийн дор үндсэн хуулийн хяналтыг зохион байгуулалтын хувьд хэд хэдэн загварт ялган хувааж болно.¹³⁴ (Мавчич, 2014)

- **Америкийн буюу шүүхийн хяналтын загвар** /төвлөрсөн бус, нээлттэй хэлбэр/ Үндсэн хуулийн асуудлыг аль ч шатны ердийн шүүх нийтэг журмаар хэлэлцэн шийдвэрлэж болно.гэсэн үндэслэл бүхий загвар юм. ... Дээд шүүх нь харьяаллын нэгдмэл байдлыг хангаж ажиллах ёстой. (inter omnes)

- **Хамтын нөхөрлөл /Маврики-ийн шинэ /Британи/загвар нь** Европ Америкийн загвараас өөр юм. Энэ бол улс төрийн томилгоогүй, ердийн шүүгчдээс бүрдсэн Дээд шүүхийн харьяалал дахь төвлөрсөн хяналтын загвар бөгөөд урьдчилсан хяналт хэрэгжүүлж зөвлөмжийн шинжтэй үүрэг гүйцэтгэнэ. Шийдвэр нь нийтээр дагаж мөрдөх (erga omnes)

- **Австрийн” буюу Үндсэн хуулийн эх газрын хяналтын загвар** бөгөөд Үндсэн хуулийн шүүх, эсхүл зарим тохиолдолд Дээд шүүх, түүний танхим тусгайлсан журмаар авч үзэх явдал бас байдаг байна.

7. а/ Үндсэн хуулийн шүүх

8. б/ Улсын дээд шүүх болон тусгай танхим

- **Холимог буюу Америкийн эх газрын загвар**

¹³⁴ Мавчич. Арне. Үндсэн хуулийн хяналт. УБ., 2014. 24 дэх тал.

а/ Үндсэн хуулийн шүүх

Европт: Португал

Төв болон Өмнөд Америкт: Колумби, Эквадор, Гватемал, Перу

б/ Дээд шүүх болон түүний танхим

Европт: Грек, Швейцар

Азид: Индонез, Тайвань

Африкт: Кабо Верде

Төв болон Өмнөд Америкт: Бразил, Салвадор, Хондурас болон Венесуль

- **“Франц” –ын буюу эх газрын загвар** бол 1958 оны Францын Үндсэн хуулийн Зөвлөлийн зарчимд үндэслэсэн загвар

- **Үндэсний зөвлөл, Парламент болон Парламентын тусгай байгууллагаас Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг улс:**

Европт: Финлянд

Дундад Азид: Бахрейн, Кувейт, Оман

Африкт: Конго, Зимбабве...

Азид: Афганистан, Мьянмар, Хятад, Хонг-Конг

- **Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийн шүүхийн хяналтын тогтолцоогүй улс:**

Европт: Их Британи, Нидерланд

Африкт: Ливи, Либери

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх зарим чиг үүрэгтэй олон Улсын байгууллага:

- Страссбург дахь Европын хүний эрхийн шүүх

- Хүний эрхийн Африкийн шүүх

Арне Мавчичийн ангилалтаас үзэхэд дээрх тогтолцооны доторх загварын ангилалт байгаа хэдий ч үндсэн хуулийн хяналтын тогтолцоогүй улс орон мөн олон улсын байгууллага, шүүхэд Үндсэн хуулийн маргаанаа харьяалуулан шийдвэрлэдэг улс орон ч байгаа гэдгийг анзаарсан гэж бодож байна. Үндсэн хуулийн хяналтын загварын ангиллын асуудал өнөөдөр манай хууль, эрх зүйн ном сурах бичигт 3 загварын түвшинд тайлбарлан бичигдсэн байдаг.

Иймээс бид үндсэн хуулийн хяналтын ангилалтыг хэрхэн ангилах асуудалд олон өнцгөөс харах болсон гэдгийг өгүүлэх гэж хичээсэн билээ. Үндсэн хуульд нийцсэн байдлыг шүүхээр хянан шалгах тогтсон уламжлалыг хоёр том төрлөөр судалж болно. Эхнийх нь төвлөрсөн бус, хоёрдугаарт төвлөрсөн тогтолцоо.

Үндсэн хуулийн шүүхүүд тусгай санал гаргахыг зөвшөөрдөг, эс зөвшөөрдөг асуудлыг эрх зүйн бүл, үндсэн хуулийн хяналтын тогтолцооны төрөл зэргээс хамаардаг эсэх, цаашилбал тухайн улс орон ямар эрх зүйг чухалчлан авч үздэгээс хамаарах эсэх өөрөөр хэлбэл нийтлэг болон иргэний эрх зүйг алийг чухалчлахаас шүүгч тусгай саналаа илэрхийлэхэд нөлөөлдөг эсэхийг тодруулах, шүүгчийн тусгай саналын чиг хандлага, улс орнуудын баримталдаг үзэл санааны талаар

харьцуулан илэрхийлэхийг зорилоо.

Нийтлэг эрх зүйн орнуудад шүүгчийн бие даан үг хэлэх нь шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх, шүүхийн үйл явцын ил тод байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Харин иргэний эрх зүйг эрхэмлэдэг улс орнуудад шүүхийн зөвлөлдөх тасалгааны нууцад ихээхэн ач холбогдол өгдөг байна. Тухайлбал: Монгол Улсад тусгай саналаа нийтлүүлэх эрхийг 2012 онд УДШ шүүгчид, 2016 онд Цэцийн гишүүнд өгөхөөр хуульчилсан. Гэвч Үндсэн хуулийн Цэц 2016 оны 6 сарын 17 -ны 4 дүгээр тогтоолоор Цэцийн гишүүний тусгай саналаа нийтлэх заалтыг хүчингүй болгосон бол 2016 оны 9 р сарын 28 -ны 10 дугаар дүгнэлтээрээ Дээд шүүхийн шүүгч тусгай саналаа нийтлүүлэх заалтыг түдгэлзүүлсэн байдаг.¹³⁵ (О.Мөнхсайхан, 2023) Энэ нь эх газрын бүл буюу иргэний эрх зүйг чухалчилж байдаг улс орны нийтлэг чиг хандлага юм гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой юм байна гэж үзэж байна. Үүнийг Үндсэн хуулийн Цэц Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзэх үндэслэл байхгүй байна гэж дүгнэлээ.

Зарим улсууд шүүгчийг тусдаа үзэл бодлоо илэрхийлэхийг хориглодог эсвэл эрх зүйн зохицуулалт огт байдаггүй ч улс орон байдаг байна. Тухайлбал: Австри, Бельги, Франц гэх мэт.

Үндсэн хуулийн шинэчлэл, өөрчлөлт нь Үндсэн хуулийн

¹³⁵ www.ltoim /хандсан. 2026.05.03/

Цэцийн маргаан хянан шийдвэрлэх процессын явцад эцсийн шийдвэр гаргахад нөлөөлж буй нь тодорхой аливаа эрх зүйн асуудалд хөгжлийн чиг баримжаагаар бус улс төрийн өнцгөөс хандсан тэх битгий хэл Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр гарсны дараа хаалт бүхий хуулийн зүйл заалтыг зохих хуульд нэмж оруулсан нь их хачирхалтай зүйл болсныг доорх жишээ тод харуулна. Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны онолын түвшинд тухайн үзэл баримтлалыг онол болгохоор санал болгосон шинэ асуудлууд үндсэн хуульд орж ирсэн. Тухайлбал: Үндсэн хуулийн эрх зүйд үндсэн хуульд нийцээгүй үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн агуулга нь үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээг нэмэгдүүлэн, эрх зүйн зохицуулалт шаардахгүйгээр үндсэн хуулийн оршил хэсэг, үндсэн хуулийн суурь бүтэц, үзэл баримтлал зөрчсөн нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Цэц 2022 оны 8 сарын 25 ний өдрийн шийдвэрийг жишээ болгон хэлж болох юм. Энэ бол Үндсэн хуулийн эрх зүйн үндсэн хуульт ёсны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон үйл баримт болсон гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл шүүхийн идэвх буюу “ court activism ” бол үндсэн хуульт ёсны сүүлийн үеийн хөгжлийн чиг хандлагын нэг гэж эрдэмтэд үздэг болсон. Хөгжил чиг хандлагаар асуудалд хандаж байхыг сануулахад илүүц биз ээ. Үндсэн хуульд хандах зарчим, арга, хэлбэр,

арга барил эв дүйд тулгуурлан Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан хуулийг бодитой үнэлж, зөв тайлж, онож хэрэглэх үзэл, онол, мэдрэмжийн тухайд Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагын хүрээнд авч үзэх хэрэгтэй.

Мөн Латин Америкийн улс орнууд дан Үндсэн хуулийн шүүхэд болон дотоодын нэгэн байгууллагад хяналтыг өгөхөөс илүүтэй холимог хяналтын тогтолцоог болон үндэстэн дамнасан шүүхийн байгууллагаар үндсэн хуулийн маргаанаа хянан шийдвэрлүүлэх чиг хандлагатай байгааг харж болно. Тухайлбал сүүлийн үеийн үндсэн хуулийн шинэчлэлүүдээс үүдэн үндэсний ялгаа арилж, нийтлэг шинж чанар нэмэгдэх болсныг анзаарах хэрэгтэй болсон. Тухайлбал тухайн улсын доторх хүний үндсэн эрх болон үндсэн хуулийн маргаанаа олон улсын бичиг баримт, гэрээ конвенцоор, үндэстэн дамнасан эрх зүйн стандартаар олон улсын болон холбооны хүний эрхийн байгууллага, шүүхээр шийдүүлэх чиг хандлагыг харах болсон.

Хүснэгт 1-ээс харвал олон улсын болон холбооны шүүхүүдэд үндсэн хуулийн хяналтын эрхээ хэрэгжүүлэх эрхээ өгч байгаагаас мөн зарим нэгэн үндсэн эрхийн маргаан дээр “Үндсэн хуулийн блок”-ийг хэрэглэх зэргийг нэрлэж болох юм. Өөрөөр хэлбэл олон соёлт үзэл болон үндэстэн дамнасан үзлийг хүлээн зөвшөөрөх чиг хандлага руу чиглэж байна.

Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудалд харьцуулсан эрх зүйгээс зайлсхийх биш харин ашиглах явдал чухал өөрөөр хэлбэл бусдын туршлагаас суралцах юм.

1.2 Үндсэн хуулийн хяналтын тогтолцооны төрөл нь хуулийн тодорхой болон тодорхойгүй байдалд нөлөөлөх нь, тэдгээрийг даван туулах арга зам

а/ Үндсэн хуулийн хяналтын тогтолцооны төрөл болох төвлөрсөн, төвлөрсөн тогтолцооны давуу ба сул тал ба тогтолцоо ба хуулийн тодорхой болон тодорхой бус байдлын харилцан хамаарал.

Өмнөх хэсэгт хяналтын тогтолцоо, түүний төрлийн талаар бичсэн учраас тэдгээрийн сул болон давуу талаар нь хуулийн тодорхой болон тодорхой бус байдалд нөлөөлөхийг нь тодруулъя.

Төвлөрсөн бус тогтолцоо:

Түүхээс үзвэл ердийн шүүгчид төвлөрсөн бус хяналтаар үндсэн хуулийн хяналтын гол хэлбэрийг хэрэгжүүлж байв. Жишээлбэл, хамгийн анхны үндсэн хуулийн хяналтын загвар болох Америк загвар нь төвлөрсөн бус хяналтын системийн шинжийг агуулна. Энэ загварын дагуу хувь хүмүүс аливаа хэм хэмжээний акт, нэг бүрчилсэн актыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг ердийн шүүхээр хэлэлцүүлж, тухайн асуудалд дүгнэлт гаргадаг.

Гомдол гаргагчийн зүгээс харахад

үндсэн хуулийн төвлөрсөн бус хяналтын гол давуу тал нь үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар өөр өөрөөр тайлбарлаж болох юм. Энэ нь уялдаа холбоогүй, **тодорхойгүй байдал (uncertainty)**, зөрчилтэй шийдвэрт хүргэж болзошгүй юм. Гэсэн хэдий ч энэ нь хууль, эрх зүйн плюрализм болон эксперимент¹³⁶ - ийг хөхүүлэн дэмжиж болох бөгөөд бүхий л төвлөрсөн бус системийн адил илүү сайн хууль гаргах үр дүнд хүргэж болно.

Өөр нэг сул тал нь үндсэн хуулийн шүүх хүртэл бүхий л замаар давж заалдснаар шүүх ажиллагааг сунжирсан, зардал ихтэй байдалд хүргэж болно. Хэрэв маргааны талууд давж заалдахаас татгалзвал тухайн хууль үндсэн хуулийн тайлбар гаргасан шийдвэргүйгээр **тодорхой бус байдалд** үлдэж болно.¹³⁷ (хүрээлэн, 2023)

Төвлөрсөн тогтолцоо:

20-р зуунд төвлөрсөн бус загвараас ялгаатай төвлөрсөн хяналтын загварыг Ханс Келзен 1920 оны Үндсэн хуулийн жишээн дээр боловсруулсан.

Төвлөрсөн системээр ихэвчлэн ердийн шүүхийн тогтолцооноос тусдаа бие даасан шүүхэд хэм

¹³⁶ Эксперимент (Латин экспериментум - туршилт, туршлага) нь таамаглал, онолыг дэмжих, няцаах, батлах зорилгоор гүйцэтгэдэг процедур юм.

¹³⁷ Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн. Хувь хүний шүүхэд хандах эрх. Шинэчилсэн тайлан. УБ., 2023. 4 дэх тал.

хэмжээний актууд нийцэж байгаа эсэхийг шалгах, үндсэн хууль зөрчсөн актуудыг хүчингүй болгох бүрэн эрх олгогдсон байдаг. Ийм системд үндсэн хуулийн хяналтыг үндсэн хуулийн шүүх эсхүл дээд шүүх дангаар хэрэгжүүлдэг бөгөөд дээд шүүх хэрэгжүүлэх тохиолдолд хяналтын журмаар хэрэг шийдвэрлэхээс гадна үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг давхар хэрэгжүүлдэг.

Төвлөрсөн загварт хоёр гол давуу тал бий.

Нэгдүгээрт, энэ нь маргааны харьяаллыг илүү нэгдмэл болгодог. Энэ нь үйл явцыг оновчтой болгох, үндсэн хуулийн хуулийг өөр өөр шүүх, харьяаллын дагуу тайлбарлах зөрчилдөөнийг багасгах бүтцийг бий болгох явдал гэсэн үг. Хоёрдугаарт, энэ нь хуулийн хэрэглээг ойлгомжгүй болгож болзошгүй үндсэн хуультай холбоотой асуудлаар санал зөрөлдөөнтэй шийдвэр гаргахаас сэргийлдэг тул хууль зүйн тодорхой байдлын зарчмыг (**legal certainty**) илүү дэмждэг.

Төвлөрсөн хяналтын сул тал нь ердийн шүүх болон үндсэн хуулийн шүүхийн хооронд хурцадмал байдал, зөрчилдөөн үүсэж болзошгүй юм. Үндсэн хуулийн шүүхийн хууль тогтоомжийн хэрэглээ, тайлбарыг дүгнэж, тодорхой хэрэгт хөндлөнгөөс оролцдог.

Түүхийн хувьд төвлөрсөн загварыг дэмжих европын хувилбар нь үндсэндээ **эрх зүйн тодорхой**

байдлын үнэ цэнэ холбоотой байдаг. Үндсэн хуулийн шүүх хуулийг зөвхөн хийсвэрээр бус, бас тохиолдол тус бүрээр хянадаг ба гаргаж буй тайлбарууд нь бараг эрх зүйн салбарыг хөндөж, ердийн шүүхийн “өөрийн” тайлбарлах уламжлалт үүргийг зөрчиж, тэдний хуулийн зүйл заалт хэрэглэх хүрээг хязгаарладаг.

б/ Хуулийн тодорхой бус байдал

“Тодорхой бус байдал” гэдэг нь эргэлзээтэй, тодорхойгүй гэсэн үг, “Тодорхойгүй байдал” гэдэг үг нь илүү олон утгаар ойлгогдох чадвартай гэсэн үг.¹³⁸

Хууль, эрх зүйн тодорхойгүй байдал нь хууль тогтоомж, эрх зүйн зарчмуудыг хэрэглэх, тайлбарлахад тодорхойгүй, ерөнхий байдлаар зохицуулсан урьдчилан таамаглах боломжгүй байдлыг хэлдэг¹³⁹. Энэ нь эрх зүйн хэм хэмжээнүүдээр шууд зохицуулагдах харилцаа нь хуульчлагдаж чадаагүйгээс эрх зүйн үйлчлэл дутагдаж, үр дагавар бий болгосон хууль зүйн онцгой нөхцөл байдал мөн¹⁴⁰.

Энэ нь ерөнхийдөө эрх зүйн үр дагавар бүхий хуульчлагдаагүй нөхцөл байдал ба тухайн улс оронд нийгмийн зохицуулалтын түвшин ямар байгаатай ихээхэн холбоотой. Хуулийн тодорхой бус байдал нь хувь хүмүүс, аж ахуй эрхлэгчид, хуулийг

¹³⁸ *Concept of legal uncertainty_8232017002.pdf*

¹³⁹ https://link.springer.com/chapter/10.1007/978-3-658-24385-2_3

¹⁴⁰ Д.Баярсайхан *Эрх зүйн онол*, 2010., УБ., 212 дах тал

хэрэглэгчдэд хууль эрх зүйн орчныг ойлгох, хэрэгжүүлэхэд томоохон бэрхшээлийг үүсгэдэг.

Эрх зүйн эх сурвалжийг маргааныг хянан шийдвэрлэхдээ ашиглах арга зүйн хүрээнд ч тухайлсан зохицуулсан хуулийн тусгай зүйл заалтаас эхлээд хуулийн зорилго, зарчим луу чиглэх буюу тусгайгаас ерөнхий анги руу гэсэн бүтцийг ашигладаг бол тухайлсан хууль байхгүй тохиолдолд хууль дээдлэх зарчмаар Үндсэн хуулиас зохицуулалтыг хайх нөхцөл бүрддэг тиймээс Үндсэн хуулийн зүйл, заалт тодорхой бус байх ёсгүй ч хэрэв тодорхой бус байдал үүсэхэд даван туулах арга зам нээлттэй байдаг гэдгийг доорх хэсэгт багахан ч гэсэн илэрхийлэв.

в/ Хуулийн тодорхойгүй байдал, түүнийг даван туулах арга зам

Үндсэн хуульд болон хуульд тодорхой заагаагүй асуудал, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам, боломж:¹⁴¹

- Хуульд хандах зарчим, арга, хэлбэр, арга барил эв дүйд тулгуурлан Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан хуулийг бодитой үнэлж, зөв тайлж, онож хэрэглэх

үзэл, онол, мэдрэмжийн¹⁴² тухайд Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагын хүрээнд авч үзэх;

- Хууль тогтоогч тухайн асуудал, нөхцөл байдлыг нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;

- Эрдэмтэд, судлаачид олон ургалч үзлээр уг асуудал, нөхцөл байдлыг хуульд зааснаас өргөтгөн тайлбарлах замаар шийдвэрлэх;

- Үндсэн хуулийн маргаанд талуудын тайлбарт олон улсын гэрээ, конвенцын нэр томьёог, бусад улсын эрх зүйн зохицуулалт зэргийг дурдан шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхэд ашиглах болсон.

*Тухайлбал, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.*¹⁴³

- Улс төрийн практикт өрнөх үйл явдлыг шийдэх арга замыг жишиг болгох замаар шийдэх;

- Үндсэн хуулийн шүүх тухайн асуудлыг шаардлагатай ба зөв заалтыг дурдан¹⁴⁴ зарим хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэхийг зөвтгөх, эсэргүүцэх зорилгоор хууль эрх зүйн үндэслэл болгон ашиглах;

¹⁴¹ Ардчилсан Үндсэн Хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн Баатар, Ардын Багш, Гавьяат Хуульч, Доктор, Профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд явуулсан оюутан М.Тэмүүлэн “Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам, боломж чиг хандлага” илтгэлээс. Удирдсан багш. Х.Одонтуяа.

¹⁴² Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 198 дах тал.

¹⁴³ https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123489875221&fbclid=IwAR3WGxHbTIVP2iTKpCr63tndUkxSOO9WA5wjxUtyanmhBuQMzEEcx0T0c_E

¹⁴⁴ Necessary and Proper Clause. <https://law.justia.com/constitution/us/article-1/60-necessary-and-proper-clause.html>

Юутай ч эрх зүйн хэм хэмжээг шинэтгэн тогтоож, зөв ойлгож, үр нөлөөтэй хэрэгжүүлдэг болгох нь нийгмийн бодит хэрэгцээ мөн. Хэрэгцээг дүүрэн харгалзах нь илүү үр дүнд хүргэдэг¹⁴⁵ хэмээн Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид илэрхийлсэн байдаг.

Дүгнэлт

Үндсэн хуулийн хяналтын загвар, тогтолцоог харьцуулан авч үзэхэд үндсэн хуулийн хяналтын дээрх хувилбарууд нь түүхэн хөгжлийн хувьд ялгаатай боловч өнөөдрийн хувьд эдгээрийн ялгаа, онцлог нь бүдгэрч байгаа гэдгийг харьцуулсан эрх зүйн судлаачид анхаарах цаг нэгэнт болжээ.¹⁴⁶

“Үндсэн хуулийн хяналтын загвар” ба “Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо” гэсэн нэр томъёо нь тухайн улсын үндсэн хуулийг хэрхэн тайлбарлаж, хэрэгжүүлэхтэй холбоотой ижил төстэй ойлголтыг ихэвчлэн хэлдэг боловч тэдгээр нь нарийн ялгааг агуулдаг. Энэ хоёр нэр томъёоны тайлбар ба тэдгээр нь хоорондоо хэрхэн холбогдож байгааг авч үзлээ.

Гэхдээ үндсэн хуулийн хяналтын тогтолцоо нь тухайн улсын эрх зүйн бүл, ямар эрх зүйг чухалчилж байгаагаас хамаардаг, мөн

хамаарахгүй ч тохиолдол байдаг. Дэлхийн улс орнуудын эрх хөгжлийн чиг хандлагыг нь уг мөн чанар, ул суурьтай, харьцуулан тайлбарлах, тодорхойлох нь чухал юм. Эрх зүйн бүлийн ялгавартай байдал, онцлогийг бүдгэрүүлэх чиг хандлагад автахгүй байхыг зарим эрдэмтэд илэрхийлсэн гэдгийг бас анхаарах ёстой.

Үндсэн хуулийн хяналтын тогтолцооны төрөл, түүний төрөл нь аль эрх зүйгээ өмнөтгөлөө болгож байгаагаас хамаарах, хуулийн тодорхой, тодорхой бус байдалд нөлөөлж байдаг, тэдгээрийг даван туулах арга зам нээлттэй гэдгийг уг илтгэлийн зорилго болгон илэрхийлэхийг зорилго.

Үүний тулд илтгэлд дурдсан уг тогтолцоонуудын давуу, сул талыг дурдаад аль тогтолцооны төрлийг сонгосон нь хуулийн тодорхойгүй болон тодорхой бус байдалд нөлөөлдөг, мөн тэдгээрийг даван туулах аргаас бага ч гэсэн хуваалцлаа.

Эдгээрийн ялгаа, онцлог нь бүдгэрч байгаа гэдгийг харьцуулсан эрх зүйн судлаачид анхаарах нь цаг нэгэнт болжээ.¹⁴⁷

“Үндсэн хуулийн хяналтын загвар” ба “Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо” гэсэн нэр томъёо нь тухайн улсын үндсэн хуулийг хэрхэн тайлбарлаж, хэрэгжүүлэхтэй холбоотой ижил төстэй ойлголтыг

¹⁴⁵ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. 198 дахь тал. УБ., 2002.

¹⁴⁶ <https://academic.oup.com/icon/article/2/3/461/789224/mamсан>. 2023.03.27/

¹⁴⁷ <https://academic.oup.com/icon/article/2/3/461/789224/mamсан>. 2023.03.27/

ихэвчлэн хэлдэг боловч тэдгээр нь нарийн ялгааг агуулдаг. Энэ хоёр нэр томъёоны тайлбар ба тэдгээр нь хоорондоо хэрхэн холбогдож байгааг энд харуулав. Гэхдээ үндсэн хуулийн хяналтын тогтолцоо нь тухайн улсын эрх зүйн бүл, ямар эрх зүйг чухалчилж байгаагаас хамаардаг, мөн хамаарахгүй ч тохиолдол байдаг. Дэлхийн улс орнуудын эрх хөгжлийн чиг хандлагыг нь уг мөн чанар, ул суурьтай, харьцуулан тайлбарлах, тодорхойлох нь чухал юм. Эрх зүйн бүлийн ялгавартай байдал, онцлогийг бүдгэрүүлэх чиг хандлагад автахгүй байхыг зарим эрдэмтэд илэрхийлсэн гэдгийг бас анхаарах ёстой.

Үндсэн хуулийн хяналтын тогтолцооны төрөл, түүний төрөл нь аль эрх зүйгээ өмнөтгөлөө болгож байгаагаас хамаарах, хуулийн тодорхой, тодорхой бус байдалд нөлөөлж байдаг, тэдгээрийг даван туулах арга зам нээлттэй гэдгийг уг илтгэлийн зорилго болгон илэрхийлэхийг зорилоо. Үүний тулд илтгэлд дурдсан уг тогтолцоонуудын давуу, сул талыг дурдаад аль тогтолцооны төрлийг сонгосон нь хуулийн тодорхойгүй болон тодорхой бус байдалд нөлөөлдөг, мөн тэдгээрийг даван туулах аргаас бага ч гэсэн хуваалцлаа.

Хуулийн тодорхойгүй байдлын талаарх судалгаа бие даасан судлагдахууны сэдэв болон олон судлаачдын анхаарлыг татах байх гэж бодож байна. Жишээ нь: хэл

зүй, философи, хууль зүйн техник, эрх зүйн үүднээс авч үзэн, тулгарах бэрхшээл, сайн жишгийг судлах нь зүйтэй гэж бодож байна.

Хүснэгт-1

Үндсэн хуулийн хяналт хэрэгжүүлж буй бие даасан шүүх болон шүүх, байгууллага						
Үндсэн хуулийн шүүх /Constitutional court/	Дээд шүүх /Supreme court/	Үндсэн хуулийн шүүх ба дээд шүүх //Constitutional court and Supreme court/	Захиргааны хэргийн давж заалдах шүүх, холбооны шүүх, болон Үндсэн хуулийн шүүхэд харьяалуулсан /appeal court supreme court, federal court, law court, judicial yuan - Тайван/	Олон Улсын болон Холбооны шүүх бусад байгууллагаар дамжуулан хэрэгжүүлсэн ¹⁴⁸ /other organization/	Үндсэн хуулийн зөвлөл /constitutional consul/	Захиргааны хэргийн дээд шүүх болон Дээд шүүх /Supreme administrative court supreme court/
65	60	4	5	8	11	1 ¹⁴⁹

Эх сурвалж: Судлаач

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг 154¹⁵⁰ орны Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд судалгаа хийж, дүгнэж үзэв. /Хавсралт-1/

График 1-ээс харахад. Ердийн шүүх болон Үндсэн хуулийн шүүхэд

¹⁴⁸ Европын хүний эрхийн шүүх

- Афганистаны үндсэн хуулийн хэрэгжилтийг хянах хараат бус комисс

- Африкийн Хүний ба ардын эрхийн комисс ба шүүх

- Европын Холбооны шүүх

- Зүүн Карибын тэнгисийн дээд шүүх

- inter - American Court of Human rights

¹⁴⁹ / Финланд/


¹⁵⁰ Constitutional court /<https://www.venice.coe.int/webforms/courts/?lang=EN>

үндсэн хуулийн хяналтын эрх мэдлийг олгосон болон төвлөрсөн, төвлөрсөн бус хяналтын тогтолцоог хэрэгжүүлж байгаа нь 154 -аас 65 улс орон Үндсэн хуулийн шүүхтэй, 60 улс Үндсэн хуулийн маргааныг Улсын дээд шүүхэд, УДШ болон Үндсэн хуулийн шүүхэд хамтад нь харьяалуулсан 4 орон байна. Мөн шүүх биш төрийн байгууллагад харьяалуулсан улс орон байгаа нь сонирхол татахуйц.

Үүнд: Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах коллеги, Төрийн зөвлөл, Афганистаны Үндсэн хуулийн хэрэгжилтийг хянах бие даасан комисс гэх мэт өөр байгууллагаар үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

График-1


Үндсэн хуулийн хяналт хэрэгжүүлж буй бие даасан шүүх болон шүүх, байгууллага /тоогоор/



/Эх сурвалж: хавсралт-1-ээс/

122

Диаграмм-1 Үндсэн хуулийн хяналт хэрэгжүүлж буй бие даасан шүүх болон шүүх, байгууллага /хувиар/



Эх сурвалж: Хүснэгт-1

Диаграмм 1-ээс харвал үндсэн хуулийн хяналтыг үндсэн хуулийг шүүх хэрэгжүүлж байгаа нь 42 хувь буюу дийлэнх байгаа нь харагдаж байна. Мөн Ард түмний болон хүний эрхийн Африкийн комисс, Африкийн ард түмний ба хүний эрхийн шүүх, Европын хүний эрхийн шүүх, Европын хүний эрхийн шүүх, Баруун Карибын тэнгисийн шүүх гэх мэт холбооны болон үндэстэн дамнасан байгууллага, шүүхэд үндсэн хуулийн хяналтаа хэрэгжүүлдэг 5 хувь байгаа нь Үндсэн хуулийн процессын эрх зүй дэх үндсэн хуулийн хяналтын механизм нь үндэстэн дамнасан болон хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээ, стандартыг хэрэглэх болсон нь тухайн салбарын эрх зүйн хөгжлийн шинэ чиг хандлагыг бий болгож байгаа нь харагдаж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээр

[1] Цогтоо. Ш. Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2019.

[2] Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000.

[3] Өнөрбаяр.Ч. А.Бямбажаргал. “Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа, шинжилгээний тойм” - // Д.Солонго. Үндсэн хуулийн хяналтын хэрэгждэг хэлбэрийн харьцуулсан судалгаа. УБ., 2019.

[4] Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн процессын эрх зүй: Суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ., 2005.

[5] Арне Мавич. Үндсэн хуулийн хяналт. УБ., 2014.

[6] Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн. Хувь хүний шүүхэд хандах эрх. Шинэчилсэн тайлан. УБ., 2023.

[7] Д.Баярсайхан Эрх зүйн онол. УБ., 2010.

[8] Ардчилсан Үндсэн Хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн Баатар, Ардын Багш, Гавьяат Хуульч, Доктор, Профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд явуулсан оюутан М.Тэмүүлэн “Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам, боломж чиг хандлага” илтгэлээс. /Удирдсан багш. Х.Одонтуяа./

[9] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002.

[10] Хууль зүйн яам. Дэлхийн банк. Харьцуулсан эрх зүй. УБ., 2013

Цахим сайт

- [1] <https://academic.oup.com/icon/article/2/3/461/789224> /татсан. 2023.03.27/
- [2] Constitutional court / <https://www.venice.coe.int/webforms/courts/?lang=EN>
- [3] Rodrigo Uprimny. The Recent Transformation of Constitutional Law in Latin America:
Trends and Challenges.
- [4] <https://onlinelaw.wustl.edu/blog/common-law-vs-civil-law/>
- [5] <https://onlinelaw.wustl.edu/blog/common-law-vs-civil-law/>
- [6] www.ltoim /хандсан. 2026.05.03/
- [7] [Conceptoflegaluncertainty_8232017002.pdf](#)
- [8]https://link.springer.com/chapter/10.1007/978-3-658-24385-2_3
- [9] https://legalinfo.mn/mn/l?lawId=16123489875221&fbclid=IwAR3WGxHbTIVP2iTKpcr63tndUkxSOO9WA5wjxUtyanmhBuQMzEEcx0T0c_E
- [10] Necessary and Proper Clause. <https://law.justia.com/constitution/us/article-1/60-necessary-and-proper-clause.html>
- [11]<https://academic.oup.com/icon/article/2/3/461/789224>
- [12] Constitutional court / <https://www.venice.coe.int/webforms/courts/?lang=EN>

ЭХ СУРВАЛЖИЙН ОНОЛЫН ХҮРЭЭНД ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДЛЫГ АВЧ ҮЗЭХ НЬ



Хууль зүйн докторант, Шихихутуг
Их Сургуулийн Хувийн эрх зүйн
тэнхимийн ахлах багш
Ё.БОЛОРМАА

ӨМНӨТГӨЛ

Практикт Хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, шүүхээс маргааныг шийдвэрлэхэд холбогдох хууль тогтоомжийг хэрэглэж байгаа хэдий ч хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхол зарим тохиолдолд зөрчигдөж байдаг.

Эх сурвалжийн онолын хүрээнд, тус хууль тогтоомжийн онцлогийн дагуу, талууд хууль хэрэгжүүлэх, шүүхээс хууль хэрэглэхтэй холбоотой зарим асуудлыг онолын болон практик хэрэгжилтийн үүднээс авч үзэхэд оршино.

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар судлаачид авч үзсэн байдаг. Судлаачийн зүгээс тодорхой заалтууд, эх сурвалжийн онолын нэгдмэл байдлын хүрээнд

асуудлыг авч үзлээ.

Нэр томьёо: эх сурвалжийн онол, суурь хэм хэмжээ, зохистой тэнцвэрт байдал, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт

АГУУЛГА

1. Эх сурвалжийн онол ба хөдөлмөрийн хууль тогтоомжийн онцлог
2. Хөдөлмөрлөх эрх ба Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хэрэглээний зарим асуудал

1. Эх сурвалжийн онол ба хөдөлмөрийн хууль тогтоомжийн онцлог

Хүчин төгөлдөр үйлчлэх хуулийн тоо ихэссэнээр шүүгчийн хувьд л гэхэд нэг хэрэг маргаан дээр нэлээд хэд хэдэн хуулийг авч үзэх ёстой болно.

Жишээлэхэд нийтийн эрх зүйн субъект албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах нөхцөлд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль болон бусад хөдөлмөр хамгааллын холбогдолтой хууль тогтоомж, зарим асуудлаар мөн Иргэний хууль болон талууд хоорондын хамтын гэрээ зэргийг зайлшгүй үзэх болдог. Эдгээрийн нэг

хэсгийг УИХ-аас баталсан байхад нөгөө хэсгийг Засгийн газар, зарим нь зөвхөн ажил олгогчдын холбоо ба үйлдвэрчний эвлэл хоорондын тохиролцоо байх жишээтэй. Өөрөөр хэлбэл ганцхан практик тохиолдолд хэрэглэх хэм хэмжээ маань олон эх сурвалжтай байна гэсэн үг. Энэ утгаараа хууль зүйн шинжлэх ухаанд **эх сурвалжийн онолыг** хэрэглэх, хууль тогтоогч энэ онолыг баримтлан үйл ажиллагаагаа явуулж, хууль хэрэглэгч эл онолын дагуу хууль тогтоомжийг хэрэглэж төлөвшсөн байх нь амин чухал асуудал билээ. Тус онолын үндсэн чиг үүрэг нь шүүгч шийдвэр гаргахдаа ямар хэм хэмжээг зайлшгүй хэрэглэх ёстой вэ гэсэн асуултад хариулах, мөн тэдгээрийг хууль батлах түвшинд эх сурвалжийнх нь дагуу системчлэх явдал байдаг.¹⁵¹

Эндээс эх сурвалжийн онол нь 3 түвшинд харагдана. Өөрөөр хэлбэл, хууль батлах, хуулийг хэрэгжүүлэх, хууль хэрэглэх гэж үзэж болохоор байна. Хөдөлмөрийн хууль тогтоомж нь¹⁵² ерөнхийгөөс тусгай руу нарийвчлагдсан байж сая тус онолын ач холбогдол оршино.

¹⁵¹ Б.Буянхишиг, “Хувийн эрх зүй: онол-арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал” эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, 8 дахь тал.

¹⁵² Хөдөлмөрийн хууль тогтоомжийг анхдагч, хоёрдогч, гуравдагч эх сурвалж гэж авч үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, анхдагч эх сурвалжид хууль, хоёрдогч эх сурвалжид УИХ, ЗГ, Сайдаас баталсан хэм хэмжээ тогтоосон акт, гуравдагч эх сурвалжид байгууллага дотооддоо дагаж мөрдөхөөр батлан гаргасан эх сурвалж. /Судлаач/

Ерөнхий байдлаар батлан гаргасан Хөдөлмөрийн тухай хуулийг илүү нарийвчлан болон нөхөн зохицуулалт хийсэн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг бий болгосноор ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдах нэгэн баталгаа нь болох юм.

Тиймээс эрх зүйн онолын түвшинд хуулийн нэгдмэл байдлыг хүлээн зөвшөөрөх явдал нь идеал зорилго¹⁵³ төдий хийсвэрлэл билээ. Гэсэн хэдий ч хууль тогтоогчоос эхлэн хууль хэрэглэгч хүртэл энэ идеал зорилгыг хэрэгжүүлэхээр тэмүүлэх нөхцөлд хуулийн хийдэл, зөрчил арилж байдаг гэжээ.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийн харилцааг¹⁵⁴ зохицуулж буй суурь хэм хэмжээ нь¹⁵⁵ Хөдөлмөрийн тухай хууль¹⁵⁶ юм. Тус суурь хэм хэмжээ нь аль болох талуудын хөдөлмөрлөх эрх, ашиг сонирхлын тэнцвэрийг хангахад чиглэгдсэн. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд тоглогч талуудыг ажил

¹⁵³ Н.Лүндэндорж, ХЗС-иас эрхлэн гаргасан Эрх зүй онол, практик, мэдээллийн цуврал 2-3, 2007 он, 229 дэх тал.

¹⁵⁴ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 4.1.15 дахь заалт.

¹⁵⁵ Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөр эрхлэлттэй холбоотой суурь хэм хэмжээг тогтоож байгаа нь тухайн салбарын онцлогтой холбоотой бөгөөд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нарийвчилсан тоглоомын дүрмийг ажил олгогч, ажилтан талууд холбогдох хуулиар үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр бий болгох шаардлагатай.

¹⁵⁶ Монгол улсын хувьд, Хөдөлмөрийн тухай хууль нь шинэчилсэн найруулга хийгдэж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

олгогч, ажилтан гэж үзвэл тус хууль нь хууль зүйн тоглоомын дүрэм болохынхоо хувьд ерөнхий буюу нийтлэг зохицуулалттай¹⁵⁷ байгаа нь зохицуулагдаж буй харилцааны онцлогтой шууд холбоотой. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.4 дэх заалтад, ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан /хоёр ба түүнээс дээш/ гаргасан, эсхүл хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шууд цуцлахаар хөдөлмөрийн гэрээнд тусгайлан заасан **ноцтой зөрчил** гаргасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах боломжтой. Эндээс Хөдөлмөрийн тухай хуульд холбогдох зөрчлийг жагсааж хуульчлах боломжгүй бөгөөд ноцтой зөрчлийг ажил олгогч бүр тухайн байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл, онцлогуудыг харгалзан харилцан адилгүйгээр нарийвчлан хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээндээ тусгаж өгөх нь хууль зүйн үндэслэлийн хувьд зөв болохыг харуулж байна.

Түүнчлэн, Хөдөлмөрийн тухай хуулийн 82.3 дахь заалтад, хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр энэ хуулийн 82.1, 82.2-т заасан тэтгэмжийн хэмжээг ¹⁵⁷ /2022/ Хөдөлмөрийн тухай хуульд ...ж болно гэсэн заалт 91,...заасны дагуу гэсэн заалт 43, ...хангах гэсэн заалт 35,...харилцан тохиролцох гэсэн заалт 4, ...тогтоож болно 6, ... хэрэгжүүлэх 21, ...тогтоож болно гэсэн заалт 6 гэх мэт байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааг талууд нарийвчлах болон нөхөн зохицуулах шаардлагатайг илэрхийлж байна гэж үзэж болох юм.

нэмэгдүүлэн олгохоор тогтоож болно гэсэн нь холбогдох хуулиар, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмж олгох тухайлсан зохицуулалтыг /ХтХ 82 дугаар зүйл/ хуульчилсан байдлыг талууд харилцан тохиролцсоны дагуу дүрэм, журмаар /хамтын гэрээ, бусад/ зохицуулах боломжтойг илэрхийлсэн гэж үзэх боломжтой. Мөн Хөдөлмөрийн тухай хууль нь материаллаг зохицуулалт ихтэй, процессын зохицуулалт багатай.

Энэ нь ажил олгогч, ажилтан талууд хөдөлмөр эрхлэлтэй холбоотойгоор процессын зохицуулалтуудыг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай гэх мэт олон заалтуудыг дурдаж болно.

Эндээс дурдвал, ... бэлгийн дарамтыг хориглоно /юуг тооцох, илэрсэн тохиолдолд ямар хариуцлага ногдуулах, шийдвэрлэх албан тушаалтан, холбогдох комиссыг тодорхой болгох, нууцлалыг хэрхэн хангах вэ зэрэг/, ... чөлөө авч болно гэж холбогдох дүрэм, журамд заасныг /хэрхэн хэрэгжүүлэх, хэнд хандах, хэд хоногийн өмнө хандах, ямар хэлбэрээр хандах вэ...гм/ гэсэн нь тодорхой байх нь чухал.

Хөдөлмөр эрхлэлтийн явцад Хөдөлмөрийн тухай хуулийн ерөнхий зохицуулалтыг, нарийвчлан зохицуулаагүй тохиолдолд. Тухайлбал, ажилтан тус хуулийн 82 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр ажлаас чөлөөлөгдөх, халагдах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцааг

цуцлах, дуусгавар болохтой холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмж авах хууль зүйн боломжийг эдэлж чадахгүй байх тохиолдол практикт үүсдэг. Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хууль дахь суурь хэм хэмжээг байгууллагад мөрдлөг болгох дотоод хэм хэмжээгээр нарийвчлан, нөхөн тодорхойлж, бодитой хэрэгжих хууль зүйн боломжуудыг ажилтнуудад олгох нь зүйтэй байна.

Түүнчлэн, Хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотойгоор бусад хуулиудад болон тусгайлсан дүрэм, журмуудаар тухайлан зохицуулсан зохицуулалт байдгийг анхаарах шаардлагатай.¹⁵⁸

Нэг бүрчилсэн хэм хэмжээ нь хэрэглэх ёстой эрх зүйн ерөнхий хэм хэмжээг тусгайлан хэрэглэх акт юм. гэсэнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хууль нь ерөнхийгөөс тусгай руу нарийвчилсан хэм хэмжээгээр хэлбэржиж байж л Хөдөлмөрийн тухай хуулийн зорилт хангагдах нөхцөл нь бүрдэнэ. Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх ойлголт нь

ялгаатай ойлголтууд байдаг. ...Хууль хэрэгжүүлэх түвшинд хэрэглээний тодорхой зарчмыг баримтлах, улмаар эрх зүйн тогтолцооны нэгдмэл байдлыг хангаж ажиллах томоохон үүрэг ноогдож байдаг....Ийнхүү тодорхой хүрээ хэмжээнд эрх зүйн нэгдмэл байдал хэмээх харьцангуй үнэлэмж буй болдог.

Харин энэ нь хууль тогтоох болон хууль хэрэглэх байгууллагын аль алиных нь үйл ажиллагааны ерөнхий суурь болж байдаг, хуульчдын хувьд энгийн, заримдаа бүр ач холбогдолгүй мэт санагдаад байгаа эх сурвалжийн онолоос эхтэй, түүний хэрэгжилттэй нягт холбоотой юм.¹⁵⁹ Тус хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ажил олгогч, ажилтан талуудад хамааралтай. Хөдөлмөрийн тухай хуультай холбоотойгоор ажил олгогч нарийвчилсан хэм хэмжээ гаргахгүйгээр хэрэгжүүлэхийг зорих нь том түлхүүрээр жижиг цоож онгойлгохтой агаар нэгэн буй.

2. Хөдөлмөрлөх эрх ба

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хэрэглээний зарим асуудал

“Хөдөлмөр” хүний амьдрах эрхийн уг сурвалж юм. Хөдөлмөр хүнийг бий болгосон гэсэн үзэл сургаал ч бий болж байлаа. Үүнийг дарвинизмын үүднээс биш юм

¹⁵⁸ Хууль /30% + Хэм хэмжээ тогтоосон акт /70% = Хууль тогтоомж /100% гэж үзэж болох юм. Хууль /30% буюу Хөдөлмөрийн тухай хууль /суурь зохицуулалт/, харин хэм хэмжээ тогтоосон акт /70 %-д нэгдүгээрт, УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, Сайдын тушаал хэлбэрээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд нийтээр заавал дагаж мөрдөхөөр батлагдсан. дүрэм, журам, жагсаалт. Хоёрдугаарт, зөвхөн тухайн байгууллага дотооддоо мөрдлөг болгохоор дээр дурьсан хууль, хэм хэмжээ тогтоосон актад нийцүүлэн гаргасан дүрэм, журам, жагсаалт, гэрээ г.м/

¹⁵⁹ Б.Буянхишиг, “Хувийн эрх зүй: онол-арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал” эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, 7, 8 дахь тал.

гэхэд хүн үндсэн ба үндсэн бус хэрэгцээтэй. Түүнийг хангадаг үйлдэл нь хөдөлмөр гэдэгтэй одоо маргах боломжгүй. Тийм учраас хөдөлмөрийг хувь хүн, нийгмийн хэрэгцээг хангахад чиглэсэн хүний ухамсартай, зорилго чиглэлтэй үйл ажиллагаа,¹⁶⁰ хэрэгцээгээ хангах зорилгоор байгалийн юмсыг өөрчлөх, тохиромжтой болгох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг хүний зохистой үйл ажиллагаа¹⁶¹ гэх зэргээр тодорхойлжээ.¹⁶² Эрх зүйн ойлголтын эх үндэс нь эрх мөн. Эрх бол нэг талаас нийгмийн харилцаанд оролцогчдын зан үйлийн хэмжүүр, нөгөө талаас иргэн, албан тушаалтан, аж ахуй нэгж байгууллагад олгогдсон хууль зүйн тодорхой боломж юм.

Энэ боломж байгалиас заяагдсан жам ёсоор, эсвэл хуулиар нийтэд эсвэл тодорхой субъектэд зөвшөөрөгддөг олгогддог. Үүнээс үндэслэн эрхийг агуулгаар нь жам ёсны, хууль зүйн буюу позитив эрх гэж ангилдаг. Жам ёсны эрхийг төр, ер нь хэн ч бий болгодоггүй, хүн хэмээх бодгаль болж төрснийх нь хувьд байгалиас заяагдсан тийм боломж¹⁶³ юм. Жам ёсны эрхэд хүн амьд явах эрх, эрх чөлөөтэй байх, өмчлөх хөрөнгөтэй байх, гэр орон сууцтай байх гэх зэргийн хүн болж

төрсний хувьд зайлшгүй эдэлж байх ёстой эрх хамаарна. Ийм эрхийг зарим судлаачид “Төрөлх” эрх гэж нэрлэсэн ч бий. Жам ёсны эрхийг төр тогтоодоггүй, төр зөвхөн хүлээн зөвшөөрдөг, хамгаалдаг. Сонгодог утгаараа төр зайлшгүй хамгаалж байдаг эрх юм.

Хууль зүйн позитив эрх гэдэг бол сонгодог утгаараа эрх зүйт төрийн хүсэл зоригийн бүтээгдэхүүн болсон хууль, эрх зүйн хэм хэмжээ бүхий актаар тогтоогдсон, мөн л төрийн хамгаалалтад байдаг эрх юм.

Позитив гэдэг үг нь эрх зүйн тухай философи сэтгэлгээний нэг урсгал чиглэлийн томъёолол бөгөөд түүнийг хууль зүйн позитивизм гэж нэрлэдэг.¹⁶⁴ Гол утга нь эрх зүйд байх ёстой шаардлагуудыг, жишээ нь: нийтийн ашиг сонирхол, шударга ёс, тэгш байдал, эрх, эрх чөлөө, сайн сайхан байдал зэргийг нийтээр сахин мөрдөх албан ёсны хэм хэмжээ болгон тогтоон баталгаажуулж өгсөн хууль гэж ойлгож болно.

Тэгж чадаагүй бол “Хууль” нэртэй байсан ч хууль биш болно. Жинхэнэ позитив эрхийг “Хууль зүйн эрх” хэмээн нэрлэхэд буруудахгүй. Хууль бол эрхээс өмнө бий болсон зүйл биш, харин хуулиас аль хэдийнээ өмнө бий болчихсон эрхийг албан ёсны болгодог, түүний шаардлагыг албажуулсан хэм хэмжээт /норматив/ бичмэл байдлаар хэлбэршүүлсэн баримт бичиг юм.

¹⁶⁴ Д. Лүндээжанцан, Н. Жалбажав, Х. Сэлэнгэ, Д. Отгонтуяа, Эрх зүйн философи, УБ, 2014, 264-269 дэхь тал.

¹⁶⁰ Труд.Энциклопедия социологии

¹⁶¹ <http://ru.wikipedia.org/wiki/Труд>

¹⁶² Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль /шинжлэх ухааны/ тайлбар, УБ, 2022, 200 дахь тал.

¹⁶³ О. Амархүү, Эрх зүйн онол, УБ, 2018, 85 дахь тал.

Позитив эрх нь нийгмийн харилцаанд заавал дагаж мөрдөх дэг журам болж байдаг. Иргэн, хуулийн этгээд, хууль тогтоогчид хүлээн авдаг, дагаж биелүүлдэг, зөрчигдвөл хариуцлага хүлээдэг, эрх зүйг хэрэглэгчид, юуны өмнө шүүх хэмжээ хязгаараас нь хальж гарч болдоггүй эрх зүйн шинжлэх ухааны судалгаанд өртөж, давуутай болон сул талыг нь илрүүлэн нотолж байдаг үндсэн шинж төлөвийг агуулдаг сонгомол утгыг илэрхийлдэг ёстой.

Позитив эрх нь эрх зүйн хэм хэмжээгээр тогтоогддог, мөн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгддөг. Уг эрхийг нийгмийн тодорхой харилцаанд оролцогчид эдэлж эхлэхээр субъектив буюу субъектийн эрх хэмээн нэрлэгддэг. Эрх гэдэг ухагдахууны нэг талын бид боломж гэж нэрлэдэг.

“Хувь хүний эрх бол нийгмийг ёс суртахууны хуульд захируулах арга хэрэгсэл билээ”¹⁶⁵. Хөдөлмөрлөх эрх бол хүний үндсэн эрх юм. Хөдөлмөр эрхлэлт нь амьдралын чанарыг дээшлүүлж, нийгмийн дунд давхрааг өргөжүүлэх, нийгмийн хамгааллыг бэхжүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх үндсэн арга хэрэгсэл, хөшүүрэг юм.

Үүнийг хангахын тулд ажил олгогч болон ажилтан гэсэн хоёр тал хууль ёсны дагуу эрх, үүргээ хамтын зарчмаар хэрэгжүүлдэг. Үндсэн хуулиараа “Монгол Улсын иргэн

ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, ... эрхтэй” гэж заасан. “Хөдөлмөрлөх эрх”-ийг хүний үндсэн эрх гэдгийг хүлээн зөвшөөрч, тунхаглан зарлаж, энэ эрхийг хэн ч, ялангуяа төр, түүний дотроос хууль тогтоогч нарын хөндөж үл болох ёс болгосонд оршино¹⁶⁶ гэжээ.

Хувь хүн болон нийгмийн хэрэгцээг хангах, орлого, баялаг бүтээхэд чиглэсэн иргэдийн зорилго, чиглэлтэй, рационал үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлт гэж ойлгож болно.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, төрийн зохицуулалтын талаарх онолын үндсийг А.Смит, Ж.М.Кейнс, К.Маркс, Ж.Б.Сэй нарыг боловсруулсан гэж үздэг. Шотландын философич Адам Смит “Үндэстний баялаг” хэмээх алдарт бүтээлдээ (Хувийн эрх ашиг, өмч хөрөнгөтэй болохын төлөөх идэвх, чармайлт хөдөлмөрийн хуваарь ба тусгай мэргэшил чөлөөт худалдаа ба өрсөлдөөн гэсэн гурван хүчин зүйл нь улс үндэстний баялаг, ард иргэдийн хангалуун чинээлэг амьдралын эх сурвалж болохыг тэмдэглэсэн. Үүгээрээ бүхий л баялгийн үндэс нь зөвхөн хөдөлмөр болох)-ыг¹⁶⁷ тодорхойлж, баялгийг хөдөлмөрийн бүтээмжээр тодорхойлох шинэ үнэлэмжийг нэвтрүүлснээс гадна

¹⁶⁶ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль /шинжлэх ухааны/ тайлбар, УБ, 2022, 200 дахь тал.

¹⁶⁷ Шотландын философич Адам Смит, Үндэстний баялаг, 2011 он

¹⁶⁵ Айн Рэнд, Капитализмыг өмөөрөх нь, УБ хот, 2005, 73 дахь тал.

хувийн болон нийгмийн баялгийг бий болгоход хөдөлмөр эрхлэлтийн үүрэг, үнэ цэнэ өндөр болохыг нотолжээ.¹⁶⁸

Капиталистууд ажилчин ангийг ажиллах орчин нөхцөлөөр хангаж, ажлын цагийг нь тохиромжтой, хөдөлмөрийн хуваарийг уян хатан болгож, хийсэн ажилд нь тохирох цалин хөлс олгодоггүй боловч тэдний бүтээсэн нэмүү өртгөөр баяждаг.

Энэхүү нөхцөл байдал даамжирвал нэг талаас нийгэмд ажилгүйдэл өсөн нэмэгдэнэ, нөгөө талаас ангийн тэмцэл өрнөж, хүнийг хөдөлмөрөөс хөндийрүүлнэ.¹⁶⁹

Германы улс төр судлаач Карл Маркс ажлын нөхцөл, орчинг сайжруулж, ажиллагчдын эрх ашгийг дээдэлсэн, шударга бөгөөд хүрэлцээтэй цалин хөлс олгосон бол энэ нь сайн хөдөлмөр хэмээн үзэж байсан ба уг санаа Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зохистой хөдөлмөр эрхлэлтийн үзэл баримтлалд тусгалаа олсон юм. Тогтвортой хөгжлийн хөшүүрэг болох зохистой ажлаас дурдвал¹⁷⁰,

SDG 1. Ядууралд амьдарч буй хүмүүсийн хамгийн чухал хөрөнгө бол өөрсдийн хөдөлмөрийн чадвар бөгөөд тэдний хүчин чадал үр бүтээлтэй ажиллах. Тиймээс ядуурлаас гарах гол арга зам бол зохистой хөдөлмөр юм.

¹⁶⁸ Симон Баут ба бусад, 2009 он, 18 дахь тал.

¹⁶⁹ Карл Маркс, *Капитал*, 1999, 272-273 тал.

¹⁷⁰ <https://www.ilo.org/publications/social-impact-investing-quality-jobs-investment-strategies-achieve-cross> /ОУХБ, *Зохистой хөдөлмөр ба 2030 он хүртэл тогтвортой хөгжлийн хөтөлбөр* (2014)/

SDG 2. Эрүүл ажилтан, зохистой, аюулгүй хөдөлмөрийн нөхцөл нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Үүний эсрэгээр, эрүүл мэндийн хувьд шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжгүй байдал, түүнчлэн үйлдвэрлэлийн осол гэмтэл болон өвчин нь хүмүүсийг ихэвчлэн ажиллах хүчнээс гаргаж, ядууралд хүргэдэг.

SDG 3. Бүх эмэгтэйчүүдэд зохистой хөдөлмөр эрхэлж, ижил үнэ цэнтэй ажилд ижил цалин хөлс өгөх нь жендерийн тэгш байдлыг хангах түлхүүр юм.

SDG 4. Шударга орлого, ажлын байран дахь аюулгүй байдал, нийгмийн хамгааллыг чухалчилдаг нь зохистой хөдөлмөр гэж тодорхойлжээ.

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн эх сурвалжийн онол нь зохистой хөдөлмөрлөх, хөдөлмөрлөх эрх, ашиг сонирхлоо баталгаатай эдлэх хууль зүйн боломжийг бий болгоно. Хувийн эрх зүй нь хувь хүний өөрийн зорилгоо хэрэгжүүлэх эрх чөлөөг хамгаалдаг¹⁷¹ гэжээ.

“Хэрэгжилт” гэдэг томъёолол утга агуулгаараа позитив эрх зүйн хэм хэмжээг амьдрал үйл ажиллагаанд бодит байдал болгон хувиргаж, нийгэмд үзүүлэх нөлөөний үр дүнг хүртэх өргөн хүрээтэй ойлголтын хувьд нэр үгээр илэрхийлэгдэнэ. Харин тэр бүхнийг нарийвчлан задлан шинжилж зохих

¹⁷¹ Ernest J. Weinrib, *The Idea of Private Law*, 2012, 1,2.

субъектүүдийн үйл ажиллагаагаар дамжин бодит байдалд хувиргадаг утгаар нь “хэрэгжүүлэх” гэсэн үйл үгээр илэрхийлэх нь монгол хэл зүйн найруулгад илүү нийцэлтэй. Эрх зүйн хэрэгжилт гэдэг ойлголтыг хамгийн товчоор тодорхойлбол: Эрх зүйн харилцааны субъектүүд хууль тогтоомжоор олгогдсон субьектив эрхээ эдлэх, хууль зүйн үүргээ биелүүлэх ухамсарт үйл ажиллагааны үр дүн мөн.¹⁷²

Позитив эрх зүйн бичвэрийг субъектүүдийн зан төлөвөөр дамжуулан амьдралд хэрэгжүүлэх явдал юм.¹⁷³ Энэ хүрээнд Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн зарим асуудлыг объектив, субьектив эрхийн байдлаар авч үзвэл, **Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйл / Хөдөлмөрийн дотоод журам/** Хөдөлмөрийн эрх зүй нь нийтлэг эрх зүй эсвэл иргэнлэг эрх зүйн үндэстэй байх нь эдийн засгийн бүтээмж, үр ашгийн ялгааг тайлбарладаг гэж үздэг.¹⁷⁴ Тус эрх зүй нь холимог эрх зүйд¹⁷⁵ хамаарах талаар судлаачид тодорхойлсон байдаг.

¹⁷² О.Амархүү, *Эрх зүйн онол*, 2018 он, УБ хот.

¹⁷³ Н.А.Пьянов. *Теория государства и права. Часть 2. Теория права “Юристпруденция”*, 2011 стр. 227. /дам ишлэв/

¹⁷⁴ Beth Ahlering and Simon Deakin, ‘Labor Regulation, Corporate Governance and Legal Origin: A Case of Institutional Complementarity?’ (2007) *Law & Society Review* 865 ff. More generally, see Nuno Garoupa and Andrew Morris, ‘The Fable of the Codes: The Effi’ /дам ишлэв/

¹⁷⁵ Ё.Болормаа “Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн зорилт ба хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжлээ”, *Хууль дээдлэх ёс*, №4 /2023/, 85 дахь тал.

Хууль бол зохион байгуулагдсан шударга ёс гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй биз ээ¹⁷⁶ гэсэнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хууль нь тусгай зохицуулалт зайлшгүй шаарддаг. Холбогдох заалтын хэрэгжилттэй холбоотойгоор, тухайлсан байдлаар, бага насны /3-12 насны/ хүүхэдтэй ажилтнуудаас¹⁷⁷ авагдсан судалгааны ерөнхий үр дүнг багцалж авч үзвэл /өглөөд ажилдаа хоцордог, хүүхдээ цэцэрлэгээс нь оройтож авдаг, сургууль цэцэрлэгийн тодорхой арга хэмжээнд хүүхдэдээ цаг зав гаргаж чаддаггүй, сурагчдын улирлын амралтаар, хүүхэд өвдөх үед хүүхэд харах асуудал хүндрэлтэй.../ зэргийг дурджээ.

Энэхүү судалгааны үр дүнгээс гарсан тодорхой асуудал нь ажил олгогчоос заавал дагаж мөрдүүлсэн байх үүрэгжүүлсэн хэм хэмжээ болох хөдөлмөрийн дотоод журамд хэрхэн тусгагдсаныг авч үзвэл,

¹⁷⁶ Фредерик Бастиа, “Хууль”, орчуулсан, Н.Баярбаатар. 2001 он, УБ хот.

¹⁷⁷ Байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журам дахь ажлын цагийн зохицуулалттай холбоотойгоор холбогдох байгууллагуудад ажиллаж буй 70 орчим ажилтнуудаас /4 байгууллагын/ олон нийтийн цахим платформыг ашиглан авагдсан санал асуулгыг дам ашиглав.

№	Шалгуур үзүүлэлтүүд ¹⁷⁸	X1 ¹⁷⁹	X2	X3	X4
	Ажилд ирэх, явах цагийг уян хатан зохицуулсан эсэх	үгүй	үгүй	тийм	үгүй
	Хүүхдээ гэртээ харах /сурагчдын амралт, ханиад хүрэх гэх мэт асуудал үүссэн/ үед цахимаар ажиллах боломжийг бүрдүүлсэн эсэх	үгүй	үгүй	үгүй	үгүй
	Гибрид ¹⁸⁰ ажлын байрны загварын зохицуулалт байгаа эсэх	үгүй	үгүй	үгүй	үгүй

Иргэний журамт харилцаанд хүмүүсийг байгаагаар нь, хуулийг шаардлагатай хэм хэмжээнд нь аваачин, ямар нэгэн зөв шударга, баттай зохицуулалтаар төрийг удирдаж болох эсэхийг би судлахыг хүссэн юм.¹⁸¹ гэсэнтэй адилтган авч үзэж болох юм.

Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн дотоод журмыг заавал батлан мөрдүүлсэн байхыг ажил олгогчид үүрэгжүүлсэн нь практикт хэрэгжиж байгаа боловч дурдсан асуудлын хүрээнд, бодит байдал дээр журмын зохицуулалт үгүй байгааг харж болно.

Үүссэн асуудал нь жижиг мэт боловч үүний цаана хүүхдийн эрх зөрчигдөх, хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, ажлын бүтээмж буурах зэрэг үр дагаврууд үүсэхийг үгүйсгэх аргагүй. Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд ажлын

цагийн дээд хязгаарыг хуульчилсан. Харин аж ахуй нэгж байгууллагууд дээрх асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн үүрэгжүүлсэн хэм хэмжээ¹⁸² болох Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ болон үүрэгжүүлээгүй хэм хэмжээний хүрээнд ч шийдвэрлэх хууль зүйн боломж бий. Тухайлбал, Ажил үүргийн онцлогтой холбоотойгоор ажил эхлэх болон дуусах цагийг уян хатан зохицуулах, зайнаас болон гэрээсээ ажил хөдөлмөр эрхлэх боломжийг эрх зүйн зохицуулалтын хувьд бий болгож шийдвэрлэх зэрэг. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны онцлогт тулгуурласан сурвалжийн онолын ач холбогдлоор илэрхийлэгдэнэ. Ажил олгогч болон ажилтан талуудын эрх, үүрэг нь *Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн хэм хэмжээ тогтоосон акт /тухайлбал, байгууллагын хүрээнд ХДЖ/, хөдөлмөрийн гэрээ /төрлүүд/-ээр* хэлбэржиж хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, талуудын эрх, үүргийн давхцалгүй, тухайлсан

¹⁷⁸ Судалгааны ерөнхий үр дүнгээр тулгамдсан байж болох асуудлуудыг багцалж шалгуур болгов.

¹⁷⁹ Судалгаанд хамрагдсан

байгууллагуудын нэрийг төлөөлүүлэв.

¹⁸⁰ Ажлын уян хатан хэлбэр бөгөөд ажилчдад оффис дээрээ ажиллах эсвэл алсаас ажиллах хоёрын аль нэгийг сонгох боломжийг олгодог хосолсон загвар юм. (ahaslides.com)

¹⁸¹ Жан Жак Руссо “Нийгмийн гэрээ буюу улс төрийн эрхийн зарчмууд”, №1, 19 дэх тал

¹⁸² Үүрэгжүүлсэн хэм хэмжээ нь ажил олгогчийн зүгээс тухайн дүрэм, журмыг заавал батлан мөрдүүлсэн байхыг ойлгох бөгөөд агуулгын илрэл нь императив, диспозитив байх боломжтой.

байдал, хөдөлмөрийн тухай хуулиар үүрэгжүүлсэн¹⁸³ болон үүрэгжүүлээгүй¹⁸⁴ хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний зохицуулалтаар илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн тухай хуулиар зохистой тэнцвэрт байдлыг хуульчлахдаа, аль болох ажил олгогчийг үүрэгжүүлэх /үүрэг, хориглолт, хязгаар/, ажилтанд эрх олгох /эрх, хангамж, баталгаа/ байдлаар илэрдэг. Түүнчлэн холбогдох хуулиудад¹⁸⁵ нэмэгдэл

¹⁸³ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль 122 дугаар зүйл, "Хөдөлмөрийн дотоод журам" /нэмэлт өөрчлөлт/, 7.4 дэхь заалт, "Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам", 45.1 дэхь заалт, "Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам", 43.2.8 дахь заалт, "Хяналтын төхөөрөмж байршуулж, ашиглах журам"

¹⁸⁴ Тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлог, соёл, хүний нөөцийн бодлогоос хамаарна.

¹⁸⁵ Төрийн албаны тухай хууль, Иргэний хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай... мөн түүнчлэн Авлигын эсрэг хууль, Боловсролын хууль, Дипломат албаны тухай, Дээд боловсролын тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай Захиргааны Ерөнхий хууль Иргэний бүртгэлийн тухай, ИХШХШТХ, Компанийн тухай Прокурорын байгууллагын тухай, Тагнуулын байгууллагын тухай, Татварын ерөнхий хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Төр, сум хийдийн харилцааны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай зэрэг

амралт, цалинтай чөлөө, сахилгын шийтгэл, нэмэгдэл зэргийг тусгайлан зохицуулсан байдаг.

Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 3.4 дэх заалтад, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар тусгайлан зохицуулаагүй төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг энэ хуулиар зохицуулна. Харин Төрийн албаны тухай хуулийн 4.3 дахь заалтад, Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

Тус хуулийн 4.4, 41.3 дах заалтад, Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар зохицуулна. Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна гэж хуульчилсан. Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 99.9 дэх заалтад, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл амралтын хугацааг холбогдох хуулиар тогтоож болно гэснийг тухайлбал, боловсролын салбарт харж болно. Боловсролын тухай хуулийн 13.3-т Багш, ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана: 13.3.1. хөдөлмөрийн онцлогийг харгалзан хуулиудыг дурьдаж болох юм

бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15 өдөр, багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох. Тус 13.7-д Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан нэмэгдэл амралт хуулийн 13.3.1-д заасан албан тушаалтанд хамаарахгүй гэж хуульчилжээ. Эндээс, тусгайлсан зохицуулалт бусад хуулиар байгаа тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн нийтлэг зохицуулалт үйлчлэхгүйг анхаарах нь зүйн хэрэг.

Хөдөлмөр эрхлэлтийн явцад холбогдох хууль тогтоомж хэрэгжихгүй байх, хэрэгжилтийн явцад процесс тодорхойгүй байх, ажилтнуудын сэтгэл ханамж, ажил олгогчдын нийгэмд эзлэх байр суурь, бүтээмж буурах, ажилтнууд тогтворгүй болох, ажилтнуудын ажил үүргийн зүй зохисгүй хуваарилалт, холбогдох хөдөлмөрийн дотоод хэм хэмжээн дэхь эрх, үүргийн эсрэгцэл, нарийвчлалгүй байдал зэрэг нь хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй шууд болон шууд бусаар хамааралтайг анхаарах нь чухал.

Эх сурвалжийн онолын хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэхийн зэрэгцээ, холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх асуудал ч хамаарна. Энэ нь

эх сурвалжийн нэгдмэл байдалтай холбоотой. Өмнө дурьдсанчлан Хөдөлмөрийн эрх зүй нь холимог шинжтэй. Нийтийн болон хувийн эрх зүйн хоорондын ялгаа нь Европын эх газар, тэдгээрийн хуучин колони байсан улс орнуудын хувьд маш чухал юм.

Хэдийгээр хоорондын ялгааг хэрхэн эсхүл хаана зурах талаар баталгаатай санал нийлсэн тохиолдол байхгүй ч ерөнхийд нь авч үзвэл нийтийн эрх зүй нь иргэн, төр засгийн хооронд үүсэх харилцааг зохицуулдаг бол хувийн эрх зүй нь нийгэм дэх хувь хүмүүс эсхүл бүлэг этгээдүүдийн хоорондын харилцааг тус тус зохицуулна.¹⁸⁶ Нийтийн болон хувийн эрх зүйг ялгаж байгаа зүйл нь холбогдох зохицуулалтыг зөрчсөн талаар гомдол гаргах эрх хэнд хамаарах вэ гэдэг асуудал юм.¹⁸⁷

Хөдөлмөрийн маргаан нь аль аль салбарт яригдаж байгаагийн хувьд захиргааны хэргийн шүүх, иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг тоймлон харуулбал¹⁸⁸, Практикт¹⁸⁹ хөдөлмөрийн тухай

¹⁸⁶ Рэймонд Вакс “Эрх зүй” товч танилцуулга, ОКСФОРД, 2022, 62 дах тал

¹⁸⁷ Randy E. Barnett, 1986, 270-271

¹⁸⁸ ИХШ, ЗХШ-ээр шийдвэрлэгдсэн Хөдөлмөрийн маргааныг ХтХ шинэчлэн найруулга хийгдэхээс өмнөх 1 жил, шинэчилсэн найруулга нийгдсэнээс хойш 1 жилийг анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг холбогдох хууль тогтоомжийн хэрэглээнд шинжилгээ хийх зорилгоор түүвэрлэсэн болно. Хавсралт №1, 2 харна уу. /Судлаач Ё.Болормаа/

¹⁸⁹ ХтХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс өмнөх нэг жилийн хугацаанд ИХШ-ээр шийдвэрлэгдсэн маргаан нь 12 төрлөөр

хууль тогтоомжийг хэрэглэхтэй холбоотой шүүхийн шийдвэр / ажлаас үндэслэлгүй халагдсан/ ихэнх тохиолдолд ажилд нь эгүүлэн тогтоосон, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгох, төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхээр гарч байгаа нь ажил олгогчид Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг гаргаагүй, гаргасан ч нарийвчлан зохицуулалтгүй, хоёрдмол утгатай, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн зэрэг ажиглагдах нь бий. Энэ нь үйлчлэлтэй байхын тулд хэм хэмжээг тогтоох ёстой. Хэрэв түүнийг тогтоогоогүй бол тэр үйлчлэхгүй. Хэрэв тэр үйлчлэлгүй бол тогтоогдсон зүйл нь хэм хэмжээ биш болж таарна¹⁹⁰ гэдгийн ижил юм. Өөрөөр хэлбэл, Эх сурвалжийн нэгдмэл байдлын онолын үүднээс хөдөлмөрийн хууль тогтоомж нь хэрэгжүүлэлтийн шатанд сайн байх нь, холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх шатанд ч илэрч харагдана гэж үзэж болох юм.

Тухайн байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд ажил олгогч, ажилтан талуудын эрх, үүрэг ерөнхийгөөс тусгайлсан

байдлаар холбогдох хэм хэмжээнд тусгагдсан байх нь тухайн байгууллагын бодлого, хүний нөөцийн менежменттэй салшгүй холбоотойгоор хэрэгжинэ.

Практикт Хөдөлмөрийн тухай хууль дахь талуудын эрх, үүргийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ / тухайлбал, ХДЖ/ болон хөдөлмөрийн гэрээнд гол төлөв хуулбарлах, нэг ижил агуулга, хэлбэржилттэй хөдөлмөрийн гэрээг байгууллагын нийт ажилтнуудтай байгуулах зэрэг нь түгээмэл байдаг. Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээ зэрэгтэй холбоотойгоор харилцан адилгүй дүрэм, журмуудыг байгууллага өөрөө бий болгож, дагаж мөрдөх хууль зүйн боломж нь илүүтэй.

Түүнчлэн талуудын хооронд байгуулагдах хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт нь байгууллагын зорилго, хэтийн зорилтоос урган гарсан байх төдийгүй, бүтэц, бүрэлдэхүүн нь тодорхой байсны дагуу ажилтан бүрийн хийх ажил үүрэг нь харьцангуй тодорхой, давхцалгүйгээр боловсруулагдах, ажил олгогчид бүтээмжийг бий болгох, ажилтны хийх ажил үүргүүд нь тодорхой болж, эзэнжих, хариуцлагажих нөхцөл бүрдэнэ.

Эх сурвалжийн онолын гол чиг үүрэг нь эрх зүй, эрх зүйн хэм хэмжээ гэж юу болохыг тодорхойлох, тэдгээрийг танин мэдэх шалгуур

803 хэрэг шийдвэрлэгдэж байсны, ажлаас үндэслэлгүй халагдсан маргааны 458 хэргийн тодорхой хувьд нь тоймлон авч үзэв. / Судлаач, цаашид шүүхээр шийдвэрлэгдсэн байдалд хууль хэрэглээний дүн шинжилгээ хийхээр ажиллаж байна/

¹⁹⁰ Ханс Кельзен "Хэм хэмжээний тухай ерөнхий онол", 2013 он, УБ хот, 166 дахь тал.

үзүүлэлтийг тодорхойлох, мөн хэм хэмжээний хэрэглээнд тодорхой шат дараалал тогтоох явдал юм.¹⁹¹ Эрх зүйн тогтолцооны хэм хэмжээний шат дараалсан бүтцийг буй болгосноор хэм хэмжээ хоорондоо зөрчилдсөн нөхцөлд хууль хэрэглэгч нь дээд шатны хэм хэмжээг авч хэрэглэх ёстой бөгөөд энэ нь доод шатны хэм хэмжээ үйлчлэх боломжийг хаана.¹⁹²

Харин хөдөлмөрийн тухай хуулийг хэрэглэх нь талуудын хооронд үүссэн маргааныг шүүхээс шийдвэрлэх асуудал бөгөөд "...эрх зүйн тогтолцоонд хандах шинэ үзэл, хандлага баримтлахад нийтийн ба хувийн эрх зүйн тухай сургаалыг тулгуур болгох нь зүйтэй" гэсэн нь Үндэсний эрх зүйн тогтолцоонд хөдөлмөрийн эрх зүй нь нийтийн ба хувийн эрх зүйн аль алинтай нь хамаарал бүхий "Холимог" шинжтэй оршиж байгаатай холбоотойгоор цаашид хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэглээний асуудлыг энэхүү талаас нь эрх зүйн уламжлал, философи, онол, сэтгэлгээний үндэслэлтэйгээр авч үзэж, нэгдмэл хэрэглээг бий болгох нь онолын болон практик ач холбогдолтой байж болох юм.

Дүгнэлт

Хөдөлмөрийн эрх зүй нь үндэсний эрх зүйн тогтолцооны хувьд холимог байхын зэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж нь бусад эрх зүйтэй харьцуулахад хууль батлах түвшинд нэгдмэл байдлаар гарах боломжгүй бөгөөд харин хэрэгжүүлэх шатанд нэгдмэл болгох нь л эх сурвалжийн нэгдмэл байдлын онолтой салшгүй холбоотой юм. Тус салбарт эх сурвалж нэгдмэл байх нь харилцан нөхцөлдсөн хууль батлах, хэрэгжүүлэх, хэрэглэх аль ч шатанд хөдөлмөрлөх эрх, ашиг сонирхлыг хангаж, хамгаалах баталгаа нь болно.

Эх сурвалжийн нэгдмэл байдлын онол, хөдөлмөрийн хууль тогтоомжийн онцлогын хүрээнд хэлбэрийн бус агуулгын зохицуулалтыг бий болгох нь талуудад онолын болон хууль зүйн хувьд өгөгдсөн боломж гэж үзэж болохоор байна. Энэхүү боломж нь ашиглагдвал холбогдох эрх, ашиг сонирхол талуудад хангагдах боломжтой гэж дүгнэж байна. Санал, Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах механизмыг сайжруулах

¹⁹¹ С.Нарангэрэл, "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо", 116 дахь тал

¹⁹² *Lex superior derogate legi inferior* /дам ишлэв/

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Хөдөлмөрийн тухай хууль. 2022

Ном, өгүүлэл, бусад

1. О. Амархүү, Эрх зүйн онол, УБ, 2018, 85 дахь тал
2. Д. Лүндээжанцан, Н. Жалбажав, Х. Сэлэнгэ, Д. Отгонтуяа, *Эрх зүйн философи*, УБ, 2014, 264-269 дэхь тал
3. С.Нарангэрэл, “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо”, УБ, 2001, 116 дахь тал
4. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль /шинжлэх ухааны/ тайлбар, УБ, 2022, 200 дахь тал.
5. Н.Лүндэндорж, ХЗС-иас эрхлэн гаргасан Эрх зүй онол, практик, мэдээллийн цуврал 2-3, УБ, 2007, 229 дэх тал.
6. Б.Буянхишиг, “Хувийн эрх зүй: онол-арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал” эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, 7, 8 дахь тал.
7. Ё.Болормаа “Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн зорилт ба хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэглээ”, Хууль дээдлэх ёс, №1 /2023/, 85 дахь тал
8. Труд.Энциклопедия социологии
9. [http://ru.wikipedia.org/wiki/ Труд](http://ru.wikipedia.org/wiki/Труд)
10. Шотландын философич Адам Смит, *Үндэстний баялаг*, 2011
- 11.Симон Баут ба бусад, УБ, 2009, 18 дахь тал.
12. Карл Маркс, *Капитал*, УБ, 1999, 272-273 тал.
13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн шинжилгээ, УБ, 2020, *Удирдлагын академийн судалгааны тайлан*
14. Артур Оукен “Оукены хууль”
15. Ernest J.Weinrib, The Idea of Private Law, УБ, 2012, 1,2.
16. Н.А.Пьянов. Теория государства и права. Часть 2. Теория права “Юристпруденция”, 2011, УБ, стр. 227.

17. Beth Ahlering and Simon Deakin, 'Labor Regulation, Corporate Governance and Legal Origin: A Case of Institutional Complementarity? (2007) Law & Society Review 865 ff. More generally, see Nuno Garoupa and Andrew Morris, 'The Fable of the Codes: The Effi

18. Фредерик Бастиа, “Хууль”, орчуулсан, Н.Баярбаатар, УБ, 2001

19. Айн Рэнд, *Капитализмыг өмөөрөх нь*, УБ хот, 2005, 73 дахь тал

20. Randy E.Barnett, 1986, 270-271

21. Ханс Кельзен “Хэм хэмжээний тухай ерөнхий онол”, 2013, УБ хот, 166 дахь тал

22. Lex superior derogate legi inferior

23. Рэймонд Вакс “Эрх зүй” товч танилцуулга, ОКСФОРД, 2022 он

24. Жан Жак Руссо “Нийгмийн гэрээ буюу улс төрийн эрхийн зарчмууд”, №1

ХҮНИЙ ГЕНИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ БУЮУ ГЕНИЙН ХУВИРГАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Хууль зүйн докторант

Ц.АМАРСАНАА

ОРШИЛ

Генийн инженерчлэл буюу генийн хувиргалт нь биотехнологийн тусламжтайгаар амьд биетийн генд өөрчлөл оруулах процесс юм. Генийн инженерчлэл бол генетикийн болон биохимийн аргуудыг ашиглан байгаль дээр байдаггүй шинэ нэгдлүүдийг тодорхой зорилгоор гарган авахтай холбоотой шинжлэх ухааны болон хөгжиж ирсэн.

1972 онд эрдэмтэн П.Берги ДНХ-ийн эрлийз молекулыг хуруу шилэнд¹⁹³ буй болгосон үеэс эхлэн генийн инженерчлэлийн үндэс суурь тавигдсан.

Генийн инженерчлэл нь нэг биеийн тодорхой уураг, үйл ажиллагааг хариуцсан генийг нөгөө биед шилжүүлэн суулгаж удамшлын мэдээллийг өөрчлөх замаар хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн биологийн идэвхт болон бусад

¹⁹³ Англи - *In vitro*

бодис нийлэгжүүлэгч эс, эд, биед бий болгоход чиглэгдсэн хавсарга судалгаа юм.

Генийн инженерчлэл¹⁹⁴ нь нэг биеэс нөгөө биед генийг шилжүүлэн суулгахад хэрэгцээт цогц арга технологи юм. Генийн инженерчлэлээр гаргасан авсан амьтан, ургамлыг нийтэд нь генийн өөрчлөлттэй организм¹⁹⁵ гэж нэрлэгдэг. Нарийвчлан хэлбэл шинээр ген нэмж суулгасан амьтныг трансгенийн буюу ген шилжүүлэн суулгасан¹⁹⁶ амьтан гэж тодорхойлдог. Харин өөрийн генийг нь авч хаясан, сольж өөрчилсөн бол нокаут¹⁹⁷ буюу генээ нам цохиулсан амьтан гэж нэрлэдэг байна.

Уг шинжлэх ухааны дэвшилтэд талуудын талаар туршилтуудыг дурдаж болох юм.¹⁹⁸ Харин үүнийг хүн дээр хэрэглэх, турших талаар олон улсын түвшинд хориглож байна. Учир нь уг туршилтын эцсийн үр дагаврыг одоогоор тооцоолох боломжгүй юм. Үүний зэрэгцээ хууль зүйн хувьд тодорхой зарчим, хүний эрхийг асуудал хөндөгдөж байдаг.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага 1997 онд Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглалыг

¹⁹⁴ Англи - *Genetic engineering*

¹⁹⁵ Англи - *Genetically modified organism*

¹⁹⁶ Англи - *Transgenic*

¹⁹⁷ Англи - *Knockout*

¹⁹⁸ <https://legalddata.mn/b/1717>

баталсан. Уг тунхаглал нь заавал дагаж мөрдөх албагүй баримт бичиг боловч гишүүн орнуудыг дагаж мөрдөхийг уриалсан байна. Тус тунхаглалд судалгаа, шинжилгээ, оношилгоо хийх эрх чөлөөг нээлттэй үлдээсэн. Цөөн улс орнуудын хувьд үр хөврөл, үүдэл эдийн эсийг импортлох, экспортлоход тусгай зөвшөөрөл олгож байгаа бол зарим улсад шууд хориглодог. Олон улсад хүний эрүүл мэнд, сайн сайхны төлөө генийн инженерчлэлийг зөвшөөрөх эсэх нь эргэлзээтэй байна.

Монгол Улсын хувьд хүний генетикийн шинжлэх ухаан багагүй ахиц гарч байгаа боловч хууль тогтоомжийн хувьд нарийвчилсан зохицуулалт дутагдалтай хэвээр буйг дурдах нь зүйтэй.

Хүний генийн инженерчлэл нь хүний төсөөллийн хувьд оршин буй биш бодит үр дүн гаргасан үзэгдэл болсон гэдгийг хүлээн зөвшөөрч, түүний хууль зүйн зохицуулалтыг хийх шаардлага үүссэн гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

1. Хүний генийн инженерчлэх буюу хувиргалт хийх ажиллагааны талаар хууль зүйн тулгамдаж буй асуудал

Генийн инженерчлэлийн шинжлэх ухаан нь аль хэдийн амьт биет дээр хийгдэж туршигдсан боловч тэдгээрийн үр ашгийн талаар одоо хүртэл эрдэмтдийн хооронд маргаан үргэлжилсээр байна.

Харин хүний генийг инженерчлэх буюу хувиргалт хийх талаар олон улсын хувьд хориглох байр суурьтай байна. Үүний дагуу олон улсын, бүс нутгийн хэмжээний тунхаг бичгүүд батлагдан гарч зарим улс тэдгээрийг дагаж мөрдөн өөрсдийн хууль тогтоомжид тусган зохицуулж байна.

Тухайлбал, хүний генийг инженерчлэх буюу хувиргалт хийх нь дараах зарчим, хүний эрхийг зөрчих магадлалтай юм. Үүнд:

- Хүний нэр төр.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийн хувьд адил тэгш байна...”¹⁹⁹ гэж заасан байдаг. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²⁰⁰, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактын тунхаглал хэсэгт “... угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх...”²⁰¹, Хүүхдийн эрхийн конвенцийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй”²⁰², Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци²⁰³, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенци²⁰⁴, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий,

¹⁹⁹ <https://legalinfo.mn/mn/detail/1271>

²⁰⁰ <https://legalinfo.mn/mn/detail/1257>

²⁰¹ <https://legalinfo.mn/mn/detail/1284>

²⁰² <https://legalinfo.mn/mn/detail/1276>

²⁰³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1242>

²⁰⁴ <https://legalinfo.mn/mn/detail/1285>

хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци²⁰⁵ зэрэгт тусгасан.

Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн төрөлхтний генетикийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх нь хүн төрөлхтний бүх гишүүн улс орнууд заяагдмал нэр төрд халдаж болзошгүй нийгэм, улс төрийн шинж чанартай аливаа тайлбарыг бий болгох ёсгүй” гэж онцолсон²⁰⁶ бөгөөд тунхаглалын 2 дугаар зүйлийн (а) “Хүн бүр генетикийн шинж чанараас үл хамааран нэр төр, эрхийг хүндэтгэнэ” гэж заасан.

Био ёс зүй ба хүний эрхийн тухай тунхаглалын 3 дугаар зүйлд “...хувь хүний ашиг сонирхол, сайн сайхан байдлыг шинжлэх ухаан, нийтийн ашиг сонирхлоос дээгүүрт тавих ёстой” гэж заасан байдаг.

Бүс нутгийн хувьд Овьедогийн конвенци²⁰⁷, Европын Холбооны Хүний эрхийн дүрэм²⁰⁸, Хүний болон ард түмний тухай Африкийн дүрэм зэрэгт тусгасан байна.

Хүний нэр төр халдашгүй байх бөгөөд генийн инженерчлэл буюу генийн хувиргалт нь судалгаа болон эмнэл зүйн хэрэглээний түвшинд аль алинд нь хүндэтгэлтэй хандах ёстой. Генийн шинж байдал, чанараар нь ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг хориглох, удамшлын

²⁰⁵ <https://legalinfo.mn/mn/detail/1156>

²⁰⁶ Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1997 он. Оршил хэсэг.

²⁰⁷ Oviedo convention

²⁰⁸ Charter of Fundamental Rights of the European Union, 2000/C 364/01.

өвөрмөц байдал, олон янзын байдлыг хүндэтгэн үзэх, хувь хүний ашиг сонирхлыг бусад эрх ашиг, шинжлэх ухааны ололт амжилтаас илүүд үзэх шаардлагатай байна.

- Бие махбодын бүрэн бүтэн байдлыг хангах эрх.

Уг эрх нь өргөн цар хүрээтэй ойлголт бөгөөд амьд явах эрхээс ялгагдах онцлогтой. Тухайн генийн бүрэн бүтэн, гадны нөлөөлөлгүй байх нөхцөлийг хангах, өөрийн генийн бусад хүчин зүйлийн нөлөөллөөс ангид байлгах эрх гэж энгийнээр ойлгож болох юм.

Еровпын Холбооны Хүний эрхийн дүрэмд хүний бие бялдар, оюун санааны бүрэн бүтэн байдалд нөлөөлөх ноцтой болон хүндэвтэр хэлбэрүүд, түүнчлэн зөвшөөрөлгүй аливаа эмнэлгийн эмчилгээ хийхийг хязгаарласан байдаг. Бие махбодын халдашгүй байдлын эрхийг шинжлэх ухааны судалгаа хийх эрх чөлөөг шууд хязгаарлах явдал гэж тодорхойлсон.

Үр хөврөлийг генийн инженерчлэл болон бусад хууль бус судалгаанаас хамгаалах, аливаа үр удамд генд өөрчлөлт оруулахыг туйлын хориглосон нь бие махбодын бүрэн бүтэн байдлыг хангах эрх нь үр хөврөл тэр ч байтугай хойч үедээ ч хамааралтай гэдгийг харуулж байна.

- Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрх.

Генийн инженерчлэлийн судалгааны үр шимийг судлаачид хүртэх эрхтэй бөгөөд гагцхүү хувь хүний

нууцаар хязгаарлагдана. Гэхдээ зарим улс уг судалгааг хуулиар хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь уг эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж байдаг. Шинжлэх ухааныг зүй бусаар ашиглах, сөрөг нөлөөллөөс хамгаалах ёстой. Мөн бусад хүний эрхийн асуудал урган гарч ирнэ. Тухайлбал, ялгаварлан гадуурхахгүй байх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх зэрэг асуудал хөндөгдөнө.

2. Хүний генийн инженерчлэлийн зарим улсын хууль тогтоомжийн зохицуулалт

АНУ

АНУ-ын хувьд генийн инженерчлэлийг хориглодоггүй боловч үр хөврөл, ялангуяа үр хөврөлийн генийн инженерчлэлтэй холбоотой судалгааны санхүүжилтэд хязгаарлалт тавьдаг. Хуулиар хүний үр хөврөлийг “эхийн хэвлийд байгаа ургийн судалгаанд зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн устгах, гэмтээх, үр үхэх” эрсдэлтэй судалгааг санхүүжүүлэхийг хориглодог.

Шинжлэх ухаан, технологийн бодлогын алба²⁰⁹ нь биотехнологийн бүтээгдэхүүний холбооны зохицуулалтын тогтолцоог шинэлэхээр ажиллаж байгаа бөгөөд генийн инженерчлэл, түүний хэрэглээний зохицуулалтын бодлого тодорхой болгохоор ажиллаж байна.²¹⁰ Үүнтэй

зэрэгцэн муж дотоодын эрх зүйн зохицуулалтаар шууд хориглосон байдаг. Тухайлбал, Калифорнийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуульд “хүний эсээс өөр хүний бус өндгөн эс рүү шилжүүлэхийг хориглох” зохицуулалтыг тусгасан байдаг.²¹¹

ОХУ

ОХУ-ын Иргэний хуульд хүний үр хөврөлийн генетикийн бүрэн бүтэн байдлыг өөрчлөх аргуудыг патентлахыг хориглосон заалтын 2014 онд оруулсан.²¹² Мөн Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хуулиар эмнэлгийн үзлэг, оношилгоонд орж байгаа эмэгтэй өөрийн генетикийн шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлэл авах эрхтэй байдаг.²¹³

Мөн 2016 онд генийн инженерчлэлийн үйл ажиллагааны чиглэлийг генийн оношилогоо, генийн эмчилгээнээс бусад тохиолдолд хүний эд, эсийг генийн инженерчлэлийн арга ашиглахыг хориглосон байна. Түүнчлэн Био анагаахын бүтээгдэхүүний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4-т “Бир анагаахын эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор хүний үр

²¹¹ California Health and Safety Code, Sec. 24185-24187.

²¹² ОХУ-ын Иргэний хуулийн 1349 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг. 2,3-т 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 35-ийн Холбооны хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

²¹³ Russian Citizens Health Protection law No. 5487-I, 22 July 1993 (as amended 2009), Art.35(4).

²⁰⁹ Office of Science and Technology Policy

²¹⁰ <https://www.fda.gov/downloads/Food/IngredientsPackagingLabeling/GEPlants/UCM537311.pdf>

хөврөлийг бий болгохыг хориглоно” гэж заасан байна.²¹⁴

ИЗРАЙЛ

Израйль улс нь генетикийн хөндлөнгийн оролцоог хориглох тухай хуультай бөгөөд тус хуулиар ёс суртахуун, хууль зүй, нийгэм, шинжлэх ухаан, хүний нэр төрд үзүүлэх нөлөөллөөс хамаарч тодорхой төрлийн генетикийн үйл ажиллагааг хориглодог. Гэхдээ анагаах ухааныг хөгжүүлэхийн тулд шинжлэх ухааны судалгааны эрх чөлөөг харгалзан үздэг байна.²¹⁵

Дээрх хуулиар хүн бүтээхийн тулд (үр хөврөлийн генийн эмчилгээ) зориудаар генийн өөрчлөлт орсон нөхөн үржихүйн эс суулгахыг хориглодог. Хэрэв зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд дөрвөн жил хүртэл хорих ял оноодог. Гэхдээ хүний нэр төрд халдахгүй гэж үзэж зөвлөх хорооны зөвлөмж, түүний тогтоосон нөхцөлийн хүрээнд генийн инженерчлэл хийх эрхийг сайдын зөвшөөрлөөр олгодог.

ЭНЭТХЭГ

Генийн инженерчлэл буюу засварлахтай холбоотой гол хууль нь 1994 оны Жирэмслэхээс өмнө ба төрөхийн өмнөх оношилгооны аргын

²¹⁴ “The Regulation of Genome Editing and Human Reproduction Under International Law, EU Law and Comparative” Law.Dr Rumiana Yotova.June 2017.p 50.

²¹⁵ *Prohibition of Genetic Intervention (Human Cloning and Genetic Manipulation of Reproductive Cells) Law 5759-1999, Art.1.*

тухай хууль²¹⁶ юм. Энэхүү хуулийн зорилго хүйс сонгохыг хориглох бөгөөд оношилгооны төрлийг²¹⁷ нарийвчлан зааж өгсөн байдаг.

Анагаах ухааны судалгааны зөвлөлөөс гаргасан генийн инженерчлэл буюу засварлах хоёр багц заавар байдаг.²¹⁸ Нэгдүгээрт генийн судалгааны тусгай зарчмуудыг тусгаж өгсөн. Хоёрдугаарт 2017 оны Үүдэл эсийн судалгааны үндэсний удирдамжийн төсөл байна. Дээрх удирдамж нь дагаж мөрдөх албагүй бөгөөд зөвлөмж хэлбэртэй байна.

ЯПОН

Япон улсын ген засварлах зохицуулалтыг 2002 оны генийн эмчилгээний эмнэлзүйн судалгааны удирдамжид тусгасан. Удирдамжид “генийн эмчилгээ гэж өвчнийг эмчлэх зорилгоор хүний биед ген эсвэл генийг нэвтрүүлсэн эсийг удирдах” гэж тодорхойлсон байна.²¹⁹ Генийн эмчилгээний эмнэлзүйн судалгаа нь удамшлын ноцтой эмгэг, хорт хавдар, дархлал олдмол хомсдол болон бусад амь насанд аюултай өвчин, биеийн үйл ажиллагааг ихээхэн доройтуулдаг эмгэг зэрэг олон шаардлагыг хангах ёстой байдаг.

²¹⁶ *Pre-Conception and Pre- Natal Diagnostic Techniques Act 1994 (as amended 2002).*

²¹⁷ *Хромосын эмгэг, удамшлын бодисын солилцооны өвчин, гемоглобинопати, хүйстэй холбоотой удамшлын өвчин, төрөлхийн гажиг болон Хяналтын төв зөвлөлөөс тогтоосон бусад эмгэг, өвчин.*

²¹⁸ http://www.icmr.nic.in/ethical_guidelines.pdf

²¹⁹ *Japan Guidelines on Gene Therapy Clinical Research 2002 (as amended 2008), s.2(1).*

Удирдамжид зааснаар үр хөврөлийг засварлахыг шууд хориглодог.

ГЕРМАН

Германы генийн засварлахтай холбоотой харилцааг Үр хөврөлийг хамгаалах тухай хуулиар зохицуулдаг байна. Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний үр хөврөлийн эсийн удамшлын мэдээллийг зохиомлоор өөрчилсөн хүнийг тав жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ”, мөн хуулийн хоёр хэсэгт “Хүний бэлгийн эсийг зохиомлоор өөрчилсөн удамшлын мэдээлэл бүхий бэлгийн эсийг үр тогтоолгох зорилгоор ашигласан этгээдэд шийтгэл ногдуулна.” гэж заасан байна. Мөн түүнээс олсон орлогыг хураан авах зохицуулалтыг гурав дахь хэсэгт тусгасан байна.²²⁰

МЕКСИК

Мексик улсад хүний генетиктэй холбоотой бие даасан хуульгүй боловч 1997 онд баталсан Эрүүл мэндийн ерөнхий хуулиар зохицуулж байна. Тус хуулиар үргүйдлийн эмчилгээ, нөхөн үржихүйн эрхийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд генийн засварлах, өөр бусад байдлаар ашиглахыг хориглосон байна.

Эрүүл мэндийн тухай ерөнхий хуульд хүний генийг “хүний төрөл зүйлийн шинж чанар бүхий удамшлын бүх мэдээллийг агуулсан,

²²⁰ https://www.bundesgesundheitsministerium.de/fileadmin/Dateien/3_Downloads/Gesetze_und_Verordnungen/GuV/E/ESchG_EN_Fassung_Stand_10Dez2014_01.pdf

хүний биологийн үндсэн нэгдэл, олон янз байдлын үндэс болсон удамшлын материал”²²¹ гэж тодорхойлжээ. Мөн хүний гентэй холбоотой мэдлэг нь хүн төрөлхтний өв бөгөөд шинжлэх ухаан, технологийн хөгжил нь эрүүл мэндийг хамгаалахад чиглэх, хүний эрхийг нэн тэргүүнд байхаар хуульчилсан байна.

Эрүүгийн хуулийн 154 дүгээр зүйлд “Хүнд өвчин, нөхцөл байдлыг арилгах, таслан зогсоохоос өөр зорилгоор хүний генийг өөрчилсөн байдлаар генотипийг өөрчилсөн этгээдийг зургаан жил хүртэл хугацаагаар хорих, мэргэжлээрээ ажиллах эрхийг хасах эсхүл түдгэлзүүлэх шийтгэл оногдуулдаг.”²²² Мөн Эрүүгийн хуулиар хориглосон үйлдлийн улмаас хүүхэд төрснөөс үүдэн гарах иргэний эрх зүйн үр дагавар, хохирлыг барагдуулах, асаргааны төлбөрийг төлөх²²³ зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

АВСТРАЛИ

Австрали улс 2002 онд Хүний нөхөн үржихүйн хувилалтыг хориглох тухай хуулиар генийн өөрчлөлтийг эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. Тус зохицуулалтад хүний генийн өөрчлөгдсөн байдал нь үр удамд дагаж удамшихаар өөрчилсөн болон түүнийг төлөвлөж бэлтгэсэн бол

²²¹ General Law on Health. Art. 103.

²²² Art. 154 (3) Código Penal para el Distrito Federal

²²³ Art. 155 (3) Código Penal para el Distrito Federal

гэмт хэрэг гэж үзнэ. Уг гэмт хэрэгт 15 жил хорих ял шийтгэхээр тусгасан байна.²²⁴ Мөн хуулиар хориглосон үр хөврөлийг импортлох, экспортлох, хадгалахыг гэмт хэрэгт тооцдог.

ФРАНЦ

Францын Иргэний хуулиар хүний үр хөврөлийг өөрчлөх, удамшлын шинж чанарыг өөрчлөх, удамшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэхэд чиглэсэн судалгаа хийхийг хориглодог.²²⁵ Мөн Био ёс зүйн хуульд хүний удамшлын шинж чанарыг өөрчлөх аргуудыг патентлах боломжгүй гэж заасан байдаг.

Эрүүгийн хуулиар евген²²⁶ болон нөхөн үржихүйн клончлолыг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлж, хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах евгений дадлыг хэрэгжүүлбэл гучин жил хорих, 7,500,000 еврогийн торгууль ногдуулна гэж заасан байдаг.²²⁷

Дээрх улсуудын хууль, тогтоомжид хүний генийн инженерчлэлийн талаар тодорхой зохицуулалтыг

²²⁴ Art. 15, *Prohibition of Human Cloning for Reproduction Act 2002 (as amended 2008)*.

²²⁵ Art. 16-4 *Code civil (1804) (as amended March 2017)*.

²²⁶ Түүхээс харахад евгеникстууд хүний удмын санг өөрчлөхийг оролдсон нь бусдаас доогуур гэж үнэлэгдсэн хүмүүс, бүлгүүдийг хасч, эсвэл илүү гэж дүгнэгдсэн хүмүүсийг сурталчилж байв. Сүүлийн жилүүдэд энэ нэр томъёо нь CRISPR, генетикийн скрининг зэрэг шинэ технологиудын хэрэглээний талаарх биоэтикийн хэлэлцүүлэгт сэргэж, эдгээр технологийг евгеник гэж үзэх хандлага байна.

²²⁷ Art. 214-1, *Code Penal (as amended April 2017)*.

агуулж байгаа боловч нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна. Үүнтэй уялдан хүний генийн инженерчлэх ажиллагааны үр дүн эцэслэн батлагдаагүй учир түүнд улс бүр хориглох, хязгаарлах болон тодорхой зөвшөөрлийн хүрээнд судалгаа хийх эрхийг нээлтэй байдлаар хуульчилжээ.

ДҮГНЭЛТ

Хүний генийн инженерчлэл буюу хувиргалтын талаар олон улсын болон бүс нутгийн түвшинд хориглох талаар гишүүн улсуудад уриалга дэвшүүлж байгаа боловч хүний сайн сайхан, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, судалгаа шинжилгээ хийх эрхийг хангах хүрээнд тодорхой хэмжээнд хязгаарлалт тогтоон зөвшөөрч байна.

Хүний генийн инженерчлэл буюу хувиргах ажиллагаа нь шинжлэх ухааны олон салбарын дунд маргаан дагуулсан асуудал юм. Учир нь түүний үр дагаврын нөлөөлөл хэрхэн гарч ирэх талаар дүгнэлт нь таамаглал төдий хэвээр байна.

Түүнчлэн хууль зүйн хувьд хүний эрхтэй шууд холбоотой асуудал учир таамаглалд үндэслэж генийн инженерчлэлийн үйл ажиллагааг шийдвэрлэх боломжгүй юм.

Хуулиараа үүнийг хүлээн зөвшөөрснөөр хүний эрх хөндөгдсөн тохиолдолд түүнээс үүдэн гарах үр дагаврыг нөхөн сэргээх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна. Харин гадаадын зарим улсад хүний сайн сайхан, эрүүл

мэндийн хамгаалах тохиолдолд генийн инженерчлэл буюу хувилах ажиллагааг зөвхөн судалгааны үйл ажиллагаа явуулах хүрээнд хүлээн зөвшөөрч байна.

Зарим улсын хууль тогтоомжийн зохицуулалтаас авч үзвэл дараах байдлаар генийн инженерчлэлийн хүрээ хязгаарыг тогтоосон байна. Үүнд:

1. Хүний генийн судалгаа, түүнийг хувиргах;
2. Хүний үр хөврөлийн явцын судалгаа, түүнийг хувиргах;
3. Ерөнхий судалгаа буюу зөвхөн нөхөн үржихүйн бус бусад хүний генийн судалгаа гэж ангилан авч үзэж болох юм.

АНУ, ОХУ, Израйл, Энэтхэг, Япон, Герман, Мексик, Австрали, Франци улсуудын хуульд хүний генийн инженерчлэл буюу хувиргах ажиллагааг бие даасан хууль болон холбогдох хуулиар хориглосон байна. Зарим улсын хувьд зөвхөн шинжилгээний хувьд зөвшөөрч байгаа бөгөөд түүнийг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл эсвэл төрийн байгууллагын хяналтын дагуу хийж гүйцэтгэж байна. Мөн уг хориглосон үйл ажиллагааг хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулах, иргэний нөхөн төлбөр гаргуулах зэрэг зохицуулалтыг тусгажээ.

НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ, конвенци

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
4. Хүүхдийн эрхийн тухай конвенци
5. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци
6. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенци
7. Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал
8. Био ёс зүй ба хүний эрхийн тухай тунхаглал
9. Африкийн Хүний болон ард түмний тухай дүрэм.
10. Европын Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Хууль, тогтоомж

1. Австрали улсын Хүний нөхөн үржихүйн хувилалтыг хориглох тухай хууль.2002 он
2. Израйл улсын Генетикийн интервенцийг хориглох тухай хууль.1999 он
3. Мексик улсын Эрүүл мэндийн ерөнхий хууль.1997 он
4. ОХУ-ын Иргэний хууль.2014 он
5. ОХУ-ын Иргэний эрүүл мэндийг хамгаалах тухай хууль.1993 он
6. Францын Эрүүгийн хууль.2017 он
7. Энэтхэг улсын Жирэмслэлт ба төрөхийн өмнөх оношилгооны аргын тухай хууль.1994 он

Ашигласан ном, сурах бичиг

1. “Хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх ажиллагааны талаарх хууль зүйн зохицуулалт” Ц.Амарсанаа.2023 он
2. “The Regulation of Genome Editing and Human Reproduction Under International Law, EU Law and Comparative” Law.Dr Rumiana Yotova.June 2017
3. Japan Guidelines on Gene Therapy Clinical Research 2002

Ашигласан цахим хуудас

www.legalinfo.mn

www.legaldata.mn

www.fda.gov

www.icmr.nic.in

www.bundesgesundheitsministerium.de

**ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ, ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС
БАЙДЛЫН ЗАРЧИМ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДАГАВАР**



Хууль зүйн докторант, Шихихутуг
их сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн ахлах багш
Э.АНХБАЯР

Шүүгчийн хараат бус байдал гэдэг бол шүүгч хэний ч нөлөөнд автахгүй, хууль бус юунаас ч хамаарахгүйгээр гагцхүү хуульд захирагдан, аливаа хэрэг маргааныг бие дааж шийдвэрлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ, тэгж ажиллаж чадахыг хэлнэ.

Харин шүүхийн бие даасан байдал нь юуны өмнө хараат бус ажиллаж байгаа шүүгчийнхээ үйл ажиллагаагаар хангагдана.

Шүүхийн бие даасан байдал гэдэг нь Монгол улсын Үндсэн хууль, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөнөөс ангид оршин тогтнож, шүүх эрх мэдлийг бие даан хэрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн хэрэг юм. Үүний сацуугаар шүүх эрх мэдэл бие даасан байна гэдэг нь

хууль, шүүхийн байгууллагын үйл ажиллагааг хэн ч шүүмжлэх ёсгүй, тэд өөрсдийн дураар ажиллах, ямар ч хяналтгүй, харилцан хамааралгүй онцгой байгууллага, эрх мэдэлтэй гэсэн хэрэг биш²²⁸.

Шүүх, шүүгчийн ёс зүй, үнэнч шударга байдалд итгэх ард түмний илтгэл нь өнөөгийн хүмүүнлэг ардчилсан нийгмийн амин сүнс билээ.

Хараат бус, бие даасан шүүхийн нэр хүндийг ариун байлгах гол нөхцөл нь шүүгч гагцхүү Монгол Улсын үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдан шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй чанд сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа ямагт үнэнч байх явдал бөгөөд шударга, хариуцлагатай байх, хууль дээдлэх, хүн бүрд адил тэгш хандах, шүүхийн нэр хүндийг өндөрт өргөх нь шүүгчийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн²²⁹. Сонгодог улс төрийн эдийн засгийн ухааныг үндэслэгчдийн нэг Адам Смит бичихдээ: “Ямар нэг улсыг бүдүүлэг аж байдлын

²²⁸ Д.Лүндээжанцан., Төрийн эрх мэдлийн хуваарилалт., УБ., 2014 он., 340 дах тал

²²⁹ Шүүгчийн ёс зүй ба сахилга сэдэвт олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа., 31 дэх тал /Монгол улсын шүүхийн ёс зүйн хорооны гишүүн В.Жавхлан., Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм түүний хэрэгжилт, тулгамдсан зарим асуудал илтгэлээс эшлэв/

доод шатнаас сайн сайхны өндөр дээд шатанд дэвшүүлэхэд зөвхөн гурван үндсэн нөхцөл, тодруулбал: энх амгалан амьдрал, зохимжит татвар татаас, **боломжийн шүүх байгууллага** хэрэгтэй бөгөөд бусад нь цөмөөрөө зүй ёсны явдал дундаа өөрөө аяндаа төлөвшинө” гэжээ. Сонгодог сэтгэгч энэ хүн шүүх эрх мэдэлд ийм өндөр ач холбогдол өгч байжээ. **“Боломжийн”** гэдэг утга санааг тодруулж, олон зүйлийг өгүүлж болох боловч, энэ утгаа өдгөөчилж авч үзвэл, хэн нэгэн албан тушаалтан аль нэг байгууллагын засаглах эрх мэдэл хийгээд өнгө, мөнгө, үзэл суртал, намын чиглэл, удирдамж, хүчирхийллийн ямар нэгэн зүйлээс хараат бус зөвхөн хуульдаа захирагддаг, шударга ёсны баталгаа болсон шүүх эрх мэдлийн тухай яригдаж, түүнийг мөрөөдөж байсан нь гарцаагүй²³⁰.

Хүн бүхэн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн шүүхийн шаардлагыг хангасан иргэний болон эрүүгийн шүүн таслах ажиллагаагаар хэргээ таслуулах эрхтэй. Шударга шүүхийн ажиллагаа нь холбогдох талуудад урьдчилан мэдэгдсэн байх, нээлттэй хуралдаанаар хэргээ хэлэлцүүлэх, үг хэлэх, нотлох баримт гаргах, гэрч дуудах, шударга бөгөөд **хараат бус шүүгчээр** хэргээ шийдүүлэх шүүхийн шийдвэр нь олон улсын шударга шүүхийн жишигт нийцсэн байх зэрэг

шаардлагыг хангасан байна²³¹. Шударгаар шүүлгэх нь хүний эрх юм. Энэ нь дэлхийн улсууд 1948 онд байгуулсан, олон улсын хүний эрхийн тогтолцоонд тулгийн чулуу болсоор байгаа. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд тусгагдсан, бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн суурь баталгаануудын нэг юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар баталгаажсан **шударгаар шүүлгэх эрх нь** олон улсын заншлын эрх зүйн нэг хэсэг болохынхоо хувьд бүх улсад заавал биелэгдэх хүчин чадалтай үйлчилж байна. Нөгөө талаасаа хүн бүрийн эрхийг хүндлэх нь шударга байдлын үндэс юм.

Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд “Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг эш үндэс болгон хэмээсэн байдаг”²³².

Монгол улсын шүүхийн тухай хуулиар Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, **шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах**, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг

²³⁰ Д.Лүндээжанцан., *Төрийн эрх мэдлийн хуваарилалт.*, УБ., 2014 он., 338 дах тал

²³¹ Х.Викор Кондэ., *Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага.*, 2002 он., 54 дэх тал

²³² *Эмнести интернэшнл.*, *Шударгаар шүүлгэх эрх.*, гарын авлага., 2014., 15 дах тал

тодорхойлох, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулахад оршино²³³ хэмээн зохицуулаад мөн тус хуульд **шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг** хуульчлахдаа: Шүүх нь шүүх эрх мэдлийг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг алдагдуулсан хууль тогтоомж болон хэм хэмжээний акт гаргахыг хориглоно.

Бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, тухайлсан хэрэг, маргаантай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглоно. Шүүх нь Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөрөөс бусад хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглоно.

Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна.

Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.²³⁴ гэж зохицуулсан байна.

Шүүхийн бие даасан байдлын агуулгад шүүгч хэрэг маргааныг хуулийн хүрээнд, зөвхөн хуульд захирагдах өөрийн мэргэшлийн эрх зүйн ухамсар, ёс зүй, ёс суртахуун, мэргэшлийн мэдлэг туршлагадаа тулгуурлан дотоод итгэл үнэмшлээрээ бие даан шийдвэрлэх нь багтах учиртайг хэлэх ёстой²³⁵.

Харин шүүхийн хараат биш байдал гэдэг нь бүх шатны шүүх, шүүгчид улс төр, эдийн засгийн болон аливаа бусад нөлөөллөөс ангид байх, хэрэг маргааныг шийдвэрлэх нөхцөл, боломжийг тодорхойлсон ойлголт юм.

Шүүгчийн хараат биш байдал гэдэг нь “Зөвхөн хэрэг шийдэхэд биш” харин шүүх эрх мэдлийг бие даан хэрэгжүүлэгчийн хувьд албаны болон хувийн аль ч талаар ямар ч байгууллага, албан тушаалтан, түүний дотор шүүхийнхээ дарга, бусад хэний нөлөөнд автах ёсгүй” түүнчлэн улс төрөөс ангид алба амьдралын нөхцөлтэй, мэргэшил ёс зүйн хаттай байх гэсэн үг²³⁶ юм.

²³⁴ egalinfo.mn/mn/detail?lawId

²³⁵ Лүндээжанцан., Төрийн эрх мэдлийн хуваарилалт., УБ., 2014 он., 380 дах тал

²³⁶ Б.Чимид., Үндсэн хуулийн мэдлэг., 309 дэх тал /дам эшлэв/

²³³ Монгол улсын шүүхийн тухай хууль., 2021 оны шинэчилсэн найруулга., 1 дүгээр зүйл

Шүүгчийн хараат бус байдал нь **хараат бус ажиллаж байгаа шүүгчийнхээ үйл ажиллагаагаар хангагдах** тул шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие заасан байдлыг хангахын тулд шүүгчийг хараат бусаар ажиллах нөхцөлийг хангахыг зорьсон байна.

Шүүх эрх мэдлийн асуудал Үндсэн хуулийн эрх зүйн бие даасан институт болж олон улс орны Үндсэн хуульд баталгаажсан байдаг. Тухайлбал, шүүх хараат бус гагцхүү хуульд захирагдах зарчим нь АНУ-ын Үндсэн хуулийн зүйлийн 1, Японы Үндсэн хуулийн 76-р зүйл, Испанийн Үндсэн хуулийн 176-р зүйл, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 92-р зүйлд тус тус хуульчлагджээ²³⁷.

Манай улсын хувьд Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл бие даасан бүлэг болж орсон бөгөөд 47-56 дугаар зүйлүүдэд шүүхийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим зэрэг шүүх эрх мэдлийн суурь асуудлууд зохицуулагдсан юм. Эдгээр заалт нь шүүхийн тухай хуулиар улам нарийвчлагдан зохицуулагдсан билээ. Өөрөө хэлбэл **шүүх нь бие даасан, шүүгч нь хараат бусаар шүүн талсах үйл ажиллагаа явуулах нь** хүний хүний эрхийн баталгааны үндэс болдог учраас хүн төрөлхтөн олон зууны тэртээгээс шүүх шударга байх, шүүгч хараат бус байх нөхцөл боломжийг олон улсын

хэм хэмжээ болон дотоодын эрх зүйн зохицуулалтаар хангаж ирсэн байна. Үүний нэг илрэл нь манай улсын хувьд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дурдаж болохоор байна.

Тус хуулиар манай улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, **шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахтай** холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна. Тухайлбал **бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна** гэж зохицуулсан байна.

Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлалд маш олон хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнээс шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлын зарчим, түүний хэрэгжилт, үр дагавар дээр төвлөрөн судалгаа хийхийг зорилоо.

Учир нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх эрх зүйн зохицуулалтуудыг нэлээдгүй суд-лаачид олон талаас нь харж судалсан.

Үүний ачаар эрх зүйн зохицуулалтууд боловсронгуй болон хөгжиж байна. Гэвч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-т заасан **“Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүгчийн**

²³⁷ Лүндээжанцан., Төрийн эрх мэдлийн хуваарилалт., УБ., 2014 он., 342 дах тал

хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна” гэж заасан зохицуулалтын хэрэгжилт анхаарал татаж байна.

Тухайн зарчмын хэрэгжилтийг судлахын тулд оюуны түрүүнд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүгчид ямар шаардлага тавигддаг, мөн дээрх зарчим нь зохих ёсоор хэрэгжээгүйн үр дагавар нь шүүхийн хараат бус, шүүгчийн бие даасан байдалд хэрхэн нөлөөлөхийг судалъя.

Өөрөөр хэлбэл шүүгч гэж хэн болох ажил мэргэжлийн онцлог, шүүгч болоход тавих шаардлага нь шүүгчийн хараат бус байдалд хамааралтай эсэх, шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд хэрхэн нөлөөлөх, түүний үр дагавар, гарах арга замыг судлахыг зорьсон болно.

Ардчилсан нийгэмд шүүхийг хүмүүс засаг төрийн эрх барихын төлөө биш харин өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, аж амьдралынхаа нийгмийн хэвийн нөхцөлийг сахих хамгаалахын төлөө байгуулдаг байна.

Ийм шүүхийг ардчиллыг хамгаалах “араа шүд” гэдэг²³⁸ байна. Шүүх, шүүгч бүр шүүх эрх мэдлийг бүрэн төгс бие даан хэрэгжүүлдэг нь түүний эрх зүйн байдлын хосгүй онцлог мөн²³⁹. Тэгвэл шүүгч гэдгийг Монгол улсын үндсэн хуулийн

51.3 дугаар зүйлд: “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; **хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно**” гэсэн бол 2013 оны хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19.6-р зүйлд “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр хуульч нь өмгөөлөгч, прокурор, **шүүгчээр** ажиллана” гэсэн эрх зүйн зохицуулалт хийж өгсөн байна.

Хуульч гэдгийг нарийвчлан судалбал: хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд байх бөгөөд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тогтоосон зарчим, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг баталгаажуулсан албан ёсны баримт бичгийг хэлнэ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар хуульчийн шалгалтад тэнцэж батламж авсан этгээд батламж авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор Хуульчдын холбоонд гишүүнээр элсэх өргөдөл гаргах бөгөөд өргөдөлдөө дараах баримт бичгийг

²³⁸ Д.Лүндээжанцан., *Төрийн эрх мэдлийн хуваарилалт.*, УБ., 2014 он., 376 дах тал

²³⁹ Б.Чимид., *Үндсэн хуулийн мэдлэг.*, 305, 306 дах тал /дам эшлэв/

хавсаргана:

✓ хуульчийн шалгалтад тэнцсэн батламж

✓ ял шийтгэгдэж байгаагүйг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт

✓ **хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүйг нотолсон эрүүл мэндийн тодорхойлолт.** Хуульчдын холбоо нь өргөдөлд хавсаргасан баримт бичгийн үнэн зөв байдлыг шалгаж, хуульчид тавигдах зан байдлын болон **эрүүл мэндийн шаардлагыг харгалзан** гишүүнээр элсүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Хуульчдын холбоо өргөдөл гаргагчийг гишүүнээр бүртгэж авсан тохиолдолд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан этгээд хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэх эрхтэй болно²⁴⁰.

Дээрхээс дүгнэхэд:

Шүүх эрх мэдлийг 25 насанд хүрсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэн байх нь харагдаж байна.

Мөн хуульч нь хуульчийн шалгалтад тэнцсэн, ял шийтгэгдэж байгаагүй, мэргэжлийн үйл ажилла-

гаа эрхлэхэд **харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй байхыг** хуулиар шаардлага болгон зохицуулсан байна.

Мөн Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар нарийвчлан тусгайлан зохицуулалтыг хийж өгснийг харахад: шүүгч Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн гурав дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна: гээд

✓ эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй

✓ шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй

✓ шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх

✓ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх

✓ шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх.

Шүүгчид тавих болзол, шаардлагад харшлах өвчин сэтгэцийн эмгэггүй байх ёстой гэж тусгайлан зааж өгсөн байна. Өөрөөр хэлбэл шүүгч нь шүүх эрх мэдлийг бие даан, хараат бусаар хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуульд заасан тодорхой насанд хүрсэн байх, хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан **хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүйг** байх, Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан

²⁴⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8661>

шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй байх шаардлагыг тус тус хангасан байх ёстой байна.

Шүүгч нь шүүгчид тавих болзол, шаардлагад харшлах өвчин сэтгэцийн эмгэгтэй байх нь шүүх эрх мэдлийг бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх боломжгүйд хүрнэ. Үүний хортой үр дагавар эргээд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, ардчилал, эрх зүйт төрийн зарчим алдагдахад хүрнэ. Иймийн учир шүүгч бие даан, хараат бусаар үйл ажиллагаа явуулах нэг баталгаа бол яах аргагүй шүүгчийн эрүүл мэндийн асуудал мөн.

Шүүгчийн эрүүл мэндийн асуудал нь анх хуульч болох цаашлаад шүүгч болоход тавьсан шаардлагыг хангаж байсан боловч эрхэлж байгаа ажлын онцлог, ачаалал болон бусад хүчин зүйлсээс болоод муудан доройтох магадлалтай байдаг байна.

Суут гүн ухаантан Гегель нь “Гүн ухааны түүх” зохиолдоо “Хүний оюун санааны, тэрчлэн гүн ухааны хөгжил дэх түүхэн уламжлал нь олж авснаа ямар ч өөрчлөлтгүй яг л байгаагаар нь хямгадаж бөөцийлдөг гэрийн хахир хатуу эзэгтэй төдий бус аж.

Хүний оюун санаа бол огтын хөдөлгөөнгүй шавар баримал бус харин амьд бүхний адил улам бүр өргөжин тэлж, хөгжиж байдаг хүчирхэг урсгал юм” гэдгийг тэмдэглэсэн байдаг²⁴¹.

²⁴¹ Ч.Даваадаш., Гегелийн “логикийн шинжлэх ухаан” суут бүтээлийн тухайд., 3 дахь тал

Бие хүн гэдэг нь хувийн **сэтгэл зүйн шинж чанараараа** онцлог, нийгмийн болон нийгэм сэтгэл зүйн тодорхой үүргүүдийг гүйцэтгэж байгаа ухамсарт үйл ажиллагаа бүхий хувь хүн юм.

Бие хүний гол шинжийн нэг тод илрэл бол нийгмийн харилцааны бүтцэд эзлэх байр, нийгмийн болон хувийн идэвх, ухамсар, хувийн **сэтгэл зүйн** онцлогоороо хэзээ ч үл давтагдах төрөлх байдал юм²⁴². Үүнээс хүний оюун санаа, бие хүний сэтгэл зүйн шинж чанар тогтмол шавар баримтал бус өөрчлөгдөж байдаг ба хэзээ ч үл давтагдах төрөлх өгөгдөл гэдэг нь харагдаж байна. Энэ утгаар нь шүүгч нь анх **сэтгэцийн эмгэггүй гэх тодорхойлолттой** ажилд орсон ч ажил мэргэжлийн онцлог, ачаалал ихтэй, шүүгчийн орон тоог дутмаг байдлаас болоод шүүгчид сэтгэл зүйн асуудал үүсэх эрсдэл байгааг харуулж байна.

Өөрөөр хэлбэл шүүгч нь олон жил ажиллахын хэрээр туршлага, мэдлэг хуримтлуулах боловч бие хүн болохынхоо хувьд ажлын ачаалал өндөр, шүүгчийн орон тоо хүрэлцээгүй байдлаар олон жил ажиллах нь стресст өртөх үндсэн нөхцөл болохыг харуулж байна.

Шүүгчийн стресс болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудал нь шүүгчийн хараат бусаар эрүүл, саруул ухаанаар хэрэг маргааныг шийдэх,

²⁴² М.Хишиг-Ундрах., Хуулийн сэтгэл судлал., УБ., 2021 он., 28 дах тал

хүний эрхийг хамгаалах шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлж болох юм.

Иймээс хууль тогтоогч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-т **“Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна”** гэж хуульчилсан байна. Гэвч харамсалтай нь тус эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт нь бодит байдалд хангалтгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна. Тодруулбал:

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийн ажлын ачааллыг судлах зорилгоор 2017-2021 он буюу таван жилийн улсын хэмжээнд шүүн таслах ажиллагааны тоон мэдээнд үндэслэсэн судалгаа хийжээ. Үүний дүнд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн ачаалал бусад шүүхүүдийн ачааллаас өндөр байгаа ч орон тооны дутагдалтай гэсэн дүн гарсан байна²⁴³.

Мөн шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэнгээс шүүгчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор Монгол улсын хэмжээнд шүүн таслах ажиллагаа явуулж буй давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгч нарыг хамруулсан судалгаа явуулжээ.

Судалгаанд орон нутгийн 160, Улаанбаатар хотын 73, нийт 233 шүүгч оролцсон байна.

Судалгааны үр дүнд: Нийт шүүгчдийн **18,9 хувь нь стрессийн өндөр түвшинтэй** байсан байна. Мөн шүүгчээр **6-15 жил ажиллаж буй шүүгч нарт стресс илүү илэрсэн** бөгөөд нийт шүүгчдийн 13,3 хувь нь ажлаас халшрах хам шинж хэвийн хэмжээнээс өндөр илэрч, 68,4 хувь дунд зэрэг илэрчээ.

Дээрхээс харахад шүүгчдэд ажлын стресс болон ажлаас халшрах хам шинж өндөр байгаа нь харагдаж байна. Ажлын стресс болон сэтгэл зүйн гэмтэл нь хоорондоо уялдаатай байх бөгөөд үүнд амьдралын асуудлаас гадна ажлын стресс сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг байна.

Монгол Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 208 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн 2023 оны ажлын зохист ачааллыг тогтоохдоо анхан шатны шүүх эрүүгийн хэрэг 91, иргэний хэрэг 206, захиргааны хэрэг 35, зөрчлийн хэрэг 731 байхаар тогтоосон бол давж заалдах шатны шүүхийн ажлын зохист ачааллыг эрүү 49 хэрэг, иргэний хэрэг 95, захиргааны хэрэг 31, зөрчлийн хэрэг 110 байхаар тогтоосон байхад шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо жил ирэх тутам өсөж байгаагаас шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал нэмэгдэх болсон байна.

²⁴³ https://www.judcouncil.mn/site/news_full/12694

Тухайлбал: бүх шатны шүүх 2014 онд нийтдээ 48,6 мянган хэрэг шийдвэрлэж байсан бол 2021 онд 80,4 мянга болж өссөн бол **2023 онд 524 шүүгч 113 мянга 284 хэрэг хянан шийдвэрлэсэн байна**²⁴⁴. Энэ нөхцөл байдал шүүгчид ажлын ачааллаас үүдэлтэй бухимдалд орох, сэтгэл гутрал үүсэх шалтгаан болж байна. Энэ нь стресст өртөх үндсэн нөхцөл төдийгүй шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлдөг²⁴⁵ байна.

Монголын хуульчдын холбооноос 2019 онд нийсэн “Шүүгчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, нөхцөл боломж” судалгаанаас үзэхэд **шүүгчдийн 91 хувьд сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай**. Нийт шүүгчдийн:

✓ 50-иас дээш нойргүйдэх, толгой өвдөх, амархан ядрах шинжүүд

✓ 40-өөс дээш хувьд санаа зовних, байнга ажлаа бодох, уурлах бачимдах гэх мэт стрессээс үүдэлтэй сэтгэл зүйн шинжүүд илэрдэг” гэж дурдсан байна²⁴⁶.

Стрессийн түвшинд ажлын ачаалал их нөлөөлдөг. Урт цагаар ажиллах, амрахгүй байх, ажил амьдралын тэнцвэр алдагдахад хүн стресст ордог. Хэчнээн ур чадвартай байлаа гээд амрахгүй ажиллах нь хүний бүтээмжийг бууруулж, стресс

уур бухимдлыг нэмэгдүүлдэг байна.

Шүүгч нарын ажлын ачааллыг судалсан судалгааг харахад: судалгаанд хамрагдсан зургаан дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэг шүүгчид 310 хэргийг шийдвэрлэхэд 323 өдөр зарцуулж байгаа нь ачаалал харьцангуй ихтэйг харуулж байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын таван өдрийн дунджаар нэг өдөрт ажлын цагийн 55% буюу 245.4 минутыг (4 цаг 5 минут) хавтаст хэрэгтэй танилцах, шүүхээс гарах эрх зүйн акт боловсруулах, нотлох баримт цуглуулах зэрэг ажилд, 9% буюу 39.4 минутыг (39 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 5% буюу 22.8 минутыг (22 минут) шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах, баталгаажуулах ажлуудад зарцуулдаг байна.

Шүүгч жилд 230 өдөр ажиллана гэж үзвэл 93 өдрөөр ажлын ачаалал илүү байгаа бөгөөд үүнийг ажлын өдөр болон амралтын өдөр ажиллаж нөхдөг байна.

✓ Илүү ажиллаж буй 93 өдөр нь ажлын 744 цаг болж байгаа бөгөөд шүүгч жилд 1840 цаг ажиллах ёстой гэж үзвэл **40 хувиар илүү ачаалалтай ажиллаж байна**²⁴⁷ гэсэн

²⁴⁴ https://www.judcouncil.mn/site/news_full/13893

²⁴⁵ Д.Мөнхцэцэг., Хуулийн сэтгэл судлал ба сэтгэл зүйн зөвлөгөө., УБ., 2020 он., 66 дахь тал

²⁴⁶ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл., УБ., 2023 он., 484 дахь тал

²⁴⁷ Шүүхийн Ерөнхий зөвлөл., хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвөөс хийсэн “Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох

судалгаа гарсан байна. Мөн шүүгч нарын дунд явуулсан ганцаарчилсан ярилцлагаар шүүгчид өөрсдийн ачааллыг хэрхэн үнэлж байгааг тодорхойлсон байна.

✓ Судалгаанд оролцсон шүүгчдийн ажлын ачааллын өөрийн үнэлгээнээс харвал Нийслэл болон орон нутгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 55 хувь, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 95 хувь, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн **83.3 хувь** нь ачаалалтай ажиллаж байгаагаа илэрхийлсэн байна.

✓ Судалгаанд оролцсон шүүгчдийн зүгээс бүх салбар шүүхийн шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл бол **шүүгчийн орон тооны дутмаг байдал** хэмээн үзсэн байна.

Иймээс шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа анхдагч бөгөөд нийтлэг шалтгаан нь шүүхийн байгууллагын орон тооны хүрэлцээгүй байдал гэж дүгнэхээр байна.

Шүүгч нь төрийн нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг, эрх мэдэл үйл ажиллагаа нь нэг бүрчлэн хуулиар зохицуулагдсан өвөрмөц нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг²⁴⁸ онцлогтой. Шүүгчийн хувьд сайн сайхан ирээдүй, шударга ёсыг тогтоох хүсэл мөрөөдөл өвөртлөн

судалгааны тайлан”, УБ., 2018 он

²⁴⁸ М.Хишиг-Ундрах., *Хуулийн сэтгэл судлал*., УБ., 2021 он., 124 дахь тал

хуулийн байгууллагад хөл тавьдаг боловч ажлын ачаалал, орон тоо хүрэлцээгүй байдлаас үүдэлтэй стрессээс болоод сэтгэл хангалуун бус байх, ичгүүр сонжуургүй болох, түрэмгий аашлах зэргээр бие, сэтгэл болон зан үйлд сөргөөр өөрчлөлт гарах магадлал өндөр байна.

Урт цагаар ажиллах, амрахгүй байх, ажил амьдралын тэнцвэр алдагдахад хүн стресст ордог. Хэчнээн ур чадвартай байлаа гээд амрахгүй ажиллах нь хүний бүтээмжийг бууруулж, стресс уур бухимдлыг нэмэгдүүлэх²⁴⁹ хүчин зүйлс болно. Энэ нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бусаар үйл ажиллагаа явуулах зарчмын хэрэгжилтэд сөрөг үр дагавартай.

Шүүгчийн орон тооны хүрэлцээг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн ч түүний хэрэгжилт хангалтгүй байгаа нь дээрх судалгаануудаар нотлогдож байна.

Иймээс хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг сахиулах үүрэгтэй шүүгч нарынхаа эрүүл мэндийг анхаарах, хамгаалах, ажлын ачааллыг бууруулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Тодруулбал: шүүгчийн сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн гэмтлээс урьдчилан сэргийлэх бодит арга хэмжээ авах, тодорхой эрх зүйн зохицуулалт хийх, мөн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн тав дугаар зүйлийн 5.5-т заасан **“Бүх шатны**

²⁴⁹ Д.Мөнхцэцэг., *Хуулийн сэтгэл судлал ба сэтгэл зүйн зөвлөгөө*., УБ., 2020 он., 66 дахь тал

шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна” гэж заасан зарчмын хэрэгжилтийг хангах арга замыг төрийн бодлогын хүрээнд боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД СОЁЛЫН КАПИТАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ



Бизнесийн удирдлагын докторант,
Шихихутуг их сургуулийн Удирдахуйн
ухааны тэнхимийн эрхлэгч
Г.ГАНТӨГС

Оршил

Хүн төрөлхтний оюуны болоод соёл, урлагийн үнэт өв санг монгол үндэстний ур ухаан, нүүдэлчний дахин давтагдашгүй зан заншил, соёл, уламжлал бүхэн нь өөрийн өнгө төрхөөр баяжуулж байдаг билээ.

Үүнийг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч, соёлын үнэт өвд бүртгэснээр цаашид уламжлан хадгалах, хамгаалан хөгжүүлэх үүрэг бидэнд ирж буй юм.

Улс орон, үндэстэн бүр өөр өөрийн онцлог, аж байдалтай холбоотойгоор өөрийн өвөрмөц соёл, уламжлал, зан үйлтэй, түүнийгээ хойч үедээ уламжлан үлдээсээр иржээ. Биет бус өвд Монголын ард түмний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, наадам, ардын

арга ухаан, уламжлалт технологи зэрэг соёлын өвийн олон төрөл багтдаг.

Улс орнууд бүс нутгийн болон үндэсний хамтын нийгэмлэгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд гарсан ахиц дэвшлийг хэмжихийн тулд тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн (SDI) хүрээг бий болгох нь түгээмэл болсон. (Dalziel, Saunders, Fyfe, & Newton, 2009)

Манай орны хувьд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Тогтвортой хөгжлийн зорилгод суурилсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2016-2030” зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулж байсан бол 2020 онд “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулан Улсын Их Хурлаар баталсан нь ТХЗ-2030 баримт бичигтэй уялдан хэрэгжиж буй урт хугацааны нэгдсэн бодлогын баримт бичиг болоод байна. (Б.Ананд, 2021)

Аливаа улсын хувьд эрх зүйн шинэтгэл хийгдэж байгаа эсэхийг тодорхойлоход хамгийн гол анхаарах асуудал нь энэ бүх шинэчлэлт, өөрчлөлт нь нийтлэг болон сайн засаглал, тогтвортой хөгжилд нийцэж байгаа эсэх мөн чиг хандлагыг тодорхойлохын тулд зорилго, зорилт

түүнд хүрэх арга замуудыг багтаасан бодлогоо эргэн харах хэрэгтэй болно. Үүний тулд соёлын үнэт өв, соёлын капитал нь үндсэн хууль болон бусад хуулиудад хэрхэн төлөвшсөн цаашид түүнийг боловсронгуй болгох эрх зүйн шинэтгэлийн хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Соёлын капиталаар дамжуулан эрх зүйн түвшин, чиг хандлагыг тодорхойлох нь салбар дундын шинжтэй асуудал мөн бөгөөд үндэсний өвөрмөц байдлаа хадгалж, олон улсын хамтын нийгэмлэгтээ зэрэгцэн орших улсуудын язгуур ашиг сонирхлыг хангах шаардлага үүссэн гэж үздэг.

Соёлын капиталын үндсэн ойлголт болох шашин шүтлэг, итгэл үнэмшил, зан үйл, уламжлал нь эрх зүйн тогтолцоонд цаашилбал эрх зүйд нөлөөлж, Үндсэн хууль, хууль, хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг талаар Үндсэн хуулийн тодорхой зохицуулалтад тулгуурлан судалгаагаа чиглүүлсэн.

Аливаа улсын Үндсэн хууль нь тус улсын эрх зүйн тогтолцооны үндэс болохоос гадна улс орны эрх зүйн хөгжил, бүх салбарынх нь үндэс болдог.

Иймээс уг сэдвийн хүрээнд соёлын капиталын онолын хүрээнд тодорхойлолт, ангиллыг авч үзэхээс гадна Монгол улсын Үндсэн хуульд хэрхэн төлөвшсөнд дүн шинжилгээ хийн, Үндсэн хууль дахь соёлын капиталын үндсэн ойлголтын үндэс, цаашдын чиг хандлагыг өнөөгийн

байр суурийг тодорхойлохыг зорив.

Нэр томъёо: соёл, соёлын капитал, дадал зуршил, хэм хэмжээ, хууль, эрх зүй, эрх зүйн соёл, зан заншил culture, cultural capital, habits, norms, law, legal culture, customs

ҮНДСЭН ХЭСЭГ

1.СОЁЛЫН КАПИТАЛ, ТҮҮНИЙ АГУУЛГА

Юуны өмнө соёлын тухай ерөнхий ойлголтоос гадна соёл ба соёлын капиталын хоорондын хамаарлыг авч үзье.

Соёл ердийн ухамсрын түвшинд бол урлаг, шашин, шинжлэх ухаан, сэлтийг нэгтгэсэн хам дүрийн байдалтай илэрч байдаг. Соёл судлал бол соёл гэсэн ойлголт ашигладаг бөгөөд энэ ойлголт нь хүний ахуйн мөн чанарыг бүтээл, эрх чөлөөний биелэл юм гэдгийг нээн харуулдаг. (Н.А.Бердяев, 1990) Соёл бол хүний амьдралын утга санааг оршин агчийн утга санаатай харьцалдуулан нээн батжуулах, утга, санааг чиглүүлэх арга замаар хүн өөрийгөө бүтээлчээр илэрхийлэн тодруулах түгээмэл арга.

Соёл бол хүмүүсийн сэтгэлийг бадрааж зарим нэг хам нийгэмлэгт (үндэстэн, шашны юм уу мэргэшлийн бүлэглэл гэх мэт) нягтруулж өгдөг утга санааны ертөнц болой. (мэт, 1999) Утга санааны энэ ертөнц нь үе дамжсаар, хүмүүсийн оршихуй ертөнцийг мэдрэн сэрэхүйн аргыг тодорхойлдог.

Утга санааны ийм ертөнцийн үндэс нь зонхилох санаа буюу соёлын утга санааны **доминант зонхирго** юм. Соёлын утга санааны доминант гэдэг нь **бусад бүх утга санаа, харилцааны шинж чанарыг тодорхойлдог тэр гол санаа, ертөнцөд хандах хүний ерөнхий хандлага** юм. Ингэхдээ соёл, түүний утга санааны доминант нь янз бүрээр хэрэгжиж болох боловч утга санааны нэгдэл нь хүмүүсийн үйлдэл, сэтгэл догдлол энэ бүхнийг бүхэллэг чанартай болгоно. (С.Н.Жаров, 1998)

Соёлын утга санааны доминант байвал соёл судлал шинжлэх ухааны хувьд орших боломж бүрдэнэ. Үүнд соёлын бүх талыг нэгмөсөн хамрах боломжгүй, харин зонхилох утга санааг ялгаруулан ойлгож, задлан шинжилж болох юм.

Иймээс “Соёлын капитал” -ыг онцлон, түүний агуулгыг тодруулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль дахь соёлын капиталын үндсэн ойлголтын үндэс, цаашдын чиг хандлагыг өнөөгийн байр суурийг тодорхойлон, соёлын капиталын үндсэн ойлголт болох **шашин шүтлэг, итгэл үнэмшил, зан үйл, уламжлал** нь эрх зүйн тогтолцоонд цаашилбал үндэсний эрх зүйд нөлөөлж, Үндсэн хууль, хууль тогтоомжинд тусгалаа олсон байдаг талаар Үндсэн хуулийн тодорхой зохицуулалтад тулгуурлан судалгаагаа чиглүүлнэ.

Соёлын капитал, түүний агуулга

Францын нэрт социологч Пьер Бурдьё (Bourdieu) 1979 онд анх франц хэлээр хэвлэгдсэн “Ялгаа: Амтыг үнэлэх нийгмийн шүүмжлэл” (Murdock, Vol. 16, No. 1, February 2010, 63–65) номондоо “соёлын капитал” гэсэн ойлголтыг танилцуулсан. 1983 онд Германы хэвлэлд уг ойлголтын талаар бичиж, гурван жилийн дараа англи хэл дээр орчуулж, дахин хэвлүүлсний дараа “соёлын капитал” гэсэн нэр томьёо судлаачдын үгийн санд орж ирсэн гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн байдаг. Бурдьё “Ялгаа” номдоо нийгмийн давхарга ба соёлын амт хэрхэн огтлолцож, нийгмийн тэгш бус байдлыг бий болгож, нөхөн үржихийг судалдаг.

Бурдьё соёлын капиталыг хувь хүний нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх замаар олж авсан соёлын мэдлэг, ур чадвар, дадал гэж тодорхойлсон байдаг. Энэхүү соёлын капитал урлаг, уран зохиол, хөгжим, хэл, шашин, зан заншлаар илрэн гардаг гэж авч үзсэн байдаг. Бурдьё соёлын капитал нь хувь хүний нийгмийн байдал, нийгэм дэх амжилтад хүрэх боломжийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзсэн.

Бурдьёгийн соёлын капиталын үзэл баримтлал нь социологи, соёл судлалд нөлөө үзүүлж, нийгмийн давхаргажилт, тэгш бус байдалд соёлын хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буй хүрээг тодорхойлсон.

Тэрээр соёлын капиталыг дараах нэр томъёогоор тодорхойлдог.

1. Соёлын капитал нь угсаатны, шашин шүтлэгийн болон цөөнхийн бүлгийн гишүүдийг хооронд нь холбосон сүлжээний хүч чадал, чанараас (жишээлбэл, том гэр бүлийн бүтэц) бий болдог. Үүнд үе дамжин уламжлагдан ирсэн итгэл үнэмшил, зан үйл гэх мэт орно.

2. Соёлын капитал гэдэг нь тухайн бүлгийн гишүүд, бүлгүүд бүхэлдээ эдийн засаг, улс төр, нийгмийн ололт амжилтыг бий болгохын тулд хөрөнгө, нөөц болгон хөгжүүлж чадах үнэт зүйлс, хэм хэмжээ, уламжлал, зан үйлийн цогц юм. Жишээлбэл, капиталын бусад хэлбэрт хувиргах эсвэл соёл урлагийн үйлдвэрлэл, хэрэглээ, тухайлбал баяр наадам, угсаатны захын газар гэх мэт нийгмийн эв нэгдлийг дэмжих дэд бүтцийг бий болгох замаар.

3. Соёлын хэм хэмжээ, үнэт зүйл гэх мэт нь соёлын хөрөнгийн нөөцийн байнгын/тодорхой эх үүсвэр юм.

Түүний томоохон бүтээлүүд болох “Өв залгамжлагчид” (1964) ба “Нөхөн үржихүй” (1970) номдоо тэрээр соёлын динамикийг судалсан байдаг. Иймээс судлаачид Бурдюгийн санааг янз бүрийн нөхцөл байдалд хэрэгжүүлж, өргөжүүлэн хөгжүүлж, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөдөлгөөн болон нийгмийн амьдралын бусад салбарт соёлын

капиталын гүйцэтгэх үүргийг судалжээ.

Бурдюгийн соёлын капиталын онол нь **хувь хүн мэдлэг, ур чадвар, боловсрол, нийгмийн харилцаа холбоо** зэрэг соёлын үнэт зүйлсийг эзэмшсэнээрээ нийгмийн байр суурь, эрх мэдлийг олж авдаг гэж үздэг. Тэрээр эдгээр соёлын үнэт зүйлсийг эдийн засаг, нийгмийн давуу тал болгон хувиргаж, нийгмийн давхраажилд, тэгш бус байдлыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг гэж үзсэн.

Бурдые соёлын давуу тал нь аливаа тогтолцоонд найдвартай бэхлэгдсэн гэж үздэг нийгэмд ноёрхож буй нөхцөл байдлаас үүдэн бий болсон ойлголт, гэр бүл, боловсролын систем, насанд хүрэгчдийн амьдралын олон орчин зэрэг нь үндэслэл бүхий матрицууд буюу зуршил нь бидний соёлыг удирдан чиглүүлдэг үл үзэгдэх удирдаачийг бүрдүүлдэг гэж үзсэн.

Бурдые Марксын онолд ангийн байр суурь гэж нийгэм, соёлын, эдийн засгийн хөрөнгөөр гэж үздэг тодорхойлогддог онолд томоохон засвар хийсэн.

Нийгмийн албан ёсны соёлын хэлбэрүүд нь өмч хөрөнгө эзэмшихтэй зэрэгцэн үйл ажиллагаагаа баталгаажуулдаг.

Тухайлбал, Алдартай уран зураг гэхэд захиалагчтай, хожим цаг хугацааны эргэлтэд тэр зургийн эзэмшигч нь үнэтэй зургийн өмчлөгч бөгөөд энэ нь эдийн засгийн эргэлтэд

мөнгөний харилцаанд орж, үнэ цэнэ нь өссөөр байдаг.

Бурдыегийн онолын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд:

Бурдьюгийн онолын үндсэн ойлголт болох зуршил /habitus/, дадал, бэлгэдэл зэрэг капиталын янз бүрийн хэлбэрүүдийг соёл, эдийн засаг, нийгмийн үүднээс танилцуулах явдал юм. Хүйс, анги, үндэс угсаа, соёл, боловсрол, түүхэн цаг үе нь хувь хүний дадал зуршлыг бүрдүүлдэг бол өдөр тутмын амьдралдаа хийж буй дасгал нь яг л жазз хөгжимчний сэдвийн талаар импровизаци хийхтэй адил хөдөлгөөн бүхий байдаг.

Дадлага бол хувь хүний дадал хэвшил, янз бүрийн хэлбэр, үйл ажиллагааны талбар хоорондын харилцааны үр дүн юм. (Power, 27 Apr 2015) Хувь хүмүүсийг нийгмийн тодорхой нөхцөл байдалдаа тохируулан нийгэмшүүлэх замаар хандлага, хүсэл сонирхол, дадал хэвшлийг олж авахыг санал болгосон.

Дасал хэмээн нэрлэгддэг энэхүү дотоод хүрээ буюу дадал хэвшил нь хувь хүмүүс ертөнцийг хэрхэн ойлгож, сонголт хийж, биеэ авч явах байдалд нөлөөлдөг. Хувь хүний нийгмийн анги, хүмүүжил, соёлд маш их нөлөөлдөг.

Соёлын капитал гэдэг нь хувь хүмүүсийн эзэмшиж буй мэдлэг, чадвар, соёлын чадварыг хэлэх ба нийгмийн дэг журмыг хадгалахад соёлын капитал маш чухал үүрэг

гүйцэтгэдэг Ер нь боловсрол, өндөр соёлд давуу эрх олгосноор олж авдаг соёлын капитал ихтэй хүмүүс нийгэмд өвөрмөц давуу талтай. Учир нь тэдний соёлын чадварыг үнэлж, шагнадаг.

Нийгмийн капитал гэдэг нь олон нийтийн сүлжээн дотор бий болсон итгэлцэл, харилцан холбоо, нийгмийн харилцаа зэрэг эх үүсвэрүүдийг хэлнэ. Олон нийтийн нөлөө бүхий сүлжээнүүдэд нэвтрэх нь хувь хүмүүст хөгжил дэвшилд хүрэх боломж олгож, одоо байгаа хүчний бүтцийг бэхжүүлэх боломжийг олгодог.

Хувь хүмүүст соёлын давамгайлсан хэм хэмжээ, үнэт зүйлсийг ихэвчлэн тэдний мэдлэггүйгээр тулгадаг арга замуудыг дүрслэхийн тулд бэлгэдлийн сүр хүч тухай ойлголтыг танилцуулсан. Бэлгэдлийн **сүр хүч** нь одоогийн байгаа хүчний динамикийг хууль ёсны болгож, алтернатив үзэл бодлыг үл тоомсорлосноор нийгмийн тэгш бус байдлыг үргэлжлүүлдэг.²⁵⁰

Капиталд бие махбодын капитал, санхүүгийн капитал, хүмүүн капитал, нийгмийн капитал, байгалийн капитал, соёлын капитал гэсэн 6-н төрөл байдаг. (Professor Paul Dalziel, 2009) Энэхүү судалгаанд зургаа дах төрлийн капитал болох соёлын капиталыг авч үзлээ. Соёлын капитал нь соёлын үнэ цэнийг харуулсан

²⁵⁰ Beyond bias: Cultural capital in anti-discrimination law

хөрөнгө гэж тодорхойлдог. Түүний эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурладаг соёл, эдийн засгийн үнэ цэний хоорондын уялдаа холбоог судалж, эдийн засгийн судалгаанд соёлын капиталын үр дагавар, түүний дотор өсөлт, тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын үнэлгээний асуудлуудаар хэлэлцсэн байж болзошгүй үр дагаврыг судалдаг. (Throsby, February 1999)

“Соёлын капитал” гэдэг нэр томъёог олон янзаар тодорхойлсноос хууль, эрх зүйн салбар, хууль хэрэглээнд хэрхэн тусгалаа олсныг харьцуулж болно. Ерөнхийдөө соёлын капитал нь хуулийн тогтолцооны янз бүрийн талуудыг төлөвшүүлэхэд боловсрол, сургалтаас эхлээд хууль эрх зүйн практик, шийдвэр гаргах, хууль зүйн салбарын хүрээнд гарах үр дүн, боломжуудад нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Хувь хүний анхан шатны мэдлэгээр олж авдаг бөгөөд эргэн тойрны хүмүүсийн нөлөөгөөр ухамсаргүй нөлөө үзүүлдэг байна. Хувь хүний амьдралдаа тодорхой соёлоор олж авдаг ертөнцийг хүмүүс хэрхэн үзэж, байгаагаар ойлгодог мэдлэг юм. Энэ нь орчин үеийн ертөнц, түүний зан үйлийг ойлгоход хэрхэн тусгалаа олохыг харж болно. (Huang, 2019)

Дараагийн сэдэв бол соёлын капиталын соёл, эдийн засаг, нийгмийн хүрээнээс илүүтэй эрх зүйд үзүүлэх нөлөө, түүний Үндсэн

хуулийн үндэс, тэдгээрийн агуулгыг эрх зүйн зохицуулалтад ач холбогдол өгөн авч үзье.

1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХ СОЁЛЫН КАПИТАЛЫН ҮНДЭС, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН НӨЛӨӨЛӨЛ

Нийгэмд дэх аливаа соёл нь хүмүүсийн харилцааны зохицуулалтад онцгой нөлөө үзүүлдэг, мөн үүнээс гадна соёлыг эд юм, баялаг гэж биш, харин баялгийг бүтээдэг үйл ажиллагаа хэмээн үзэх ёстой. Соёлгүй бол ухамсрын тухай ярих утгагүй. (Д.Баярсайхан, 1996)

Эрдэмтэн судлаачид одоог хүртэл эрх зүйн соёл, түүний бүтэц бүрэлдэхүүнийг тайлбарлахдаа нэгдсэн дүгнэлтэд хүрч чадаагүй бөгөөд эрх зүйн соёлын талаарх албан ёсны 400 орчим тодорхойлолт байдаг.

Эрх зүйн соёл нь зөвхөн хувь хүний эрх зүйн, зан үйлийн субъектив талыг харуулаад зогсохгүй үзэл суртал, мэдрэмж, төсөөлөл, ойлголт зэргийн хэрэглэгдэхүүнийг харуулдгаараа нийтэд хүлээн зөвшөөрөгддөг. Түүний мөн чанар нь эрх зүйг мөн түүний хэрэгжилтийг биш харин төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, эрх зүй болон түүний хэрэгжилтийн тухай хүмүүсийн төсөөлөл, ойлголтыг гаргаж өгдөгт оршино.

В.И. Калинская, А.Г.Ратинов, Н.М.Кейзеров нар эрх зүйн соёлын бүрэлдэхүүнд дараах соёлын

цогцолборуудыг хамааруулан авч үздэг. Үүнд: эрх зүйг бүтээх үйл ажиллагаа, эрх зүйн шинжлэх ухаан, эрх зүйн харилцаа, эрх зүйн зан байдлын болон эрх зүйн тухай улс төрийн үнэлэмжийн шалгуур, эрх зүйн ухамсар, эрх зүйн зан байдал, эрх зүйн байгууллага.

Эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн хэм хэмжээний акт, эрх зүй хэрэглэсэн шийдвэр гэх зэрэг эрх зүйн үзэгдлүүд соёлын онол болон практикийн тусгал болдог. Эдгээрийг хууль зүйн шинжлэх ухаанд тусгай ойлголтоор илэрхийлдэг бөгөөд эрх зүйн бодит байдлын тусгал уг ойлголт нь эрх зүйн ухамсар юм.

Соёлын капиталыг хэмжих үзүүлэлтүүд маш олон салбарт тухай ойлголт нь хуулийн салбартай хэд хэдэн аргаар холбогдож болно. Үүнд:

1. Хууль зүйн боловсрол, сургалт:

Соёлын капитал нь хууль зүйн боловсрол, сургалтад хамрагдахад нөлөөлнө. Хууль зүйн боловсролын амжилт, хууль эрх зүйн хэм хэмжээ, байгууллагуудтай танилцах тал дээр соёлын капиталын өндөр түвшинд эзэмшсэн, онцгой эрх бүхий гарал үүсэлтэй хувь хүмүүс хууль зүйн боловсрол эзэмшиж, хуулийн мэргэжилд орох илүү боломжтой байж болох юм.

2. Хууль зүйн практик, өмгөөлөл:

1. Хууль зүйн практикт соёлын капитал нь харилцааны хэв маяг, хэлний мэдлэг, хууль эрх

зүйн зан заншил, уламжлалтай танилцахад нөлөөлнө. Соёлын илүү их капиталтай хуульчид үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс хууль зүйн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, үр дүнтэй өмгөөлөхөд илүү сайн бэлтгэгдэж болно.

3.Хуулийн шийдвэр гаргах:

Соёлын капитал нь шүүх болон бусад хуулийн байгууллагын хүрээнд хуулийн шийдвэр гаргах үйл явцад ч нөлөөлж болно. Шүүгч, хуулийн мэргэжилтэн нар өөрсдийн соёлын талцалд, үзэл бодлыг хуулийн талаарх тайлбартаа авч ирж болох бөгөөд энэ нь хуулийн хэргүүдийн үр дүнг төлөвшүүлж чадна.

4.Шударга ёсыг тогтоох боломж:

Соёлын капитал нь хувь хүмүүсийн шударга ёсыг тогтоох боломжид нөлөөлж болно. Соёлын капиталын өндөр түвшинтэй хүмүүс хууль эрх зүйн эх сурвалж, төлөөлөл, дэмжлэгийг илүү сайн хүртэх боломжтой. Нөгөөтээгүүр, соёлын капиталын доод түвшинтэй хүмүүс хуулийн системээр аялах, эрхээ батлахад саад бэрхшээлтэй тулгарч болох юм.

5.Хуулийн шинэчлэл ба бодлого:

Хууль, эрх зүйн байгууллагуудын соёлын хэмжээг ойлгох нь хууль зүйн шинэчлэл, бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой. Соёлын капитал хуулийн системд хэрхэн ажилладгийг хүлээн зөвшөөрөх

нь илүү их тэгш эрх, шударга ёсыг тогтоох боломжийг хөхүүлэн дэмжих хүчин чармайлтыг мэдэгдэж чадна.

Манай улс 1990 оны ардчилсан хувьсгалаар социалист хэмээх нийтийн эрх ашгийг дээдэлсэн чиг баримжаанаас татгалзаж, хувь хүний эрх ашиг эн тэргүүнд байх ёстой гэж үздэг хүнлэг энэрэнгүй хэмээх чиг баримжааг сонгосон билээ.

Эдгээр чиг баримжаа нь агуулгынхаа хувьд ийм эрс ялгаатай ойлголт тул төрийн тогтолцоо болон тухайн нийгмийн харилцааг зохицуулж байсан эрх зүйн тогтолцоог мөн адил бүхэлд нь өөрчлөх шаардлагатай болсон юм.

Иймээс 1992 онд эрх зүйн харилцааны гол тулгуур болсон “Монгол Улсын Үндсэн Хууль”-ийг батлан гаргаж, үүндээ нийцүүлэн бусад хууль эрх зүйн актуудаа шинэчлэн өөрчилж эхэлсэн.

Ингэснээр төрийн байгуулал, батлан хамгаалах, гадаад харилцаа, төсөв, татвар, гааль, эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, газар байгаль орчин, аж ахуйн үйл ажиллагаа, дэд бүтэц зэрэг нийгмийн гол гол харьцаануудыг зохицуулсан 180 гаруй хуулийг 1998 он хүртэлх хугацаанд батлан гаргаж (Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил илтгэл болон зөвлөмжүүдийн эмхэтгэл, 2003), тэдгээрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авчээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд Үндсэн хуульд нэр заагдсан 41 хууль

бүгд батлагдан гарч, өмнө гарсан хууль, байгуулагдсан олон улсын гэрээг “Үндсэн хуульд” нийцүүлэн өөрчлөх ажил үндсэндээ хийгдсэн байна. Товчхондоо энэ үеэс эрх зүйн шинэтгэлийн үйл явц эрчимтэйгээр өрнөж эхэлсэн гэж үзэж болно.

Энэхүү эрх зүйн шинэтгэлийн үйл явц маш эрчимтэй өрнөсөн гэдэг нь өнөөдөр манай улсад нийт 391 (хүрээлэн, 2008) хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагийн ердөө хоёрхон хуулийг нь өмнөх нийгэмд батлан гаргасан байгаагаас харагдаж байна. Тухайлбал, 1957 оны “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай”, 1988 онд батлагдсан “Газрын хэвлийн тухай” гэсэн хоёр хууль юм.

Тухайн цаг хугацаанаас хойш өнөөг хүртэл Монгол улсад шинэ үндсэн хууль батлагдсанаас хойш үе үеийн УИХ-аас төр, нийгмийн харилцааг бүхэлд нь зохицуулахаар өнөөдрийг хүртэл нийтдээ 880 хууль баталжээ. (хүрээлэн, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2024) Нийт мөрдөгдөж буй хуулиудад дүн шинжилгээ хийвэл соёлын салбарын болон салбарын холбогдох хууль тогтоомж нийт 90 хууль байгаа нь 10.2 хувийг эзэлж байгаа нь чамлалтгүй үзүүлэлт болох нь харагдаж байна. (яам, 2024)

Энэ нь маш том ололт гэж харж болох талтай. Гэвч өнөө хир нь батлагдсан хууль нь хэрэгждэггүй, хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй,

батлагдсан хууль амьдралд нийцдэггүй, ойлгомжгүй, зохицуулах чадваргүй, тунхаглалын шинжтэй, тодорхой субъектүүдийн эрх ашигт нийцүүлсэн байгаагийн дээр хуулиуд тогтворгүй байна хэмээх шүүмжлэлүүд нийгмийн зүгээс байнга гардаг.

Энэ нь УИХ-ын үндсэн үүрэг (*Үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдана*) болох хууль тогтоох үйл ажиллагаа, түүнд баримталж байгаа бодлоготой салшгүй холбоотой юм. Тодруулбал эдгээр шүүмжлэлүүдийг араасаа дагуулсан хуулиуд нь Монгол Улс дахь **“Хууль бүтээх бодлогын гажуудал”**-аас үүссэн үр дүн юм. Хууль бүтээх бодлогын **“гажуудал”** нь хууль тогтоомжид гэхээс илүүтэйгээр УИХ-ын хууль бүтээж буй практикт амь бөхтэйгээр оршиж байгаа юм. Жишээлбэл, Хууль санаачлах эрх бүхий субъектууд санаачилсан хуулиа Засгийн газраар хянуулж байж УИХ-аар хэлэлцүүлдэг байдал практикт тогтсон, хууль тогтоох явцад Үндсэн хуулийг дээдлэх ёс зүйн асуудал бүрэн гүйцэд шийдэгдээгүй байгаа зэргийг судалгаануудад байнга онцлон үзсэн байдаг. (төсөл, 2006 он)

Ерөнхий онолын хүрээнд “хэм хэмжээ” хэмээх ойлголтын утга учрыг хамгийн товчоор Ханс Кельзен “хэм хэмжээ нь зөвхөн түүнийг бий болгоход чиглэсэн хүсэл зоригийн актаас гадна мөн жам ёсоор өөрөөр

бий болдог,... Хэм хэмжээ нь түүнийг тогтоох акт буюу хэвшлээр хүчинтэй болдог. Хэм хэмжээ хүчинтэй гэдэг нь тухайн хэм хэмжээ байна гэсэн үг..., хүчин төгөлдөр бүхий хэм хэмжээгээр тухайн этгээд тодорхой байдлаар биеэ авч явахыг журамласан бол тэрвээр тэгэх “үүрэгтэй” болж таарна.

Харин аль нэг хэм хэмжээгээр түүнд ямар нэг бүрэн эрх олгосон бол тэрвээр тийм байдлаар биеэ авч явж болно гэсэн үг юм” (Кельзен, 2017) гэж маш энгийн ойлгомжтой хэлсэн байна. Зохиогч цааш нь “... тодорхой зан үйлийг тогтоосон хэм хэмжээг дагаж мөрдөх буюу зөрчих боломжтой байдаг билээ. Үүнээс гадна хэм хэмжээг ... бас хэрэглэх боломжтой байдаг” (Кельзен, 2017) гэсэн нарийн утга санааг тайлбарласан байна.

“Хэм хэмжээ” гэдэг үг шууд утгаараа “зохицуулалт”, “тохируулалт” гэсэн монгол хэлний утгыг буулгана. Оросын эрдэмтэн судлаач С.С.Алексеев хэм хэмжээг “ямар ч үед байнга даган мөрдөж байх үйл, төрх байдлын ерөнхий дүрэм” гэж хэлсэн байдаг.

Нийгмийн амьдралд хүний үйл ажиллагааг тохируулах, зохицуулах, чиглүүлэх, зохион байгуулах хэм хэмжээнүүд байсаар ирсэн, байх ч ёстой.

Тийм хэм хэмжээ хүн хоорондын төдийгүй хүнээс төр, нийгэмтэйгээ харилцах харилцаанд ч илэрч гардаг. Гэхдээ хооллох, унтаж амрах, өдрийн дэглэмээ тохируулах, үр хүүхдээ

сургамжлах гэх мэтийн ердийн амьдралд мөрдлөг болгох хэвшмэл хэм хэмжээ энд авч үзэж буй эрх зүйн ойлголтод хамаарахгүй.

Нийгмийн хэм хэмжээний гол шинж нь хүний үйлдэл, үйл ажиллагаанд байнга, тогтвортой, нийтээр заавал дагаж мөрддөгт оршино. Нийгмийн хэм хэмжээг амьдралд үйлчилдэг, гүйцэтгэдэг үүргийнх нь талаас дор дурдсан дөрвөн бүлэгт ангилан үзнэ.

- Зан заншлын хэм хэмжээ
- Ёс суртахууны хэм хэмжээ
- Шашин шүтлэгийн хэм хэмжээ
- Эрх зүйн хэм хэмжээ

Эдгээр нь өөр хоорондоо сүлжилдсэн харилцан уялдаатай бүхэллэг ойлголтыг гаргадаг хэдий ч үүсэл, оршин байх байдал, дагаж мөрдөх ёс жаяг, хамгаалагдах аргаараа өөр хоорондоо ялгаатай. Эдгээр хэм хэмжээ үндсэндээ бичмэл болон бичмэл бус байдаг, харин эрх зүйнх нь ямагт бичмэл, өөрөөр хэлбэл хууль тогтоомжийн хэлбэртэй байна.

Аливаа улсын үндсэн хууль нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны үндэс суурь нь болдог мөн хууль хууль тогтоомжууд нь үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Иймээс гол эх сурвалж болох үндсэн хуульд тулгуурлан судалгааг хийсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршлоос:

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,

- хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,


- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна. (хууль, 1992)

Оршил нь Үндсэн хуулийн бүтцийн салшгүй хэсэг, бас онцгой үүрэгтэй. Хэдийгээр хэм хэмжээний шууд чиг үүргийг агуулдаггүй боловч улсын гол суртлыг илэрхийлж, Үндсэн хуулийн хамгийн гол, амин сүнс болсон эрхэм зорилго, зорилтыг агуулдаг.

Тийм учраас “Оршил хэсэг” нь Үндсэн хуулийг танин мэдэх, ойлгох, судлах, тайлбарлах, хэрэглэх үндсэн үзэл баримтлал болно.

Монгол улсын үндсэн хуулийн оршил хэсэг нь өнгөрсөн одоо ирээдүй үеийн 3-н цагийн хэлхээсийг холбосон холбоос байдаг. Жишээлбэл:

Диаграмм 1. Монгол Улсын Үндсэн хууль гурван цагийн хэлхээс болох нь*Эх сурвалж: Судлаач өөрөө*

Хүмүүс нийгмийн дунд амьдарч, аж төрөх, хөдөлмөрлөх явцдаа олон төрлийн харилцаанд оролцохдоо олон хэмжээс дунд амьдардаг. Эрх зүйн хэм хэмжээ бий болохоос өмнө хүн төрөлхтөн, ёс суртахууны болон заншлын хэм хэмжээнд тулгуурладаг байсан.

Нийгмийн энэхүү хэм хэмжээг дөрвөн бүлгийн хувьд Монгол улсад мөрдөгдөж байгаа Үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд соёлын элементүүдийг багтаасан соёлын капиталыг хэрхэн тусгасан, төлөвшүүлсэн зэрэгт дүн шинжилгээ хийн соёлын капиталын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох гэж зорьсон болно.

Зан заншлын хэм хэмжээ:

Монголчуудын овог, аймгийн үеэс, бүр монгол үндэстэн бүрэлдэн тогтсон нэн эртний үеэс өдгөөг хүртэл монгол хүний ахуй, аж байдлын хүрээнд төдийгүй төр захиргааны харилцааны хүрээнд ч олон мянган, олон зуун жилээр тогтож хэвшсэн, уламжлал болж үлдсэн, монгол хүн бүр дагаж журамладаг, журамлах ёстой зан үйлийн горим журам болно. (О.Амархүү, 2018)

Диаграмм 2. Зан заншлын хэм хэмжээг Монгол Улсын Үндсэн хуульд зохицуулсан нь

Монгол улсын үндсэн хууль	Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж
	Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна
	Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна
	Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна
	Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. Энэхүү заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө.
	Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.
	Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ
	Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.
	Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.
	Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.
	Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;
	Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй.

Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.
Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

Ёс суртахууны хэм хэмжээ:

Ёс суртахууны хэм хэмжээ бол хувь хүний ухамсар, зан араншин, соёл, хүмүүжил, төлөвшлийн төлөв байдал, олон нийтийн итгэлд үндэслэгдсэн горим журам юм. Юуг хийж болох, юуг болохгүй, зөв буруу,

сайн муу, шударга, шударга бус гэх мэт үйлдлийг ёс суртахууны хэм хэмжээгээр шалгуур болгон үнэлэн цэгнэж, гажуудал, зөрчил болсон эсэх, эсвэл байх ёстой хэмжээн дотроо байгааг тогтоож болно.

Диаграмм 3 Ёс суртахууны хэм хэмжээг Монгол Улсын Үндсэн хуульд зохицуулсан нь

Монгол улсын үндсэн хууль	хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж
	Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн
	Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
	хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
	хуулиар ногдуулсан албан татвар төлөх;
	Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.
	Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
	Хүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.
Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;	

Шашны хэм хэмжээ:

Шашин шүтлэгийн хэм хэмжээ эргэл мөргөл, залбирал даяанчлал, хурал хурах, өргөл барих, зул өргөх, маань унших, хөгжөөх, мандал өргөх, айлтгал айлдуулах гэх олон янз зан үйлд дагаж мөрддөг. Тэр бүхний далд утга нь муу муухай бүхнийг үлдэн хөөж арилган зайлуулах, сайн сайхан бүхнийг урин дуудаж дэвжээн дэлгэрүүлэх, нүглээс зугтан зайлж, буяныг хураан хуримтлуулж арвижуулах, бусдыг хүндлэн хайрлах, бусдад туслах гэх мэтийн итгэл үнэмшлийг бий болгож, тэр утгаараа

нүгэл, буяныг, хар, цагааныг, муу, сайныг ялган зааглаж, тэгш дүүрэн аж төрж амьдрах сэтгэл оюуны таашаалыг хүнд өгдгөөрөө нийгмийн ач холбогдолтой гэж эрдэмтэн О.Амархүү тодорхойлсон байдаг.

Иймээс дэлхийн улс орнуудын Үндсэн хуулиуд дахь шашны талаарх байр суурийг хэрхэн бэхжүүлэн зохицуулдаг талаар авч үзье. Үүнд: төрийнхөө шашин Үндсэн хуульдаа зарлан тунхагладаг, мөн шашингүй байх /Энэтхэг-No socialist, secular²⁵¹/,

²⁵¹ Олон улс шашин, төрийн хэргийг салгаж,

шашны талаар төвийг сахисан, мөн цөөнхийн шашныг хамгаалсан буюу Үндсэн хуульд цөөнхийн шашны эрхийг хамгаалах өөрөөр хэлбэл олонхын шашин шүтлэгээр тэднийг гадуурхахгүй байх заалтуудыг тунхагласан ч байдаг /Мяамар/, эсхүл аль нэг тодорхой шашны нэр заахгүйгээр эрх чөлөөтэй, сонголттой байхаар тус тус хуульчилж өгсөн байдаг.

/Монгол Улс/ Мөн урлаг, соёлын бүтээлд тухайн шашны нөлөөллөөр хөгжиж ирсэн улс орон уг шашнаа тэргүүлэх шашинд тооцох өөрөөр хэлбэл шашин нь соёлын болон түүхэнд нь чухал үүрэг гүйцэтгэдэг улс орнуудад шашин ба төрийн хооронд ямар нэгэн албан ёсны холбоо тогтоохгүйгээр энэ нөлөөг үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн байр сууриа үндсэн хуулиараа тунхагласан хүлээн зөвшөөрөлт нь иргэддээ шашны итгэл үнэмшлийг тулгахгүйгээр тухайн орны өв уламжлал, уламжлалыг тусгадаг цаашилбал өөрсдийнхөө давамгай шашныг төрийнхөө үйл хэрэгт ач холбогдолтойгоор авч үзсэн Үндсэн

хуулийн байр суурь байдаг. /АНУ

Эрх зүйн хэм хэмжээ: Эрх зүйн хэм хэмжээ бол төр засгийн хүчин төгс байдалд түшиглэсэн, нийгмийн харилцаанд оролцогчдод байнга үйлчилдэг, тэдний заавал дагаж мөрдөх горим журам юм.

- Эрх зүйн хэм хэмжээ ерөнхий утгаараа өөрийн гэсэн хэд хэдэн шинжийг агуулна. Тухайлбал:

- Төр засаг, түүний эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бичмэл хэлбэрээр тогтоосон,

- Нийгмийн харилцааны субъектүүдийн үйл ажиллагаа үйлчилж зохицуулалт, тохируулалт хийдэг,

- Нийгмийн харилцааны оролцогч бүхэн заавал дагаж мөрддөг

- Дагаж мөрдөөгүй буюу буруу зөрүү дагаж мөрдвөл төрийн өмгөөлөл, хамгаалалд ордог

- Нийгмийн бусад хэм хэмжээтэй харилцан холбоотой оршдог төдийгүй өөр хоорондоо холбоо харилцааны зохицлыг агуулан хадгалдаг.

Монгол улсын үндсэн хууль	Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.
	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

шашингүйн зарчмыг баримталдаг. Шашнаас ангид улсууд аливаа шашныг дэмждэггүй, бөгөөд итгэл үнэмшлээс нь үл хамааран бүх иргэдийн шашин шүтлэгийн эрх чөлөө, тэгш байдлыг хангахыг зорьдог. Жишээлбэл, Франц улс шашингүйн үзлийн хатуу хэлбэрийг laïcité гэж нэрлэдэг.

Диаграмм 4. Шашны хэм хэмжээг Монгол Улсын Үндсэн хуульд зохицуулсан нь

Диаграмм 5 Монгол Улсын Үндсэн хууль, Салбар хуулиуд, Олон улсын гэрээ конвенци дах эрх зүйн үндэс

Монгол улсын үндсэн хууль	Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн..
	Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна
	Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.
	Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн
	Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.
	эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
	соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;
	Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.
	Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
Салбар эрх зүйн хуулиуд	монгол хэлний тухай хууль
	Соёлын тухай хууль
	Соёлын өвийг хамгаалгах тухай хууль
	Номын сангийн тухайхууль
	Музейн тухай хууль
	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль
	Үндэсний их баяр наадмын тухай
	Кино урлагыг дэмжих тухай
	Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
Олон улсын гэрээ конвенци	Төр сүм хийдийн харилцааны тухай хууль
	Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай конвенци (Гаага. 1954.05.10. Монгол улс 1964 онд нэгдэн орсон)
	Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр оруулах, гаргах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенци (Парис. ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 16 дугаар чуулганаар 1970.11.14-ний өдөр баталсан. Монгол улс 1991 онд нэгдэн орсон)
	Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци (Парис. ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар 1972.11.16-ны өдөр баталсан. Монгол улс 1990 онд нэгдэн орсон)
	Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц (Парис. ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын ээлжит 32 дугаар чуулганаар 2003.10.17-ны өдөр баталсан. Монгол улс 2005 онд нэгдэн орсон)
	Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенци (ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 33 дугаар чуулганаар 2005.10.20-ны өдөр баталсан)
	Соёлын олон төрөл зүйлийн тухай ЮНЕСКО-гийн түгээмэл тунхаглал (Парис. ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 31 дугаар чуулганаар 2001.11.02-ны өдөр баталсан)
	Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах тухай олон улсын харти (Венец. 1964 он)
	Музейн мэргэжлийн ёс зүйн хууль (Олон улсын музейн зөвлөл (ICOM) 1986)

Дүгнэлт

Эрх зүйд соёл тэр дундаа соёлын капитал хэрхэн нөлөөлж буйг нийгмийн 4 хэм хэмжээ буюу ёс суртахуун, шашны, зан заншлын, эрх зүйн хүрээнд Үндсэн хууль болон бусад хууль, хууль тогтоомжид хэрхэн зохицуулагдсаныг эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан дүн шинжилгээ хийлээ.

Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд голчлон авч үзсэн нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны үндэс мөн хууль, хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцэж байх үүднээс тэргүүлэх байр сууринд иш болгов.

Үнэ цэнийн хувьд оюуны капитал эрх зүйд нөлөөлж, эрх зүйн зохицуулалтад орж ирснээр хүн төрөлхтөн шашин, итгэл үнэмшлээрээ дамжуулан урлагийн бүтээл туурвиж тэр нь эргэлтэд орсноор үнэ цэнэ нь хуулиар тэр дундаа Үндсэн хуулиар баталгаажиж өгснөөр соёлын капитал, эрх зүйн хоорондын харилцааны үндэс тодорхойлогдож байна.

Соёлын капитал бол нийгмийн байгуулал буюу төрийн бүрэн эрхт байдлын бүрэлдэхүүн болох эдийн засаг, соёл, сошиал буюу нийгэмшлийн үндсийн суурь үндэс болж өгдөг байгаараа нийгэмд үнэ цэнтэй үнэлэгдэх чухал үзүүлэлт. Жишээ нь шашнаар дамжуулж урлаг соёлын. Бүтээл туурвигдаж, итгэл үнэмшлээр дамжуулан ёс суртахуун бэхжиж, угсаатан, үндэсний цөөнх зан заншлаа өвлүүлэн дамжуулж,

эдгээр нь эрх зүйгээр хамгаалагдаж байгаа нь баталгаатай болж байгааг илэрхийлэхийг зорьсон зорилгоо биелүүллээ. Соёлын капиталаар дамжуулан урлагийн бүтээл туурвигдан тэр нь эдийн засгийн эргэлтэд орж байгаа нь эдийн засгийн үнэ цэнэ гэж тод харагдана.

Санал, дүгнэлт

- Соёлын капиталын өвөрмөц байдлын төлөвшил, өөрчлөлтийг даяаршлын нөлөөг харгалзан үзэх;

- Соёлын хүчин зүйлс хувь хүний онцлогийг төлөвшүүлэхэд хэрхэн нөлөөлдөг мөн эдгээрийг соёлын капиталын агуулгаар авч үзэх;

- Антологи /anthology/ нь нутгийн соёлын олон талт байдал, өвөрмөц талыг судалж, угсаатны буюу өвөрмөц онцлогийг даяаршлын огтлолцол дээр авч үзэх;

- Соёлын капиталын олон талт шинж чанарыг антропологи, социологи, сэтгэл судлал, соёл судлал зэрэг янз бүрийн өнцгөөс судалсан судалгааны материалуудад тулгуурлан хууль зүйн салбарын хувьд эдгээртэй хамааралтайгаар судалгааны зорилтыг тодорхойлох;

Хамгийн гол нь дэлхийн нэгдсэн соёл бий болсон өнөө үед улс бүр өөрийн онцлогийг хадгалах, түүнийгээ соёлоороо дамжуулан эргэлтэд оруулах, сурталчлах, хамгаалах шаардлага бий болсныг эрх зүйн зохицуулалтаар хангах ёстой. Дэлхий дахины харилцаа эрчимжиж байгаа нь бусад соёлыг

хүлээн зөвшөөрч буй нэгдмэл соёл нь фундаменталист болон үндсэрхэг үзлээр эсэргүүцэлтэй тулгарч байна гэдгийг бас орхих сэдэв биш билээ.

Мөн “гуравдагч соёл” бий болж, үндэстний улсын хил хязгаарыг давж гарах элементүүдийг судлах. Дэлхийн нэгэн төрлийн нэгдмэл байдлын цар хүрээ, шалтгаан,

үр дагаврыг судлахын зэрэгцээ нийгмийн шинжлэх ухаанд үзүүлэх нөлөөг авч үзэх ёстой гэж олон эрдэмтэд дэвшүүлэн санаа бодлоо илэрхийлсээр байна.

Хавсралт 1 Соёлын капиталыг хэмжих үзүүлэлтүүд

Боловсролын амжилт:

- Боловсролын түвшин (жишээ нь, их, дээд сургуулийн диплом, бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байх)
- Боловсролын магадлан итгэмжлэл (г.м., эрдэм шинжилгээний шагнал, гэрчилгээ)
- Боловсролын хөтөлбөр, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох

Хэлний чадварын:

- Нэг буюу түүнээс дээш хэлээр чөлөөтэй ярьдаг
- Нийгмийн янз бүрийн нөхцөлд үр дүнтэй харилцах чадвартай
- Тусгай буюу академик хэлний мэргэжилтэй

Соёлын зан үйл, уламжлалын тухай мэдлэг:

- Соёлын зан үйл, уламжлал, зан үйлтэй танилцах
- Соёлын арга хэмжээ, баяр наадам, ёслолын арга хэмжээнд оролцох
- Нийгмийн янз бүрийн нөхцөлд ёс зүй, хэм хэмжээний тухай ойлголт

Соёлын нөөцийн хүртээмж:

- Соёлын эд өлгийн зүйл, ном, урлагийн бүтээл, хөгжмийн зэмсэг эзэмших
- Музей, номын сан, театр, галерей зэрэг соёлын байгууллагад хандах боломж
- Аялал жуулчлал, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан олон янзын соёлын твшлагыг олж авах

Олон нийтийн сүлжээ ба холбоо:

- Нийгмийн эсвэл мэргэжлийн бүлгүүдэд гишүүнээр элсэх
- Нөлөө бүхий хувь хүмүүс эсвэл зөвлөхүүдтэй харилцах
- Нийгмийн капиталыг хувийн болон мэргэжлийн хөгжил дэвшилд ашиглах чадвартай

Соёлын хэрэглээний загварууд:

- Соёлын бараа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээ (жишээ нь, ном, кино, хөгжим)
- Соёлын арга хэмжээнд оролцох (жишээлбэл, концерт, театрын тоглолт, урлагийн үзүүлбэр)
- Уран бичлэг, уран зураг, хөгжим зохиох зэрэг соёлын үйл ажиллагаанд оролцох

Амт, хүсэл сонирхол:

- Соёлын бэлэг тэмдэг, хэв маяг, чиг хандлагыг танин мэдэх, үнэлэх
- Нийгмийн өндөр статустай холбоотой соёлын зан үйлийг хүлээн зөвшөөрөх
- Соёлын ялгаа, дэг журмыг ялган таних, үнэлэх чадвартай

Институт, эрх мэдэлтнүүдтэй харилцах:

- Төрийн албан хаагчийн тогтолцоо, албан байгууллагыг удирдан зохион байгуулах туршлага
- Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй танилцах
- Байгууллагын нөхцөлд өөрийн эрх, ашиг сонирхлыг өмгөөлөх чадвартай

Үе үеийн дамжуулалт:

- Гэр бүл, хамт олны соёлын хөрөнгө, үнэт зүйлсийг өвлөх
- Хүмүүжил, боловсролоор дамжуулан соёлын зан үйл, мэдлэгийг дэлгэн үзүүлэх
- Соёлын капиталыг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх

Эдийн засаг, нийгмийн байдал:

- Соёлын капитал ба эдийн засгийн нөөцийн уялдаа холбоо
- Нийгмийн байр суурь, нэр хүнд, эрх мэдэлд соёлын капиталын нөлөө
- Нийгэм дэх боломж, нөөц бололцоонд соёлын капиталын үзүүлэх нөлөө

Хууль эрх зүй:

- Хууль зүйн боловсрол сургалт
- Хууль зүйн практик өмгөөлөл
- Хуулийн шийдвэр гаргах
- Шударга ёсыг тогтоох боломж
- Хуулийн шинэчлэл ба бодлого

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ЗАРИМ ТӨРЛИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ



Хууль зүйн магистр, Шихихутуг
ИС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн
багш Б.ОЮУН-ЭРДЭНЭ

Хураангуй:

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэлээдгүй өргөн хүрээний асуудал. Тэр дундаа бага үнийн дүнтэй хэргийн судалгаа болон түүнийг шийдвэрлэж буй процессын асуудал нэлээдгүй их цаг хугацаа шаардагддаг бөгөөд нийт маргааны тодорхой хувийг тогтмол эзэлж байна. иймд энэ төрлийн маргааныг илүү хялбараар шийдвэрлэх арга замыг боловсронгуй болох хэрэгцээ шаардлага үүсч байна.

Түлхүүр үг:

Иргэний хэрэг, маргаан, бага үнийн дүнтэй хэрэг, хялбаршуулсан журам, эвлэрүүлэн зуучлал, дагнасан шүүх, процессын ажиллагаа.

ОРШИЛ

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн нь нийгэм болон эрх зүйн шинэ үйл явц болсон. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хийгдсэн эрх зүйн хамгийн том шинэчлэлийн нэг бол 2002 оны Иргэний хууль юм.

Иргэний хууль батлагдсантай холбогдуулан тухайн цаг үед үйлчилж байсан хуулиудыг тус хуулийн суурь зохицуулалт, үзэл санаанд одоог хүртэл нийцүүлж буюу боловсронгуй болгож чадаагүй хууль тогтоомж цөөнгүй юм. Нийгмийн амьдрал өдрөөс өдөрт хувьсан өөрчлөгдөж, дэлхийн улс орнууд даяарчлагдаж байгаа өнөө цаг үед нийгмийн харилцааг зохицуулагч эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн ажлуудын нэгт “Хувийн эрх зүйн шинэтгэл”-ийн үйл явцын талаар тусгагдсан. Энэ үйл ажиллагааны хүрээнд хууль тогтоогч болон хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс үе шаттай, системтэй ажлыг зохион байгуулж байгаа билээ.

Хувийн эрх зүйн шинэтгэл нь цаг үеэ олсон маш оновчтой ажил гэж харж байгаа бөгөөд хувийн

эрх зүйн салбарт дутагдаж байсан асуудлыг хөндөх мөн тулгамдаж буй асуудлыг нарийвчлах, зохицуулалтгүй байсан харилцааг зохицуулах, бие даасан хууль гаргах, шаардлагатай хэм хэмжээ, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд яригдах юм.

Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлээр хувийн эрх зүйн шинэтгэлийн тулгамдаж буй асуудлын нэг болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны асуудал буюу бага үнийн дүнтэй хэргийг хэрхэн хянан шийдвэрлэж байгаа, хэдий хэр хугацаа зарцуулдаг, нийт маргааны хэдэн хувийг эзэлдэг зэрэг асуудлыг хөндөхийг зорилоо.

НЭГ: БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 04 дүгээр сарын иргэн, эрүү, захиргааны хэргийн хөдөлгөөний мэдээг нэгтгэн, судалгаа гаргасан байна.²⁵² Хэрэг хүлээн авсан нэхэмжлэл нь захиргааны хэргийн нэхэмжлэл 334, эрүүгийн 13 85 хэрэгт, иргэний хэрэгт 6332 байна. Хэрэг хянан шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл захиргаа 250 хэрэг, эрүү 1273, иргэний 4524 байгаагаас дүгнэвэл иргэний маргаан нь нийт маргааны 65.5 хувийг эзэлж байна. Үүнээс өмнөх оны судалгааг

харьцуулан авч үзвэл улсын хэмжээнд 43,000 гаруй хэрэг хянан шийдвэрлэснээс иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэсэн нь 48 хувийг эзэлж байсан.²⁵³ Үүнээс бага үнийн дүнтэй иргэний хэрэг 5,710 болж өмнөх оны үзүүлэлтээс 299-өөр буюу 5.3 хувиар өссөн байна.

Бага үнийн дүнтэй хэрэг нь ихэвчлэн 10 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй хэргийг ойлгох бөгөөд үүнд иргэд хоорондын зээлийн маргаан, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээл, цахим зээл, аливаа нэг үйлчилгээний төлбөр, улсаас олгосон хөнгөлөлттэй зээл зэрэг багтдаг.

Иргэд хоорондын зээл болон банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн гэрээний маргаан нь үнийн дүн харилцан адилгүй байдаг ч ихэвчлэн бага үнийн дүнтэй маргаан байдаг. Цахим орчин хөгжсөнтэй холбоотойгоор иргэд гар утасны аппликейшнээр дамжуулан зээлийн үйлчилгээ авдаг болсон. Энэ төрлийн маргаан сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа юм.



2018 болон 2019 онд нийслэл болон орон нутгийн хэмжээнд бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн байдлыг харвал 50-60 орчим хувийг нийслэлд, 40-46 хувийг орон нутагт үүнээс 7-8 хувийг сум дундын шүүх шийдвэрлэсэн байна.²⁵⁴

Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн дүнгээр авч үзвэл 90

²⁵² Шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлагын мэдээ, 2023 он, №27

²⁵³ Шүүхийн статистик., 2019 он

²⁵⁴ Шүүхийн шийдвэрийн судалгаа., Цуврал 7., 2022 он, 24 дэх тал



хувь нь 13 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй, 10 хувь нь 13 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй байна.

Бага үнийн дүнтэй иргэний хэргийн үнийн тогтоохдоо Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх²⁵⁵ зохицуулалтыг шалгуур үзүүлэлт болгосон бөгөөд шүүхийн статистик мэдээнд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэлийн үнийг дүнгийн талаарх мэдээлэл

²⁵⁵ Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргах болон шүүхээс баримт бичиг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

байдаггүй тул хуулийн энэхүү заалтаас өөр шалгуур үзүүлэлт байгаагүй²⁵⁶.

Бага үнийн дүнтэй хэргийг маргааны төрлөөр ангилснаас авч үзвэл иргэд хоорондын зээл, улсаас олгосон хөнгөлөлттэй зээл зэрэг зээлийн гэрээний харилцаанаас үүссэн маргаан нь нийт шүүхээр шийдвэрлэсэн хэргийн 10-13 хувийн эзэлж байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна. мөн үүнээс гадна бага үнийн дүнтэй, үйл баримтын хувьд тодорхой, маргаан

²⁵⁶ Шүүхийн шийдвэрийн судалгаа., Цуврал 7., 2022 он, 25 дах тал

багатай хэрэг шүүхийн практикт тогтмол багагүй хувийг эзэлдэг²⁵⁷ ба энэ төрлийн маргааныг илүү түргэн шуурхай, хэргийн оролцогч нарт төвөггүй, шүүхэд ачаалал бага үүсгэхээр шийдвэрлэдэг байх хуулийн зохицуулалт хэрэгтэй юм.

Мөн шүүн таслах ажиллагааны тоон мэдээнээс дараах хоёр үзүүлэлт анхаарал татсан бөгөөд тэдгээрийг тулгамдсан асуудлууд гэж үзэж болно. Тодруулбал, нэг дэх асуудал нь дээрх төрлийн бага үнийн дүнтэй иргэний хэргийн 3.5-4 хувьд нь талууд давж заалдсан бол 1.6-1.8 хувьд нь өмнөх шатны шүүхийн шийдвэрүүдийг хяналтын шатны шүүхээр хянуулсан гэх үзүүлэлт юм. хоёр дахь асуудал нь эдгээр төрлийн хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацааг тооцоолж гаргах нь хүн хүч болон техникийн нөхцөл байдлаас хамаарч хүндрэлтэй байсан боловч барагцаалбал 27 орчим хувьд нь буюу 1/3-д нь 60 ба түүнээс дээш хоног зарцуулж шийдсэн байх магадлалтай байв. дээрх хоёр үзүүлэлтээс угтаа нэхэмжлэлийн үнийн дүн харьцангуй бага, үйл баримтын хувьд тодорхой, маргаан багатай хэрэгт талууд гурван шатны шүүх дамжиж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан болох нь харагдаж байна гэж²⁵⁸ шүүхийн шийдвэрийн судалгаагаар гарсан байна.

²⁵⁷ Шүүхийн шийдвэрийн судалгаа., Цуврал 7., 2022 он, 37 дэх тал

²⁵⁸ Шүүхийн шийдвэрийн судалгаа., Цуврал 7., 2022 он, 38 дэх тал

ХОЁР: ЗАРИМ ГАДААД ОРНЫ ХАРЬЦУУЛАЛТ

Япон улсын хувьд:

Япон улсын шүүхийн тогтолцоо нь дээд шүүх, гэр бүлийн шүүх, тойргийн буюу орон нутгийн шүүх, жижиг хэргийн шүүх гэсэн байдаг²⁵⁹ ба жижиг хэргийн шүүх нь иргэдэд хамгийн хүртээмжтэй шүүх хэмээн тооцогддог 438 шүүх тус улсад үйл ажиллагаа явуулдаг байна.

Жижиг хэргийн шүүх нь дараах хэрэг маргааныг анхан шатны журмаар, шүүгч дангаараа хянан шийдвэрлэдэг байна.²⁶⁰

- Үнийн дүн нь 1,400,000Yen-ээс хэтрэхгүй иргэний хэрэг

- Хууль тогтоомжоор жижиг хэргийн шүүхэд харьяалуулсан, торгох болон бусад хөнгөн ял шийтгэл бүхий хулгай, залилан зэрэг гэмт хэрэг

- Хуульд 3 хүртэл жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан эрүүгийн гэмт хэрэг. Товчхондоо тус шүүх нь анхан шатны шүүхээс ялгаатай тал нь иргэний хэргийг илүү хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдгээрээ онцлог. Иргэний процессын тухай хуулийн зарим зүйл заалтанд жижиг хэргийн онцлогийн талаар зохицуулсан ба үүнд:

²⁵⁹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа :Япон улс., Г.Мөнхтулга, Г.Мөнхсайхан., 2022он, 21 дэх тал

²⁶⁰ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа :Япон улс., Г.Мөнхтулга, Г.Мөнхсайхан., 2022он, 26 дэх тал

- Үнийн дүн зөвхөн 1,400,000Yen-ээс хэтрэхгүй хэргийн тухайд хандах боломжтой

- Шүүхэд нэхэмжлэлийг заавал бичгээр биш амаар гаргах боломжтой.

- Шүүх хуралд гаргах тайлбар, мэдүүлгээ заавал бичгээр гаргах шаардлагагүй

- Хэргийн оролцогчид эхний шүүх хурлаас хойш заавал биечлэн оролцох шаардлагагүй гэх зэрэг зохицуулалтаас харвал илүү хялбар бөгөөд зохигч нарт хүндрэл бага бас түргэн шуурхай шийдвэрлэх процесс харагдаж байна. эдгээр зохицуулалт нь ердийн шүүхийн зохицуулалтад өөрөөр заасан байдаг байна.

Жижиг хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчид өмгөөлөгчгүйгээр оролцох нь цөөнгүй байдаг бөгөөд энэ нь хэргийн түргэн шийдвэрлэх процессын асуудалд хамаарахгүй бөгөөд нэмэлт өөрчлөлтөөр өмгөөлөгч оролцох боломжийг олгосон байна.

Дээрхээс үзвэл манай улсад шүүхийн тогтолцооны асуудал бас яригдах бөгөөд анхан шатны шүүхэд бүх хэрэг төвлөрдгөөс үзвэл шүүхийн ачаалал их байхаас өөрцгүй юм. Зарим бага дүнтэй хэрэг олон жил үргэлжилдэг бөгөөд дагнасан шүүх байгуулагдвал энэ төрлийн буюу бага үнийн дүнтэй хэрэг маргааныг шийдвэрлэх нь шүүхийн ачаалал болон зохигч нарт илүү хялбар болно.

Англи улсын хувьд:

Англи улсын шүүхийн тогтолцоо нь Магистрантын шүүх, Титмийн шүүх, Мужийн шүүх, дээд шатны шүүх, давж заалдах шатны шүүх болон дээд шүүхээс бүрдэх ба иргэний хэргийн хувьд Мужийн шүүх (Магистратын шүүхийн тодорхой хэргүүд), дээд шатны шүүх, давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн танхим, дээд шүүх гэсэн бүтэцтэйгээр хэрэг хянан шийдвэрлэдэг.

Мужийн шүүх нь иргэний хэргийн дийлэнх хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүүргийн шүүгчийн орлогч, дүүргийн шүүгч, тойргийн шүүгчид оролцдог байна.

Бага үнийн дүнтэй хэргийг дүүргийн шүүгч нь хянан шийдвэрлэх ба энэ нь дээд шатны шүүхийг бодвол харьцангуй зардал бага мөн шуурхай²⁶¹ шийдвэрлэдэг. Мөн бага үнийн дүнтэй хэргийг давж заалдах тохиолдол нь анхан шатны шүүхээс зөвшөөрөл авч, давж заалдах гомдлын үндэслэлээ²⁶² тодорхойлдог байна.

Япон улс шиг бага үнийн дүнтэй хэрэг шийдвэрлэдэг дагнасан шүүх байдаггүй бөгөөд энэ үүргийг Мужийн шүүх хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг. Мужийн шүүхийн ихэвчлэн “Бага үнийн дүнтэй хэргийн шүүх” гэж нэрлэдэг²⁶³ байна.

²⁶¹ Шүүхийн шийдвэрийн судалгаа., Цуврал 7., 2022 он, 57 дэх тал

²⁶² Мөн тэнд

²⁶³ Мөн тэнд

Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн үнийн дүн нь 10,000 фунт буюу 43 сая төгрөгөөс хэтрэхгүй байхаар зохицуулсан ба маргааны төрлийн хувьд худалдах, худалдан авах гэрээнээс үүдсэн маргаан, иргэд аж ахуйн нэгж, байгууллага хоорондын бага үнийн дүнтэй маргаан, түрээслэгч түрээслүүлэгчийн төлбөрийн болон засвар үйлчилгээний маргаан зэрэг багтдаг.

Мужийн шүүхээс 2004 оны байдлаар бага үнийн дүнтэй хэрэгт дараах үнийн дүнтэй маргаанууд орсон байна. Судалгааг шүүхийн шийдвэрийн цувралаас авав.²⁶⁴


Англи улсын бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай. Илүү хялбар процессын ажиллагаатай бөгөөд шүүгчийн захирамжаар шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг авч болдог.²⁶⁵

Япон болон Англи улсын шүүхийн тогтолцоо, иргэний хэрэг тэр дундаа бага үнийн дүнтэй хэргийг хэрхэн хянан шийдвэрлэдэг талаар харьцуулан авч үзлээ.

Европын болон Ази дундаа эрх зүйн болон нийгмийн хөгжлөөрөө энэ хоёр улс харьцангуй өндөр бөгөөд манай улсын хүрээнд эрх зүйн орчиндоо авч хэрэгжүүлэх зохицуулалт нэлээдгүй байна.

Бага үнийн дүнтэй хэргийн доод хэмжээг тогтоож өгсөн, мөн ямар ямар хэргийн төрөл ордог зэргийг тодорхойлж өгсөн байна.

Дээрх хоёр улс нь эрх зүйн тогтолцоо, хүн ам зэрэг олон асуудлаар манай улсаас өөр ч гэсэн хэрэг хянан шийдвэрлэх асуудал нь манай улсыг бодвол илүү хөгжингүй байгаа учраас жишээ татан, боловсронгуй болгох ийм шийдэл байж болох юм гэдэн талаас нь харьцуулан судаллаа.



²⁶⁴ Мөн тэнд

²⁶⁵ Шүүхийн шийдвэрийн судалгаа., Цуврал 7., 2022 он, 64 дэх тал

ДҮГНЭЛТ

Манай улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэдийгээр болж байгаа мэт боловч хуулийн зарим нэг зохицуулалтыг “Хувийн эрх зүйн шинэтгэл”-ийн хүрээнд авч үзэж, холбогдох хууль тогтоомжийг сайжруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй бий болоод байгаа билээ.

Шүүхийн шийдвэрийн судалгааг нийслэл болон орон нутгийн хэмжээнд авч үзэн харвал шүүхийн ачаалал, нэг шүүгчид ногдох хэрэг зэрэг нь илт их байгаа бөгөөд үүнээс үүдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ²⁶⁶аширсан, иргэд хүлээлттэй, хэргээ шийдүүлэх гэж цаг хугацаа, хөрөнгө мөнгөөрөө хохирох зэрэг асуудал цөөнгүй байгаа билээ.

Нийслэл болон орон нутгийн нийт шийдвэрлэсэн хэргийг авч үзвэл иргэний хэргийн маргаан ²⁶⁶илд давуу их байгаа бөгөөд үүнд бага үнийн дүнтэй хэрэг нэлээдгүй хувийг эзэлж байгаа юм.

Процессын ажиллагааны хувьд бага үнийн дүнтэй хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх асуудал дутмаг байгаагаас энэ хэрэг нь хэдэн жил дамнан удааширдаг тул энэ ажиллагааг шүүхийн ачаалал болон хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг бодсон ч илүү хялбараар шийдвэрлэдэг болох нь зүй хэрэг. Харин хуульдаа бага үнийн гэдэг доод хэмжээг дээрх хоёр улс шиг хуульчлан тогтоох шаардлагатай

²⁶⁶ 2023 оны 04 дүгээр сарын байдлаар захиргаа 250, эрүү 1273, иргэн 4524 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

бөгөөд процессын нарийн ажиллагааг хүртэл ойлгомжтой байдлаар хуульчилбал зохистой.

Эвлэрүүлэн жуучлах ажиллагаа ²⁶⁷байдаг хэдий ч талууд энэ газар хандах нь бага бөгөөд шууд шүүхэд нэхэмжлэл гаргадаг.

Ялангуяа дээр судалгаанд дурдсан хэрэг болох иргэд хоорондын зээлийн гэрээ, цахим зээл, төлбөр тооцоо болон улсаас олгосон хөнгөлөлттэй зээл түгээмэл бага үнийн дүнтэй маргааныг тооцон эхлээд заавал эвлэрүүлэн жуучлалд хандаж тэнд маргааныг эцэслэсэн шийдвэрлээгүй тохиолдолд шүүхэд ханддаг зохицуулалт дутмаг юм.

Дээрх судалгаа болон хоёр орны харьцуулалтаас дүгнэвэл манай улс бага үнийн дүнтэй хэргийг илүү хялбараар, бодитой, түргэн шуурхай шийдвэрлэдэг процессын асуудал зайлшгүй бий болох хэрэгцээ шаардлага байгаа юм.

Хэдийгээр зарим гадаад орон шиг дагнасан шүүх шууд байгуулах нь цаг хугацаа, судалгаа, хүний нөөцийн асуудал яригдах хэдий ч урт хугацаандаа дагнасан шүүхтэй болох нь иргэний шүүхийн энэ их ачааллыг багасгах хамгийн дөхөм арга гэж үзэж

²⁶⁷ Тус хуулийн 30.1 дэх хэсэгт “Шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн жуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн жуучлах ажиллагааг явуулж болно.” Буюу талуудад сонгох боломжтойгоор хуульчилсан байгаа бөгөөд үүнийг заавал гэх сонголт руу орох нь илүү нарийвчилсан зохицуулалт болж өгөх юм.

байна. Дан ганц бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэдэг шүүх байхаас гадна гэр бүлийн хэрэг, хөдөлмөрийн маргааныг ч мөн адил дагнасан шүүх байгуулан шийдвэрлэх нь зохистой гэж дүгнэж байна.

ЭХ СУРВАЛЖ

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-2002 он
2. Улсын тэмдэгтийн тухай хууль-2010 он
3. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль-2012 он
4. Шүүхийн шийдвэрийн судалгаа цуврал 7-2022 он
5. Шүүхийн хэргийн хөдөлгөөн удирдлагын мэдээ дугаар 27-2023 он
6. Г.Мөнхтулга, Г.Мөнхсайхан-Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: Япон улс-2022 он

ЯЛЫН ЗОРИЛГО, ТҮҮНИЙ ТӨРЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



*Сонгинохайрхан дүүргийн
Эрүүгийн хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч, шүүгч-судлаач,
шүүгч-сургаач багш хууль зүйн
докторант Б.БАТАА*

184

УДИРТГАЛ

Хууль бол эрх чөлөөт хүмүүсийн нийгэмд нэгдэх гэрээ билээ.²⁶⁸ Тодруулбал, эрх чөлөөт хүмүүс эрх чөлөөнийхөө тодорхой хэсгээс татгалзаж /бусдад өгч/ хариуд нь үлдсэн эрх, эрх чөлөөгөө аюулгүй байлгах, бас баталгаатай эдлэх боломжийг бүрдүүлэх гэсэн нийтлэг ашиг сонирхлоор нэгдсэн юм. Энэхүү ашиг сонирхлынхоо төлөө өргөл болгосон тэр л эрх чөлөөний хэлтэрхийнүүдээс нийтлэг эрх ашиг буюу ерөнхий том ашиг сонирхлын сан бүрэлдэж, төрийг бий болгосон гэж үзэх онол одоо ч үнэ цэнээ алдаагүй байна. Энэ бол нийгмийн гэрээний онол.

Гэтэл зөвхөн ийм нийтлэг эрх ашгийн сан буюу төрийн эрх мэдэл байгаад хангалтгүй байсан бөгөөд эрх баригчийн хувьд бусдын эрх, эрх чөлөө, нийтлэг эрх ашгийг хамгаалахын тулд хуулийг үл хэрэгсэгч зарим хүний мэдрэхүйг цочроогч шаардлагатай болжээ. Энэхүү мэдрэхүйг цочроогч бол хууль зөрчигчид, бусдын эрхэд халдагчид хүлээлгэдэг ял шийтгэл болой.²⁶⁹ Энэхүү тодорхойлолт нь эрүүгийн эрх зүй дэх ялын талаарх онолын үндэс болсон төдийгүй ялын зорилго, мөн чанарыг тайлбарлахад чухал ач холбогдолтой болсон юм.

Тэртээ XVIII зуунд Италийн нэрт сэтгэгч, хуульч Чезаре Беккариа нь ялын зорилго, түүний төрлийн талаар “Ялын зорилго нь нэгэнт үйлдчихсэн хэргийн төлөө хүнийг үгүй хийх, тамлан зовоох явдал бус. Харин гэмт этгээдийг дахин бусдад хор уршиг учруулахад саад хийх, бусдыг мөн тийм гэмт хэрэг үйлэхээс сэргийлэх зорилготой бөгөөд гэмт хэрэгтний бие махбодод аль болох бага зовлон зүдүүр учруулахын хамтаар сэтгэл санаанд нь аль болох гүн хоногшиж, хүчтэй сэтгэгдэл төрүүлэх төрөл хэлбэрийг сонгож хэрэглэх нь үр нөлөөтэй.”²⁷⁰ хэмээн тодорхойлсноор ял шийтгэлийн талаарх хүн

²⁶⁸ Ж.Ж.Руссо., *Нийгмийн гэрээний онол.*, 14 дэх тал

²⁶⁹ Орч Г.Эрдэнэбат., *Чезаре Беккариа., Гэмт хэрэг ба ялын тухай.*, 2021 он., 23 дахь тал

²⁷⁰ Мөн номын 47 дахь тал

төрөлхтний уламжлалт ойлголтыг үндсээр нь өөрчилсөн билээ.

Иймд ялын талаарх нийгэм-эрх зүйн эх сурвалж, үүсэл хөгжил, манай улсын түүхэн уламжлалыг тоймлон харуулахын зэрэгцээ өнөөдөр дэлхийн улс орнууд ямар зорилгоор ямар төрлийн ялыг сонгон хэрэглэж байгааг тодруулан харуулах зорилгоор иргэний эрх зүйн бүлийн томоохон төлөөлөл болох ХБНГУ, Францыг, нийтийн эрх зүйн бүлээс Их Британи, АНУ-ыг, пост коммунист улсуудаас Узбекистаныг, мөн хоёр хөршөө сонгон авч эрүүгийн хариуцлагын зохицуулалтыг харьцуулан судлав.

МОНГОЛ УЛСЫН ОРЧИН ЦАГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Манай улсын хувьд ялын зорилгын талаар анх 1942 оны Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлж ирсэн бөгөөд энэ хуульд “1. Гэмт хэрэг үйлдэгчдийг дахин шинэ гэмт хэрэг өдүүлэхээс цээрлүүлэх; 2. Нийгмийн бусад тогтворгүй хүмүүст сануулга болгох; 3. Гэмт явдал үйлдэгчдийг засаж хүмүүжүүлэх.”²⁷¹ гэж заасан байдаг. Дараа нь 1961 оны Эрүүгийн хуульд “шийтгэгдэгчийг хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгож засан хүмүүжүүлэх, шийтгэгдэгчийг дахин гэмт хэрэг

үйлдэхээс ба бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх”²⁷² хэмээн тодорхойлсон байна. Эндээс үзвэл гэмт хэрэгтнийг засан хүмүүжүүлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго чухал байр суурь эзэлж байсан бөгөөд засан хүмүүжүүлэх зорилгыг тодорхой чиглэлд хандуулсан байгаа нь тухайн үеийн 1960 оны Үндсэн хуулийн зорилгоос улбаатай юм.

1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь цээрлүүлэх, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг үзэлтэй болгож засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх”²⁷³ гэж заасан байна. Энд ялын хүмүүжүүлэх зорилгыг засан ба дахин хүмүүжүүлэх хэмээн заагтай авч үзсэн нь нэлээд онцлог болсон юм. Засан хүмүүжүүлэх нь ялтны зан үйлийг өөрчлөн засах зорилго байсан бол дахин хүмүүжүүлэх гэдэг нь ялтныг шинэ хүн болгон төлөвшүүлэх явдал байжээ.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж, бид цоо шинэ нийгэм рүү шилжин орсны дараа Эрүүгийн хуулийн 1993 оны нэмэлт, өөрчлөлтөөр дахин хүмүүжүүлэх гэсэн зорилгыг хасаж, засан хүмүүжүүлэх социалист

²⁷¹ Б.Баярсайхан нар., *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, УБ хот., 2011 он., 360 дахь тал.

²⁷² Мөн номын 421 дэх тал.

²⁷³ Мөн номын 512 дахь тал.

чиг хандлагыг халж, харин гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах гэсэн шинэ зорилгыг нэмж томъёолсон юм. Шинэ Үндсэн хуулиас хойш батлагдсан Эрүүгийн хууль²⁷⁴ /2002/-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэгт “Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.” гэж зааснаар анх удаа зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгыг хуульчилсан байна.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.” гэж тодорхойлсныг эрүүгийн эрх зүйн салбарын судлаачид болон хуульчид томоохон дэвшил хийгээд өөрчлөлт болсон гэж үздэг.

Учир нь, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх явдал нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг бодитойгоор сэргээн эдлүүлэх боломж олгохын зэрэгцээ хохирлоо төлсөн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх хууль зүйн шалгуурыг бий болох үндэс болсон юм. Нөгөөтээгүүр, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хүмүүжүүлэх гэсэн хийсвэр /абстракт/ зорилгыг халж, нийгэмшүүлэх гэсэн бодит хийгээд боломжтой зорилгоор сольсон нь нийгэм-эрх зүйн чухал ач холбогдолтой болсон гэж судлаачийн хувьд үздэг.

Харин хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгын тухайд хуульч, судлаачид харилцан адилгүй байр суурьтай байгааг энд цухас дурдахын зэрэгцээ энэхүү судалгааны хүрээнд хуулийн этгээд эрүүгийн субъект болох эсэхийг авч үзэхийг зорьсонгүй.

Судалгааны хүрээнд ялын төрлийн талаар 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтыг харьцуулан харуулья. Учир нь, энэхүү хоёр хуулийн хооронд эрүүгийн хариуцлагын бүрдэл, ялын төрлийн талаар үзэл баримтлалын шинжтэй томоохон өөрчлөлт гарсан юм. Жишээ нь, ял тэнсэх тухай эрүүгийн эрх зүйн уламжлалт ойлголтыг эрс өөрчилжээ.

²⁷⁴Төрийн мэдээлэл., 2002 он., №05.

№	2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль ²⁷⁵
1	45.2 “Эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр хүлээлгэ.”	5.1.2 “Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.”
2	Ялын төрөл: - Торгох; - Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; - Эд хөрөнгө хураах; - Албадан ажил хийлгэх; - Баривчлах; - Хорих; - Цаазаар авах;	Ялын төрөл: - Торгох; - Нийтэд тустай ажил хийлгэх; - Зорчих эрхийг хязгаарлах; - Хорих; ○ Хугацаатай ○ Бүх насаар - Эрх хасах. (Эхний 4-ийг үндсэн, сүүлчийнхийг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.)
3	Албадлагын арга хэмжээний төрөл: - Эмнэлгийн чанартай; - Хүмүүжлийн чанартай.	Албадлагын арга хэмжээний төрөл: - Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах; - Эмнэлгийн чанартай; - Хөрөнгө, орлогыг хураах. Албадлагын арга хэмжээний тусгай төрөл: - Хүмүүжлийн чанартай /хүүхдэд/; - Татан буулгах /хуулийн этгээдэд/.

2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн ялын төрөлд орсон хамгийн том өөрчлөлт нь цаазаар авах ялыг бүх насаар хорих ялаар сольж, Монгол Улс албан ёсоор цаазаар авах ялыг Эрүүгийн хуулиас хассан явдал юм. Дараа нь, зорчих эрхийг хязгаарлах замаар гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлан хорилгүй нийгэмшүүлэн цээрлүүлэх боломж бүрдүүлсэн явдал юм.

Цаазаар авах ялын тухайд түүнийг буруутгах олон үндэслэл байдаг. Жишээ нь, хүнлэг бус ял, хэзээ ч нөхөн сэргээгдэхгүй буюу алдааг засах боломжгүй ял, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг хангадаггүй ял, шийдсэн хулгайч буюу улам аюултай хүн болгох эрсдэлтэй ял гэх мэт олон янзын няцаалт бий.

²⁷⁵ Төрийн мэдээлэл., 2016 он., №07

Дээр дурдсан түгээмэл хандлага, няцаасан үндэслэлээс гадна судлаачийн хувьд Чезаре Беккариагийн цаазаар авах ялыг алдарт Ж.Ж.Руссогийн төрийн үүсэл, мөн чанарын талаарх “Нийгмийн гэрээний онол”-д тулгуурлан тайлбарласан үндэслэл маш их таалагдсан учир уг үндэслэлийн агуулгыг тоймлон та бүхэнтэй хуваалцъя.

Эрүүгийн хариуцлагын нийгэмшүүлэх зорилгын тухайд 2015 оны хуульд хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнд тодорхой шалгуурын үндсэн дээр хорих ялыг оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан нь чухал ач холбогдолтой болсон юм. Хорих ялыг оногдуулахгүйгээр тэнсэх тохиолдолд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг

Төр бол эрх чөлөөт хүмүүсийн сайн дурын үндсэн дээр шилжүүлсэн эрх, эрх чөлөөний хэлтэрхийнүүдээс бүрдсэн тэдний нийтлэг ашиг сонирхлоор баталгаажсан эрх мэдэл буюу хийсвэр зүйл билээ. Хүмүүст хүн алах эрх байхгүйтэй нэгэн адил тэдний эрхээс шилжүүлэн авсан төрд мөн адил хүн алах эрх байхгүй. Өөрөөр хэлбэл, хүмүүс угаас өөрт байхгүй эрхээ төрд шилжүүлэх боломжгүй юм. Тиймээс төрийн хувьд цаазаар авах эрх мэдэл нь яагаад ч зүй ёсны байж таарахгүй.

заавал хэрэглэх бөгөөд үүргийн төрөл, эрхийн хязгаарлалтыг гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилттой уялдуулсан байна.

Түүнчлэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгын хүрээнд тусгай ангид заасан ялын дээд доод хэмжээг хөнгөрүүлэх хууль зүйн гол шалгуур нь гэмт этгээд учруулсан хохирлоо нөхөн төлсөн байхыг шаардах бөгөөд хохирлоо нөхөн төлөөгүй хүнд тусгай ангид заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах боломжгүй.

Богино хугацаанд ганцаарчлан хорих буюу баривчлах ялын төрөл нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц /товчилсон нэр/-ыг зөрчиж байгаа талаар Олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн механизмууд (гэрээний хороод)-аас байнга буруушааж, уг ялыг устгах талаар зөвлөж байсан тул хүнийг ганцаарчлан хорьдог ялын төрлийг халсан юм. Харин албадан ажил хийлгэх ялын нэр томъёог Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-аас баталсан Албадан хөдөлмөрийг хориглох тухай конвенцод нийцүүлэн “нийтэд тустай ажил хийлгэх” гэж шинэчлэн тодорхойлсон байна.

ГАДААД УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

Нэг. Бүгд Найрамдах Узбекистан Улс /БНУУ/:

Бүгд Найрамдах Узбекистан Улсын Эрүүгийн хууль²⁷⁶-ийн Дөрөв дүгээр бүлэгт Ялын төрөл болон зорилгыг хуульчилсан байна. Тус бүлгийн 42 дугаар зүйлд “Ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг засан хүмүүжүүлэх, ялтан болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.” гэж заасан байна.

Ялын төрөл /тогтолцоо/-ийг тус хуулийн 43 дугаар зүйлд “торгох, тодорхой эрхийг хасах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, албан тушаалаас түдгэлзүүлэх, баривчлах, сахилгын байранд шилжүүлэх, хорих, цаазаар авах” гэж тогтоосон байна. Албан тушаалаас түдгэлзүүлэх болон сахилгын байранд шилжүүлэх ялыг зөвхөн цэргийн алба хаагчид оногдуулна.

Харин тодорхой эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын шинжтэй хэрэглэж болно. Үүнд цэргийн болон бусад тусгай цол хасах хамаарна.

²⁷⁶ Тус хууль нь 1994 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан болно.

Торгох ял /44 дүгээр зүйл/:

Эрүүгийн хуульд заасан хэмжээгээр гэм буруутай этгээдэд мөнгөн торгууль оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ял нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас дээш зургаан зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байна. Хэрэв шүүхээс оногдуулсан торгох ялаас зайлсхийвэл торгох ялын биелүүлээгүй хэсгийг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл албан тушаалаас түдгэлзүүлэх, эсхүл баривчлах ялаар солино. Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн хэмжээний торгох ялыг нэг сараар тооцно.

Тодорхой эрхийг хасах ял /45 дугаар зүйл/:

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг шүүхээс тогтоосон хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой албан тушаал эрхлэхийг, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахыг тодорхой эрхийг хасах ял гэнэ. Хязгаарлах албан тушаал, эсхүл үйл ажиллагааны төрлийг шүүхийн шийтгэх тогтоолоор тогтооно. Хэрэв гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэхүй нь түүний эрхэлж буй албан тушаал, эсхүл үйл ажиллагаатай нь холбоотой бол уг ялыг үндсэн ялын хувьд нэг жилээс таван жил хүртэл, нэмэгдэл ялын хувьд мөн нэг жилээс таван жил хүртэл байна. Энэ ялыг үндсэн ялаар оногдуулаагүй бол тусгай ангид заасан өөр төрлийн үндсэн ял дээр нэмэгдэл ял болгон

шүүхээс оногдуулж болно. Тодорхой эрхийг хасах ялыг нэмэгдэл ялын хугацааг баривчлах, сахилгын байранд шилжүүлэх, хорих үндсэн ялын хувьд эдэлж дууссан үеэс, хэрэв хорих ялыг тэнссэн бол шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс тус тус тоолно.

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх /46 дугаар зүйл/:

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнийг шүүхээс тогтоосон аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл бусад газарт цалингийнх нь арваас гучин хувийг суутган авч албадан ажиллуулахыг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял гэнэ. Энэхүү ял нь зургаан сараас гурван жил хүртэл хугацаатай байна. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэтгэврийн насны, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, хүүхэд асрах чөлөөтэй, цэргийн алба хааж байгаа хүнд оногдуулахгүй. Тус ялын нийт хугацааны аравны нэгээс зайлсхийвэл эдлээгүй үлдсэн ялын хугацааг хорих ялаар солих ба зайлсхийсэн хугацааг эдэлсэн ял оруулан тооцохгүй.

Албан тушаалаас түдгэлзүүлэх ял /47 дугаар зүйл/:

Шүүхээс тогтоосон хугацаанд цэргийн офицер, алба хаагч, гэрээт цэргийн алба хаагч нарын цалингийн арваас гучин хувийг суутган тооцож, тодорхой эрх, ашиг сонирхлыг түр хугацаагаар хязгаарлахыг албан тушаалаас түдгэлзүүлэх ял гэнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд албан тушаалыг

хоёр сараас хоёр жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно. Нийгмийн хор аюул багатай, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол шүүх хэргийн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан хугацааг ялгамжтай тогтооно. Албан тушаалаас түдгэлзүүлэх ял эдэлж буй ялтан албан тушаал дэвших, цол хэргэм ахих эрхгүй бөгөөд ажилласан жил, тэтгэвэр тогтоолгох хугацаанд оруулан тооцохгүй.

Баривчлах ял /48 дугаар зүйл/:

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнийг нэгээс зургаан сар хүртэл хугацаанд ганцаарчлан хорихыг баривчлах ял гэнэ.

Сахилгын байранд шилжүүлэх ял /49 дүгээр зүйл/:

Цэргийн алба хаагчийг шүүхээс тогтоосон хугацаагаар чанга дэглэмтэй цэргийн тусгай ангид ажиллуулах замаар эрх чөлөөг нь хязгаарлахыг сахилгын байранд шилжүүлэх ял гэнэ. Энэ ял нь гурван сараас нэг жил хүртэл хугацаатай байна.

Хорих ял /50 дугаар зүйл/:

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар хорих ангид тусгаарлахыг хорих ял гэнэ. Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хэд хэдэн төрлийн ялыг нэгтгэж байгаа тохиолдолд хорих ялын хугацаа хорин таван жил байж болно. Жараас дээш настай эрэгтэй, эмэгтэй хүнд оногдуулах хорих ял

нь тусгай ангид заасан гэмт хэргийн дээд ялын дөрөвний нэгээс хэтэрч болохгүй.

Цаазаар авах ял /51 дүгээр зүйл/:

Цаазаар авах ялыг зөвхөн хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хүнийг санаатай алах (97 дугаар зүйлийн 2 дахь хэсэг), түрэмгийлэл (151 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг), төрлөөр устгах (153 дугаар зүйл), террор үйлдэх (155 дугаар зүйл) гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулна. Жараас дээш настай эрэгтэй, эмэгтэй болон арван найман насанд хүрээгүй хүнд цаазаар авах ял оногдуулахгүй. Өршөөлийн хуулиар цаазаар авах ялыг хорин таван жилийн хорих ялаар сольж болно.

Хоёр. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/:

Германы эрүүгийн хууль тогтоомжид зааснаар эрүүгийн хариуцлага буюу эрүүгийн ял хүлээх этгээд нь 14 насанд хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна. Эрүүгийн хуулийн 19-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 14 нас хүрээгүй хүнийг хэрэг хариуцах чадваргүй гэж үзнэ” гэж заажээ. Насанд хүрээгүй этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх тухай 1953 оны хуулиар насны шалгуурыг хоёр ангиллаар тогтоосон байдаг. Тухайлбал: насанд хүрээгүй (14-18 нас), залуучууд (18-21 нас) гэсэн хоёр ангилалд хувааж тус тусад нь хэрэг хариуцах чадварын хязгаарлагдсан болон хязгаарлагдаагүй байх түвшний

шалгуурыг тогтоожээ.

Германд хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болдоггүй. Түүнчлэн хуульд зааснаар гэмт холбогдолгүй буюу гэмт хэрэг үйлдсэн эсэх нь нотлогдоогүй этгээд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болохгүй.

Хэрэг хариуцах чадварыг а) Эмнэлгийн, б) Хууль зүйн гэж хоёр шалгуураар авч үздэг. Эмнэлгийн шалгуурт сэтгэцийн эрүүл мэнд, бүрэн бүтэн байдал ба түүний алдагдсан буюу хязгаарлагдсан эсэхийг I үздэг бол хууль зүйн шалгуурт насны болон гэмт холбогдлын байдлыг хамааруулдаг.

Германы Эрүүгийн хуульд ялын ойлголт болон зорилгыг тодорхойлсон зүйл байдаггүй. Харин ялын төрөл тус бүр дээр нь ялын зорилгоо тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, Германы эрүүгийн эрх зүйд ялын зорилгыг хэрхэн тодорхойлсноос хамаарч ялын төрлүүдийг бий болгон зохицуулсаар иржээ.²⁷⁷

Ялын төрлүүд:

Германы Эрүүгийн хуульд зааснаар ялыг үндсэн ба нэмэгдэл гэсэн хоёр төрөлд ангилдаг. Үндсэн ялын төрөлд: Хорих ял (*Эрүүгийн хуулийн 38-39-р зүйл*), Торгох ял (*Эрүүгийн хуулийн 40-43-р зүйл*) хамаарна. Нэмэгдэл ялын төрөлд: Тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглох (*Эрүүгийн хуулийн 44-р*

зүйл), Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хураах (*Эрүүгийн хуулийн 73-р зүйл*), Гэмт хэрэгт ашигласан багаж, зэвсэг, техник хэрэгслийг хураах; (*Эрүүгийн хуулийн 295-р зүйл*), Тусгайлан хуулиар тогтоосон бусад нэмэгдэл ял /*Амьтныг хамгаалах хууль, насанд хүрээгүй этгээдийн талаарх хууль гэх мэт*/ зэрэг хамаарна.

Хорих ял:

Хорих ял нь төрлийн хувьд а) Бүх насаар хорих, б) Хугацаатай хорих ял гэж ялгагдах ба гэмт хэрэг болон эрүүгийн зөрчилд оногдуулах хугацаатай хорих ялыг нэг жил хүртэл, нэг жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял гэж ялгадаг. Түүнчлэн, дэглэмээр нь хөдөлмөрлүүлэх замаар хорих, гянданд хорих, жирийн дэглэмд хорих, баривчлан хорих зэргээр ангилсан байна.

Торгох ял:

Энэ ялыг өдрийн орлогоор тооцож оногдуулах бөгөөд 7 хоногт 5 өдрөөс, 1 жилд 360 өдрөөс хэтэрч болохгүй. Торгуулийн хэмжээ хэргийн хүнд, хөнгөнөөс хамаарч 1-5000 евро хүртэл байна.

Тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглох:

Энэхүү нэмэгдэл ялыг гэмт хэрэг үйлдэхдээ тээврийн хэрэгсэл ашигласан тохиолдолд тухайн этгээдэд тээврийн хэрэгсэл жолоодохыг 1 жилээс 3 жил хүртэл хугацаагаар хориглодог. Энэхүү ялыг хорих ялтай хамт хэрэглэсэн

²⁷⁷ Д.Баярсайхан., Харьцуулсан эрүүгийн эрх зүй., УБ хот., 2017 он., 217 дахь тал

бол тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглох хугацааг хорих ялаа эдэлж дууссан өдрөөс тоолно.

Германы эрүүгийн хууль тогтоомжоор ял хэрэглэх асуудал томоохон байр суурийг эзэлдэг. Энэ нь ял оногдуулсан шийдвэр гарсан өдрөөс эхлээд ялаас чөлөөлөх, ялаас хугацааны өмнө тэнсэн суллах болон ялын хөнгөрүүлэх нөхцөл байдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдсон цогц ажиллагаа болдог

Юуны өмнө шүүх тухайн этгээдэд ял оноох шийдвэр гаргах үедээ ялын зорилго, ялтны гэмээ хүлээсэн, хохирлоо арилгасан байдал, ял эдлэх явцад болон эдэлж дууссаны дараа ялтанд ялын үзүүлэх нөлөө зэрэг бүхий л үр дагаврыг тал бүрээс нь судалж тогтоосон байх шаардлагатай. Германы Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хохирлыг бүрэн буюу хэсэгчлэн төлсөн тохиолдолд шүүх ялыг хөнгөрүүлэх буюу ял оногдуулахаас бүр мөсөн татгалзаж ч болно. Гэхдээ нь нэг жил хүртэл хорих буюу торгох ялтай хэргийн хувьд л боломжтой.

Гурав. Бүгд Найрамдах Франц Улс /БНФУ/:

Франц улсын Эрүүгийн хууль²⁷⁸-д эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъектийн тухай ойлголт нь хувь хүн болон хуулийн этгээд байхаар хуульчлагдсан байна.

²⁷⁸ Энэ хууль нь Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд 1994 онд батлагдсан байна.

Францийн Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, хохирогчийн эрхийг сэргээхэд оршино.

Хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шалгуур:

- Хуулиар тусгайлан тогтоосон насанд хүрсэн байх; (*Эрүүгийн хуулийн 122-р зүйлийн 8-д зааснаар 13 нас хүрсэн байх*);

- Өсвөр насны хүүхдийн хувьд хуулиар заасан насны тодорхой нөхцөлийг хангасан байх; (*13 наснаас 16 нас хүртэлх*);

- Насанд хүрээгүй зарим хүний хувьд насны тодорхой нөхцөлийг хангасан байх; (*16 наснаас 18 хүртэлх*);

- Сэтгэцийн эрүүл мэндийн шаардлага хангасан байх;

- Биеийн эрүүл мэндийн шаардлага хангасан байх;

- Харьяаллын болон иргэний статусын шаардлага г.м.

Субъектийн хувьд хувь хүн 13 насанд хүрээгүй тохиолдолд ямар ч гэмт хэрэг үйлдсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

13-18 нас хүртэлх хувь хүн (*18 насанд хүрээгүй*) эрүүгийн хариуцлагын хүнд биш санкцыг оноож болно. 18 насанд хүрээгүй ямар ч хүнийг цагдан хорих замаар мөрдөн шалгах үед хязгаарлалтын дэглэм нь чанга биш, аль болох жирийн нөхцөлийг сонгох байдлаар хуульчлагдсан байдаг.

Насанд хүрээгүй хүнд (13-18 настай) ял шийтгэл оногдуулахдаа аль болох хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зорилгыг хангасан хорихоос өөр төрлийн ялыг эхний ээлжид сонгож хэрэглэх журамтай байдаг.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шалгуур:

Францын Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Байгууллагад ашигтай буюу түүний төлөөлөгчид ашиг хонжоо олгох зорилгоор хуульд тусгайлан заасан гэмт үйлдэл, эс үйлдэхгүйг үйлдсэн төрөөс бусад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” Хуулийн этгээд гэдэг ойлголтод хуульд зааснаар дараах субъектийг оруулдаг байна. Үүнд:

- Ашиг олох зорилготой хувийн эрх зүйн хуулийн этгээд; (Үйлдвэр, худалдаа, харилцааны компани, нэгтгэл, корпорац);

- Ашиг олох зорилгогүй хувийн эрх зүйн хуулийн этгээд; (Улс төрийн нам, ассоциаци, үйлдвэрчний болон төрийн бус, олон нийтийн байгууллагууд);

- Нийтийн эрх зүйн хуулийн этгээд; (Яам, агентлаг, төрийн өмчийн байгууллагууд).

Францын эрүүгийн хуулийн 121-р зүйлийн 2-1-д заахдаа: “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хувь хүн, албан тушаалтанд оногдуулах ялаар орлуулж тооцож болохгүй” гэжээ. Францын хууль тогтоомжид зааснаар

эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох хуулийн этгээдийн 30 шахам төрлийг нэрлэн заасан байдаг.

Ялын төрлүүд:

Францын эрүүгийн эрх зүйд ялын тогтолцоо нь гэмт үйлдэхүйн категори, ангиллаас хамаарч дараах гурван төрөлд хуваагдана. Үүнд:

1) Эрүүгийн ял; (les peines criminelles)

2) Засан хүмүүжүүлэх ял; (les peines correctionnelles)

3) Цагдаагийн ял; (les peines police)

Эрүүгийн ял буюу “цээрлүүлэх ял” (peines afflictives et infamantes) нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хүнд төрөл юм. Эрүүгийн ял нь дараах үндсэн төрлүүдтэй.

- Бүх насаар нь хорих;

- 10 жилээс 30 жил хүртэл хугацаагаар хорих;

- Торгох; (20,000-50 сая евро)²⁷⁹

Эрүүгийн ялын төрөлд хамаарч байсан хамгийн хүнд ял болох цаазаар авах ялыг Франц улс 1981 онд бүрэн халсан ажээ.

Засан хүмүүжүүлэх ял нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оноох ялын хөнгөн төрөл бөгөөд дор дурдсан ялын төрлүүд багтана. Үүнд:

- 10 жил хүртэл хугацаагаар хорих;

- Торгох (20.000 евро хүртэл);

- Хоногоор торгууль тооцох;

²⁷⁹ Франц Улс нь Европын холбоонд нэгдэж орсноос хойш торгох ялын нэгжийг франкаар бус еврогоор тооцдог болжээ.

(өдөрт 1000 хүртэл евро 360 хоногоос дээшгүй);

- Нийтэд тустай ажил хийлгэх; (40-240 цаг);

- Эрх хасах ба эрхийг хязгаарлах; (Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйлийг хураах, чек гаргах, банкны гүйлгээ хийх эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, ан агнах эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах гэх мэт)

Дээр дурдсан хоёр төрлийн ялыг хэрэглэхтэй холбоотой нэмэгдэл ялыг (*peines complementaires*) сонгох боломжтойгоор оноох явдлыг хуульчилсан. Энэхүү нэмэгдэл ялын төрлүүдэд төрийн байгууллагад тодорхой албан тушаал эрхлэхийг 5 жил хүртэл хугацаагаар хориглох, гэр бүлийн гишүүний эрх, сонгох, сонгогдох эрхийг 10 жил хүртэл хугацаагаар хасах гэх мэт хамаарна.

Цагдаагийн ял нь эрүүгийн зөрчил гаргасан этгээдэд оногдуулах хөнгөн төрлийн ял бөгөөд манай улсын зөрчлийн хуулиар оногдуулах шийтгэлтэй адил гэж ойлгож болно.

Дөрөв. Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/:

Хятадын эрүүгийн эрх зүйд эрүүгийн хариуцлага хүлээх чадвар гэдэгт 16 насанд хүрсэн хүн бүр, корпорац, түүнчлэн хуульд заасан эрх мэдэл бүхий албан тушаалтан гэж зааглан үздэг. Хувь хүний хувьд

тодорхой төрлийн гэмт хэрэгт 14 нас хүрсэн бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байна. Тодруулбал, 14 насанд хүрсэн хүүхэд зориуд хүн алсан, хүндээр гэмтээсэн, хорт бодис хууль бусаар дамлан худалдсан, галдан шатаасан, хүчирхийлж хүчиндсэн, дээрэм тонуул хийсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Эрүүгийн хариуцлагын зорилгын талаар тодорхой заалт үгүй байх бөгөөд тус улсын Эрүүгийн хууль²⁸⁰-ийн 2 дугаар зүйлд "... аливаа гэмт хэрэгтэй тэмцэх, улс орны амар төвшнийг тогтоох, засгийн эрх болон нийгэм журамт байгууллыг хамгаалах, улсын хийгээд хөдөлмөрчин түмний өмч хөрөнгийг хамгаалах, ард иргэний биеийн эрх, ардчиллын эрх ба бусад эрхийг хамгаалах, нийгмийн болон аж ахуйн эмх дэглэмийг сахиулах, нийгэм журамт бүтээн байгуулалтын үйлсийн урагштай явагдахыг батлах явдал болно." гэж заасан байна.

Ялын төрлүүд:

БНХАУ-ын Эрүүгийн хууль²⁸¹-ийн 32-р зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагыг гол эрүү ба нэмэлт эрүү хэмээн хоёр ангилдаг байх бөгөөд 33-р зүйлд зааснаар гол эрүүгийн төрөлд Захиран хамаарах; Хорьж хөдөлмөрлүүлэх; Хугацаатай

²⁸⁰ Орч Б.Батзориг нар., БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль., УБ хот., 2006 он.

²⁸¹ БНХАУ-ын Ардын төлөөлөгчдийн Их Хурлын Тавдугаар хуралдаанаас 1997 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталж, мөн оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.

хорих; Хугацаагүй хорих /бүх насаар/; Алахаар шийтгэх /цаазаар авах/ зэрэг хамаарна. Харин 34-р зүйлд зааснаар нэмэлт эрүүгийн төрөлд Зоосоор яллах /торгох/; Улс төрийн эрхийг хасах; Эд хөрөнгийг хураан авах зэрэг багтах бөгөөд нэмэлт эрүүг хөнгөн хэрэгт дангаар тохируулан хэрэглэж болдог.

Түүнчлэн, гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын харьяат хүнийг хилээс хөөж гаргах шийтгэлийг дангаар буюу нийцүүлэн хэрэглэж болно.

Гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол гэмт этгээдэд хуульд заасан эрүүгээр шийтгэхээс гадна хохирлыг төлүүлэхээр шийдвэрлэвэл зохино гэж 36-р зүйлд заажээ.

Захиран хамаарах ял /38-41 дүгээр зүйл/:

Захиран хамаарах ялын хугацааг гурван сараас дээш хоёр жилээс доош тогтооно. Захиран хамаарагдахаар ял шийтгүүлсэн хүнийг Дотоодыг хамгаалах байгууллагын хяналтад байлгана. Уг ялаар шийтгүүлсэн ялтан дараах үүргийг журамлан сахих ёстой. Үүнд:

- Хууль цааз, засаг захиргааны хууль, тогтоолыг журамлан сахиж, хяналтыг дагах;

- Хяналт тавьж буй байгууллагын зөвшөөрөлгүйгээр үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэрэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх²⁸² эрх чөлөөг эдлэхгүй

²⁸² Жагсаал цуглаан зэргээр гаргаж тавьсан шаардлагыг шийдвэрлэхгүй, хүлээж авахгүй байгаа тохиолдолд хариу дарамт, шахалт үзүүлэх эрх чөлөөг тус

байх;

- Хяналт тавьж буй байгууллагын даалгаснаар өөрийн ажил байдлын талаар мэдүүлэх;

- Бусадтай уулзах талаар хяналт тавьж буй байгууллагын журмыг сахин биелүүлэх;

- Сууж байгаа хот, сийнаас салах буюу нүүж одох бол хяналт тавьж буй байгууллагаас зөвшөөрөл авах.

Захиран хамаарах ялын төрөл нь манай Эрүүгийн хууль дахь зорчих эрхийг хязгаарлах ялтай нэлээд төстэй байна.

Хорьж хөдөлмөрлүүлэх ял /42-44 дүгээр зүйл/:

Хорьж хөдөлмөрлүүлэх ялын хугацааг нэг сараас дээш зургаан сараас доош тогтооно. Хорьж хөдөлмөрлүүлэх ялыг Дотоодыг хамгаалах байгууллагад ойрхон газарт эдлүүлнэ.

Уг ялыг эдэлж буй ялтан сард нэгээс хоёр өдрийн чөлөөгөөр гэртээ харьж болно. Ялын хугацааг шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж эхэлсэн өдрөөс тооцно. Хэрэв ял эдэлж эхлэхээс өмнө урьдчилан хоригдсон бол хоригдсон нэг хоногийг хорьж хөдөлмөрлүүлэх ялын нэг хоногоор тооцон хасна.

Хорих ял /45-47 дугаар зүйл/:

Хорих ял нь хугацаатай болон хугацаагүй гэсэн хоёр төрөлтэй байх бөгөөд хугацаатай хорих ял нь зургаан сараас дээш арван таван жил хүртэл хугацаатай байна. улсын Үндсэн хуулиар “сүр үзүүлэх” хэмээн тодорхойлсон ажээ. Жишээ нь, өлсгөлөн зарлах, суулт хийх гэх мэт

Хугацаатай, хугацаагүй хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд хөдөлмөрлөх чадвартай хэн боловч цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжин өөрчлөгдөх ёстой гэж хуульчилжээ.

Алахаар шийтгэх ял /48-51 дүгээр зүйл/:

Алахаар шийтгэх ялт этгээдийг заавал даруй гүйцэтгэх хэрэгтэй биш бол шийтгэлийн гүйцэтгэлийг хоёр жил хүртэл хугацаагаар алгуурлан гүйцэтгэж болно. Мөн алахаар шийтгүүлсэн хүний хэргийг заавал Ардын Дээд Шүүх хороонд мэдүүлж зөвшөөрүүлсэн байх шаардлагатай. Гэмт хэрэг үйлдэх үед арван насанд хүрээгүй хүүхэд, эсхүл шүүн таслах үед жирэмсэн байгаа эмэгтэйд алах ялыг хэрэглэхгүй.

Зоосоор яллах ял (торгох ял) /52-53 дугаар зүйл/:

Зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг харгалзан үзэж яллах зоосныг тоог тогтоох ёстой бөгөөд шүүхээс тогтоосон хугацааны дотор нэг удаад, эсхүл хэсэгчлэн хувааж тушаана. Тогтоосон хугацаанд тушаагаагүй бол албадан тушаалгана. Ялласан зоосыг төлж дийлэхгүй байвал (хөрөнгө орлого хүрэхгүй) Ардын шүүх хороо ялтны хөрөнгө орлогыг олж мэдмэгц тухай бүрд нь тушаалгахаар шийдвэрлэж болно.

Улс төрийн эрхийг хасах ял /54-58 дугаар зүйл/:

Сонгох, сонгогдох эрх, үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах,

сүр үзүүлэх эрх чөлөө, төрийн албанд ажиллах эрхийг нэг жилээс дээш таван жил хүртэл хугацаагаар хасахыг улс төрийн эрхийг хасах ял гэнэ.

Эд хөрөнгийг хураан авах ял /59-60 дугаар зүйл/:

Эд хөрөнгийг хураан авах нь гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн өмч хөрөнгийн нэг хэсгийг, эсхүл бүгдийг хурааж авах ял юм. Эд хөрөнгийг бүгдийг нь хураан авахдаа гэмт этгээдийн хувийн хийгээд гэр бүлийнхэнд чухал бүхий амьдралын зардал үлдээх ёстой. Эд хөрөнгийг хураахдаа гэмт этгээдийн гэр бүлийнхний өмчлөлд хамаарах эд хөрөнгийг хураан авч болохгүй.

Тав. Оросын Холбооны Улс /ОХУ/:

Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай байхыг шаарддаг. Онц хүнд болон хүндрүүлэх шалтгаантай 20 орчим гэмт хэргийн тухайд 14 насанд хүрсэн байх ёстой. Гэмт хэрэг үйлдсэн хүн сэтгэцийн хувьд үйлдлээ ухамсарлаж чадаагүй буюу өөрийн зан төлөв, үйлдлээ удирдаж чадаагүй бол хэрэг хариуцах чадваргүй гэж үзэн эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг.

ОХУ-ын Эрүүгийн хууль²⁸³-д зааснаар эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх,

²⁸³ Тус хууль нь 1996 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан байна.

ялтан этгээд болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Ялын төрлүүд:

Тус улсын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар Торгох; Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан тушаал эрхлэхийг хориглох; Төрийн одон медаль, төрийн шагнал, цэргийн цол, хэргэмийг хасах, хүчингүй болгох; Нийтэд тустай ажил хийлгэх; Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх; Цэргийн алба хаахыг хязгаарлах; Эрх чөлөөг хязгаарлах; Баривчлах; Хорих (хугацаатай); Цэргийн сахилгын дэглэмд хяналтад байлгах; бүх насаар хорих; цаазаар авах ялын төрөлтэй.

Торгох ял /46 дугаар зүйл/ нь үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэгдэх бөгөөд торгох ялын хэмжээг шүүгдэгчийн хоёр долоо хоногоос таван жил хүртэлх хугацааны цалин хөлс, орлогын хэмжээгээр, эсхүл 2500-1 сая рублиэр тогтооно.

Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан тушаал эрхлэхийг хориглох ял /48 дугаар зүйл/-ыг үндсэн болон нэмэгдэл ялын аль алианаар нь хэрэглэх бөгөөд үндсэн ялын хувьд нэг жилээс таван жил хүртэл, нэмэгдэл ялын хувьд зургаан сараас гурван жил хүртэл хугацаатай байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял /49 дүгээр зүйл/ нь зөвхөн үндсэн ялаар хэрэглэгдэх бөгөөд 60-240 цаг байхаар тогтоож, өдөрт 4 цагаас хэтэрч болохгүй.

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял /50 дугаар зүйл/-ыг хоёр сараас хоёр жил хүртэл хугацаагаар тогтооно. Нийтэд тустай ажил хийлгэх болон засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг 1-р зэргийн хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн болон 3 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй, цэргийн алба хаагчид оногдуулахгүй.

Баривчлах ял /53 дугаар зүйл/ нь үндсэн ялын чанартай хэрэглэгдэх бөгөөд нэгээс зургаан сар хүртэл хугацаатай байна. Энэхүү ялыг 16 насанд хүрээгүй, жирэмсэн болон 14 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйд хэрэглэхгүй.

Хугацаатай хорих ял нь хоёр сараас хорин жил хүртэл хугацаанд үндсэн ял болж хэрэглэгдэнэ. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор хорих ял оногдуулсан бол гучин жилээс хэтэрч болохгүй. Харин нэг шийтгэх тогтоолоор оногдуулсан хэд хэдэн ялыг нэмж нэгтгэх бол хорин таван жилээс илүүгүй хугацаагаар тогтооно. Бүх насаар хорих ялыг онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ба үндсэн ялын чанартай хэрэглэгдэнэ. Энэ ялыг эмэгтэйчүүд болон 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулахгүй.

Цаазаар авах ял /59 дүгээр зүйл/-ыг зөвхөн хүний амийг онц ноцтойгоор хөнөөсөн хүнд хэрэглэнэ. Бүх насаар хорих ял оногдуулж болохгүй хүмүүст мөн адил цаазаар авах ял шийтгэхгүй. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн

3 дахь хэсэгт зааснаар цаазаар авах ял шийтгүүлсэн хүнд уучлал үзүүлсэн бол бүх насаар нь, эсхүл 25 жилийн хорих ялаар солино.

Зургаа. Их Британи Умар

Ирландын Нэгдсэн Хаант Улс:

Тус улс нь жишгийн эрх зүйн тогтолцоотой бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг дундад зууны үед боловсруулсан “actus non facit reum nisi mens sit rea” гэсэн томъёололд тулгуурлан нэг талаас хориглосон гэмт үйлдэл, нөгөө талаас хориглосон гэмт бодол гэсэн хоёр шалгуурыг нэгэн зэрэг хангасан байх нөхцөлөөр тайлбарладаг.

Гэмт үйлдэл болон хүсэл зоригийн шалгуурыг, жишгийн, эсхүл статут хуулийн заалтыг, нотлох үйл явц нь процедурын шаардлагыг тус тус хангасан бөгөөд тодорхой насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Түүнчлэн, ялын зорилгыг тодорхойлсон ямар нэгэн хууль тогтоомж байхгүй байсан бөгөөд 2003 онд анх удаа томъёолжээ.

Эрүүгийн шүүх цаазын хууль²⁸⁴-ийн 142 дугаар зүйлд “Ялын зорилго нь хэрэг, зөрчил гаргасан хүнд цээрлэл үзүүлэх, гэмт явдлыг багасгах, хэрэг, зөрчил гаргасан хүнийг засан төлөвшүүлэх, дахин нийгэмшүүлэх, нийгмийг хамгаалах, учирсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэхэд оршино.” гэж заасан байна.

Англид ялын тогтолцоо нь харьцангуй уян хатан, сонгомол нөхцөлөөр өөр хоорондоо уялдсан бөгөөд эрүүгийн төрөлжсөн хуульгүй байдгаас үүдэн олон төрлийн хууль, хуульчилсан актыг үндэслэн ял шийтгэл оногдуулах боломжийг шүүхэд олгосон байдаг. Зарим ялын төрлийг нэгж, түвшин, зэрэглэлээр нь таблиц болгон ангилсан байдаг. Жишээ нь торгох ял.

Ялын төрөл гурван төрөл хэсгээс бүрдэх бөгөөд Хорих ял; Эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлах ял; Торгох ялын төрөлтэй.

Хорих ялыг хугацааны хувьд а) бүх насаар хорих; б) уртасгасан хорих; в) хязгаарлагдсан хорих ял гэж ангилдаг. Бүх насаар хорих ялыг онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн (*урьдчилан төлөвлөж хоёр ба түүнээс дээш хүнийг алсан, садист хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, хүүхдийг хүчиндсэн, хүчирхийлсний дараа алсан, улс төр, шашин, үзэл суртлын зорилгоор хүн алсан*) бөгөөд 21 насанд хүрсэн хүнд оногдуулдаг. Харин уртасгасан хорих ял гэдэг нь онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн бөгөөд 18 насанд хүрсэн хүнийг 30 жил, түүнээс дээш хугацаанд хорих ял юм.

Хязгаарлагдсан хорих ялыг 18 насанд хүрсэн хүнд 15 жилээс доошгүй, харин 18 насанд хүрээгүй хүнд 12 жилээс доошгүй хугацаагаар оногдуулна. Торгох ял нь бусад төрлийн ялтай харьцуулахад харьцангуй түгээмэл хэрэглэгддэг

²⁸⁴ Criminal Justice Act., 2003., c44

бөгөөд гурван хэрэг тутмын нэгд нь торгох ял оногдуулдаг ажээ. Торгуулийн хэмжээг гэмт хэргийн түвшний байдлыг дээд хязгаараар нь авч үзвэл 1-р түвшинд 200 фунт хүртэл, 2-р түвшинд 500 фунт хүртэл, 3-р түвшинд 1000 фунт хүртэл, 4-р түвшинд 2500 фунт хүртэл, 5-р түвшинд 5000 фунт хүртэл байхаар тогтоосон байна.

Долоо. Америкийн Нэгдсэн Улс /АНУ/:

АНУ-ын 1978 оны Холбооны ял оногдуулах ба гүйцэтгэх тухай загвар хуульд “Гэмт этгээдэд цээрлэл үзүүлэх, нийгмээс тусгаарлах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх, засан төлөвшүүлэх сургалт-хүмүүжлийн арга хэмжээний хөтөлбөрт хамруулах” зэргийг ялын нөлөөлөл буюу зорилго гэж тодорхойлжээ.

Ялын төрлүүд:

Ялын тогтолцоог хүндээс нь хөнгөн рүү дараах байдлаар тогтоосон байна. Үүнд: цаазаар авах, бүх насаар хорих, хугацаатай хорих, хянан харгалзах (тэнсэх), гэрийн хорионд байлгах, торгох ял зэрэг болно.

Цаазаар авах ялыг АНУ-ын 36 муж улсад хэрэглэж байгаа бөгөөд зарим муж улсын эрүүгийн хууль тогтоомжид 16 наснаас доош насны этгээдэд цаазаар авах ял оноож байсан түүхэн баримт бий. Жишээ нь Флорида, Алабама муж улсад эрүүгийн хариуцлага хүлээх насны

хязгаарыг тогтоогоогүйгээс болж 10-12 насны этгээдэд цаазаар авах ял хэрэглэж (7 наснаас доошгүй) ирсэн байна. Харин АНУ-ын Дээд Шүүх (Оклахомагийн эсрэг Томпсоны хэрэг) 1989 онд тогтоол гаргаж 13 нас хүрээгүй хүнд цаазаар авах ял оноох нь Үндсэн хууль зөрчсөн хэрэг хэмээн зарлажээ.

Мөн цаазаар авах ялыг эмэгтэйчүүдэд хэрэглэх явдлыг хориглоогүй. Тус улсын цаазаар авах ял хэрэглэдэг ихэнх муж улсад ялыг гүйцэтгэхдээ цахилгаан сандалд суулгах аргыг хэрэглэдэг бөгөөд зарим мужид хорт хийгээр хордуулах (Аризон, Невада), буудах (Юта), дүүжлэх (Монтана, Вашингтон) аргыг хэрэглэдэг ажээ.

Америкт нийгмээс тусгаарлан цээрлүүлэх болон нийгмээс шахаж зайлуулах онолын баримтлал хүчтэй дэлгэрсэн байдаг. Цаазаар авах ялыг дэмждэг Д.Макнамари, Э.Сатерленд нарын үзлээр бол цаазаар авах ял нь төрийн гэхээсээ илүү нийгмээс хүлээлгэж буй дээд хэмжээний цээрлэл бөгөөд хувь хүн, төр, нийгмийн ухамсарт зайлшгүй шаардлага болж төлөвшсөн учраас энэхүү ял нь Америкийн шударга ёсны натурал зарчимд тохирно гэж тайлбарладаг.

Бүх насаар нь хорих ял нь АНУ-д хэрэглэгддэг хорих ялын нэг төрөл юм. Энэ ялыг голдуу цаазаар авах ялтай дүйцэхүйц тохиолдолд хэрэглэдэг боловч онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн фелони

гэмт хэрэгт 2 буюу гурван удаагийн шийтгэлтэй этгээдэд хэрэглэнэ. Ялангуяа гурван удаа хэрэг үйлдэж, гурван удаа ял шийтгүүлсэн хүнийг дөрөв дэх удаагаа яллах үед бүх насаар нь хорих ялыг сонгох түгээмэл. Зарим онцгой тохиолдолд тодорхой нөхцөл байдлыг харгалзан цаазаар авах ял шийтгүүлсэн хүний ялыг бүх насаар хорих ялаар орлуулан солих байдлаар хэрэглэдэг.

Хугацаатай хорих ялын хувьд түүний нөхцөл, хугацаа, дэглэмийг Эрүүгийн хууль тогтоомжоор нэг мөр нарийвчлан тогтоодоггүй бөгөөд ихэнхдээ шүүхийн жишигт нийцүүлэн шүүхээс тогтоодог, эсхүл ял эдлүүлэх байгууллага өөрөө тодорхойлдог. Өөрөөр хэлбэл хугацаатай хорих ялын доод ба дээд хэмжээний хувьд дундаж ерөнхий нөхцөл гэж байдаг.

Хянан харгалзах ял нь хорихоос өөр төрлийн ялын хувьд томоохон байр суурь эзэлдэг. Энэ нь ялаас чөлөөлж байгаа хэлбэр биш, түүнчлэн ял тэнсэх, ял хойшлуулах хэлбэр ч биш юм. Хүнд биш хэргийн хувьд хорих ялыг заавал эдлүүлэх шаардлагагүй үед хууль тогтоомжид заасан журмын дагуу цагдаагийн болон засаг, захиргааны тусгай албаны түшмэдийн хяналт дор тодорхой үүрэг, шаардлагыг биелүүлэх болзол тавьж, албадан хангуулах ял юм.

Торгох ял нь хорих болон хянан харгалзах ялтай хамт хэрэглэгддэг. Харин жижиг гэмт хэрэг буюу зөрчлийн хувьд дангаараа бие

даасан шийтгэл болгон хэрэглэдэг. Торгох ялын дээд хэмжээ хувь хүнд 50,000 ам доллароос дээшгүй, хуулийн этгээдийн хувьд 500,000 ам доллароос дээшгүй байна. Торгох ялаа төлж чадахгүй үед хорих ялаар солигдоно. Торгох ялыг оноохдоо шүүгдэж буй хүний долоо хоногийн орлого, эд хөрөнгийн байдал, санхүүгийн түвшин зэргийг тал бүрээс харгалзан ялгавартай тогтоодог.

ДҮГНЭЛТ

Ял нь харьцуулсан эрүүгийн эрх зүйн салшгүй чухал институт төдийгүй харьцангуй бие даасан судлагдахуун мөн.²⁸⁵ Нэрт эрдэмтэн Чезаре Беккариа Гэмт хэрэг ба ялын тухай бүтээлдээ “Ял шийтгэлийн хамгийн гол зорилго бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх буюу гэмт зан үйлийг тогтоон барих явдал бөгөөд хатуу чанга ял шийтгэлээ гээд энэхүү зорилго хангагдахгүй.

Харин үйлдсэн гэмт хэргийн хор хөнөөл, гэм буруутай хүний зан төлөвт тохируулан ял шийтгэлийн төрөл болон хэмжээг ялгамжтай оногдуулах нь үр нөлөөтэй.” гэсэн үзэл санааг дэвшүүлсэн нь өдгөө эрүүгийн эрх зүйд шударга ёсны зарчим (ял тохирсон байх) болон тогтжээ.

Судалгааны хүрээнд авч үзсэн улс орнуудын хувьд “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” ялын зорилгын

²⁸⁵ Д.Баярсайхан., *Харьцуулсан эрүүгийн эрх зүй.*, УБ хот., 2017 он., 127 дахь тал

талаар нийтлэг тусгасан байх ба ОХУ, Узбекистан зэрэг улсууд засан хүмүүжүүлэх зорилгыг чухалчилсан байна. Бас нэгэн нийтлэг байгаа зорилго бол гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх явдал байв.

Манай улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг нэгэн адил хуульчилсан бөгөөд засан хүмүүжүүлэх зорилгыг 2015 оны Эрүүгийн хууль / шинэчилсэн найруулга/-аар халсан юм. Гэвч энэ судалгаанд хамрагдсан улсууд цөм засан хүмүүжүүлэх, төлөвшүүлэх гэсэн зорилгыг хуульчилсан байгаа нь нэлээд анхаарал татлаа. Эсрэгээрээ, манай улсын Эрүүгийн хуульд шинээр орж ирсэн зөрчигдсөн эрхийг сэргээх зорилго нь бусад улсын Эрүүгийн хуульд харагдсангүй.

Миний бие хүний эрх, эрүүгийн эрх зүйг хавсран судалдаг судлаачийн хувьд ял шийтгэл нь хүмүүжүүлэх зорилгыг хангаж чадахгүй, хийсвэр зорилт гэж үздэг. Учир нь, гэмшил харамсал нь хүнийг ухааруулах боломж олгодог боловч хүний хүмүүжлийг өөрчлөх боломжгүй юм. Хувь хүнээс бие хүн болон төлөвших явц нь бага насанд хүчтэй явагддаг бөгөөд хүмүүжлийн суурь тэнд тавигддаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн хүмүүжнэ гэсэн хүлээлтээс илүүтэй хаширсан, харамссан болов уу гэсэн хүлээлт нь илүү бодитой юм.

Ялын олон төрөлтэй, сонголттой

байх нь ял тохирсон байх шударга ёсны зарчмыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд аль болох хорихоос өөр төрлийн үр нөлөөтэй ялын төрлийг хуульчлах, хэрэглэх нийтлэг хандлага улс орнуудад тогтож байгаа юм байна. Ялангуяа торгох ялыг өргөнөөр хэрэглэх болжээ.

Гэхдээ торгох ялаар цээрлүүлэх боломжгүй гэмт хэрэг, гэмт хэрэгтэн гэж бас бий. Жишээ нь: авлига албан тушаалын болон эдийн засгийн зэрэг хөрөнгө мөнгө, эрх мэдэл, давуу байдал, ашиг сонирхлоос үүдэлтэй гэмт хэрэгт торгох ял бараг үр нөлөөгүй.

Шунахайн сэдэлтэй учраас хулгайлах, дээрэмдэх, завших зэрэг гэмт хэрэгт торгох ял үл тохирох бөгөөд нийгмээс тусгаарлан хорих нь үр нөлөөтэй гэсэн Чезаре Беккариагийн үзэл санаа өнөөдөр ч манай болон бусад улсын Эрүүгийн хуульд уламжлагдан ирсэн шиг, орчин цагт албан тушаалын болон эдийн засгийн гэмт хэрэгтэй хорих ялаар тэмцэх нь шударга ёсны зарчимд нийцнэ гэсэн хандлага бий. Түүнчлэн, гэмт хэрэгтний зан үйлийн эдийн засгийн учир шалтгааны онол²⁸⁶-ыг боловсруулсан эрдэмтэн, шүүгч Гари Бекер “Гэмт хэргээс олж буй ашиг нь түүнд зарцуулах зардлаас илүү байгаа тохиолдолд тэр төрлийн гэмт хэрэг буурахгүй.” хэмээн баталсан нь цагаан захтай

²⁸⁶ Гари Бекер энэхүү онолоороо 1968 онд Нобелийн шагнал хүртсэн.

гэмт хэрэгтэнд өндөр өртөг шингэх ялын төрөл тохиромжтой болохыг харуулжээ.

Ном зүй

А. Монгол эх сурвалж

1. Төрийн мэдээлэл., 2002 он., №05.
2. Төрийн мэдээлэл., 2016 он., №07
3. Б.Батзориг нар., БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль., УБ хот., 2006
4. Б.Баярсайхан нар., Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), УБ хот., 2011
5. Д.Баярсайхан., Харьцуулсан эрүүгийн эрх зүй., УБ хот., 2017
6. Г.Эрдэнэбат /орч/, Чезаре Беккариа., Гэмт хэрэг ба ялын тухай., 2021

Б. Гадаад эх сурвалж

1. Markus Dubber., Theories of Crime and Punishment in German Criminal Law., 2006., University of Toronto.
2. Sagar Shelke, Jyoti Dharm., Theories of Punishment: Changing Trends in Penology., September 2019., International Journal of Engineering and Advanced Technology.

В. Эрх зүйн эх сурвалж

1. Эрүүгийн хууль (2002)
2. Эрүүгийн хууль (2015)
3. Criminal Justice Act (2003)

Г. Цахим эх сурвалж

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:
<https://legalinfo.mn/mn>

ЭРХЗҮЙН АНТРОПОЛОГИ

/ Эрхзүйн хүн судлал /



Хууль зүйн магистр, Монголын
Криминологичдын холбооны судлаач
С.НОМЫНБАЯСГАЛАН

Хураангуй:

Энэхүү өгүүллийн сэдвийг “Эрх зүйн антропологи” гэж томъёолон, агуулгыг хууль зүйн нэр томъёоны асуудлаар хязгаарлав. Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан юм. Судлагдахуун нь гол төлөв урт хугацааны туршид зорилтот оролцогчдыг ажиглаж, бодит амьдрал дээрх зүйлсийг судлахад оршино. Өөрөөр хэлбэл антроплогичид эртний болон өмнө судлагдаагүй зүйлсийг хамруулан аливаа юмс, үзэгдэл зэрэг олон хэлбэрээр орших нийгмийн үзэгдлийг судалдаг. Эрх зүйн антропологи бол антропологийн ухаанд XIX зууны дунд үеэс бий болсон ууган салбар бөгөөд олон янзын нийгэм, соёлын онцлог ялгааг нэг талаас нийгэм, соёлын; нөгөө талаас эрх зүйн харилцааны үүднээс судалдаг.

Түлхүүр үгс:

Хүн судлал (антропологи), эрх зүйн антропологи (хууль зүйн антропологи), хууль зүйн нэр томъёо, ius, lex.

Оршил

Хууль зүйн салбарт Чезаре Ломброзо (**Cesare Lombroso**)–ийн үндэслэсэн антропологийн онол буюу биологийн антропологийн үүднээс илүүтэй авч үзэж ирсэн болохоос **эрх зүйн антропологийн талаар төдийлөн судалж байгаагүй** байна. Ломброзогийн үндэслэсэн онолыг “**эрүүгийн эрх зүйн антропологийн сургаал**”²⁸⁷ эсвэл “**гэмт явдлын биологийн онол**”²⁸⁸ буюу “**био криминологи**”²⁸⁹ гэж нэрлэх нь бий. Энэ талаар Э.Булаг Монгол дахь ястны үзэл ба үндэсний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал хэмээх (2020) бүтээлд “**. . . угсаатны асуудал нь Монгол Улсын эрх зүйн судалгааны объект байж ирээгүй...**”²⁹⁰ байсаар өнөөг хүрсэн тухай хөндсөн нь энэ чиглэлээр судалгаа хийх үндэс нь

²⁸⁷ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Гурав дахь хэвлэл, Уб., 2011, 409 дэх тал

²⁸⁸ Осман Долу, Криминологийн онолууд, (Орчуулсан: Дашгаадан Э.), Уб., 2022, 70 дахь тал

²⁸⁹ Жанцан С., Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол, I боть, Уб., 2009, 926 дахь тал

²⁹⁰ Булаг Э., Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, (Орчуулсан: Туулайхүү Э., Туяа Ш.), Уб., 2020

болж байна. Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно...”²⁹¹ гэсэн нь антропологийн (хүн судлалын) судалгаа хийх хууль зүйн үндэслэл нь болох юм. Тиймээс эрх зүйн антропологи (монгол хэлэнд “**эрх зүйн хүн судлал**” гэж буулгав) гэж юу болох, түүний агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ гэдгийг антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Социализмын гэх тодотголтой өмнөх үеийн эрх зүйн тогтолцоонд “**хүн судлал**”²⁹²–ын талаар судлах

²⁹¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

²⁹² Монгол хэлний нэр томъёоны хувьд: Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь хэмээх (1966) бүтээлийн “Хүн” гэсэн үгэнд холбогдох үгүүдэд хүн судлал гэсэн нэр томъёоны талаар бичиж тэмдэглээгүй байна. Харин Шинжлэх ухааны академиас эрхлэн гаргасан Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Таван боть, (Х – Я), УБ., 2008, 2752 дахь талд “хүн судлал” гэсэн нэр томъёог хэрэглэж, утгыг нь хүний гарал үүсэл, түүхэн хөгжил, эрүүл анатоми, галбир төрх, хэл, соёл судалдаг ухаан гэж тайлбарласан байна. Монгол хэл дээр хэвлэгдсэн хүн судлалын талаархи бүтээлүүдэд: 1/хүн судлал буюу антропологи (anthropology) нь хүнийг өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван цагийн хэмжээст төдийгүй бөмбөрцгийн бүхий л хэсэгт байгаа жишээ баримтад тулгуурлан

бололцоо ихээхэн хомс байв. Энэ нь “**хөрөнгөтний гадны**”²⁹³ гэж үзэж байсантай холбоотой болов уу. Өдгөө энэ байдал эрс өөрчлөгдөж, өөрийн хөгжлийн шинэ чиг хандлагаа төдийгүй төрөлжин хөгжих нөхцөл боломж нь бүрдсэн байна. Тухайлбал, энэхүү **хүн судлалын ухааны** үүднээс өөрийн орны үндэсний хууль тогтоомжийг судлах нь хүн судлалын ухааны нэгэн томоохон салбар болох эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийг Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай нөхцөл боломж болно гэж үзэж байна. Энэ нь цаашлаад монголын эрх зүйн тогтолцоонд хүн судлалын эрх зүйн сэтгэлгээ, онолын урсгалыг бий болгож, хүн судлалын ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд нөлөөгөө улам өргөжүүлэн тэлж, төрөлжин хөгжих боломж байгаа

судалдаг ухаан юм. Харин хүнийг судалдаг бусад нийгэм, хүмүүнлэгийн ухаанаас арга зүй, судалгааны сэдэв, судлагдахуун болох хүний асуудлыг хүн төрөлхтөн үүссэн эрт цагаас өнөөг хүртэлх цаг хугацааны өргөн хүрээнд судалдагараа онцлогтой.

Антропологи хэмээх нэршил нь үгийн гарлын хувьд Грек хэлний *anthropos* буюу хүн хүмүүн, *logos* буюу судлал, тэмдэглэл гэсэн холбоо үгс юм. Мөнх – Эрдэнэ Г., Чулуунбат П., Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, УБ., 2017, 3 дахь тал/хүн судлал бол хүний тухай шинжлэх ухааны байж болох бүхий л судлагдахууны нарийн түвэгтэй байдлыг тусган харуулсан, бүхнийг хамарсан, хамгийн ерөнхий нэр томъёо юм. *Anthropologie* гэдэг үг нь герег хэлний *anthropologos* (*anthropos*: хүмүүн) хэмээх үг латин хэлнээ зээлдсэн *anthropologia* гэсэн үг болно. Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), УБ., 2007, 9 дэх тал

²⁹³ Номынбаясгалан С., Түвшинсанаа О., Хүчиндэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын антропологийн асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ., 2022, №2, 67 – 68 дахь тал

гэдгийг илэрхийлж байна. Энэ нь **“хүн судлалын ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ”** гэсэн асуулт хариултаа хүлээсээр байгааг харуулна.²⁹⁴ Хүн судлал (антропологи) бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд судлагдахуун гол төлөв урт хугацааны туршид зорилтот оролцогчдыг ажиглаж, бодит амьдрал дээрх зүйлсийг судалдаг.²⁹⁵ Тиймээс **“хүн судлалын талаарх эрх зүйн судалгааг дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс нийтийн болон хувийн эрх зүйн, нэн ялангуяа салбар эрх зүйн хүрээнд үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүй, эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүйн чиглэлээр төрөлжүүлэн хийж болох”** талаар өгүүллийн оршилд онцлон дурдаж байна. Улмаар эрх зүйн мөн чанар нь хүний мөн чанарт үндэслэгдэх тул орчин үеийн эрх зүй судлаачид нь юуны өмнө сайн хүн судлаач байх шаардлагатай болсон байна.²⁹⁶

Энд ийнхүү нуршин өгүүлэхийн учир нь өнөө үед (**XX зууны сүүл, XXI зууны эхэн**) эрх зүйн ерөнхий онол нь дэлхийн улс орнуудад,

²⁹⁴ Номынбаясгалан С., Хууль зүйн нэр томъёоны асуудлууд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, Уб., 2022, №1, (100), 80 дахь тал

²⁹⁵ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, Уб., 2022, №1, 101 дэх тал <https://bit.ly/3AnnYwe> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.25)

²⁹⁶ Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №2 – 3, 97 дахь тал

ялангуяа эх газрын эрх зүйн тогтолцоотой улс оронд хууль зүйн цоо шинэ шинэ шинжлэх ухааны (**эрх зүйн антропологи болон бусад**) шинэ мэдлэг, арга зүйн болон үзэл суртлын олон ургалч хандлагад тулгуурлан хөгжиж байна.²⁹⁷ Энэ утгаар Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд эрх зүйн антропологи / эрх зүйн хүн судлал/–ийн судалгаа хийхийн (**Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухаанд судалгааны объектуудыг антропологичлох**) зэрэгцээ эрх зүйн антропологи / эрх зүйн хүн судлал/–ийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна. Хэдий тийм боловч монголын хуульч эрдэмтэн судлаачид эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн чиглэлээр төдийлөн судлаагүй байна.²⁹⁸ Иймд энэ чиглэлийн судалгаа хийж эхлэхээс өмнө нэн тэргүүнд нэр томъёог цэгцлэх жишээлбэл **“хуулийн хүн судлал”**²⁹⁹ эсвэл **“хуулийн антропологи**

²⁹⁷ Нямсүрэн Ч., Эрх зүйн ерөнхий онол, (Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал), Хоёр дахь хэвлэл, Уб., 2017, 44 дэх тал

²⁹⁸ Сарантуяа Ц., Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №1, 20–21 дэх тал, Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №2 – 3, 97 – 99 дэх тал, Номынбаясгалан С., Улс төрийн намын тухай хуульд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг тодорхойлсон нь, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2021, №3, 56 дахь тал, Номынбаясгалан С., Түвшинсанаа О., Хүчиндэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын антропологийн асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2022, №2

²⁹⁹ Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), Уб., 2007, 71 болон 135 дахь тал

судлал³⁰⁰, мөн түүнчлэн **“хууль зүйн антропологи”**³⁰¹ буюу **“эрх зүйн антропологи”**³⁰² хэмээх нэр томъёонуудын үзэл санаа, утга агуулгыг хүн судлалын ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хэрхэн зөв оноож хэвшүүлэн хэрэглэх вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Энэ байдлыг харгалзан энэхүү өгүүллээр нэр томъёоны нэршил, оноолтын талаар авч үзэхийг гол зорилгоо болгов. Энэ үндсэн дээр эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ гэж юу болохыг тодорхойлох оролдлого хийв.

II. Эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/: Нэр томъёоны асуудал

Эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/-ийн тухай лавшруулан судлахаас өмнө нэн тэргүүнээ тодруулбаас зохих хэдэн зүйл байгааг энэхүү хэсэгт тайлбарлах нь зүйтэй. Үүнд: эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ гэж юу болох, эрх зүй судлал гэсэн бүхэл бүтэн нийгмийн шинжлэх ухааны асар том ухаан байхад хүн судлалын ухаан ямар хэрэгтэй болох, түүнээс юугаараа ялгаатай болох,

эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ нийгмийн яг ямар ухагдахууныг судалдаг болох, эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар мөн эсэх, гадаад хэлэн дэх **“legal anthropology”**, **“anthropology of law”**, **“law’s anthropology”**³⁰³ хэмээх нэр томъёо, түүний агуулга, хэрэглээ монгол хэлэн дэх “хуулийн хүн судлал” эсвэл “хуулийн антропологи”, мөн түүнчлэн “хууль зүйн антропологи” буюу “эрх зүйн антропологи” хэмээх ухагдахуунтай хэрхэн зохицон нийцэх тухай асуултуудад **утгын гурвалжингийн**³⁰⁴ үүднээс хариулт өгөхийг оролдлоо.

³⁰³ Burke Paul., *Law’s Anthropology, (From ethnography to expert testimony in native title), Printed by Griffin Press, 2011* https://books.google.mn/books?id=IR-l8jTxwMYC&printsec=frontcover&dq=legal+ethnography&hl=mn&sa=X&redir_esc=y#v=onepage&q=legal%20ethnography&f=false (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

³⁰⁴ Нэр томъёоны бүрэлдэхүүн хэсэг нь ухагдахуун, тэмдэгт буюу нэр томъёо, тодорхойлолт юм. Үүнийг “утгын гурвалжин”-гаар үзүүлбэл, Ухагдахуун гэдэг нь хүний оюун санаанд аливаа юм үзэгдлийн онцлогийг тусгаасан хийсвэр дүр зураг юм. Нэр томъёо гэдэг нь тэр ухагдахууны гадаад илрэл юм. Өөрөөр хэлбэл тухайн ухагдахууныг илэрхийлсэн (тусгай зориулалтын хэл буюу мэргэжлийн хэлэнд) тэмдэг юм. Тэр тэмдэг нь дан үг юм уу эсвэл нийлмэл үг байж болно. Нэр томъёоны өөр нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол тодорхойлолт юм. Тодорхойлолт гэдэг нь тухайн юм үзэгдлийн талаарх ухагдахууныг зөв оновчтой, бүрэн гүйцэд илэрхийлсэн тайлбарыг хэлнэ. Мөнхцэцэг Н., Хууль зүйн нэр томъёог боловсронгуй болгоход анхаарах хэдэн зүйл, Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 64 – 65 дахь тал

³⁰⁰ Булаг Э., Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, (Орчуулсан: Туулайхүү Э., Туяа Ш.), УБ., 2020, 130 дахь тал

³⁰¹ Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, УБ., 2021, 524 дэх тал

³⁰² Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, УБ., 2022, №1, 101 дэх тал

Эдгээр асуултуудын хариулт нь нэгэн зангилаа бөгөөд нэгнийх нь хариулт нөгөөгөө тодруулсаар төгсгөлд нь илэрхий тодорхой болно гэж үзэж байна. Хариултаа сүүлээс нь буюу нэр томьёоны гадаад болон монгол хэлний үгийн утга, түүний хэрэглээний талаар авч үзье.

А. Нэр томьёоны тухай цөөн үгээр

Монголчууд төрөөс тогтоосон хэм хэмжээний актыг “цааз” гэж нэрлэж байжээ.³⁰⁵ Үүнээс гадна <<цааз хууль>>, <<хууль цааз>> гэсэн хоршоо үг өргөн хэрэглэгдэж байв. Монголчууд “хууль” гэдэг үгнээс “цааз” гэдэг үгийг илүүтэй хэрэглэж байснаа яваандаа “хууль цааз” гэж хоршуулан хэрэглэж байсан нь түүхийн сурвалж бичгүүдээс харагддаг.³⁰⁶ Жишээлбэл цаазын бичиг (хуулийн эмхэтгэл), цааз зарлах (хууль гаргах), шүүх цаазын бичиг (эрүүгийн хууль), цаазлах (шийтгэх) гэх мэт нэр томьёо үүсжээ.³⁰⁷ Харин “эрх зүй” гэдэг энэхүү монгол нэршил 1978 оноос албан ёсны нэр томьёо болж хэрэглэгдсээр өнөөг хүрсэн байна.³⁰⁸ Эрх зүй гэсэн үгийн “зүй” гэсэн үг нь

ч монголчуудын сэтгэлгээнд хожуу бий болсон бололтой.³⁰⁹ Өмнө нь “эрх” гэсэн нэр томьёог хэрэглэн захиргааны эрх, эрүүгийн эрх гэх зэргээр нэрлэж байсан байна.

Жан Копаны Угсаатан судлал, хүн судлалын удиртгал хэмээх (2007) орчуулгын бүтээлд “. . . **Хууль цаазын болон аман уламжлалын өргөн талбар бол хуулийн хүн судлалын салбарыг үүсгэдэг. Хүн судлалын олон сэтгэгчид хуульчид байсан учраас хуулийн үүднээс бодож сэтгэж байв . . .**”³¹⁰ гэж бичсэн байна. Ийнхүү эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн үүднээс авч үзвэл, монголын эртний уламжлалт хууль цаазын дурсгалт бичгүүдэд тусгагдсан нэр томьёог гүнзгий судалж, өнөөгийн практикт тусгаж хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой байж болох юм. Тэр тусмаа “тодорхой” нэр томьёо тухайн үедээ ямар утга санаа илэрхийлж байсныг сайтар судалж, түүнийг утгыг нь тайлбал нэр томьёо судлалд их нэмэртэй.³¹¹ Энэ талаар эрх зүй судлаачдын дунд цөөн хэдэн үзэл санаа бий. Жишээ болгон дурдвал доктор, профессор Т.Сэнгэдорж “уламжлалаар цааз, хууль цааз, хууль зүй гэсэн ойлголтууд өргөн

³⁰⁵ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, УБ., 2008, 550 дахь тал

³⁰⁶ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 146 дахь тал

³⁰⁷ Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, УБ., 2021, 555 дахь тал

³⁰⁸ Улсын нэр томьёоны комиссын мэдээ, Хууль зүйн нэр томьёо, №107–108 (Тэргүүн дэвтэр) УБ., 1978

³⁰⁹ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 146 дахь тал

³¹⁰ Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), УБ., 2007, 71 дэх тал

³¹¹ Баярсайхан Д., Хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёог цэгцлэн төгөлдөржүүлэх асуудалд, Эрх зүй сэтгүүл, УБ., 2001, №4–5, 49 дэх тал

хэрэглэгдэж байсныг сэргээн судалж **эрхзүй** гэсний оронд **хууль зүй** гэсэн нь илүү оновчтой байна”³¹² гэж үзэв. Тэгвэл академич С.Нарангэрэл “монгол хэлний өдөр тутмын ярианд монголын хууль тогтоомж гэхээсээ монголын эрх зүй гэж хэлэгдэх нь илүүтэй болжээ”³¹³ гэж бичиж байв.

Харин доктор, профессор Х.Сэлэнгэ “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл” хэмээх (2014) бүтээлд “эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёонуудын үндэс, агуулгыг хэл шинжлэл, эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн онолын үүднээс авч үзэхийн зэрэгцээ эрх зүй гэсэн нэр томъёоны оронд хууль зүй гэсэн нэр томъёог хэрэглэх нь үндэслэлтэй хийгээд зохистой юу? Эрх зүй гэсэн нэр томъёог хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёоноос хасах нь зөв үү? Энэ нь монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд сайн нөлөөтэй юу гэсэн асуултуудад үндэслэл бүхий хариултуудыг өгсөн байна. Тодруулбал: **Нэгд**, хууль зүйн шинжлэх ухааны тулгуур нэр томъёо болох “эрх зүй” нь хожуу бий болсон нь монголчуудын эрхийг бус үүргийг дээдэлж ирсэн эрх зүйн сэтгэлгээний хөгжил, түүний онцлогтой холбоотой гэж үзсэн байна. Учир нь энэхүү нэр томъёог хэрэглэснээр эрх зүйн **мөн чанар, агуулга, үнэт зүйлийг**

³¹² Сэнгэддорж Т., Эрх зүй хэмээх нэр томъёоны эргэн тойронд, Эрх зүй сэтгүүл, УБ., 2012, №1–2 (21), 8 дахь тал

³¹³ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 5 – 6 дахь тал

ойлгон танин мэдэж, хуулийг агуулгаар хэрэгжүүлэх үндэс, боломж тавигдсан гэж үзэв.³¹⁴ **Хоёрт**, хэл шинжлэлийн үгийн үндэс, язгуур, гарал зүйн үүднээс “эрх зүй”, “хууль”, “хууль зүй” гэсэн нэр томъёонууд нь ялгаатай байх тул эрх зүй гэсэн нэр томъёоны оронд хууль, хууль зүй гэсэн нэр томъёог хэрэглэх нь зохистой биш гэсэн дүгнэлтийг хийв.³¹⁵ **Гуравт**, эрх зүйн онолын түүхэн үүднээс авч үзвэл хууль зүйн шинжлэх ухааны тулгуур нэр томъёо болох эрх зүй, хууль гэсэн нэр томъёо нь өрнийн улс орнуудад анх эртний Ромд үүссэн. Ромын хуульчид “эрх зүй”, “хууль”-ийг нэр томъёоны хувьд ялгаж, эрх зүйг “**ius**”, хуулийг “**lex**” гэж нэрлэж байв.³¹⁶ **Дөрөвт**, хүн төрөлхтний эрх зүйн сэтгэлгээний түүхийн үүднээс авч үзвэл Ромын хуульчид эрх зүй, хууль гэсэн ойлголтуудыг нэр томъёоны хувьд ялгахгаас гадна агуулгын хувьд ялган зааглаж байсан юм. Эдгээр нэр томъёо нь ялгаатай байх тул эрх зүйг хууль гэж үзэж, хуулиас өөр нэр томъёо байхгүй гэж үзэж болохгүй нь байна гэж тэмдэглэв.³¹⁷

Тавд, хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд “эрх зүй судлал”,

³¹⁴ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 145 дахь тал

³¹⁵ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 147 дахь тал

³¹⁶ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 147 дахь тал

³¹⁷ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 148 – 149 дэх тал

“хууль зүй судлал” хөгжиж байна. Эрх зүй судлал, хууль зүй судлал нь судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай. **Хууль зүй судлал** нь позитив эрх зүйд төвлөрч, хуулийн тухай сургаал онолуудаас гадна позитив эрхийг судлах арга зүй, позитив эрхийн тухай тайлбар, ангилал, системчлэл гэсэн эмперик фактуудыг эрх зүйн тогтолцооны хүрээнд судална. Харин **эрх зүй судлал** нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдгаараа хууль зүй судлалаас ялгаатай. **Эрх зүй судлал** нь танин мэдэхүйн хүрээнд эрх зүйн мөн чанар агуулгыг буюу эрх, эрх чөлөөний боломж, хязгаарын мөн чанар, агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг бол үнэт зүйлийн хүрээнд эрх зүйн объектив мөн чанар, үнэт зүйлийг илрүүлж, түүний зорилго, ач холбогдлыг тодорхойлдог. Түүнчлэн онтологийн хүрээнд **эрх зүй судлал** нь эрх зүйн оршин буйг нотолж, эрх зүйн объектив шинж, үүрэг зорилгыг илрүүлж, эрх зүйн илрэн гарах хэлбэр хууль болохыг тодорхойлдог байна. Ийнхүү **эрх зүй судлал** нь эрх зүйн зүй тогтол, онолыг судалдаг гэсэн байна. Эцэст нь доктор, профессор Х.Сэлэнгэ “**эрх зүй гэсэн нэр томьёог хууль зүйн шинжлэх ухаанаас хасаж, эрх зүй судлалыг үгүйсгэж, зөвхөн хууль зүй гэсэн нэр томьёог хэрэглэх нь хууль зүйн шинжлэх ухааны тулгуур ойлголтын мөн чанар, агуулгыг алдагдуулж,**

цаашлаад хууль зүйн шинжлэх ухааны зорилгоос ухарч, судалгааг хязгаарлаж байгаа явдал болно”³¹⁸ гэсэн маш үндэслэл бүхий нухацтай дүгнэлтийг хийсэн байна. Энэхүү дүгнэлт, тэдгээр үндэслэлүүдтэй бүрэн санал нэгдэж, дэмжиж байгаагаа энд онцлон тэмдэглэж байна.

Б. Нэр томьёоны нэршлийн тухайд

Хүн судлал буюу антропологи хэмээх нэр томьёо нь хууль зүйн шинжлэх ухаанд танил бус “**шинэ нэр томьёо**” болох нь монголын хууль зүйн зарим толь бичгүүдээс тодорхой (эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ гэсэн нэр томьёоны талаар дурдаж, тэмдэглээгүй) харагдаж байна.³¹⁹ Харин академич С.Нарангэрэл Эрх зүйн эх толь бичиг хэмээх бүтээлд “**эрх зүйн антропологи**” буюу “**хууль зүйн антропологи**” гэсэн нэр томьёонуудыг хэрэглэж, нэр томьёо, хэллэг, ухагдахууныг авч үзэхдээ агуулгын хувьд адилтган бичсэн байна (С.Нарангэрэл, 2008: 529, 610, 2011: 563, 610). Энэ нь дээрх нэр томьёонуудыг хууль зүйн шинжлэх ухаанд ердийн, эсвэл мэргэжлийн байна уу гэдгээс үл хамааран зохих түвшинд ямар нэгэн байдлаар нийтээр ойлгон

³¹⁸ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 151 – 152 дахь тал

³¹⁹ Амарсанаа Ж., ба бусад, Хууль зүйн тайлбар толь, УБ., 2003, Баярсайхан Б., Хууль зүйн тайлбар толь, (Монгол Улсын төр, эрх зүйн түүх), УБ., 2003 гэх мэт.

хэрэглэж дадсан болохыг нотлон харуулах нэгэн жишээ болж байна. Хэдий тийм боловч нэр томьёоны хувьд тааралдах хүндрэлүүдийн нэг нь гадаад нэр томьёог оноох, дүйцүүлэх явдал тулгарах нь гарцаагүй. Тухайлбал “**anthropology of law**”, “**legal anthropology**”, “**law’s anthropology**” гэсэн нэр томьёонууд нь англи хэлнээс монгол хэлэнд агуулгын хувьд адил төстэй, эсвэл зөрүүтэй орчуулагдах боломжтой байна. Иймд дээрх нэр томьёонуудын үзэл санаа, утга агуулгыг нэгдсэн агуулгаар тодорхойлох буюу дүйцүүлэх боломжтой эсэх, мөн түүнчлэн гадаад хэлнээс монгол хэлэнд хэрхэн хөрвүүлэн буулгах вэ, нэр томьёоны оноолтоос үүдэлтэй агуулгын зөрүүтэй байдал гарах боломжтой юу, эсвэл нэр томьёоны давхардал бий болсон уу гэх мэт асуултууд нээлттэй төдийгүй шинжлэх ухааны үүднээс хариултаа хүлээсээр үлдсэн байна.

В. Нэр томьёо оноолтын талаар эргэцүүлэх нь

Аливаа нэр томьёогоор илэрч буй ухагдахууны хүрээг харгалзах нь хувилбар нэр томьёо, давхцал, буруу оноолт зэрэг асуудлаас сэргийлэх ач холбогдолтой. Түүнээс гадна нэр томьёо нь шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийг тээгч болох тул зөвхөн хэлний тухай асуудал бус харин нийгмийн бүх салбарын нэгэн судлагдахуун байдаг

онцлогтой болно.³²⁰ Нэр томьёо, нэн ялангуяа гадаад үг хэллэгийг анхнаас нь зөв орчуулж хэрэглэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Анхнаасаа буруу орчуулагдан хэрэглэгдээд заншчихвал дараа нь янз бүрийн хүндрэл гарах эрсдэлтэй. Тиймээс хууль зүйн нэр томьёо онооход таарч тохирох тодорхой нэр томьёог олж орлуулахаас эхлэн олон асуудлууд тулгарна. Өөр бусад эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлахаас гадна эрх зүйн нэр томьёонуудын адил хамаарлыг олж тогтоох нь хоёрдмол утгагүй, төөрөгдүүлэхгүй, буруу ойлголтод хүргэхгүй байх зэрэг³²¹ чухал ач холбогдолтой болохыг санах учиртай.

Тэгээд ч хууль зүйн нэр томьёоны (**legal terminology**) үр нөлөө нь хэм хэмжээ тогтоогчид (**хууль тогтоогчдоос**) хууль зүйн нэр томьёонд тавигдах 1/ нэгдмэл; 2/ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн; 3/ тогтвортой байдал гэсэн шаардлагуудыг хангасан эсэхээс шууд шалтгаална³²² гэж үздэг. Энд онцлон тэмдэглэхэд эрх зүйн нэр томьёог хуулийн нэр томьёоноос ялган ойлгох, нэр томьёог оноох, сонгон хэрэглэхэд хэлбэр талаас нь бус харин агуулга талаас нь авч үзэхийг хүн судлалын ухааны

³²⁰ Мөнхцэцэг Н., *Нэр томьёоны орчуулга судлал*, Уб., 2020, 25 дахь тал

³²¹ Чимгээ Н., *Хууль зүйн орчуулгын онцлог, “Орчуулга, нэр томьёо, толь зүй, заах арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл*, Уб., 2010, 65 дахь тал

³²² Нарангэрэл С., *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл*, Уб., 2021, 525 дахь тал

онол, арга зүй талаасаа шаардаж байна. Энэ нь эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн дараах бүтээлүүдийн агуулгаас тодорхой харагдаж байна.³²³ Хууль зүйн шинжлэх ухаанд **нэр томьёо судлал** чухал байр буурь эзэлдэг³²⁴ бөгөөд хууль зүйн хэлний онцлог нь нэр томьёотой шууд холбоотой.³²⁵ Энэ нь үг, өгүүлбэрээр дамжин илэрдэг. Нэр томьёо товч, оновчтой, утга санаа бүрэн төгс байх нэг гол үндэс нь үгийг зөв сонгож хэрэглэх явдал юм.³²⁶ Тиймээс хууль зүйн нэр томьёог гадаад хэлнээс гадаад нэр томьёонд нутагшуулан оноон хэрэглэх эсэх сонголтыг шинээр нэр томьёо бүтээхэд баримтлах зарчмын дагуу хийх ёстой. Гэхдээ

³²³ *Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013* https://books.google.mn/books?i=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false James M. Donovan, *Legal Anthropology: An introduction, printed in the United States of America, AltaMira, 2008* https://books.google.mn/books?id=vRAfAAAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false . . . etc. (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

³²⁴ Баярсайхан Б., Монгол Улсын Үндсэн хуульт ёсны уламжлал, (БНМАУ–ын 1949 оны Үндсэн хуулийн эрх зүйн шинжилгээ), Уб., 2017, 32 дахь тал

³²⁵ Амархүү О., Эрх зүйн онолын арван таван сэдэв, Уб., 2008, 52 дахь тал

³²⁶ Амарсанаа Ж., Эрх зүй – нийгмийн харилцааг тохируулагч, Уб., 1988, 67 дахь тал

нэгэнт тогтсон хууль зүйн нэр томьёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, үзэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал байна.³²⁷ Чухамдаа **“нэр томьёог нэр томьёогоор орчуулах”**³²⁸ зарчмыг харгалзан үзэх шаардлагатай юм.

Нийтээр хэвшсэн нэр томьёог аль болох хэвээр нь хэрэглэхийн хамт **үг хэмнэх зарчмыг** баримтлахын³²⁹ зэрэгцээ хүн судлалын ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс хүлээн зөвшөөрөгдөхүйц байх нь зохимжтой гэж үзэж байна. Энэ утгаар антропологи хэмээх нэр томьёог хууль зүйн салбарт, нэн ялангуяа хуулийн антропологи гэсэн томьёог хэрэглэснээр **“эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн агуулгыг хэт явцууруулан тодорхойлуулах”** төдийгүй **“эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой адилтган ойлгох”** нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, **эрүүгийн хуулийн антропологи, иргэний хуулийн антропологи** гэх зэргээр нэрлэх нь эрүүгийн эрх зүйн антропологи, иргэний эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс

³²⁷ “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл) Уб., 2016, 73 болон 77 дахь тал

³²⁸ Сергей Влахов, Сидер Флорин., *Непереводимое в переводе, Москва, 1980, Стр. 285,*

³²⁹ Улсын нэр томьёоны комиссын мэдээ, Хууль зүйн нэр томьёо, №107–108, (Тэргүүн дэвтэр), Уб., 1978, 5 дахь тал

ялгаатай гэж үзэж байна. Түүнчлэн эрх зүйн онолын хувьд **эрх зүй хуулиас ялгаатай төдийгүй илүү өргөн агуулгаар тодорхойлогддог**³³⁰ **болохыг мартах учиргүй юм. Өөрөөр хэлбэл, эрх зүй судлал (эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг) нь хууль зүй судлал (эрх зүйн тогтолцооны хүрээнд)–** аас судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай болно. Эрх зүй, түүний илрэн гарах хэлбэр болох хууль, тэдгээрийн ялгаа, харилцан хамаарлын тухай үзэл санаа нь эрх зүйн тухай үзэл санаатай зэрэгцэн нэн эртнээс үүссэн бөгөөд одоо ч гэсэн эрх зүйн танин мэдэхүйн анхаарлын төвд байсаар байна.³³¹ Энэ дээр үндэслэн эрх зүй, хуулийг агуулгын ялгаагүй гэж үзэж болохгүй, нэн ялангуяа хууль нь агуулгаасаа гажсан тохиолдол бүр ч болохгүй юм. Харин хууль нь агуулгаасаа гажаагүй, эрх зүйд нийцсэн буюу эрх зүйт хуулийг эрх зүй гэж үзэж болох боловч өнөөг хүртэл хууль тогтоох явцад хууль нь агуулгаасаа гажиж байдаг тул эрх зүй, хууль хоёрыг ялгах хэрэгцээ шаардлага байгаа юм.³³² Тиймээс нэр томьёог хэрхэн

оноож өгснөөс шалтгаалан хоёрдмол утгаар ойлгогдох үр дагавартай байна. Өөрөөр хэлбэл эрх зүйн онол, философийн үүднээс эрх зүйн хэлбэрийг агуулгатай адилтган авч үзэх эрсдэлтэй болж байна. Тийм учраас хууль эрх зүйт шинжийг бүрэн олоогүй байгаа тохиолдолд **“эрх зүй”, “хуулийн”** ялгааг сайтар ухаарах, судлах, хууль тогтоомж бүрийг эрх зүйн шалгуураар шалгах шаардлага зайлшгүй бий. Энэ бол эрх зүйт төр, хуультай болох нэн чухал угтвар нөхцөл³³³ болохыг онолын хувьд бас санах учиртай. Хэдий тийм ч Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг хэмээх (2021) бүтээлд **хууль зүйн антропологи** гэсэн нэр томьёог хэрэглэж, англи хэлэнд **legal anthropology** гэж орчуулсан нь ихээхэн ач холбогдолтой болсон байна. Үүнээс гадна Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг Хүний эрх сэтгүүлийн 2022 оны №1 дугаарт хэвлэгдсэн Фернанда Пириегийн **“Anthropology of law”**³³⁴ хэмээх (2013) бүтээлийн орчуулгын цувралд **эрх зүйн антропологи** гэсэн нэр томьёог хэрэглэж, монгол хэлэнд буулгасан зэргийг дурдаж болох юм.³³⁵

Мөн түүнчлэн Монгол хэлний тухай хуульд “ . . . эрдэм

³³⁰ Баярсайхан Д., Эрх зүйн онол, Тав дахь хэвлэл, УБ., 2018, 34 дэх тал, Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 87 дахь тал гэх мэт.

³³¹ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 150 дахь тал

³³² Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 151 дэх тал

³³³ Лүндэндорж Н., Jurisprudence // Эрх зүй судлал: Философи, онол, УБ., 2011, 26 дахь тал

³³⁴ <https://bit.ly/3AIBmRN> (Сүүлд үзсэн: 2022.08.01)

³³⁵ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгаалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, УБ., 2022, №1, 101 – 125 дахь тал

шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ .³³⁶ гэж заасныг харгалзан эрх зүйн антропологи гэсний антропологи гэснийг гадаад нэр томъёогоор нэрлэн хэрэглэхээс илүүтэй цаашид монгол хэлэнд **“эрх зүйн хүн судлал”** гэж буулгаж, нэрлэж хэвших нь зүйтэй юу гэдгийг авч үзэх хэрэгтэй байна. Учир нь хууль зүйн салбарт эрх зүйн гүн ухаан гэхийн оронд дэлхий нийтээр хэл зүйн хувьд ижил хэрэглэдэг философи гэдэг нэр томъёогоор нь **“эрх зүйн философи”** гэж нэрлэдгийн адил антропологи гэсэн нэр томъёог монгол хэлэнд хөрвүүлэхгүй **“эрх зүйн антропологи”** гэх нь зохистой байна уу, эсвэл заавал орчуулж **“эрх зүйн хүн судлал”** гэх нь оновчтой юу гэсэн асуултууд зүй ёсоор тавигдаж, хариултаа хүлээсээр байна.

Иймд антропологи гэсэн нэршлээр хууль зүйн салбарт нэгэнт нийтээр хүлээн зөвшөөрч нэрлэж, цаашлаад хэрэглэж **“дадсан”**, эсвэл **“дадна”** гэж үзвэл салбар эрх зүй бүрт адил утгаар ойлгон хэрэглэгддэг нийтлэг нэр томъёо болгон хэвшүүлэх боломжтой гэж үзэж байна.

³³⁶ Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйл (Монгол хэлийг хэрэглэх)–ийн 6.5 дахь хэсэгт “Бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ” гэж хуульчилсан байна.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=10932> (Сүүлд үзсэн: 2022.08.01)

Жишээлбэл, үндсэн хуулийн эрх зүйн антропологи, эрүүгийн эрх зүйн антропологи, захиргааны эрх зүйн антропологи, иргэний эрх зүйн антропологи гэх мэт. Ийнхүү өгүүллээр авч үзэж буй нэр томъёоны нэршил, оноолтын тухайд хүн судлалын ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс ***хуулийн антропологи** гэж нэрлэхийн оронд ****эрх зүйн антропологи** гэсэн нэр томъёонд хэвшүүлэн нэрлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Учир нь эрх зүй судлал нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг байхад хууль зүй судлал эрх зүйн тогтолцооны хүрээнд авч үздэг онцлогтой байна. Эндээс авч үзвэл хууль зүйн хэрэглээнд ****эрх зүйн антропологи** (хууль зүйн антропологи) гэж нэрлэн хэрэглэх нь хууль зүйн нэр томъёонд зайлшгүй тавигддаг *нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, тогтвортой, хоёрдмол утга санаагүй (нэгдмэл) байх* гэсэн шаардлагуудыг ханган илүү тохиромжтой байна.

Г. Нийгэм, соёлын үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлагын талаар

Эрх зүйн тогтолцоо хоорондын ялгаа бий болсон шалгаан нь тухайн улс орнуудын уламжлал, ахуй амьдралын хэв маяг, түүхэн нөхцөл байдалтай холбоотой байдаг болохыг харьцуулсан эрх зүйн судлагдахуунаас олж мэдэж болно³³⁷ гэж үздэг. Тодруулбал,

³³⁷ Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй – I,

байгалийн нөхцөл байдлын хувьд үйл ажиллагаагаа төлөвлөх боломжтой газар нутагт амьдардаг хүмүүс урьдчилан тогтоосон хуулийг, харин далай тэнгисийн эрэг орчмын зэрэг үйл ажиллагааг төлөвлөх боломжгүй газарт харилцааг асуудал үүссэн тухай бүрт зохицуулаад явах аргыг илүүд үздэг уламжлал тогтсон. Үүнээс үзэхэд асуудлыг тухай бүр шийдвэрлэх нь шүүгчид, харин урьдчилан, ерөнхийд нь дүрэм, журмыг тогтоох нь хууль тогтоогчид хамааралтай байна.³³⁸ Эрх зүйн уламжлал нь эрх зүйн тогтолцоог тухайн соёлтой холбож илэрхийлдэг байна. Иймд эрх зүйн гол уламжлалууд нь ихэвчлэн эдийн засаг, технологийн, эсвэл улс төрийн хувьд илүү нөлөөтэй улс орнуудаас бусад хөгжиж буй улс орнуудад түгэн дэлгэрсэн байдгаараа онцлогтой гэж үздэг.³³⁹ Харин харьцуулсан эрх зүйн үүднээс “... аливаа улс орон нь бусад улс орны нийгэмтэй харилцахад нэг талаас өөрийн үндэстний эрх зүйн үйлчлэлийг хадгалан үлдэх; нөгөө талаас эрх зүйн харьцуулалтын шинэлэг, олон талт зохицуулалтыг нутагшуулж байгаа харьцуулалтын аргачлалтай зохицож байх ёстой. Иймд эрх зүйн уламжлал болон тухайн улс орны

төрийн бодлогыг салангид биш уялдаа холбоотойгоор харьцуулалт хийх мөн улс орны даяаршлын үйл явцыг дэлхий нийтийн геополитик хуваарилалтаас соёлын болон мэдлэгийн харилцааны шинж, төвшинг тусгаарлах шаардлагатай байгаа учраас харьцуулсан эрх зүй судлалын аргачлалын шаардлага хэрэгтэй . . .”³⁴⁰ гээд “... үндсэрхэг үзлийг ойлгох чадвар нь харьцуулсан эрх зүй судлалын чиглэлд асар ихээр нөлөөлдөг . . .”³⁴¹ гэж үзсэн байна. Энэ байдлыг харгалзан эрх зүйг (**Law**) антропологиин ухааны (**Anthropology**) үүднээс авч үзэхийн зэрэгцээ антропологиин өөр нэгэн бие даасан шинжлэх ухааны салбар болох нийгэм, соёлын антропологиин (**Social and cultural anthropology**) үүднээс эрх зүйн антропологиин асуудлыг авч үзэх хэрэгцээ шаардлага бий болсон.

III. Эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/: Ерөнхий ойлголт, судлах зүйл

Эрх зүйн антропологи (эрх зүйн хүн судлал)–ийн талаар нэр томъёоны тайлбарыг хийж байгаа бол мэдээж, түүний ойлголт, агуулга, судлах зүйлийг авч үзэх нь нэр томъёог илүү зөв, тодорхой болгоно гэж үзэж байна.

(Ерөнхий анги), УБ, 2020, 18 дахь тал

³³⁸ Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй – I, (Ерөнхий анги), УБ, 2020, 18 дахь тал, J.Gordley, Foundations of Private Law: Property, tort, contract, unjust enrichment, 2007, p 34 (Дам зшлэв).

³³⁹ Оюунтунгалаг Ж., Харьцуулсан иргэний эрх зүй, УБ., 2013, 12 дахь тал

³⁴⁰ С.Должин, Харьцуулсан хувийн эрх зүй судлал, УБ, 2018, 13 дахь тал.

³⁴¹ С.Должин, Харьцуулсан хувийн эрх зүй судлал, УБ, 2018, 14 дэх тал.

А. Шарль Монтескьогийн хуулийн амин сүнсийн ойлголтын үүднээс авч үзэх нь

Хуулийн амин сүнсийн тухай хамгийн даацтай, хүлээн зөвшөөрөгдсөн онолын судалгаа шинжилгээг Шарль Монтескьог [Charles de Montesquieu] (1689 – 1755) хийсэн хэмээн үздэг. Ш.Монтескьогийн 1748 онд хэвлүүлсэн **“Хуулийн амин сүнс”** хэмээх зохиол нь хуулийн амин сүнсийг судалсан хамгийн алдартай бүтээл хэмээгдэн дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн байна.³⁴² Орчин цагийн бүхий л улс гүрнүүдийн хууль, түүний дотор “үндсэн хууль” Ш.Монтескьогийн боловсруулсан онолыг эш үндэс болгож ирсэн байна.³⁴³ Тодруулбал, АНУ-ын Үндсэн хуулиас эхлээд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал Ш.Монтескьогийн дэвшүүлсэн үзэл санаанд тулгуурлагдсан байна.³⁴⁴ Энэхүү бүтээлд “... хууль нь тухайн орныхоо газарзүйн шинж чанарт, хүйтэн, халуун эсвэл сэрүүн цаг агаарт нь, газрын хөрсний чанарт, уг орны байршилд, нутаг дэвсгэрийнх нь хэмжээ дамжаанд, цаашилбал, тариачид, анчид, малчид болох ард түмнийх нь амьдралын хэв маягт, улсынх нь

*байгууллагаар тодорхойлогддог эрх чөлөөнийх нь хэр хэмжээнд, оршин суугчдынх нь шашин шүтлэг, авьяас чадварт, мөнөөх ард түмний баялаг, тоо хэмжээнд, худалдаанд нь, зан төлөв, ёс заншилд нь нийцэж байх учиртай . . .”*³⁴⁵ хэмээсэн маш нухацтай үндэслэгээг дэвшүүлэн тавьсан байна.

Энд ийнхүү онцлон өгүүлэхийн учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг хүн судлалын судалгаа хийх хууль зүйн үндэслэл нь болох төдийгүй эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн судалгааг дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс төрөлжүүлэн хийснээр “... Угтаа бол үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөө бол хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсэд зүй ёсоор тооцогдох учиртай. Харин хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг монгол орны өвөрмөц онцлог, үндэсний хэв маяг, уламжлал, монгол хүний сэтгэлгээ, хандлагад нийцүүлэн “монгол хөрсөнд” буулгаж чадсан уу”, “монголчуудын төрт ёс, түүх соёлын үнэт зүйлс нь үндэсний хууль тогтоомжтой хэрхэн уялдаж эсвэл ондоошиж (эсрэгцэж) байна вэ”, “даяаршлын нөлөөгөөр монголд хурдан дэлгэрч байгаа орчин үеийн үзэл санаа, түүнийг илэрхийлсэн үнэт зүйлс болон

³⁴² Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, УБ., 2018, 7 дахь тал

³⁴³ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, УБ., 2018, 8 дахь тал

³⁴⁴ Нарангэрэл С., Хуулийн амин сүнсийн эрэлхийлэл, (Чингис хааны гэрээс), УБ., 2016, 10 дахь тал

³⁴⁵ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, УБ., 2018, 8 дахь тал

нөгөө талд монголчуудын түүх, соёлын өвөрмөц онцлогийг илэрхийлсэн үнэт зүйлс хэрхэн зэрэгцэн оршиж байна вэ”, “монголд хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт хэрхэн төлөвшиж, үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг бодит амьдрал дээр, нийгмийн харилцаанд хэрхэн хэрэгжиж, монголын түүх, уламжлалт соёл, ахуй амьдрал, ёс заншил, итгэл үнэмшлийн онцлогтой хэрхэн холбогдож байна вэ. . .” гэсэн асуултуудад хариулах боломж олгож байгаагаараа онолын болон практик ач холбогдолтой байна. Учир нь эрх зүйн соёлыг бүрэлдэхэд түүх – нийгэм, улс төр, эрх зүй, соёл, заншил зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг³⁴⁶ болохыг санах ёстой.

Иймээс л дэлхийн улс орон бүр **“өөрийн”** гэсэн үндэсний эрх зүйн тогтолцоотой ба тэдгээр нь хүн амын амьдралын хэв маяг, зан заншил, эрх зүйн уламжлал, сэтгэлгээний хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай учраас энэхүү онцлог байдлыг харгалзан зохицуулах асуудал үндэсний эрх зүйн шинжлэх ухаан бүрийн өмнө зүй ёсоор тавигдаж ирсэн байна. Энэ байдлыг эрх зүйн антропологи / эрх зүйн хүн судлал/–ийн ухааны үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага монголын эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэж байна. Нүүдлийн мал аж

³⁴⁶ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 181 дэх тал

ахуйн өвөрмөц соёл иргэншилтэй, өдөр тутмын амьдрал ахуйдаа эдэлж хэрэглэдэг зарим зүйлс нь Европынхоос өөр учраас монгол орны хувьд зарим хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд өвөг дээдсээс уламжилж ирсэн заншлын хэм хэмжээг баримтлах шаардлага үүсэх нь гарцаагүй.³⁴⁷

Б. Эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн ойлголт, агуулгын талаарх эргэцүүлэл

Эрх зүйн мөн чанарын тухай асуудал нь эрх зүй гэсэн үзэгдлийн дотоод талд хамаарагдах асуудал тул түүний уг сурвалжийг авч үзэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг тодорхойлох боломжгүй юм. Эрх зүйн уг сурвалж бол хүн. Иймд хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг ойлгож, түүний тухай ярих боломжгүй байна. Ер нь аливаа нийгмийн шинжлэх ухаан нь хүн судлалгүйгээр хөгжих боломжгүй³⁴⁸ гэдгийг анхаарах учиртай. Өдгөө дэлхийн улс орнууд хөгжлийн асуудлыг дан ганц эдийн засгийн талаас нь бус харин түүх соёл, улс төр, нийгмийн болон улс төрийн философи, улс төрийн эдийн засаг, **антропологийн** талаас нь бүрэн гүйцэд судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн замналыг тодорхойлохыг оролдож байна. Монголчууд бид

³⁴⁷ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 121 дэх тал

³⁴⁸ Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №2 – 3, 97 дахь тал

ч гэсэн хөгжлийн шинэ замналаа хайж байна.³⁴⁹ Үүний нэг тод илрэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаас харж болно. Тодруулбал, (1992 оны) үндсэн хууль нь социалист чиг баримжаа, тоталитар дэглэмд хамаарах өмнөх (1924, 1940, 1960 оны) 3 үндсэн хуулиас мөн чанарын ялгаатай өөр буюу “ардчилсан” маягийнх гэж үздэг. Энэ нь түүний гол гол үзэл баримтлалаар тодорхойлогдох³⁵⁰ бөгөөд эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн агуулга ч гэсэн дээрх байдлаас хөндийрэх учиргүй гэж үзэж байна. Үүнээс гадна хүн судлалаар дэмжигдэн буй хүний эрхийн хандлага (**the human rights approach supported by anthropology/ethnology**)³⁵¹ гэж байна. Орчин үеийн эрх зүйн үнэт зүйлд суурилсан хандлага нь эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ – хууль зүйн практик үйл ажиллагааны зүй зохистой харилцан хамааралтай салшгүй холбоотой юм. Иймд эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/, түүний агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ гэдгийг хүн судлалын ухаан

болон хууль зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй авч үзэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Жишээлбэл үндсэн эрхийн талаар эргэцүүлж үзвэл, антропологийн аспектаар эрх зүйн үндэс суурь нь хүн өөрөө бөгөөд төрсөн цагаасаа эхлэн нийгмийн харилцаа, дэмжлэг дунд оршин байдаг.

Ертөнцөд хүн мэндлэхэд түүнд тодорхой халамж шаардагддаг бөгөөд энэ нь түүнийг насан туршид нь дагалддаг. Хүрээлэн буй орчноос түүнийг хамгаалах дэмжүүлэх шаардлага байнга тулгардаг. Ийнхүү социаль шинж чанартай суурь харилцаануудыг тойрон үндсэн эрхүүд бий болдог. Төрийн үндэс болсон хүн, түүний хэрэгцээг зөв үнэлж, зохистой гүйцэлдүүлэх байдлаар төр өөрөө тодорхойлогдох боломжтой.

Хүний үндсэн эрэлт, хэрэгцээг төр болон эрх зүйн аль нь ч хүлээн зөвшөөрөх ёстой байдаг. Тодорхой зарим (шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх гэх мэт) үндсэн эрх нь түүхийн болон антропологийн аспектаас улбаалан үзэхэд социаль хүрээнд хэрэгжихдээ нэлээд эмзэг байдаг. Тэдгээрийг зөрчихөд хялбар боловч бүхэлдээ буюу өргөн утгаараа тэд хүний оршин байх зорилго, утга агуулгыг тодорхойлж байдаг³⁵² онцлогтой байна.

³⁵² Сарантуяа Ц., Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №1, 20 – 21 дэх тал

³⁴⁹ Ган – Очир Д., “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод анхаарах асуудлууд”, Товхимол 14, УБ, 2019, 29 дэх тал <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group14/01.pdf> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

³⁵⁰ Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, (1924–1992), Эмхэтгэл, УБ., 1998, 122 дахь тал

³⁵¹ Булаг Э., Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, (Орчуулсан: Туулайхүү Э., Туяа Ш.), УБ., 2020, 101 – 102

Товчхондоо бол эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ гэдгийг нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсрын ижилсэл, ондоошлыг; нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь судалдаг хүн судлалын ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны салбар дундын бие даасан хавсарга ухаан³⁵³ гэж тодорхойлж болох юм. Энэ утгаараа хүн судлал бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд эрх зүйн хүн судлалын онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан бичмэл болон бичмэл бус хэм хэмжээ, ахуй зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуунаа болгон судалдаг гэж үзэж болно. Тэгэхлээр эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ нь эрх зүйн мөн чанарыг нийгмийн үзэгдэл талаас нь судалдаг байна. Тиймээс эрх зүйн антропологи нь **байгаа** болон **байх ёстой** зүйлийн хүрээнд бус харин **байгаа** зүйлийн хүрээнд авч үздэгээрээ эрх зүйн философиос ялгаатай гэж үзэж болох юм.

Тэгвэл эрх зүйн антропологийн талаар дараах байдлаар авч үзсэн байна. Жишээлбэл Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь

³⁵³ Номынбаясгалан С., Мөнх – Эрдэнэ Г., Баатарцогт Б., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), УБ., 2021, 5 дахь тал

бичиг болон Эрх зүйн эх толь бичиг хэмээх бүтээлүүдэд “*“Эрх зүйн антропологи” ~ “Хууль зүйн антропологи” гээд аман (үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс, ардын аман зохиол, ардын уран бүтээл зэрэг) буюу түүхэн дурсгалт бичиг, нийгмийн практикийг задлан шинжлэх замаар нийгэм хэв маяг бүрт хэвшмэл буй хүн төрөлхтний ахуйг хуульчлах үйл явцыг судалж, тухайн тодорхой эрин үе болон нийгмийн тухайн хэв маягийг хүний эрх зүйн ахуйн үндэс болсон зүй тогтол ба логикийг тодорхойлоход чиглэгдсэн шинжлэх ухаан ба хичээлийн судлагдахуун*” гэж тэмдэглэсэн байна (С.Нарангэрэл, 2008: 529, 610, 2011: 563, 610, 2021: 524). Харин Фернанда Пириегийн Эрх зүйн антропологи хэмээх бүтээлд “*. . . эрх зүйн антропологи нь хуулийг нийгмийн хэлбэр болохын хувьд утга учир олгодог таамаг, санаануудынх нь хамтаар шинжлэх ёстой. Хууль гэж нэрлэдэг нийгмийн үзэгдлийн бүхий л хүрээг төрөл зүйл, нийцэшгүй байдал бүхэнд нь нухацтай авч үзэж, хэв маяг, нийтлэг байдал, холбоог тэдгээрийн дундаас эрэлхийлнэ гэсэн үг. Зорилго нь тодорхойлохоосоо илүүтэй зааварчилж, нийтлэг шинж, ойлголтыг эрэлхийлэх юм. . .*” гэж бичсэн байна.³⁵⁴ Мөн түүнчлэн зарим

³⁵⁴ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, УБ., 2022, №1, 123 дахь тал

бүтээлд “эрх зүйн антропологи бол хүнийг нийгмийн оршихуй болох эрх зүйн илрэл, хэмжээсийн тухай шинжлэх ухаан юм. Эрт үеэс өнөөдрийг хүртэл хүмүүсийн нийгмийн амьдралын эрх зүйн хэлбэрүүд түүний мөн чанар”³⁵⁵ гэж тодорхойлж авч үзэв.

В. Эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/ эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох нь

Доктор, профессор Х.Сэлэнгэ “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл” хэмээх (2014) бүтээлд “эрх зүй судлал нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг учраас **эрх зүй судлал** нь танин мэдэхүйн хүрээнд эрх зүйн мөн чанар агуулгыг буюу эрх, эрх чөлөөний боломж, хязгаарын мөн чанар, агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг бол үнэт зүйлийн хүрээнд эрх зүйн объектив мөн чанар, үнэт зүйлийг илрүүлж, түүний зорилго, ач холбогдлыг тодорхойлдог. Түүнчлэн онтологийн хүрээнд **эрх зүй судлал** нь эрх зүйн оршин буйг нотолж, эрх зүйн объектив шинж, үүрэг зорилгыг илрүүлж, эрх зүйн илрэн гарах хэлбэр хууль болохыг тодорхойлдог байна. Ийнхүү **эрх зүй судлал** нь эрх зүйн зүй тогтол, онолыг судалдаг гээд эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар нь **эрх зүйн философи, эрх**

³⁵⁵ Нерсисянц В. С. Юридическая антропология как наука и учебная дисциплина // Рулан Н. Юридическая антропология. Пер. с франц. М., 1999. с 1

зүйн онол болно”³⁵⁶ гэж тэмдэглэсэн байна. Үүн дээр нэмээд “**эрх зүйн антропологи**” ч гэсэн эрх зүйн судлалын шинжлэх ухааны салбарын нэг болох нь гарцаагүй юм. Энэ нь бусад салбарт, нэн ялангуяа эдийн засгийн шинжлэх ухаан (санхүү) зэрэгт ажиглагдаж байна. Жишээ болгон дурдвал, Санхүүгийн философи: дэлхийн санхүүгийн түүх хэмээх (2017) бүтээлд “. . . **Хаммурабийн хууль** (*The Code of Hammurabi*)–ийн орчуулгаас үзэхэд одоогийн 3800 орчим жилийн өмнөх эртний Вавилоны эдийн засагт зээлийн харилцаа чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Тэр үеийн хуулиар зээлийн гэрээг бичгээр хийж байж л хүчинтэй болдог байсан тул шавар самбар дээр “*cuneiform*”³⁵⁷ бичгээр үйлдэгдсэн зээлийн гэрээнүүд археологийн малтлагаар олдсоор байна . . .”³⁵⁸ гэж иргэний эрх зүйн антропологийн археологийн талаар тэмдэглэсэн байна.

Г. Эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийн судлах зүйлийг тодорхойлох нь

Өмнө дурдсанчлан хүн судлалын ухааны олон сэтгэгчид хуульчид (**Х.Мейне, Л.Х.Морган зэрэг**) байсан учраас энэ салбар ухааны хамгийн

³⁵⁶ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 151 дэх тал

³⁵⁷ Cuneiform – Эртний Меспотамд 5000 орчим жилийн өмнө үүссэн, хүн төрөлхтний анхны бичиг

³⁵⁸ Ганзориг Ө., Санхүүгийн философи, Уб, 2017, 13 дахь тал.

эртний мэргэжил мэргэшлийн нэг болсон байна.³⁵⁹ Тэд бүгд л ямар нэгэн байдлаар тухайн судалж буй нийгмийнхээ хууль, ёс заншил, дэг журмын тухай бүтээлдээ тусгаж байв. Жишээлбэл, эрх зүйн антропологиин Малиновскигийн “Бүдүүлэг нийгэм дэх гэмт хэрэг ба ёс заншил” хэмээх (2018 [1925]) бүтээл³⁶⁰ зэргийг дурдаж болох юм. Энэ утгаараа антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд түүний онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, ёс, уламжлал, зан заншил, заншил (“худалдаа, арилжааны заншил” гэх зэрэг), үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй, аж байдал зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуун болгон судалдаг. Тиймээс эрх зүйн антропологиин судлагдахуун нь үндэсний хууль тогтоомж, шүүх, арбитрын шийдвэрээр хязгаарлагдахгүй ихээхэн өргөн хүрээтэй гэсэн үг.

Нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулах боломжгүй. Тиймээс эрх зүйн харилцаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан заншил, ёс суртахууны хэм хэмжээг өргөнөөр хэрэглэдэг.³⁶¹ Заншлын хэм хэмжээ нь эрх зүйн эх сурвалж болох талаар олон улсын болон дотоодын

эрх зүйн хэм хэмжээнд маш тодорхой заасан байх нь бий. Жишээлбэл НҮБ-ын Олон улсын шүүхийн дүрмийн 38 дугаар зүйлийн “б”, Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний Вений конвенцын 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг гэх мэт. Олон улсын худалдааг ихэвчлэн заншлын хэм хэмжээгээр зохицуулж ирсэн байдаг.³⁶² Заншил бол олон улсын эрх зүйн болон ер нь эрх зүйн хамгийн эртний анхдагч эх сурвалж бөгөөд улс хоорондын харилцаанд практикт төлөвшин тогтсон, заавал биелүүлэх шинж чанарыг нь олон улсын эрх зүйн субъектууд хүлээн зөвшөөрсөн ёс журам³⁶³ хэмээн тодорхойлж үздэг.

IV. Дүгнэлт, санал

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсын хууль зүйн салбарт өнөөг хүртэл үндэсний хууль тогтоомжийг төдийгүй хууль зүйн тодорхой (тохиолдлыг) асуудлуудыг хүн судлалын үүднээс судалсан судалгаа хэвлэгдээгүй байна. Энэ нь **“хүн судлалын ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ”** гэсэн онолын асуулт хариултаа хүлээсээр байгаа гэдгийг харуулж байна. Энэ нь бас хүн судлалын судалгаа хийх **“эрх зүйн зохицуулалтын хөшүүрэг”** байхгүйтэй холбоотой байж болох

³⁵⁹ Жан Копан., *Угсаатан судлал, хүн судлалын удиртгал*, (Орчуулсан: Дулам С.), УБ., 2007, 71 дэх тал

³⁶⁰ Malinowski B., 2018 [1925]. *Crime and Custom in Savage Society*, London: Routledge.

³⁶¹ Тамир Б., *Олон улсын хувийн эрх зүй*, УБ., 2019, 74 дэх тал.

³⁶² Уянга М., *Олон улсын худалдааны эрх зүй ба дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээ*, УБ., 2016, 10 дахь тал

³⁶³ Уянга М., *Олон улсын эдийн засгийн эрх зүй*, УБ., 2014, 37 – 38 дахь тал

юм. Ийнхүү хүн судлалын ухааны онол, арга зүйн үүднээс үндэсний эрх зүйн зохицуулалтуудыг судлах нь **“эрх зүйн антропологи /эрх зүйн хүн судлал/–ийг Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хүн судлалын судалгааг дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс салбар эрх зүйн, жишээлбэл эрүү, иргэн, захиргаа, үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр төрөлжүүлэн хийх боломжтой байна”** гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрэв. Энэ үндсэн дээр дараах цөөн хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1/ *Anthropology of law, legal anthropology, law's anthropology* гэсэн нэр томъёонууд нь энгийн утгаар эрх зүйн, эсвэл хуулийн хүн судлал гэсэн утга агуулгыг илэрхийлдэг хэдий ч монгол хэлэнд хэрхэн оновчтой буулгах вэ гэсэн асуулт шинжлэх ухааны үүднээс хариултаа хүлээсээр өнөөг хүрсэн байна. Харин хүн судлалын ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс авч үзвэл ***хуулийн антропологи** гэж оноон нэрлэхийн оронд ****эрх зүйн антропологи** гэсэн нэр томъёонд хэвшүүлэн нэрлэж, хэрэглэх нь зүйтэй болов уу гэж үзэж байна. Учир нь хуулийн антропологи гэсэн томъёог хэрэглэснээр **“эрх зүйн антропологи (эрх зүйн хүн судлал)–ын агуулгыг хэт явцууруулан тодорхойлуулах**

төдийгүй эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой адилтган ойлгох” нөхцөлийг бүрдүүлж байна. Жишээлбэл, эрүүгийн хуулийн антропологи, иргэний хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь эрүүгийн эрх зүйн антропологи, иргэний эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс ялгаатай байх болно.

Энд онцлон тэмдэглэхэд, хууль зүйн салбарт нэгэнт **“эрх зүйн гүн ухаан”** гэхийн оронд дэлхий нийтээр хэл зүйн хувьд ижил хэрэглэдэг философи гэдэг нэр томъёогоор нь **“эрх зүйн философи”** гэж нэрлэдгийн адил антропологи гэсэн нэр томъёог монгол хэлэнд хөрвүүлэхгүйгээр **“эрх зүйн антропологи”** гэж нэрлэн хэвшиж, хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

2/ Дээрх хууль зүйн нэр томъёоны асуудлуудын зангилаа нь **“хуулийн антропологи, эсвэл эрх зүйн антропологи хэмээх нэр томъёогоор дамжин илэрхийлэгдэх үзэл санаа, утга агуулгыг яаж ялган ойлгох вэ, тэдгээрт уялдаа холбоо, хамаарал байгаа юу, үзэл санаа, агуулгыг нь хэрхэн тодорхойлох вэ, хэрэглэх хүрээ нь ямар байх вэ”** гэсэн асуултуудад байна гэж үзээд, тэдгээрт ач холбогдол өгч эргэцүүлж болохоор байна. Энэ үндсэн дээр эрх зүйн зохицуулалтаас цааш **(дан ганц эрх зүйн онол, философийн**

хүрээнд бус хууль зүйн хэрэглээний хүрээнд бол) өргөн утгаар нь хэрэглэх үед **anthropology of law** гэсэн агуулгаар нь ойлгох нь зүйтэй болов уу, харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд явцуу утгаар хэрэглэх тохиолдолд **legal anthropology** гэсэн агуулгаар ялган зааглаж, агуулгын болон хэрэглэж байгаа хүрээнээс нь хамааран ийнхүү авч үзэж болох юм.

3/ Эрх зүй судлалын шинжлэх ухааны салбарууд болох нь **“эрх зүйн философи”, “эрх зүйн онол”**–ын нэгэн адил **эрх зүйн антропологи** нь эрх зүйн судлалын шинжлэх ухааны нэгэн салбар болж байна. Энгийнээр бол эрх зүйн антропологи нь: нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсрын ижилсэл, ондоошлыг; нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь авч үздэг бөгөөд түүний онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуунаа болгон судалдаг гэж үзэж болохоор байна. Үндэсний хууль тогтоомжид зан заншлыг тодорхойлсон хэм хэмжээнүүд цөөнгүй бий. Энэ нь зан заншлын хэм хэмжээнд ихээхэн ач холбогдол өгснийг харуулна. Жишээ болгон Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 1 дүгээр сарын 26–ны өдөр баталсан Арбитрын тухай

хуулийн³⁶⁴ 40 дүгээр зүйл (**Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ**)–ийн 40.5 дахь хэсгийн *“Арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ”* гэснийг дурдаж болох юм. Ийнхүү антропологийн үзэл баримтлалыг ухагдахууны түвшинд тодорхойлж, эрх зүйн антропологийн онцлогийг эрх зүйн ерөнхий үзэл баримтлал болгон авч үзэх нь эрх зүйн антропологийг хөгжүүлэх суурь үндэс нь гэж үзэж байна. Энэ утгаар **эрх зүйн болон үндэсний эрх зүйн тогтолцооны** талаарх антропологи анализыг **эрх зүйн антропологи** гэж тодорхойлж болох юм.

³⁶⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12456> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

НОМ ЗҮЙ**А.Эрх зүйн эх сурвалж:**

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992.01.13)
2. Монгол хэлний тухай хууль (2015.02.12)
3. Арбитрын тухай хууль (2017.01.26)

Б.Монгол хэл дээрхи эх сурвалж:

1. Бум – Очир Д., Мөнх – Эрдэнэ Г., Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., 2012
2. Мөнх – Эрдэнэ Г., Чулуунбат П., Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., 2017
3. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, (II хэвлэл), Уб., 2008
4. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, (III хэвлэл), Уб., 2011
5. Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, Уб., 2018
6. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001
7. Нарангэрэл С., Хуулийн амин сүнсийн эрэлхийлэл, (Чингис хааны гэрээс), Уб., 2016
8. Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, Уб., 2021
9. Номынбаясгалан С., Хууль зүйн нэр томъёоны асуудлууд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, Уб., 2022, №1, (100)
10. Номынбаясгалан С., Түвшинсанаа О., Хүчиндэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын антропологийн асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2022, №2
11. Нямсүрэн Ч., Эрх зүйн ерөнхий онол, (Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал), Хоёр дахь хэвлэл, Уб., 2017
12. Сарантуяа Ц., Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №1
13. Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №2 – 3
14. Сэлэнгэ Х., Эрх зүй ба Хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1
15. Сэнгэдорж Т., Эрх зүй хэмээх нэр томъёоны эргэн тойронд, Эрх зүй

сэтгүүл, Уб., 2012, №1 – 2 (21)

16. Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., ба бусад) Хүний эрх сэтгүүл, Уб., 2022, №1
17. Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), Уб., 2007

В.Гадаад хэл дээрхи эх сурвалж:

1. Fernanda Pirie., The Anthropology of Law, Oxford university press, 2013

Г.Бусад эх сурвалж

1. Хамтын бүтээл., Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Таван боть, (Х – Я), Уб., 2008

Д.Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn
2. <https://bitly.com/>
3. <https://nhrcm.gov.mn/>

**ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ,
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ**



Хууль зүйн магистр, Шихихутуг
их сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн багш
Ё.ӨСӨХБАЯР

ОРШИЛ

Манай улсын авлигын төлөв байдал жил ирэх тусам муудаж авлига эрчимтэй ихсэж буй 10 улс орны нэгт багтаад байгаа өнөө цагт авлигатай тэмцэх эрх зүйн шинэ механизмыг эрэлхийлэх, одоо байгаа эрх зүйн зохицуулалтыг засаж сайжруулах, хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангах нь нэн тэргүүний анхаарах ёстой асуудал болоод байна. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенцод манай улс 2005 онд нэгдэн орсон боловч хэрэгжилт үр дүн хангалтгүй байгаа нэг жишээ бол Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг юм. Энэ гэмт хэргийн авлигын эсрэг үзүүлэх үр нөлөө нь маш их бөгөөд уг гэмт хэргийг амжилттай хэрэгжүүлснээр авлигын түвшинг

бууруулж чадсан дэлхийн улс орнуудын жишиг байна. Иймд уг гэмт хэргийн хэрэгжилтийн төлөв байдлыг судалж, амжилттай хэрэгжүүлэх арга замыг дэвшүүлж чадвал Монгол улсын авлигын түвшинг бодитойгоор бууруулах боломж байна гэж үзэж байна.

Авлигын гэмт хэргийн гаралт улам ихээр нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлөөс маш олныг дурьдах боломжтой. Тогтсон нийгмийн сэтгэлзүй, хүн амын боловсролын түвшин, тэгш бус байдал, төрийн албаны нүсэр бүтэц, хүнд суртал гэх мэт. Харин энэ дундаас эрүүгийн хуулиар шийдвэрлэх боломжтой бөгөөд хамгийн үр нөлөөтэй байж болохуйц арга хэрэгсэл бол авлигын гэмт хэргийн бүрэн илрүүлэх, ял шийтгэлийн зайлшгүй байх зарчмыг хангах асуудал юм.

Нэрт сэтгэгч Чезаре Беккариа-н Гэмт хэрэг ба ялын тухай бүтээлд “Гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу харгис нь бус гарцаагүй нь чухал³⁶⁵” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт халдсан этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээхгүй өнгөрөх нүх, сүв их байх тусам тухайн гэмт хэргийн гаралт ихээр нэмэгдэх аюулыг дагуулж байдаг. Авлигын гэмт

³⁶⁵ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. УБ., 2021 он. 78 дахь тал.

хэргийн нэг онцлог тал нь гэмт хэрэг үйлдсэн буюу хахууль өгсөн, авсан аль аль тал нь өөртөө эд хөрөнгийн ашигтай нөхцөл байдлыг үүсгэсэн байдаг. Мөн энэ гэмт хэргийн улмаас хэн нэг этгээдэд шууд хохирол бодитойгоор мэдрэгддэггүй, их хэмжээний мөнгөн дүн, эрх ашиг сонирхол яригддаг болохоор гэмт хэргийн ул мөрийг баллах арга хэмжээг сайтар авсан байдаг зэргээс шалтгаалан энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн төвөгтэй байдаг.

Иймд Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг өөрийн орны эрх зүйн онцлог шинжид тохируулан хуульчлах боломжтой байна. Дэлхийн бусад улс орнуудын хувьд

1. зорилтот этгээдийн хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон нийт хөрөнгө чинээ нь тухайн хүний “албан ёсны” буюу “мэдэгдэж байгаа” орлоготой нийцгүй байгааг төрийн зүгээс харуулсан бөгөөд зорилтот этгээд нь энэхүү нийцгүй байдлыг тайлбарлаагүй эсхүл тайлбарлаж чадаагүй, (нотлох үүргийг төр болон гэмт хэрэгт холбогдогч этгээдэд аль алинд хувиарлах)

2. зорилтот этгээдийн хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон нийт хөрөнгө чинээ нь тухайн хүний нийт орлогоор тайлбарлагдах боломжгүй байгааг төр дангаараа харуулсан; (төр дангаараа нотлох үүргийг хүлээх)

3. хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон хөрөнгө чинээ

нь хууль ёсны орлоготой нийцтэй байгааг зорилтот этгээд дангаараа тайлбарлаагүй буюу хангалттай тайлбар хийгээгүй.(гэмт хэрэгт холбогдогч этгээд дангаараа нотлох үүргийг хүлээнэ) гэсэн 3-н хэв загварт хуваагдаж байна. Манай улсын хувьд дээрх 3-н хувилбарын аль тохиромжтойг өөрийн орны онцлогт тохируулан сонгох шаардлагатай байна.

НЭГ. ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, АЧ ХОЛБОГДОЛ

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлд заасан авлигын эсрэг гэмт хэрэг бөгөөд манай улсын хувьд 2015 оны эрүүгийн хуульд уг гэмт хэргийг үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан билээ.

Энэ гэмт хэргийг анх Аргентин улсын Парламентад нийтийн албан тушаалтны эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгө орлогыг хурааж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудал тавигдсанаар уг гэмт хэргийн үзэл санаа үүссэн гэж хэлж болно. Үүний дараагаар буюу 1950-аад оны эхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс болох Хонконг-д нийтийн албан тушаалтны амьжиргааны түвшин үндсэн цалинтай нь харьцуулахад өндөр болох эсхүл өөрийн хөрөнгө

орлогыг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадаагүй тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалт бүхий журмыг гаргаж байсан.³⁶⁶ Египет, Сенегал, Энэтхэг, Куба, Турк, Нигер зэрэг улсууд үүний дараагаар эрүүгийн хуульдаа нийтийн албан тушаалтны үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг болгон тооцож байсан. Харин олон улсын баримт бичигт анх удаа буюу 1996 онд Авлигын эсрэг Америк хоорондын конвенц (IACAC³⁶⁷)-ийн 9 дүгээр зүйлд тусгагдан үүнээс 7-н жилийн дараа буюу 2003 онд Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Африкийн холбооны конвенц ((AUCPC³⁶⁸)-ийн нэгдүгээр зүйлд тусгагдсан байдаг.

Харин 2003 онд Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцын 20 дугаар зүйлд албан ёсоор Хууль бусаар хөрөнгөжих асуудлыг тусгасан байдаг. Ингэхдээ хууль бусаар хөрөнгөжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох

хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ³⁶⁹ гэж заажээ. Манай улсын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод 2005 онд нэгдэн орсон байдаг.

Аливаа гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдийг ойлгомжтой байдлаар нарийн тодорхойлох нь тухайн гэмт хэргийн хэрэгжилт, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлдэг ач холбогдолтой байдаг. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хувьд гэмт хэргийн бүрэлдэхүүний харьцангуй онцлогтой гэж хэлж болно. Энэ гэмт хэрэг нь анхлан эрүүгийн хуульд орохдоо нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь **хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол** үндэслэлгүй нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэмцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ³⁷⁰ гэж заасан бол эрүүгийн хуулийн 2022 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн

³⁶⁶ Aleksandar Stevanović, Laura Maria Stănilă. *Illicit Enrichment As A Criminal Offense: Possibility Of Implementation In The National Criminal Legislations*. 2022. Pg 6.

³⁶⁷ *Inter-American Convention Against Corruption, Article 9.*

³⁶⁸ *African Union Convention on Preventing and Combating Corruption, Article 1.*

³⁶⁹ *Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц. 20 дугаар зүйл.*

³⁷⁰ *Эрүүгийн хууль. 2015 он.*

нэмэлт өөрчлөлтөөр “Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр **нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол** үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ³⁷¹” гэж өөрчлөн найруулсан.

Мөн зүйлд нэмэлт өөрчлөлт оруулахдаа их хэмжээний хохирол гэдэгт тайлбар хийсэн бөгөөд энэ нь нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно гэж заасан. Үүнээс үзэхэд гэмт хэргийн объектив шинж нэг хэсэг болох гэмт үйлдэл, эс үйлдэхүй болон хохирлын хэмжээ, болон санкц буюу эрүүгийн хариуцлага хүндэрсэн өөрчлөлтүүд гарсан байна.

Уг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг задлан үзвэл:

Объект

Нийтийн эрх ашиг, төрийн албаны ил тод, итгэл даах байдал.

Объектив шинж

Хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол

Субъектив шинж

Гэм буруугийн санаатай хэлбэртэй, их хэмжээний хөрөнгө орлогоо нуух зорилготой, шунахайн сэдэлтэй.³⁷²

Субъект

Нийтийн албан тушаалтан буюу Нийтийн албанд нийтийн буюу хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан болон Авлигын эсрэг хуулийн дөрөв дүгээр зүйлд заасан албан тушаалтнууд хамаарна.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг эрүүгийн хуульд тусгахын тулд дараах зүйлүүдийг зайлшгүй тогтоох шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

1. Гэмт хэрэг үйлдэх субъект
2. Гэмт хэрэг үйлдэгдэх цаг хугацаа
3. Хөрөнгийн мэдэгдэхүйц өсөлт
4. Зорилго субъектив шинж
5. Үндэслэлгүй байдал.

Гэмт хэрэг үйлдэх субъект.

Энэ гэмт хэрэг нь тусгай субъекттэй буюу нийтийн албан тушаалтан байхын шаарддаг. Харин ингэхдээ Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод зааснаар нийтийн албан тушаалтан гэдгийн аль болох өргөн хүрээнд тавьж байж авлигатай тэмцэх боломж нэмэгдэнэ гэж үзсэн байна. Авлигын эсрэг хуулийн 4

³⁷² С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг. УБ., 2018 он. 399 дэх тал.

³⁷¹ Эрүүгийн хууль. 2015 он.

дүгээр зүйлд зааснаар

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн гэж заасан харьцангуй өргөн хүрээнд нийтийн албан тушаалтныг тодорхойлсон гэж үзэх үндэслэлтэй байна.

Гэмт хэрэг үйлдэгдэх цаг хугацаа

Гэмт хэрэг үйлдэх цаг хугацааг манай улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийтийн албан тушаал хашиж буй цаг хугацаагаар тооцож байгаа нь зарим талаараа учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл зарим зарим өндөр албан тушаалтны хувьд тухайн албан тушаалаасаа буусан ч нийтийн албан дахь нөлөө арилахгүй байх талтай байдаг. Иймд зарим төрлийн улс төрийн өндөр албан тушаалтны хувьд албан тушаалаасаа буусны дараагаар тодорхой цаг хугацаанд нийтийн албан тушаалтантай адилтган үзэж хуулийн үйлчлэх хүрээг тэлэх шаардлагатай байна.

Хөрөнгийн мэдэгдэхүйц өсөлт

Энэ ойлголт нь уг гэмт хэргийн бодит хохирлын хэмжээг илэрхийлдэг. Эрүүгийн хуулийн 2022 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр хохирлын хэмжээг 50-н сая төгрөг болон түүнээс дээш хэмжээтэй байсныг нэмэгдүүлэн 100 сая төгрөг болон түүнээс дээш хэмжээний төгрөгийг тооцохоор болсон. Энэ нь эрүүгийн хуулийн нэг мөр ойлгогдох шинжийг алдагдуулах боломжтой байна. Манай эрүүгийн хуульдаа “их хэмжээний хохирол” гэх ойлголтыг нэгэнт 50 сая төгрөг болон түүнээс дээш хэмжээтэй байхаар хуульчилсан, мөн үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хохирлын шалгуурыг нэмэгдүүлэх бодит шалтгаан байхгүй байна.

Зорилго, субъектив шинж

Гэм буруугийн хэлбэрийн хувьд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь зөвхөн санаатай хэлбэрээр үйлдэгдэх боломжтой. Өөрийн хууль бус орлогыг нуун дарагдуулах гэсэн шунахайн сэдэлт нэмэгдэл байдлаар шаардагддаг байна.

Үндэслэлгүй байдал

Энэ ойлголт нь манай эрүүгийн хуульд тодорхой тусаж өгөөгүйгээс шалтгаалан энэ гэмт хэргийн хэрэгжилт, хүлээн зөвшөөрөгдөх байдал нь хангалтгүй байгаа гэж хэлж болно. Хөрөнгө, орлого нь их хэмжээгээр нэмэгдсэн гэдгийг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэдэгт албаны чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө, бусдаас ямар нэгэн эд хөрөнгө, мөнгө, давуу байдал шаардаагүй байхад бусдаас өгсөн бэлэг орох эсэх нь эргэлзээтэй. Мөн иргэний хуульд заасан эд хөрөнгө, мөнгөн хөрөнгө зэргээс гадна бусад давуу байдлыг үндэслэлгүйгээр олж авсан тохиолдолд энэ гэмт хэргийн үйлчлэлд хамаарах эсэх нь ихээхэн тодорхойгүй байна. Харин үүнийг хоёр шалгуураар тогтоох боломжтой байна.

Нэгдүгээрт хууль ёсны орлого болон амьжиргааны түвшин хоорондын харилцан хамаарлыг авч үзэх, хоёрдугаарт хууль ёсны орлого болон өмчлөл болон эзэмшилдээ байлгаж буй эд хөрөнгийн харилцан

хамаарлыг шалгаж үзэх явдал юм.³⁷³

Ингэхдээ гэмт хэрэгт холбогдогч этгээдийн зөвхөн тухайн үеийн цалин биш өмнө эрхэлж байсан ажил үүрэгтэй холбогдох хөрөнгө, орлогыг тооцож үзэх шаардлагатай.

Харин Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн ач холбогдлын хувьд авлигын эсрэг тэмцэлд ихээхэн үр нөлөө үзүүлэх боломжтой байдагтай шууд холбоотой.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс болох Хонконг болон Бүгд Найрамдах Сингапур Улс нарын жишээн дээр авч үзэхэд дээрх хоёр улс нь 1960-аад оны үеэс авлигын түвшин маш өндөр байсантай холбогдуулан шат дараалсан авлигын эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь нийтийн албан тушаалтны үндэслэлгүй хөрөнгөжих асуудлыг хуулиар зохицуулсан явдал юм.³⁷⁴

Сингапур Улсын хувьд нийтийн албан тушаалтны үндэслэлгүй хөрөнгөжих явдлыг шууд гэмт хэрэг болгон тооцоогүй ч Прокурорын байгууллагадаа энэ тохиолдолд хяналт шалгалт явуулах эрхийг нээж, цаашлаад өөр гэмт хэргийн нээн илрүүлэх үндэс суурь болж өгсөн байдаг.

Хонконгын хувьд нийтийн албан тушаалтан үндэслэлгүй хөрөнгөжих

³⁷³ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth*. 2021. Pg 30.

³⁷⁴ Noratikah Muhammad Azman Ng, Zainal Amin Ayub, Rohana Abdul Rahman. *The Legal Aspect Of Illicit Enrichment In Malaysia: Is It A Crime To Be Rich?*. 2022. Pg 287.

явдлыг шууд гэмт хэрэг болгон зааж, ингэхдээ 10 хүртэлх жил хорих ял, 100,000 хонконг доллароор торгох ял оногдуулах хариуцлага бүхий хатуу зохицуулалтыг бий болгосон байдаг. Авлигын түвшинг тодорхойлдог хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа болох Трансперэнси Интернэшнлын авилгын индексээр дээрх 2 улс нь 2020 онд 3 болон, 11 дүгээр жагсдаг бөгөөд авлигын эсрэг амжилттай тэмцсэн орнуудад зүй ёсоор тооцогддог билээ. Үндэслэлгүй хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг болгон тооцох нь авлигын гэмт хэргүүдийн бүхэлд нь буюу маш өргөн хэмжээнд хариуцлагажуулах боломж нэмэгддэг.

ХОЁР. ХЭРГИЙН БОДИТ БАЙДЛЫГ ТОГТООХ ЗАРЧИМ БА ҮНДЭСЛЭЛГҮЙ ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭН ҮЗЭХ НЬ

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцид заасны дагуу Үндэслэлгүй хөрөнгөжих асуудлыг гэмт хэрэг болгон хуульчлахдаа үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзэх зайлшгүй шаардлагатай байдаг. Үүний учир шалтгаан нь Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн бас нэгэн онцлог болох *vice versa*³⁷⁵ (эсрэг

³⁷⁵ Ч.Хосбаяр. “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга. Шударга ёс

талаас нь нотлох буюу хууль ёсны болох нь нотлогдохгүй байх) гэх нотолгооны хялбаршуулсан стандартыг үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хэрэглэдэг.

Ихэнх үндэслэлгүй хөрөнгөжих тухай ойлголтыг эрүүгийн хуульдаа тусгасан улс орнуудад тухайн этгээдийг өөрийн хөрөнгө чинээний хууль ёсны эх үүсвэрийг нотлох баримт гаргахыг шаардсан тодорхой механизмыг тусгасан байдаг. Зарим хууль тухайн этгээдийг өөрийн “бүх хөрөнгө чинээ”-ний хууль ёсны эх үүсвэрийг тайлбарлахыг шаарддаг бол зарим хууль төрөөс тэдний мэдэгдэж буй орлогын эх үүсвэртэй нийцгүй байгаа гэж тогтоосон хөрөнгө чинээний дүнг зөвхөн тайлбарлахыг шаарддаг байна³⁷⁶. Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн ихэнх хууль тухайн этгээд түүний мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс давж байгаа нь тогтоогдсон эзэмшил хөрөнгө чинээгээ “хангалттай” (satisfactory) эсхүл “байж болохуйцаар” (reasonable) тайлбарлаж чадахгүй бол үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай зүйл ангиар ял асуух боломжтой гэсэн арай зөөлөн арга замыг ашигласан байдаг³⁷⁷ бөгөөд манай улсад үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг анх энэ

сэтгүүл. УБ., 2019 он. 8 дахь тал.

³⁷⁶ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth*. 2021. Pg 62.

³⁷⁷ Мөн тэнд. 65 дахь тал.

ангилалд хамаарах байдлаар томьёологдож хэрэглэгдэж байсан билээ.

Харин эрүүгийн хуулийн 2022 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр гэм буруугийн асуудлыг ганцхан төр нотлох үүрэг хүлээх буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжүүлэгч болох мөрдөгч, прокурорт энэ үүргийг шилжүүлсэн гэж үзэж болно.

Ерөнхийдөө эрх зүйн зөрчлийн нотолгоо нь /эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, арбитраж, олон улсын эрх зүйн гэх мэт/ танин мэдэхүйн үйл явцын хамгийн ээдрээ төвөгтэй асуудлын нэг төдийгүй ертөнцийг танин мэдэх үйл ажиллагааны нэг хэсэг болж түүний ерөнхий шинжийг илэрхийлэхийн хамтаар хуулинд заасан нөхцөлөөс хамаарч өөрийн гэсэн онцлогтой. Тиймээс үүний хуулиар зохицуулж нэгэн мөр болгох, улам боловсронгуй болгож байхыг нийгэм шаарддаг.³⁷⁸

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг эрүүгийн хуульдаа оруулсан улс орнуудын жишээнээс үзэхэд ерөнхий гурван төрлөөр энэ гэмт хэргийн нотолгооны хувиарлалтыг тусгасан байна.³⁷⁹

А. зорилтот этгээдийн хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоо-

гдсон нийт хөрөнгө чинээ нь тухайн хүний “албан ёсны” буюу “мэдэгдэж байгаа” орлоготой нийцгүй байгааг төрийн зүгээс харуулсан бөгөөд зорилтот этгээд нь энэхүү нийцгүй байдлыг тайлбарлаагүй эсхүл тайлбарлаж чадаагүй (хуулийн дагуу шууд үүрэг хүлээсэн ч);

В. зорилтот этгээдийн хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон нийт хөрөнгө чинээ нь тухайн хүний нийт орлогоор тайлбарлагдах боломжгүй байгааг төр дангаараа харуулсан;

С.Хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон хөрөнгө чинээ нь хууль ёсны орлоготой нийцтэй байгааг зорилтот этгээд дангаараа тайлбарлаагүй буюу хангалттай тайлбар хийгээгүй (хуулийн дагуу шууд үүрэг хүлээсэн ч).

Манай улсын хувьд өмнө дурдсанчлан өөрийн орны эрх зүйн онцлогт тохируулан дээрх 3-н төрлөөс боломжит хувилбарыг сонгон хэрэгжүүлэх боломжтой байна. Өөрийн орны эрх зүйн зохицуулалтын онцлог шинжийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай буюу эрүүгийн эрх зүйн зарчимд тохирсон эсэхийг шалгах үндэслэл нь үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн нотолгооны онцлог хувиарлалттай уялдан үүсдэг гэж үзэж болно.

Үүнд :

1. Үндсэн хууль болон эрүүгийн хуульд тусгалаа олсон шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн,

³⁷⁸ Б.Батзориг. Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол. УБ., 2002 он. 68 дахь тал.

³⁷⁹ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth*. 2021. Pg 95 дахь тал.

хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх³⁸⁰ зарчимд (Nulla poena sine culpa- гэм буруугийн зарчим³⁸¹) Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт холбогдсон этгээдийн гэм буруугийн тодорхой хэсгийг нотлуулах ажиллагаа нь харшилж байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл Шүүхээр нотлогдоогүй ямар ч тохиолдолд тухайн хүнтэй гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай мэтээр харьцаж, эрүүдэн шүүлтийн шинжтэй дарамт шахалт үзүүлж болохгүй юм³⁸².

2. Мөн хэргийн бодит байдлыг тогтоох үүрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлд зааснаар гагцхүү мөрдөгч, прокурорт байна гэж заасан бөгөөд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглосон байдаг. Уг зарчмын гол утга учир нь аливаа эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж хянан шийдвэрлэхдээ яллах, цагаатгах, хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг мөрдөгч, прокурор бүрэн тогтоох үүргээр илэрхийлэгдэнэ³⁸³.

Транспэрэнси олон улсын байгууллагаас жил бүр авлигын

төсөөллийн индексийг үнэлгээг зарлахдаа байр суурь, санал асуулга, нотлох баримтаар судалгаа явуулдаг байна. 2016 онд 176 улсыг хамруулсан бол сүүлийн 5 жилд 180 улс хамрагджээ. Авлигын индексийг тогтоохдоо дэлхий дахинд 16, Монгол Улсад 8 эх сурвалж ашигладаг. АТИ нь улс орны засаг төрийн байгууллагын авлигын төсөөллийг 0 /маш их авлигатай/-ээс 100 /маш цэвэр/ оноогоор эрэмбэлсэн бөгөөд манай улс 33 оноо авчээ. Монгол Улс авлигын индексээр 2017 онд 36 оноо авч, 180 улсаас 103 дугаарт, 2018 онд 93 дугаарт, 2019 онд 106 дугаарт, 2020 онд 111 дүгээрт, 2021 онд 110 дугаарт, 2022 онд 116 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.³⁸⁴ Үүнээс үзэхэд манай улсын авлигын түвшин жил бүр байр ахих хандлагатай байгаа тул цаг алдалгүй арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

2018 онд хийгдсэн судалгаагаар Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол 663.2 тэрбум төгрөг буюу тухайн жилийн улсын нийт төсвийн 8.6 хувийг эзэлж байсан байна.³⁸⁵ Энэ дүн нь 2022 онд 5 их наяд болтлоо өссөн байна.³⁸⁶

Харин Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хувьд хууль бус орлогын эх сурвалжийг тогтоохыг

³⁸⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.

³⁸¹ О.Батсүх. Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги. УБ., 2021 он. 78 дахь тал.

³⁸² Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Ханнс-Зайделийн сан. Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй: Эрүүгийн эрх зүй. УБ., 2018 он. 88 дахь тал.

³⁸³ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн Процессын Эрх зүйн Үндсэн асуудал. УБ., 2018 он. 87 дахь тал.

³⁸⁴ Транспэрэнси Интернэшнл Монголия. <https://www.transparency.mn/>

³⁸⁵ А.Түвшинбат. Авлига албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдлын талаар. Шударга ёс сэтгүүл. УБ., 2019 он. 45 дахь тал.

³⁸⁶ Авлигатай тэмцэх газар. <https://iaac.mn/post/104878>

шаарддаггүй бөгөөд гэмт хэрэгт холбогдогч этгээдийн их хэмжээгээр нэмэгдсэн хөрөнгө нь хууль ёсны биш болохыг тогтоох хангалттай байдаг. Уг гэмт хэргийн эл онцлогоос шалтгаалан эх сурвалжийн хувьд тогтоогдох боломжгүй болсон авлигын гэмт хэргүүдэд хариуцлага оногдуулах чухал механизм болж чаддаг.

Иймд өмнө дурдагдсан эрүүгийн эрх зүйн зарчмаас улбаалсан гэм буруугүй гэдгээ өөрөө нотлохгүй байх онцгой эрх болон үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн өнөөгийн ач холбогдол нарыг жинлэх үзэх шаардлага тулгарч байна.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугүй гэдгээ өөрөө нотлохгүй байх эрхийг хязгаарлах боломжтой эсэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.³⁸⁷ Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг

гажуудуулж болохгүй”. гэж заасан байдгаас үзэхэд.

1. Хязгаарлах боломжтой эрх эсэх
2. Тийм бол хуулиар хязгаарлах эсэх
3. Эрхийг хязгаарлах үндэслэл нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журамд хамаарах эсэх гэсэн шалгуурууд тавигдахаар байна.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугүй гэдгээ өөрөө нотлохгүй байх эрх нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэж заасан эрхтэй шууд холбоотой эрх байна. Гэхдээ энэ эрх нь хүний жам ёсны эрх буюу хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхэд хамаарахгүй тул уг эрхэд тодорхой хэмжээнд хязгаарлалт тавигдах боломжтой байна.

Энэ эрхийг мэдээж эрүүгийн хууль болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хязгаарлах боломжтой. Харин авлигын гэмт

³⁸⁷ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.

хэрэг нь манай өнөөгийн нийгэмд үүсээд буй хамгийн том асуудлын нэг бөгөөд нийт ард иргэдийн иргэний болон улс төрийн эрх болоод нийгэм, соёлын бүхий л эрхүүдийн хэрэгжилтэд чөдөр тушаа болж байдаг тул сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугүй гэдгээ өөрөө нотлохгүй байх эрхийг тодорхой хүрээнд хязгаарлах үндэслэлтэй байна.

ГУРАВ. ҮНДЭСЛЭЛГҮЙ ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг 2017 оноос хойш нийт 11-н хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байдалтай байна.³⁸⁸ Эрүүгийн хуулийн 2022 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн обьктив шинжийг өөрчилсөн үеэс хойш нэг ч хэрэг уг зүйл заалтаар шийдэгдэж амжаагүй байна. Энэ нь авлигын гэмт хэргийн гаралт маш өндөр байгаа болон авлигын индексээр тогтмол байр ухарч байгаа энэ үед маш хангалтгүй үзүүлэлт юм.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хэрэгжилт хангалтгүй байгаа нөхцөл байдлыг дараах зүйлстэй холбон тайлбарлах боломжтой байна.

1. Эрүүгийн эрх зүйн зарчим, хүний тодорхой эрхтэй зөрчилдөж буй ойлголтыг тайлбарлах, засах арга хэмжээг хангалттай хийгээгүй буюу эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хуульчлаагүй.

2. Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн эрүүгийн хуулийн томьёололд буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид дэлгэрүүлэх шаардлагатай ойлголтууд байна.

3. Гэмт хэргийн урьдчилсан үндэслэл бүхий таамаг, сэжиглэл үүсгэх, түүнийгээ нотлох баримтаар баталгаажуулах эрх зүйн орчин хууль хэрэгжүүлэгч этгээдүүдэд дутмаг байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод зааснаар оролцогч улсууд нь үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг хуульчлахдаа өөрийн орны үндсэн хууль эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзэх шаардлага тавигдаж байгаа билээ. Үүний дагуу уг гэмт хэргийг хуульчилсан улс орнуудын жишгээс харьцуулан үзэхэд дараах 3-н загвар нийтлэг байдлаар илэрч байна³⁸⁹.

1. Зорилтот этгээдийн хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон нийт хөрөнгө чинээ нь тухайн хүний “албан ёсны” буюу “мэдэгдэж байгаа” орлоготой нийцгүй байгааг төрийн зүгээс харуулсан бөгөөд зорилтот этгээд нь энэхүү нийцгүй байдлыг тайлбарлаагүй

³⁸⁹ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth*. 2021. Pg 95

³⁸⁸ Монгол Улсын Шүүхийн Шийдвэрийн цахим сан. <https://www.shuukh.mn/cases/2/1>

эсхүл тайлбарлаж чадаагүй, (нотлох үүргийг төр болон гэмт хэрэгт холбогдогч этгээдэд аль алинд хуваарилах)

2. Зорилтот этгээдийн хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон нийт хөрөнгө чинээ нь тухайн хүний нийт орлогоор тайлбарлагдах боломжгүй байгааг төр дангаараа харуулсан; (төр дангаараа нотлох үүргийг хүлээх)

3. Хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт тогтоогдсон хөрөнгө чинээ нь хууль ёсны орлоготой нийцтэй байгааг зорилтот этгээд дангаараа тайлбарлаагүй буюу хангалттай тайлбар хийгээгүй. (гэмт хэрэгт холбогдогч этгээд дангаараа нотлох үүргийг хүлээнэ)

Нэгдүгээр хувилбарын хүрээнд гэмт хэрэгт холбогдсон этгээдээс тогтоогдсон хөрөнгө орлогын нийцгүй байдлын талаар “тайлбар” эсхүл “үндэслэл” гаргаж өгөхийг шаардсан нотолгооны үүрэг шилжих механизм хэрэгжиж эхлэхээс өмнө хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэг дэх хөрөнгө чинээ нь гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хууль ёсны орлоготой (тухайлбал, “албан ёсны” эсхүл “мэдэгдэж буй”) нийцээгүй (эсхүл “илүү”, “харьцуулахааргүй”, “хэтэрсэн” эсхүл “тухайн орлогоор олж авах боломжгүй”) болохыг төрөөс тогтоох шаардлага үүсдэг.³⁹⁰ Үүнээс үзэхэд хуулийг хэрэгжүүлэгч этгээдүүдийн зүгээс нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын

мэдүүлгийг шалгах, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж өгөхийг шаардах эрх зүйн орчин бүрдсэн байх шаардлагатай байна. Цаашилбал, төрөөс зорилтот этгээдийн тодорхой хугацааны орлогыг ямар түвшинд нотлох нь тухайн хуулийг томьёолсон байдал, үг хэллэгээс хамаарна. Жишээлбэл, Хонконгийн хуулиар төрөөс зорилтот этгээдийн тухайн хугацаанд хүлээн авсан “албан ёсны цалин хөлс”-ний нийт дүнг харуулахыг шаарддаг бол Энэтхэгийн хуулиар улсын яллагч зорилтот этгээдийн “мэдэгдэж буй орлогын эх үүсвэр”-ийг (known sources of income) тогтоохыг шаарддаг ажээ. “Албан ёсны цалин хөлс” (official emoluments) гэх нэр томьёо нь ерөнхийдөө тухайн хүний төрийн албан хаагчийн хувиар авч буй цалин, тэтгэмжид хамаарна. Харин “мэдэгдэж буй орлогын эх үүсвэр” нь илүү өргөн хүрээтэй бөгөөд “хэргийг нарийвчлан шалгасны үр дүнд яллагч талд мэдэгдэж буй [орлогын] эх үүсвэр”-т хамаатай аж.

Мөн эрүүгийн эрх зүйн зарчим болоод үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн зөрчлийг албан ёсны тайлбар гаргах замаар хуулийн нэг мөр хэрэглээг бий болгох боломжтой юм. Жишээ нь “22.10 дугаар зүйлд нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны үндэслэлтэй эсэхийг өөрөөр нь тайлбарлахыг үүрэгжүүлсэн нь өөрөө өөрийгөө гэм буруутай, эсхүл гэм буруугүйгээ

³⁹⁰ Мөн тэнд.

нотолж буйн аль нь ч биш, гагцхүү тухайн хөрөнгө, орлого нь хууль ёсны орлогоос илтэд давсан, дүйцэхгүй байгаа талаарх хэрэгт авагдсан нотлох баримт, нөхцөл байдалтай холбогдуулан яллагдагч, шүүгдэгч хуулиар хүлээсэн нийтлэг эрхийнхээ дагуу тайлбар, хүсэлт гаргах эрхээ эдэлж буй хэлбэр учраас түүний гаргасан тайлбар, хүсэлтийг няцаасан, үндэслэлгүй болохыг баталсан үндэслэл бүхий нотлох баримт, нөхцөл байдал тогтоогдсон байвал зохино.³⁹¹ гэж тайлбарлаж болох юм.

Хоёрдугаар хувилбарын хувьд эрүүгийн хуулийн зарчим, хүний эрхтэй зөрчилдөх ямар нэгэн аргумент үүсэхгүй сайн талтай боловч Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн гол шинж болох нотолгооны хялбар процесс алдагдаж хэргийн шийдвэрлэгдэх байдал удаашрах сөрөг талтай харагдаж байна.

Гуравдугаар хувилбарын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаа дахь гэмт хэрэгт холбогдогч этгээдэд нотлох үүргийг хэт их болгосноор тухайн гэмт хэрэг нийтийн албан тушаалтны эсрэг буруугаар ашиглагдах эрсдэлтэй байна.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн эрүүгийн хуулийн томъёололд буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид дэлгэрүү-

³⁹¹ Б. Өнөрмаа, Б. Галдаа нар. Авлигын гэмт хэрэг ба Прокурорын хяналт. Гарын авлага. УБ., 2022 он. 102 дахь тал.

лэх шаардлагатай ойлголтуудын талаар.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн гэдэг нь нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцооход зайлшгүй шаардлагатай объектив /объект, объектив тал/ болон субъектив /субъект, субъектив тал/ шинжүүдийн цогц бүрдэл юм.³⁹² Харин Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн объектив тал болох “хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол” гэх хэсэгт үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол гэдэгт яг юуг ойлгох нь тодорхойгүй байна. Дээрх ойлголтод нэгдүгээрт тухайн хүн хөрөнгө чинээг эзэмшиж, үр шимийг хүртэж (enjoyed) байгаа болон Хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэгт харуулсан хөрөнгө чинээний дүнгийн хууль ёсны эх үүсвэр нь тухайн хүний хууль ёсны орлогоор зөвтгөгдөхгүй буюу тайлбарлагдахгүй байгаа³⁹³ гэсэн шинжийг агуулж байх боломжтой байна.

Гэмт хэргийн объектив шинжийн үндсэн шинж болох хохирлын хувьд эрүүгийн хуулийн 2023 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр хохирлын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 100 сая төгрөг түүнээс дээш хэмжээгээр тогтоосон нь маш олон үндэслэлгүй

³⁹² С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн Эрх Зүйн Онол. УБ., 2009 он. 275 дахь тал.

³⁹³ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth*. 2021. Pg 93

хөрөнгөжсөн үйлдэл энэ гэмт хэргийн зохицуулалтын гадна үлдэх эрсдэлийг үүсгэж байна.

Гэмт хэргийн субъектийн хувьд: Авлигын гэмт хэргүүдийн хувьд нийтийн албан тушаалтан гэх ойлголтыг аль болох өргөн хүрээнд тодорхойлох шаардлагатай байдаг. Авлигын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар

1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч; гэх албан тушаалтнууд энэ гэмт хэргийн субъект болох

боломжтой байна. Харин нийтийн албан тушаалтан хамаарал бүхий этгээдүүдэд эд хөрөнгө шилжүүлэх асуудал түгээмэл байдаг тул энэ гэмт хэргийг илрүүлэхдээ нийтийн албан тушаалтнаас гадна түүний гэр бүл, хамаарал бүхий этгээдүүдийг давхар шалгах боломж бүхий эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнээс зөвхөн албан үүргээ хашиж байгаа хугацаанаас гадна албанаасаа чөлөөлөгдсөний дараах 2 жилийн хугацаанд энэ гэмт хэргийн үйлчлэлд хамааруулах хэрэгтэй.

Гэмт хэргийн урьдчилсан үндэслэл бүхий таамаг, сэжиглэл үүсгэх, түүнийгээ нотлох баримтаар баталгаажуулах эрх зүйн орчин хууль хэрэгжүүлэгч этгээдүүдэд дутмаг байна.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч этгээд болох мөрдөгч, прокуророос гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээд нь хууль бусаар хөрөнгөжсөн байж болзошгүй талаар хангалттай үндэслэл бүхий таамаглал үүссэн байх энэ гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой. Харин энэ таамаглал үүсэхийн тулд, авлигатай тэмцэх газар болон прокурорт нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг шаардах, үнэлэх боломжийг бүрдүүлсэн хангалттай эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд Авлигатай тэмцэх газрын чиг

үүрэг, бүрэн эрхийг хуульчилсан байдаг³⁹⁴. Үүнд : Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараах чиг үүрэгтэй:

1. хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;

2. мэдүүлэг гаргагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.

3. хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;

4. хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;

5. мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авхуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх; гэх эрхүүдийг тусган өгсөн байна.

ДӨРӨВ.ҮНДЭСЛЭЛГҮЙ ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хонгконг: Гүйцэтгэх захирлын эсвэл эрх бүхий ажилтны албан тушаалд ажиллаж байсан/байгаа хүн: Дараах агуулгын хүрээнд гэм буруутайд тооцогдох асуудал яригддаг. Үүнд:

а) одоо хашиж байгаа эсхүл өмнө нь хашиж байсан албан тушаалын цалин хөлстэй үл нийцэх амьжиргааны түвшинтэй; эсхүл

б) өнөөгийн эсхүл өмнөх албан ёсны цалин хөлстэй нийцээгүй мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө хянаж байгаа бол, уг амьжиргааны түвшинг хэрхэн хангаж байгаа, мөнгөн эх үүсвэр эсхүл өмчийг хэрхэн эзэмших болсон тухай хангалттай тайлбарыг шүүхэд гаргаж чадахгүй бол түүнийг гэм буруутайд тооцно.³⁹⁵

Дээрх хуулийн заалтыг томъёолсон байдлаас харахад хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсгийг төрөөс зорилтот этгээд нь тодорхой үнэ цэнэ бүхий “амьжиргааны түвшинг хадгалж буй” эсхүл “мөнгөн хөрөнгө, өмчид хяналт тавих буюу эзэмшиж буй” гэдгийг тогтоох шаардлагатай гэж тодорхой илэрхийлжээ.

Кени улс: Тухайн этгээд нь үндэслэлтэйгээр тайлбарлагдаагүй эд хөрөнгөтэй болохыг Комисс

³⁹⁵ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth*. 2021. Pg 97

³⁹⁴ Авилгын эсрэг хууль. 2006 он.

нотлох баримтаар харуулсны дараа шүүх нь магадлалын тэнцвэрт харьцаа, цуглуулсан нотлох баримтад үндэслэн тухайн этгээдэд тайлбарлагдаагүй хөрөнгө байна гэж үзвэл тухайн этгээдээс хөрөнгөө авлигын бус арга замаар олж авсныг мэдүүлэг болон шүүхээс хангалттай гэж үзсэн бусад баримтаар нотлохыг шаардаж болно.³⁹⁶

Шүүх дээрх хуулийг хэрэглэхдээ, төр тухайн этгээдэд тайлбарлагдаагүй хөрөнгө байгааг шүүхэд нотолж чадвал өөрийн эд хөрөнгийг авлигын бус арга замаар олж авсан болохоо хангалттай нотлох үүргийг шүүгдэгчид шилжүүлнэ.

Литва улс: Тухайн өмч хөрөнгийг хууль ёсны орлогоор олж авах боломжгүй гэдгийг мэдэж байсан, эсхүл мэдэх үүрэгтэй болон мэдэх магадлалтай байсан хүн амьжиргааны баталгаажих доод түвшинг 500-р үржүүлснээс дээш үнэтэй өмчийн өмчлөх эрхийг эзэмшиж байвал түүнийг торгох, баривчлах, эсхүл 4 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

Уганда улс: Засгийн газрын ерөнхий хянан шалгагч (Inspector General), эсхүл ерөнхий прокурор, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь аливаа хүнийг дараах зүйлд сэжиглэх үндэслэл байна гэж үзвэл мөрдөн шалгах ажиллагааг явуулж эсхүл даалгаж болно: (а) амьжиргааны түвшин нь одоогийн болон урьд нь

мэдэгдэж байсан орлого, хөрөнгийн эх үүсвэрт дүйцэх амьжиргааны түвшнээс дээгүүр байх; эсвэл

(b) одоогийн болон өнгөрсөн хугацаанд мэдэгдэж байсан орлого, хөрөнгийн эх үүсвэртэй үл нийцэх мөнгөн хөрөнгө, өмчийг хянаж эсвэл эзэмшиж байгаа. Хууль бусаар олсон мөнгөн хөрөнгө, өмч эзэмшиж байгаа нь тогтоогдсон этгээдийг гэм буруутайд тооцох бөгөөд түүнд 10 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 240 нэгжтэй тэнцэх мөнгөн дүнгээр торгох, эсхүл эдгээр хоёр шийтгэлийг нийлүүлэн оногдуулна.

Баруун австралийн хууль: Шүүх 11(1)-д заасан өргөдлийг хянан хэлэлцэхдээ хариуцагчийн нийт хөрөнгө чинээний үнэлгээ нь түүний хууль ёсны дагуу олж авсан хөрөнгө чинээний үнэлгээнээс илүү байх магадлалтай бол хариуцагчийг тайлбарлагдаагүй хөрөнгө чинээтэй байна гэж шүүх зарлах ёстой. Хариуцагч нь тийм биш болохоо нотолж чадаагүй бол хариуцагчийн хөрөнгө чинээнд хамаарах аливаа өмч, үйлчилгээ, давуу байдал, ашиг хонжоог хууль бусаар олж авсан гэж үзнэ.

Аргентин улс: Зохих ёсны шаардлагын дагуу өөрийн их хэмжээгээр нэмэгдсэн хөрөнгө чинээний гарал үүслийг тайлбарлаагүй этгээд эсхүл тэдгээрийг нуун далдлахад дэмжлэг үзүүлсэн гуравдагч этгээдэд ... ял шийтгэл ногдуулна...³⁹⁷

³⁹⁶ Мөн тэнд. 100 дахь тал.

³⁹⁷ Andrew Dornbierer. *Illicit Enrichment: A Guide*

Дээрх улсууд нь үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг тодорхойлохдоо нотолгооны хувиарлалтыг өмнөх бүлэгт заасанчлан 1. нотлох үүргийг төр болон гэмт хэрэгт холбогдогч этгээдэд аль алинд хувиарлах, 2.төр дангаараа хариуцах, 3. гэмт хэрэгт холбогдогч этгээд хариуцах загваруудын аль нэгд хамаарах байдлаар томъёолсон байх бөгөөд энэ нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны онцлог шинжтэй уялдан гарж ирсэн байна.

ДҮГНЭЛТ

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь 1950-аад оны эхэн үеэс үүсэлтэй бөгөөд анх Аргентин улсын Парламентад нийтийн албан тушаалтны эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгө орлогыг хурааж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудал тавигдсанаар уг гэмт хэргийн үзэл санаа үүссэн гэж хэлж болно. Харин 2003 онд Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцын 20 дугаар зүйлд албан ёсоор Хууль бусаар хөрөнгөжих асуудлыг тусгаснаар гэмт хэргийн уг конвенцод оролцогч улсууд ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо

тулгуур зарчимд нийцүүлэн авч үзэх шаардлага тулгарч байгаа билээ.

Үүнээс гадна Манай улсын авлигын нөхцөл байдал жил дорой муудах төлөвтэй байгааг анхаарах хэрэгтэй. Транспэрэнси олон улсын байгууллагаас жил бүр авлигын төсөөллийн индексийг үнэлгээг зарлахдаа төсөөллийг 0 /маш их авлигатай/-ээс 100 /маш цэвэр/ оноогоор эрэмбэлсэн бөгөөд манай улс 33 оноо авчээ. Монгол Улс авлигын индексээр 2017 онд 36 оноо авч, 180 улсаас 103 дугаарт, 2018 онд 93 дугаарт, 2019 онд 106 дугаарт, 2020 онд 111 дүгээрт, 2021 онд 110 дугаарт, 2022 онд 116 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.³⁹⁸ Үүнээс үзэхэд манай улсын авлигын түвшин жил бүр байр ахих хандлагатай байгаа тул цаг алдалгүй арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Харин Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг албан тушаалтан албаны байдлаа урвуулан хууль бусаар эд хөрөнгө хуримтлуулахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ийм замаар бий болсон эд хөрөнгийн гарал үүслийг хууль бус болохыг нэхэн тогтоох эрх зүйн орчин, хүн хүч, арга зүй, санхүүгийн боломж хүрэлцээгүйгээс авлигын замаар хөрөнгөжих гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах, хэрэглэх байгууллагууд хүчин мөхөсдөх цагт хэрэглэдэг, авлигын гэмт

хэргийг нь нотлохгүйгээр хэрэг гарсан цаг хугацааг уг хууль бус хөрөнгө бий болсон үеэр тооцож ялладаг, яллагдаа цагаатгах баримтыг өөрөөр нь гаргуулж улмаар яллагдагч няцааж чадаагүй бол үндэслэлийг эс харгалзан ял шийтгэл хүлээлгэх байдлаар гэмт хэргийн шинжийг хялбарчлан тогтоож нотлох ажиллагааг товчлон журамласан эрүүгийн эрх зүйн хатуу арга механизм гэж үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг, түүнийг нотлох ажиллагааны агуулга, мөн чанарыг товч тодорхойлж болно.³⁹⁹

Нотолгооны хувиарлалтын онцлог байдал буюу түүний өөрийн улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд тохирох эсэх асуудлыг үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн авлигын эсрэг үзүүлэх үр нөлөөг үнэлэн үзэх шаардлага үүсэж байна. Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн давуу талын хувьд авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял шийтгэл зайлшгүй байх зарчмын хэрэгжилтийг сайжруулах давуу талтай бөгөөд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруугүй гэдгээ өөрөө нотлохгүй байх эрх нь Үндсэн хуульд заасан тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд хязгаарлах боломжтой эрх юм.

³⁹⁹ Ч.Хосбаяр. “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга. Шударга ёс сэтгүүл. УБ., 2019 он. 19 дэх тал.

САНАЛ

1. Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг хуульчлахдаа нотолгооны хувиарлалтыг төр болон гэмт хэрэгт холбогдогч этгээдэд хуваарилах хувилбарыг сонгох:

Нэгдүгээрт төр тухайн этгээдийн хөрөнгө орлогын мэдүүлэг зэргээс үнэлэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үзэх, хоёрдугаарт тухай этгээд өөрөө цагаатгах талын нотлох баримтаа гаргах хувилбар нь Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн гол онцлог болох авлигын бусад гэмт хэргийг тогтоохгүйгээр буюу хууль бусаар олсон хөрөнгө орлогын эх сурвалжыг нарийн тогтоолгүйгээр хууль бусаар хөрөнгөжсөн тэр цаг үеээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэх нотолгооны хялбаршуулсан хэлбэрийн мөн чанарыг илүүтэй гаргаж байх тул Эрүүгийн хуулийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлтийн өмнөх байдалд сэргээх.

2. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн объектив шинжийг дэлгэрүүлэх:

Манай улсын одоогийн зохицуулалтад Үндэслэлгүй хөрөнгөжих гэдэгт яг юуг ойлгох талаар тодорхойгүй байна. Энэ нөхцөл байдал нь үндэслэлгүй хөрөнгөжих гэх ойлголтыг ямар ч агуулгаар тайлбарлах, хууль хэрэгжүүлэгч этгээдүүдэд ойлгомжгүй нөхцөл байдал үүсэх боломжтой. Өөрөөр

хэлбэл хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх хэрэгцээ шаардлага үүсээд байна. Иймд үндэслэлгүй хөрөнгөжих гэх агуулгад Нэгдүгээрт тухайн үндэслэлгүйгээр олж авсан хөрөнгөө өөртөө болон гэр бүл, хамаарал бүхий этгээддээ ашигтай байдлаар ашиглаж байх, хоёрдугаарт тухайн эд хөрөнгө нь өөрийх нь цалин, бусад хууль ёсны орлогоос давсан байх гэсэн агуулгуудыг тодорхой илэрхийлэх шаардлагатай байна.

3. Нийтийн албан тушаалтан гэх ойлголтын өргөн хүрээнд тодорхойлох:

Нийтийн албан тушаалтан гэх ойлголтод авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар хязгаарлах бус тухайн этгээдүүдийн албаны чиг үүргээ хэрэгжүүлхээ больсноос хойш буюу ажлаас чөлөөлөгдсөн, шилжсэн тэтгэвэрт гарсан хугацааны эхний 2 жилийг оруулан тооцох шаардлагатай.

4. Хохирлын хэмжээг багасгах: Энэ гэмт хэрэг нь 2022 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 50,000 нэгжтэй тэнцэх түүнээс дээш хэмжээний хохирлыг шаарддаг байсан бол 100,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг түүнээс дээш болгон өөрчилсөн.

Энэ нь тухай гэмт хэргийн хамрах хүрээг үндэслэлгүй багасгасан хэрэг болсон байна мөн их хэмжээний хохирол гэх ойлголтыг нэгэнт эрүүгийн хуульдаа

тодорхойлсон байхад нэмж тайлбар хийх замаар эрүүгийн хуулийн нэг мөр байдлыг алдагдуулах шаардлагүй юм.

5. Авлигатай тэмцэх газрын хөрөнгө орлогын мэдүүлэг шалгах хянах эрхүүдийг өргөн хүрээнд тогтоох: Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн онцлогоос шалтгаалан нийтийн албан тушаалтан бусад этгээдийг ашиглан хөрөнгө орлогоо нуун дарагдуулсан тохиолдолд авлигатай тэмцэх газар үр дүнтэй ажиллах боломжоор хангах шаардлагатай буюу авлигын эсрэг хуульд энэ талаар тусгах

6. Эрүүгийн эрх зүйн зарчим болоод Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн зөрчлийн талаар албан ёсны тайлбар гаргах: Албан ёсны тайлбар гаргах эрх бүхий этгээд болох УДШ-ээс энэ хуулийн нэр томъёог тайлбарлан хэрэглэх болоод эрүүгийн эрх зүйн зарчим, тодорхой эрхүүдийг хязгаарлах үндэслэлийн талаар тайлбар зөвлөмж гаргах нь онолын болон практикийн маргааныг нэг мөр шийдэх боломжийг олгоно.

НОМ ЗҮЙ**Нэг. Хууль, Олон Улсын гэрээ**

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц. 2003 он.
3. Inter-American Convention Against Corruption, Article 9
4. African Union Convention on Preventing and Combating Corruption, Article 1.
5. Эрүүгийн хууль. 2015 он.
6. Авилгын эсрэг хууль. 2006 он.
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.

Хоёр. Ном, сурах бичиг, илтгэл өгүүлэл

1. Aleksandar Stevanović, Laura Maria Stănilă. Illicit Enrichment As A Criminal Offense:1. Possibility Of Implementation In The National Criminal Legislations. 2022
2. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг. УБ., 2018 он.
3. Andrew Dornbierer. Illicit Enrichment: A Guide To Laws Targeting Unexplained Wealth. 2021
4. Noratikah Muhammad Azman Ng, Zainal Amin Ayub, Rohana Abdul Rahman. The Legal Aspect Of Illicit Enrichment In Malaysia: Is It A Crime To Be Rich?. 2022
5. Ч.Хосбаяр. “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга. Шударга ёс сэтгүүл. УБ., 2019 он
6. Б.Батзориг. Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол. УБ., 2002 он.
7. О.Батсүх. Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги. УБ., 2021 он.

8. Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Ханнс-Зайделийн сан. Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй: Эрүүгийн эрх зүй. УБ., 2018 он
9. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн Процессын Эрх зүйн Үндсэн асуудал. УБ., 2018 он
10. А.Түвшинбат. Авлига албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдлын талаар. Шударга ёс сэтгүүл. УБ., 2019 он
11. Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. УБ., 2021 он
12. Б. Өнөрмаа, Б. Галдаа нар. Авлигын гэмт хэрэг ба Прокурорын хяналт. Гарын авлага. УБ., 2022 он
13. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн Эрх Зүйн Онол. УБ., 2009 он.

Гурав. Цахим эх сурвалж

1. Трансперэнси Интернэшнл Монголия. <https://www.transparency.mn/>
2. Монгол Улсын Шүүхийн Шийдвэрийн цахим сан. <https://www.shuukh.mn/cases/2/1>

**БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ШАЛГУУР БИЗНЕСИЙН ГЭРЭЭНИЙ
СТАНДАРТ НӨХЦӨЛИЙН ЧУХАЛ ХЭСЭГ БОЛОХ НЬ**



Шихихутуг их сургуулийн
магистрант ДОЛГОРМАА

Хувийн эрх зүй тэр дундаа эдийн засгийн харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт улам бүр өргөжин хөгжихийн хирээр энэ харилцааны үндсэн арга хэрэгсэл болох “гэрээ”, “гэрээний чөлөөт байдлын зарчим”-ын хэрэгжилтийн үр нөлөө ихсэж байна. Одоогоор эдийн засгийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн системчлэл нь дуалист хэлбэргүй байгаагаас Иргэний хуулиар эдийн засаг, бизнесийн харилцааг аль алиныг зохицуулсан шинжтэй байна. Иргэний эрх зүйн судалгааны бүтээлүүд болон хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд бизнесийн үйл ажиллагааг зохицуулж буй гэрээ буюу “бизнесийн гэрээ”-г,

а.тус гэрээний зорилго буюу талуудын хүсэл зориг нь тогтвортой ашиг хуримтлал бий болгох боломжид чиглэсэн байх,

б.гэрээний талууд бизнес эрхлэгчийн эрх зүйн байдалтайг-

аар /зөвхөн ашгийн төлөө хуулийн этгээдийн статус-тайгаар биш/ гэрээнд оролцсон байх гэж тодорхойлж болох юм.

Дээрх агуулгаар бизнесийн гэрээний нөхцөл тодорхойлон хэрэглэгчдэд санал болгохдоо урьдаас тогтоосон нөхцөл /стандарт загвар/ санал болгон байгуулах хэдий ч энэ нь хэрхэн боловсруулагдсан эсэхээс хамааран гарах эрх зүйн үр дагавар, эдийн засгийн эрсдэл, тэр ч бүү хэл гэрээний хүчин төгөлдөр байдалд шууд нөлөөлөх юм. Бизнесийн эрх зүй нь холимог эрх зүйн шинжтэй байдгаас бизнес-ийн эрх зүйн харилцаа, маргаан шийдвэрлэлт, бизнесийн гэрээний нөхцөлийг ч тэр холимог байдлаар авч үзэн судлах хэрэгцээ шаардлага гарч ирдэг. Ялангуяа бизнесийн гэрээнээс иргэний эрх зүйд үл хамаарах холимог хэсэгт бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болох олон хүчин зүйлс, тэдгээрийн шинжлэх ухааны үндэслэл тодорхой-логддог.

Арилжааны хууль боловсруулагдаж байгаа энэ цаг үед ч бизнесийн гэрээ байгуулах, бизнесийн гэрээг удирдах буюу менежментийн асуудлууд, гэрээний талуудын буюу бизнес эрхлэгч, хэрэглэгч талуудын сэтгэл судлал, гэрээний эрсдэл тооцох асуудлууд зэргээр олон олон шинжлэх ухааны шалгуур

хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх хэрэгцээ шаардлагатай байна.

Судалгааны ажлаар гэрээний стандарт нөхцөлд нөлөөлж болох хүчин зүйлсийг тодорхойлохыг хичээсэн бөгөөд хэд хэдэн шинжлэх ухааны үндэслэлийг бүрэн шийдвэрлэх, харах боломжгүйн улмаас харгалзах зайлшгүй шаардлагатай болов уу гэсэн тодорхой шалгууруудад дүгнэлт өгөхийг зорив.

Юуны өмнө бизнесийн гэрээний стандарт нөхцөл тодорхойлоход, ийнхүү нөхцөл тодорхойлж буй бизнес эрхлэгчийн ёс зүйн асуудал ихээхэн чухал юм. Гэрээ өөрөө хүсэл зоригийн илэрхийллийн үндсэн дээр хүрсэн тохиролцоо тул хүсэл зориг илэрхийлэгчийн ёс зүй гэрээний зорилго, нөхцөл, хүчин төгөлдөр байдалд ихээхэн нөлөөлнө. Ёс зүйн талаар ерөнхийгөөс нарийвчлан тодруулан тодорхойлсон нь цөөнгүй бий. Ёс зүйн зорилгыг хүний оюун санааны баялаг гэж үзэн оюуны санааны хувьд баялаг байна гэдэг нь сэтгэл санаагаа тайван, тэнцвэртэй, ямар нэг айдас зовлонгүй, сэтгэлийн догдлолгүй байх явдал хэмээсэн байх бол (Ц.Батбаяр, 2007), хүн өөртөө хэрхэн ханддагтайгаа яг адилаар бусдад хандах ёстой (Л.Төрбурам, 2013) гэж ёс зүйн утгыг тайлбарласан нь бий.

Манай улсад 1990 оноос өмнө бизнес, компани, бизнесийн ёс зүй гэсэн ойлголтыг түгээмэл хэрэглэдэггүй байсан талаар судлаачид дурджээ.

1990-ээд оноос хойш манай оронд мэргэжлийн ёс зүйн судалгаа бий болсон шинэ чиглэл бол бизнесийн ёс зүй. Энэ сэдвээр анхны сурах бичгийг Д.Лхаашид бичиж хэвлүүлжээ. Д.Лхаашид “Бизнесийн ёс зүй” (1996) хэмээх бүтээлдээ бизнесмен гэж хэн бэ? бизнесийн зорилго, бизнес эрхлэх зарчмууд, бизнесийн ёс зүй, түүний хэрэгцээ шаардлага, бизнесийн соёл, бизнесийн нийгмийн хариуцлага зэрэг үндсэн асуудлыг авч үзсэн нь өнөөдөр оюутан суралцагчдын гарын авлага болж ашиглагдаж байна.

Үүний дараа бизнесийн ёс зүйн чиглэлээр нэлээд хэдэн сурах бичиг хэвлэгдсэн байна. Тухайлбал, Б.Оюунчимэг “Бизнесийн ёс зүй” сурах бичигт ёс зүйн сэтгэлгээний үүсэл, хөгжлийн түүх, ёс зүйн сэтгэлгээний түүх, ёс зүйн үндсэн категориуд, банкны ажилтны ёс суртахуун, мэдээллийн системийн ёс зүй зэрэг ерөнхий ойлголт өгөх асуудлыг багтааж, бүлэг бүрд холбогдох кейс дасгал, сорилыг хавсаргасан байна. Эдгээр сурах бичгээс бизнесийн ёс зүйн талаарх судалгааны ерөнхий хүрээ, чиглэлийг харах бололцоотой. Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл нар 2013 онд “Бизнесийн ёс зүй” гэсэн өгүүллийн эмхэтгэлийг цахим хэлбэрээр уншигчдын хүртээл болгосон.

Зохиогчид бизнесийн харилцаан дахь ашиг хэмээх ойлголтын философи утга, бизнесийн ёс зүйн

хариуцлага, компанийн нийгмийн хариуцлага, бизнесийн ёс зүйн зарчмууд, олон улсын бизнесийн харилцааны ёс суртахууны хэм хэмжээ ба үндэсний уламжлалт соёлын уялдаа холбоо, экологийн ёс зүйн талаар судалгааны олон эх сурвалжийг ашиглаж бичсэн нь уншигчдад танин мэдэхүй ба зөвлөмжийн ач холбогдолтой гарын авлага болжээ. Мөн Д.Энхбаяр “Бизнесийн ёс зүй” хэмээх өгүүлэлдээ бизнесийн ёс зүйн тухай ойлголт, бизнесийн орчин дахь хариуцлага, бизнесийн ёс зүйн шаардлага, нийгмийн хариуцлага, бизнесийн соёлын онцлогийг тодорхойлжээ. (М.Золзаяа, 2015)

Сэтгэл зүйчид хүний туршлага төлөвшлийг бий болгож, хүн болгодог гэдгийг нотолсон байна. Хүний бие махбод, сэтгэл хөдлөл, юмсыг танин мэдэх чадвар нь нас нэмэхийн хэрээр хөгждөгтэй нэгэн адил тэдний амьдралын явцад ёс суртахууны асуудлуудыг ойлгох чадвар нь хөгждөг. (Ч.Баярчимэг, 2013)

Ёс зүйн танин мэдэхүй нь ёс суртахууны үнэлэмжээр хувь хүнийг нийгмийн ёс суртахууны тодорхой нөхцөлд тавин шинжлэх үйл явц юм. (Ч.Баярчимэг, 2013)

Бизнесийн ёс зүй⁴⁰⁰ бол арилжааны үйл ажиллагаанд ёс суртахууны шинж чанарыг харгалзан үздэг хэрэглээний ёс зүйг сахилга бат болгодог (Marcoux, 2008) гэж

⁴⁰⁰ *business ethics is the applied ethics discipline that addresses the moral features of commercial activity.*

тайлбарласан байна. Бизнесийн харилцаанд оролцогчийн хийх үйл ажиллагаа, үйл явц бүрд ухамсарлагдсан ёс зүй үргэлж хамт байдаг. Бизнесийн ёс зүйн (Goerge D, 1999) нэртэй эрдэмтэн Э.Б.Кэйролл (Carroll A.B, 2003) сүүлийн хагас зуун жилийн бизнесийн ёс зүй, компанийн нийгмийн хариуцлагын судалгааг тоймлон гаргасан өгүүлэлдээ, Бизнесийн ёс зүй бол ёс суртахууны үүрэг, хариуцлагад үндэслэсэн үзэл бодлын тогтолцоо бөгөөд үнэлэмж, зарчмуудыг авч үздэг. Бизнесийн ёс зүй бол арилжааны контекстийн орон зайд хэрэгжүүлж байгаа зан үйл, бодлого, менежер ба ажилтны үйлдэл, бизнесийн зөв, шударга чанартай холбогддог норматив шинжтэй. Компанийн нийгмийн хариуцлага, бизнесийн ёс зүй хоёр нь бие биеэ нөхөх чанартай хэмээн тодорхойлжээ. (М.Золзаяа, 2015)

Философичид бизнесийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар гишүүд нь тогтсон дүрмээ ёс зүйн дагуу дагаж мөрдөхгүй, түүнийгээ сохроор баталдаг нь буруу гэж үздэг. (Ч.Баярчимэг, 2013)

Дийлэнхдээ ёс зүй нь ашигтай зөрчилдөх үед менежер үргэлж ашгийг сонгодог. Мэрк компанийн⁴⁰¹ менежерүүд ёс суртахууны үүргээ сайн ухамсарласны үүднээс ашигтай байх боломжгүйг мэдэж байсан

⁴⁰¹ *Малын эм буюу “Ивермектин”-г ашиглан “Mectizan” үйлдвэрлэн Африкийн “голын сохор” мөн “зааны хөл” гэх өвчтөнүүдийг / ойролцоогоор 60 сая хүн/ аварсан бодит баримт байдаг.*

ч бүтээгдэхүүндээ хэдэн 10 сая долларыг зарцуулсан. Нөгөө талаас, ёс суртахуунаа хадгалж үлдсэнээр компанийн нэр хүнд хэмээх том боломжийг бий болгож чадсан байна. (Ч.Баярчимэг, 2013)

Орчин үеийн бизнесийн ёс зүйн ойлголт нь ёс зүйн талаарх философийн суурь ухагдахуунд тулгуурласан байх ба олон талаас тайлбарласан нь бий. Аристотель хамгийн сайн үйлийг шударга ёс хэмээн үзсэн байна. Шударга ёсыг тэрээр нэгдүгээрт, нийгмийн буюу хот улсын, хэсгийн буюу хувийн шударга ёс хэмээн хуваасан. Иймд ёс суртахуунтай бизнесийн орчин бол шударга байх хэрэгтэй. Нийгмийн шударга ёс бол хууль бөгөөд хуулийг сайн хэрэгжүүлдэг бизнес бол ёс суртахуунтай бизнесийн орчин гэж үзжээ. (С.Соёлмаа, 2015)

Аристотель Никомахын ёс зүй бүтээлдээ, хууль ёсны дагуу ааш авир гаргадаг, хууль ёсны дагуу ажил хэргээ явуулдаг, хууль ёсны дагуу байхыг хүсдэг тийм дүр төрхийг бид бүгдээрээ *зөв цаазат ёс* хэмээн нэрлэж дадсан гээд *зөв цаазат ёс бол дээд зэргээр төгөлдөржсөн сайн үйл мөн* гэжээ. (Аристотель, 2011)

Тэрээр Евдемийн ёс зүй бүтээлдээ дээрх утгыг бизнесийн үйл ажиллагаа, солилцооны зарчимд тайлбарласан байна. Ингэхдээ, шударга ёс бол хэмжээ зохицохуй, өөрөөр хэлбэл, хувь тэнцүүлэлт мөн гэв. Түүнийхээр, тэгш байдал бол “их”, “бага” хоёрын дундаж юм, харин

ашиг, алдагдал хоёр бол “их”, “бага” гэгдэхийн хувьд эсрэг тэсрэг юм, юу гэвэл сайн нь их, муу нь бага байгаа бол энэ нь ашиг, харин эсрэгээрээ байгаа бол энэ нь алдагдал юм. Эдгээрийн дундаж хооронд тэгш ёс байна, ийм тэгш ёсыг шударга зүйл хэмээн тодорхойлсон билээ. Ийнхүү залруулалтын тогтоосон шударга ёс бол алдагдал, ашиг хоёрын дундаж мөн хэмээв. (Аристотель, 2011) Дээрхээс дүгнэн үзэхэд. Шударга ёс гэдэг шударга үйлдэл гэсэн Аристотелийн дүгнэлтээр бизнесийн ёс зүйн шалгуурыг тодорхойлж, гэрээний талуудын тэгш ёсыг хангасан стандарт гэрээний нөхцөлийг санал болгох, энэ шалгуураар стандарт нөхцөл хүчин төгөлдөр байх үндсэн шалгуурыг тогтоодог байх нь бизнесийн ёс зүйд нийцэх юм.

Орчин үед энэ үзэл хандлага хадгалагдаж байна. Тухайлбал, эдүгээ бизнесийн харилцаанд бизнесийн 3R ёс зүйг баримталж байна. (Олин О.Оедековен, 2014) Бизнесийн ёс зүйн эхний “R” нь respect буюу *хүндлэл*. Энэ нь удирдагч, ажилчдын хоорондын харилцааны хандлага. Бизнесийн ёс зүйн хоёр дахь “R” responsibility буюу *хариуцлага*. Бизнесийн ёс зүйн гурав дахь “R” results буюу *үр дүн* юм. Энэ нь хэрхэн хүрэх арга замыг тодорхойлон, түүнээс гарах үр дүнг ёс зүйн шалгуураар үнэлж буй хэрэг юм. Стандарт нөхцөл санал болгож буй тал дээрх үндэслэлээр бизнесийн

ёс зүйн шалгуурыг баримтлан стандарт нөхцөл боловсруулахдаа дараах зарчмыг баримтлах шаардлагатай гэж дүгнэв. Бизнесийн гэрээний хариу төлбөрийн хэмжээ болон түүнд харгалзах үйлчилгээнээс авах хэрэглэгчийн сэтгэл ханамжийн харьцааг тэгш ёсны үүднээс тогтоодог байх. Бизнесийн гэрээний стандарт нөхцөл боловсруулах үйл явцын шударга байдлыг хангах байдлаар бизнесийн гэрээний стандарт тогтоох бизнесийн ёс зүй хангагдана.

Нэг. Бизнесийн гэрээний хариу төлбөрийн хэмжээ болон түүнд харгалзах үйлчилгээнээс авах хэрэглэгчийн сэтгэл ханамжийн харьцааг тэгш ёсны үүднээс тогтоодог байх утгын хувьд, дараах харьцааг хадгална.

Хоёр. Бизнесийн ёс зүй бол бизнесийн гэрээ боловсруулах үйл явцын шударга байдал юм. Үүнийг Кантын ёс зүйг шалгуур болгон дараах байдлаар авч үзэж болно. Тодруулбал, Кантын үүргийн ёс зүйн үүднээс бизнесийн байгууллагууд дараах зарчмуудыг мөрдөж болно гэж үздэг байна.


Шийдвэр гаргахдаа бүх хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг авч үзэх ёстой.

Компанийн бодлого дүрмээ тодорхойлоход оролцоог хангах ёстой. Бүх шийдвэртээ нэг хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг онцлон үзэх ёсгүй.

Нөхцөл байдлаас үүдэн нэг хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалж болох ч бусдын ашиг сонирхолд захируулах ёстой бөгөөд олонхын эрх ашгийг хүндэтгэнэ. Ашиг олж буй компаниуд ил тод тайлагнах үүрэгтэй. Бизнесийн компани бүр хууль тогтоомжид нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцааг хамгаалах процедурыг тогтоох ёстой.

Бизнесийн дүрмийг мөрдөхгүй, категорийн императивыг зөрчиж болохгүй. Ёс суртахууны хувьд зөв үйлдэх буюу үйлдлийн төлөөллийн хүсэл зориг нь тогтмолжиж, үйлдлийн максим бүх нийтийн хэлбэртэй байгалийн хуулийн дагуу байна. Кант категорийн императив бол бидний үйлдлийг үнэлэх суурь зарчим гэж тодорхойлдог. (М.Золзаяа, 2015)

$\{ \text{Гэрээний төлбөрийн хэмжээ} = \text{Хэрэглэгчийн сэтгэл ханамж} \}$



Дээр дурдсанаар, бизнесийн гэрээний стандарт тогтоохдоо дараах процессын шударга ёсыг баримтлах нь зүйтэй. Бизнесийн байгууллага бизнесийн гэрээний стандарт нөхцөл тогтоосон шийдвэр гаргахдаа хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргах. Аялал жуулчлалын байгууллага буюу ХХК нь хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр гарган албажуулсан стандарт нөхцөлийг санал болгодог байх нь аялал жуулчлалын бизнесийн ёс зүйд нийцнэ. Компанийн гэрээний төлбөрийн нөхцөл, түүнийг тодорхойлсон шалгуур нээлттэй, бодитой байх, гэрээний дагуу олсон ашиг нээлттэй тайлагнадаг байх. Бизнесийн үйл ажиллагаа, гэрээний стандарт нөхцөл нь байгалийн хуулийг зөрчсөн байж болохгүй буюу байгалийн хуулийг хамгаалсан нийтийн эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн байх. Аялал жуулчлалын гэрээний стандарт нөхцөлийн хувьд талуудын нэгдмэл ашиг сонирхол нь байгаль орчинд ээлтэй байх нийтлэг ёс суртахуунд нийцсэн байх.

ДҮГНЭЛТ /санал/

Бизнесийн ёс зүйн шалгуур нь дээр дурдсанаар, бизнесийн гэрээний тэгш-шударга ёс, бизнесийн гэрээний стандарт нөхцөл тогтооход баримтлах процессын шударга ёсны зарчмаар тодорхойлогдох ба аялал жуулчлал гэрээний мөн чанар, онцлогийг харгалзсан онцлог бүхий стандарт нөхцөл боловсруулахад

бизнесийн ёс зүйн үндэслэл болно гэж үзэв.

НОМ ЗҮЙ

1. **Carroll A.B, Schwartz M.S. 2003.** Corporate social responsibility: A three-domain approach. *www.researchgate.net*. [Online] Business Ethics quarterly, 01 2003. <https://www.researchgate.net/publication/261827186>. 1062307/385709.
2. **Carroll.A.B, Buchholtz.A.K. 2008.** Business ethics and Management. *Business and Society: Ethics and stakeholder management*. s.l.: South-Weatern Cengage learning, 2008.
3. **Goerge D, John H. 1999.** *Business ethics*. London: International Thomson business press, 1999.
4. **Landini, Sara. 2013.** *Travel and tourism contract*. M: Antezza Tipografia, 2013, p. 19.
5. **Marcoux, Alexei. 2008.** <https://plato.stanford.edu/archives/fall2016/entries/ethics-business/>. *plato.stanford.edu*. [Online] 2008.
6. **Аристотель. 2011.** Евдемийн ёс зүй. [book auth.] Д.Даш-Ёндон. [ed.] Г.Чулуунбаатар. *Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж*. Улаанбаатар: Интерпресс ХХК, 2011, Vol. II, p. 492.
7. **—. 2011.** Никомахын ёс зүй. [book auth.] Д.Даш-Ёндон. [ed.] Г.Чулуунбаатар. *Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж*. Улаанбаатар: Интерпресс ХХК, 2011, Vol. II, pp. 226-227.
8. **Б.Батсайхан, М.Дэлгэржав. 2013.** Сэтгэл судлалын судлах зүйл, сэтгэл судлалын салбарууд. *Сэтгэл судлалын үндэс*. Улаанбаатар: МУИС хэвлэл, 2013, p. 23.
9. **Д.Доржжав. 2005.** *Сэтгэл зүйн тусламж заслын арга зүйн үндэс*.

Улаанбаатар: МУИС-ийн хэвлэл, 2005.

10. Жирвэйс, Рэймонд. 2019. chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/http://portal.merit.mn/dataset/d2f3d2f4-14ce-43e5-8f22-0327600e83c7/resource/d051f544-3d5c-4cас-86a3-86ab8560a4f7/download/-pdf. *Эрсдэлийн үнэлгээ*. [Online] 2 2019. chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/http://portal.merit.mn/dataset/d2f3d2f4-14ce-43e5-8f22-0327600e83c7/resource/d051f544-3d5c-4cас-86a3-86ab8560a4f7/download/-pdf.

11. Л.Төрбурам. 2013. *Сэтгэл судлалын түүхийн жимээр*. Улаанбаатар: Хөх монгол, 2013.

12. М.Дэлгэржав. 2012. үйлдвэрийн эзэн ба менежер. *Эдийн засгийн сэтгэл судлал*. улаанбаатар: МУИС-ийн хэвлэл, 2012, pp. 112-113.

13. —. 2012. Үйлдвэрийн эзэн ба менежер. *Эдийн засгийн сэтгэл судлал*. Улаанбаатар: МУИС хэвлэл, 2012, p. 105.

14. М.Золзаяа. 2015. Монгол дахь бизнесийн ёс зүй судалгааны тойм. [book auth.] Н.Баяр, С.Соёлмаа, Ё.Ундрал, М.Золзаяа. *монголын бизнесийн ёс зүйн төлөвшил, хандлага*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2015, pp. 11-12.

15. М.Золзаяа, Н.Баяр, С.Соёлмаа, Ё.Ундрал. 2015. Монгол дахь бизнесийн ёс зүйн судалгааны тойм. [book auth.] М.Золзаяа. *Монголын бизнесийн ёс зүйн төлөвшил, хандлага*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2015, pp. 19-20.

16. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим. 2009. Гэрээний удирдлага. цуврал гарын авлага. Улаанбаатар: МҮХАҮТ. Зах зээлийн сургалт, судалгааны төв, 2009, pp. 45-46.

17. МУИС-ийн Хууль зүйн сургууль. 2017.

[trans.] Б.Буянхишиг. *ХБНГУ-ын Иргэний хууль*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК, 2017, p. 172.

18. Олин О.Оедековен, В.Алзахгүй, Ж.Алимаа. 2014. Манлайллын ёс зүй. [book auth.] В.Алзахгүй, Ж.Алима Олин О.Оедековен. *Манлайллын үндэс*. Улаанбаатар : Мөнхийн үсэг , 2014, pp. 185-186.

19. С.Соёлмаа. 2015. Монголын бизнесийн орчныг ёс зүйн үүднээс шинжлэх нь. [ed.] М.Золзаяа. *Монголын бизнесийн ёс зүйн төлөвшил, хандлага*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК, 2015, p. 40.

20. Ц.Батбаяр. 2007. *Ёс зүйн хөгжлийн түүхэн тойс*. Улаанбаатар: Сорхон цагаан, 2007.

21. Ц.Энхбаатар. 2003. *Бизнесийн харилцаа*. Улаанбаатар : s.n., 2003.

22. Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл. 2013. Ёс зүй ба бизнес. *Бизнесийн ёс зүй*. Улаанбаатар: Аридал ХХК, 2013, p. 6.

23. —. 2013. Ёс зүй ба бизнес. *Бизнесийн ёс зүй*. Улаанбаатар: Аридал ХХК, 2013, p. 11.

24. —. 2013. Ёс зүй ба бизнес. *Бизнесийн ёс зүй*. Улаанбаатар: Аридал ХХК, 2013.

25. —. 2013. Ёс зүй ба бизнес. *Бизнесийн ёс зүй*. Улаанбаатар: Аридал ХХК, 2013.

26. Ч.Жалбуу. 2023. giz.de. www.giz.de. [Online] 11 3, 2023. chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://www.giz.de/de/downloads/giz2023-mn-introduction-to-risk-management-l11.pdf.

27. Ч.Шуурав. 2014. Байгууллагын нийгмийн хариуцлага, ёс зүй. *Менежментийн шинэ парадигма төлөвшил, хөгжлийн үндсэн хандлагууд*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2014, pp. 159-181.

ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ЗАМ БА ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ



Шихихутуг их сургуулийн
магистрант Б.ХАЛИУНАА

Оршил

Үндсэн хууль хоёр агуулгаар хэрэгждэг. Юуны түрүүнд Үндсэн хууль нь албан ёсны хуулийн хувьд үндэсний эрх зүйн тогтолцооны хамгийн дээд түвшин болж бусад бүх хууль тогтоомжид албан ёсны нөлөөлөл үзүүлдэг тул Үндсэн хуульд харшилсан хууль, тогтоомжууд хүчингүй болсноор дээрх агуулга илрэн гардаг. Хоёр дахь агуулга нь улс төр, нийгмийн хүрээнд тухайн улс ямар байх ёстойг харуулсан хамгийн дээд бодлого байдаг. Тиймээс Үндсэн хуулийг дээдэлж, хамгаалах нь хамгаас эрхэм зүйл бөгөөд энэхүү үүргийг Үндсэн хуулийн шүүх буюу цэц хэрэгжүүлдэг билээ.

Үндсэн хуулийн шүүх нь өнөөдөр дэлхийн ардчилсан орнуудад Үндсэн хуулийг хамгаалах төв байгууллага гэдгээрээ хүлээн зөвшөөрөгдөөд байна. Үндсэн хуулийн шүүх ихэвчлэн улс төрийн

нийгэмлэгүүдийн гол цөмд байдаг ардчилсан засаглалын тогтолцоо, хүний эрхийн соёлыг хамгаалах эцсийн баталгаа гэж үнэлэгддэг. Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн ач холбогдол нь өндөр хэдий ч маргаан, шүүмжлэлээр хүрээлэгдсэн хэвээр байна. Тодорхой түүхүүдээс харахад Үндсэн хуулийн шүүхийг томилсон хүнийхээ зааврыг зүгээр л дагадаг улстөржсөн байгууллага гэж шүүмжлэх тохиолдол цөөнгүй гардаг.⁴⁰² Бусад үед нь Үндсэн хуулийн шүүгчид Үндсэн хуулиа хамгаалах нэрийн дор өөрсдийн бодлого, зорилгоо хэрэгжүүлдэг гэж буруутгагдах нь ч бий. Өнөөдөр Үндсэн хуулийн шүүх нь улс төрийн тогтолцоонд хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийх, Үндсэн хуульд нийцээгүй хууль, тогтоомжийг хүчингүйд тооцох бүрэн эрхийг дангаар эзэмшиж байгаа шүүх хэлбэрийн байгууллага гэдгээрээ бие даасан, хараат бус байх баталгаагаа улам сайжруулах чухал цаг үеийн асуудалтай нүүр тулаад байна.

Үндсэн хуулийн шүүх нь 1920 оны Австрийн Үндсэн хуулийн⁴⁰³ загварыг

⁴⁰² *The Ways of Federalism in Western Countries and the Horizons of Territorial Autonomy in Spain: Volume 1* (Berlin, Heidelberg: Springer, 2013), pp. 481–500, 492.

⁴⁰³ 1919 онд Бүгд Найрамдах Австри улс анхны тусгай зориулалтын Үндсэн хуулийн шүүх болох Австри улсын Үндсэн хуулийн шүүхийг байгуулсан боловч тус улсын шинэ Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон 1920 оны 10-р сарын 10 өдөр албан ёсоор Үндсэн

дагаж мөрддөг тул онолчид зарим тохиолдолд “Келсений шүүх” гэж нэрлэдэг бөгөөд эдгээрийг бүтээхэд нэрт хуульч Ханс Келсен чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. АНУ-ын тархсан хяналтын загвараас өөр хувилбар болохын хувьд Келсений анхны санаа нь энэ үйл ажиллагаанд монопол тогтоох замаар хууль тогтоомжийн үндсэн хуульд нийцсэн байдлын үнэлгээний нэгдмэл байдлыг хангах шүүх байгуулах тухай байсан юм. Энэхүү илтгэлээрээ Үндсэн хуулийн шүүхийн бүтэц зохион байгуулалт, орчин үеийн ардчилсан орнуудад гүйцэтгэх үүрэг нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын хамгаалалт болох талаар тусгасан болно. Илтгэлийн хүрээнд нэгдүгээрт: Үндсэн хуулийн шүүхийг ойлгоход чиглэсэн шинэ ойлголтыг өгөх, хоёрдугаарт: Онолын үндэслэлд тулгуурлан Үндсэн хууль, түүний үзэл баримтлалтай холбоотой маргааныг багасгахад туслах зорилготой шинэ төрлийн Үндсэн хуулийн шүүхийг санал болгохыг зорих болно.

1. Үндсэн хуулийн үзэл баримтлал түүнийг хамгаалах арга зам

Үндсэн хуулийн үзэл баримтлал нь бүрэн хэрэгжсэнээр л хууль тогтоомжуудыг Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг хянах боломжтой. Үндсэн хуулийн шүүх хууль тогтоомжуудыг Үндсэн хуулинд нийцсэн эсэхэд эцсийн хариултыг

хуулийн шүүх нь хууль тогтоомжийг хянах эрх мэдэлтэй болсон түүхтэй.

өгдөг тул улс төрийн оролцогчдоос хараат байх, өөрийгөө хязгаарлах замаар шүүхийн үйл ажиллагаанаас зайлсхийх байдлаар асуудлыг харах ёсгүй. Шүүх бол нийгмийн амьдралаас таслагдсан сансрын уудамд дүүжлэгдсэн бие цогц биш. Хүний нийгэмд оршин, төрийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тогтолцооны нэгэн хэсэг байж, нийгмийн харилцааны нарийн төвөгтэй сүлжээнд холбогдсон төрийн эрх мэдлийн нэг эрхтэн мөн.⁴⁰⁴ Хэдийгээр Үндсэн хуулийн шүүхийг төгс зохиох боломжгүй ч Келсений маягийн шүүхүүдэд тулгарч буй сорилт нь улс төрийн нөлөөлөл байгаа эсэх асуудал юм.

Ардчилсан нийгэмд Үндсэн хуулийн шүүгчид болон шүүх бүрэлдэхүүн бүхэлдээ хөндлөнгийн болон гадны аливаа дарамт шахалтаас хараат бус байх нь нэн чухал бөгөөд олон нийт тэдний шийдвэрт итгэлтэй байх хэрэгтэй. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллага, бие даасан маргаан үүсгэгч, тодорхой дарамт шахалт үзүүлэх бүлгүүд, хэвлэл мэдээлэл, хувийн ашиг сонирхлоос гадна шүүгчид нэгэндээ нөлөөлөх асуудал гаргахгүй байх нь Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлын баталгаа юм. Үндсэн хуулийн цэцийн зорилт нь Үндсэн хуулийг дээдлэх

⁴⁰⁴ Б.Чимид. *Шүүх эрх мэдлийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. (өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл)* УБ., 2007 он. 34 дэх тал.

ёсыг хангах, түүний хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх, эрх мэдлийг хязгаарлах, хүний эрхийг хамгаалах явдал.⁴⁰⁵

Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал нь төрийн ардчилсан төлөвшлийг илтгэж, эрх мэдлийг хуваарилах зарчим хэрэгжиж байгаа эсэх, хүний эрхийг дээдэлж байгааг тогтоох гол нөхцөл болдог. Үндсэн хуулийн шүүхийн болон шүүгчийн хараат бус байдал нь ардчилсан төрийн үндсэн зарчмуудын нэг гэж тууштай баримталж ирсэн нь санамсаргүй хэрэг биш юм.⁴⁰⁶

Өнөөдөр олон оронд Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулахын тулд Үндсэн хуулийн шүүхийн дарга нь болон гишүүн нь нэгэндээ нөлөөлөх оролдлогын хийвэл нэн даруй мэдэгдэх, нөлөөлөх гэж оролдсон тухай баримтыг олон нийтэд мэдээлэх үүрэгтэй байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Үндсэн хуулийн шүүхийн байрнаас тодорхой метрийн зайд байх эсхүл шүүхийн дэргэд цуглаан, жагсаал бусад арга хэмжээ зохион байгуулах, хэрэв тэдгээр нь шүүгч, шүүхэд нөлөөлөх зорилготой бол түүнийг даруй зогсоох зэрэг арга хэмжээ авч байна. Түүнчлэн зөвлөлдөх танхим, санал хураалтын нууц болон байр сүүрийг олон нийтэд мэдээлэхийг

⁴⁰⁵ Ж.Амарсанаа. Үндсэн хуулийн хяналт, түүнийг хэрэгжүүлэх арга зам. УБ., 2007 он. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өзүүлэл, эмхэтгэл) 439 дэх тал.

⁴⁰⁶ Constitutional Court's rulings, inter alia, of 6 December 1995 and 14 February 2011.

хориглодог. Мөн шүүгчийн нийгмийн (материаллаг) баталгаатай холбоотой асуудал Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд онцгой үйлчилдэг байна.

Австри, Бельги, Эстони, Франц, Герман, Итали, Люксембург, Мальта, Польш, Португал, Румын зэрэг улсуудад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг хангахад чиглэгдсэн зөвлөлдөх танхим, санал хураалтын нууцлалыг тогтоосон хуулийн зохицуулалтууд байдаг бол Словак, Испани, Чех, Бельги, Италид санал хураалтын нууцыг задруулах нь эрүүгийн гэмт хэрэг гэж үздэг байна.⁴⁰⁷

Үндсэн хуулийн цэцийг татан буулгах, эрх мэдлийг нь хязгаарлах, үйл ажиллагаанд нь саад учруулах гэсэн улс төрийн санаачилга нь зарим улс орнуудад идэвхтэй өрнөх өнгө аяс илэрч улс төрчдийн Үндсэн хуулийн цэцийг өөрсдийн хяналтанд байлгах гэсэн оролдлогын тод илрэл газар авч байна. Польш, Гүрж болон Европын бусад зарим улсад Үндсэн хуулийн шүүх тусгаар тогтнолоо хамгаалахын тулд хууль эрх зүйн хүрээнд болон үзэл санаагаар тэмцэл өрнүүлэх шаардлагатай байгаа⁴⁰⁸ бөгөөд Үндсэн хуулийн шүүх бие даасан байдлаа ямар ч

⁴⁰⁷ Draft Law No. XII-P-1134 Amending Article 19 of the Law on the Constitutional Court, registered on 25 October 2013.

⁴⁰⁸ The Fundamentals of Constitutional Courts. <https://www.idea.int/sites/default/files/publications/the-fundamentals-of-constitutional-courts.pdf> 2022 оны 12-р сарын 23-ний өндөр хандав.

тэмцэлгүйгээр умартаж байгаа нь хамгийн харамсалтай хэмээн зарим судлаач нар бичиж байна.

1. Үндсэн хуулийн шүүхийн чиг хандлагыг тодорхойлох нь

Үндсэн хуулийн шүүх оршин тогтнох, загвар зохион байгуулалтыг зөвтгөх гурван үндсэн үнэт зүйл бий. Тэрхүү үнэт зүйлс нь ардчилал, хүний эрхийг хамгаалах тогтолцоо, шүүхийн хараат бус байдал юм. Үндсэн хуулийн шүүх нь парламентын өмнө өөрийгөө хамгаалах чадвартай байх нь ардчилсан замаар сонгогдсон шүүгч нарт бодлогын хамгийн чухал шийдвэр гаргах боломжийг олгодог учраас Үндсэн хуулийн зохицуулалт нь ардчилсан зарчимтай холбоотой. Ардчилал, хүний эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх тул үндсэн хуульчлах үзлийг ерөнхийд нь хадгалах голлох үүрэг гүйцэтгэнэ. Үндсэн хуульд заасан эрхийг зөрчсөн бол төрийн эрх мэдлийг засаж залруулдаг байгууллага зайлшгүй шаардлагатай.⁴⁰⁹ Харин Үндсэн хуулийн шүүхийн сонгодог загвараар хамгийн дээд хэмжээнд байлгах ёстой үнэт зүйл бол хараат бус байдал юм. Энэ утгаараа Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал гэдэг нь шүүхийн маргааныг “хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг оролцуулан өмнө нь гарч буй талуудын эрх мэдэл, давуу байдлыг

харгалзахгүйгээр” шийдвэрлэх чадамжийг хэлдэг.

Үндсэн хуулийн шүүхтэй харьцуулахад жирийн шүүхүүд хууль дээдлэх үнэт зүйлстэй нягт холбоотой байж харьцангуй чаддаг. Тэд хараат бус гуравдагч этгээдийн үүрэг гүйцэтгэдэг учраас шүүхүүдийг бие даасан байгууллага гэж үзэхийн хэрээр тэднийг дэмжиж, эрх мэдлийг нь хязгаарлахыг оролдсон аливаа өнцөгийг олон нийт шүүмжилдэг. Харин Үндсэн хуулийн шүүхийн хувьд энгийн шүүхээс ялгаатай нь харьцангуй шинэ институци бөгөөд цэвэр “шүүхийн” зарчим хэрэгжихээс гадна улс төрийн эмзэг асуудлаар мэргэшсэн шүүгчтэй байхаас өөр аргагүйд хүрч байна. Энэ нь нөгөө талдаа Үндсэн хуулийн шүүхүүд илүү “улс төрийн” шинжтэй мэт харагдахын хэрээр жирийн шүүхүүдтэй харьцуулахад хараат бус боломж нь бага мэт харагддаг. Онолын хувьд ардчилсан Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг дээд зэргээр хамгаалах боломжтой.

Үндсэн хуулийн шүүхийн талаарх орчин үеийн судлаач нарын дүгнэлтээс үүдэлтэй үндсэн хуулийн тайлбарын талаарх эргэлзээ нь дор хаяж хоёр анхааруулгатай байх ёстой аж. Нэгдүгээрт, энэхүү эргэлзээ нь үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой хэргүүдэд “зөв хариулт” өгдөг үү, эсвэл маргааныг урьдчилж дүгнэдэггүй гэх Дворкин, Гринберг нарын байр суурийг анхаарах эсэх

⁴⁰⁹ Ю.Харбих. Холбооны бүгд найрамдах улсын холбооны Үндсэн хуулийн шүүхээс хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх нь. УБ., 2007 он. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, эмхэтгэл) 455 дахь тал.

дээр төвлөрч байна. Үндсэн хуульд хэм хэмжээний агуулгаас үзэхэд Үндсэн хуулийн шүүгчид Үндсэн хуулийн бус улс төрийн үндэслэлээр хэргийг шийдвэрлэх сонирхол байдаг. Энэ нь одоогийн Үндсэн хуулийн шүүхийн байгууллагын зохион байгуулалтын ноцтой алдаа байгааг харуулж байна. Хоёрдугаарт, Үндсэн хуулийн шүүгчийн шийдвэр гаргах эмпирик мэдлэг нь үндсэн хуулийн шүүх нь улс төрийн оролцогчдын хүсэл сонирхолд бүрэн захирагддаг гэсэн ойлголтыг өгөхгүй байх баталгаа гэлтэй. Үндсэн хуулийн шүүгчид эрх мэдэл, бие даасан байдлыг хадгалдаг бөгөөд тэдний зан байдлыг зөвхөн томилогчдын сонголтоор тайлбарлах боломжгүй.⁴¹⁰ Гэсэн хэдий ч Үндсэн хуулийн шүүгчийн томилгооны тогтолцоотой холбоотой улстөрчдийг хүндэтгэх хэлбэр нь сөрөг үр дагавар буюу байгууллагын хараат бус байдлыг харьцангуй алдагдуулж байна.

2. Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлын баталгааг сайжруулж Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хамгаалах арга зам

Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд бол энгийн нэгэн сэтгэл зүй, гэнэт санагдсан төдий сэтгэгдэл биш, харин хууль зүйн шинжлэх ухаанд үздэгээр нийгмийн эрх

зүйн ухамсрын дээд түвшинд эрэмбэлэгдэж цэгцэрсэн онолын баримтлал мөн.⁴¹¹ Энэхүү онолын баримтлалын Үндсэн хуулийн онолын шүүх буюу цэц хамгаалах үүрэгтэй бас эрхтэй бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнд эдлүүлэх нийгэм, эдийн засгийн баталгаа болох цалин, бусад материаллаг хэрэгцээг хангах нь эргээд Үндсэн хуулийн хяналтын биелэлт бодитоор хангагдах баталгаа мөн. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг тодорхойлсон боловч тэдгээрийн бүрэн эрхийн хугацааны үед эдлүүлэх нийгэм, эдийн засгийн баталгааг дэлгэрэнгүй тодорхойлж, нарийвчлан тусгасан зохицуулалт хэрэгтэй. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг маш тодорхой тусгасан боловч практикт Цэцийн гишүүнээр томилогдож буй тухайн иргэн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй байх, улс төрийн өндөр мэргэшилтэй байх гэсэн хоёр шаардлагын аль нэг шаардлагыг хангасан тохиолдолд Цэцийн гишүүний албан тушаалд томилогдох шаардлагыг бүрэн дүүрэн хангаж буй мэтээр тайлбарлаж, улмаар хэрэглэх явдал ажиглагдаж байна.⁴¹² Орчин үеийн

⁴¹⁰ *Judicial Independence in European Constitutional Law*. <https://www.cambridge.org/core/journals/european-constitutional-law-review/article/judicial-independence-in-european-constitutional-law/2022-оны-12-р-сарын-19-ний-өндөр-хандав>.

⁴¹¹ Б.Чимид, “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс”, УБ., 2006 он. 37 дахь тал.

⁴¹² Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. УБ., 2018 он. 27 дахь тал.

Үндсэн хуулийн шүүхүүд Келсений санаачилсан анхны загварт бүрэн нийцэхгүй байгаа цаад шалтгаан нь шүүхийн шүүгчид тавигдах шалгуур багассан болоод улс төрийн тодорхой нөлөөлөл орж байгаатай холбон тайлбарлаж байна. Келсений анхны санааны өөр нэг тал болох Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн улс төрийн томилгоо нь ихэнх үндсэн хуулийн шүүхийн загварт баттай туссан хэвээр байгаа явдал. Европт үндсэн хуулийн шүүгчдийг томилох механизм нь гол төлөв улс төрийн оролцогчдод чухал үүрэг гүйцэтгэдэг. Германд хууль тогтоох танхимууд үндсэн хуулийн шүүгчдийг мэргэшсэн олонхын саналаар томилдог. Харин Испанид засгийн газар тодорхой тооны шүүгч нарыг томилж болохоор зохицуулжээ. Нөгөө талдаа Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн улс төрийн томилгоог зөвтгөх үндэслэл бол мажоритарийн сөргөлдөөн гэгчийг даван туулахад тусалдаг гэсэн үндэслэл юм. Феррересийн хэлснээр, Тухайн хууль тогтоомж нь ардчилсан хууль тогтоох байгууллагын бүтээгдэхүүн учраас хууль тогтоомжид хяналт шалгалт хийх нь “ардчилсан эсэргүүцэл”-ийг үүсгэж болно. Үндсэн хуулийн шүүгчийг харьцангуй ардчилсан байдлаар сонговол энэ эсэргүүцлийг багасгах боломжтой гэжээ. Төрийн гол хуулиа гажуудуулах, бүдүүлгээр үгүйсгэн гуйвуулах явдалтай тэмцэх, тийм хандлагаас урьдчилан сэргийлэх асуудал чухал явдал

мөн.⁴¹³

Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн улс төрийн томилгоо нь цаашид асуудал дагуулахаар байна. Үндсэн хуулийн шүүгчид улс төрчдөөс хараат бус байх нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд тухайлбал, бүрэн эрхийн хугацаа, шүүхийн нөөцийг удирдах бие даасан байдал, шийдвэрээ биелүүлэх чадвар зэргээс шалтгаална. Гэхдээ бас шүүхийн томилгоо маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Стоун Свит томилгооны хоёр үндсэн тогтолцоог санал болгодог. Хувь хүнээс нэр дэвшүүлэх эсвэл хууль тогтоох чуулганд хэт олонхийн саналаар нэр дэвшүүлэх. Хууль тогтоох чуулганд хэт олонхи байх шаардлагатай тогтолцоо нь зарчмын хувьд хэт намчирхсан томилгооноос зайлсхийх зорилготой тул бодит байдал дээр парламентын хүчин чадалтай ойролцоо хэд хэдэн шүүгчийг томилдог квотын систем ажилладаг. Шүүгчдийн үзэл суртал шийдвэр гаргах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг тухай эмпирик нотлох баримтууд асар их байгаа нөхцөлд үзэл суртлын хувьд ижил төстэй үндсэн хуулийн шүүгчдийг томилох нь энэ тогтолцооны нэг онцлог шинж болдог. Шүүгчдийг улстөржсөн байгууллагуудаас томилдог болсноор томилгооны үйл явцад

⁴¹³ Б.Чимид. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Ч.Өнөрбаяр, Б.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм. УБ., 2019 он. 24 дэх тал.

улс төрийн намуудын нөлөөнд ихээхэн ордог. Тиймээс Үндсэн хуулийн шүүгчид шүүхийн нэр хүндийг хамгаалахын тулд намын улс төрөөс тодорхой хэмжээний зай барьж байх сонирхолтой ч шүүхийн хараат бус байдал асуудал болж байна. Үүнтэй холбоотойгоор одоогийн Үндсэн хуулийн шүүхүүд улстөрчдөөс харьцангуй хараат хэвээр байх боломжтой. Шүүгчийн хараат бус байдал суларсны үр дагавар нь ихэвчлэн шүүхийн нэр хүнд, хууль ёсны хамаарал алдагдахад хүргэдэг. Үндсэн хуулийн шүүгчийн томилгооны давамгайлсан тогтолцоотой холбоотой улстөрчдийг хүндэтгэх хэлбэр нь сөрөг үр дагавар буюу байгууллагын хараат бус байдлыг харьцангуй алдагдуулж байна. Үүнтэй холбоотойгоор одоогийн Үндсэн хуулийн шүүхүүд улстөрчдөөс харьцангуй хараат хэвээр байх боломжтой. Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг нь нэмэгдүүлж, Цэцэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, нөгөө талаас Цэцийг улс төржиж байгаа мэт ойлголт төрүүлж буй явдлыг хязгаарлах үүднээс мэдээлэл гаргаж буй иргэн, түүний гаргаж буй мэдээлэлд мэдээллийн томъёолол ойлгомжтой байх, агуулга тодорхой байх, нэр, хаяг тодорхой байх зэрэг шаардлага тавьж, зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай⁴¹⁴ байна.

Дүгнэлт

Үндсэн хуулийг ардчилал, хүний эрхийг дээдэлсэн дээд дүрэм болгон хамгаалах асуудалд Үндсэн хуулийн шүүх, шүүгч чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Гэвч Үндсэн хуулийн шүүхийг улс төрийн нөлөөллөөс холдуулахгүй бол аль алин нэгэндээ нөлөөлж ардчиллаар хуульчлагдсан бодлогын сонголтыг үгүйсгэхээсээ айх зүйл багатай болж Үндсэн хуулийн үзэл баримтлалаа авч үлдэх эсэх дээр сорилтууд байнга гарах болно. Шүүхийн агуу их хэмээн нэрлэж болох тэр зорилго нь хүчирхийлэх аливаа үзэл санааг эрх зүйн үзэл санаагаар сольж, төр засаг ба түүний ашиглах дуртай хүч хоёрын завсар эрх зүйн саад тогтооход оршдог.⁴¹⁵ Цаашилбал, ардчилал, тусгаар тогтнолыг хамгаалах үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн шүүгчийн бие даасан байдал, үзэл санаатай зөрчилддөг болчихвол хурцадмал байдал улам бүр нэмэгддэг. Харин Үндсэн хуулиа хамгаалах өргөн хүрээний тогтолцоотой, улс төрийн хяналтаас чөлөөлөгдсөн шүүхтэй байж чадвал олонхын эсрэг шийдвэр гаргах, сонгогдсон улстөрчдийн давуу талыг эсэргүүцэж чадах баталгаа улам нэмэгдэнэ. Үндсэн хуулийн шүүх нь цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд

⁴¹⁵ Ч.Өнөрбаяр. Монгол Улс дахь Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. Үндсэн хуулийн цэц., Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (Онол, арга зүй, хэрэгжилт) УБ., 2017 он. 129 дэх тал.

⁴¹⁴ Мөн тэнд.

нийцүүлж тэнцвэржүүлэх, тэдгээрийн хоорондын хурцадмал байдлыг зохицуулах чухал үүрэгтэй юм.

Санал

- Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулахын тулд Үндсэн хуулийн шүүхийн дарга нь болон гишүүн нь нэгэндээ нөлөөлөх оролдлогын хийвэл нэн даруй мэдэгдэх, нөлөөлөх гэж оролдсон тухай баримтыг олон нийтэд мэдээлэх үүрэгтэй байх. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Үндсэн хуулийн шүүхийн байрнаас тодорхой метрийн зайд байх эсхүл шүүхийн дэргэд цуглаан, жагсаал бусад арга хэмжээ зохион байгуулах, хэрэв тэдгээр нь шүүгч, шүүхэд нөлөөлөх зорилготой бол түүнийг даруй зогсоох зэрэг арга хэмжээ авч байх

- Зөвлөлдөх танхим, санал хураалтын нууц болон байр суурийг олон нийтэд мэдээлэхийг хориглох цогцуулалтыг хэрэгжүүлэх. Түүнчлэн шүүгчийн нийгмийн (материаллаг) баталгаатай холбоотой асуудал Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд онцгой үйлчилдэг болох

- Австри, Бельги, Эстони, Франц, Герман, Итали, Люксембург, Мальта, Польш, Португал, Румын зэрэг улсуудад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг хангахад чиглэгдсэн зөвлөлдөх танхим, санал хураалтын нууцлалыг тогтоосон хуулийн зохицуулалтуудыг Монгол Улсын Цэцийн тухай хуулинд

нарийвчлан оруулах

- Үндсэн хуулийн шүүхийн хувьд энгийн шүүхээс ялгаатай нь харьцангуй шинэ институци бөгөөд цэвэр “шүүхийн” зарчим хэрэгжихээс гадна улс төрийн эмзэг асуудлаар мэргэшсэн шүүгчтэй байхаас өөр аргагүйд хүрч байна. Тиймээс Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг сонгох шалгуурыг нэмж бодитоор үнэлэх

- Үндсэн хуулийн шүүгчийн томилгооны тогтолцоотой холбоотой улстөрчдийг хүндэтгэх хэлбэр нь сөрөг үр дагавар буюу байгууллагын хараат бус байдлыг харьцангуй алдагдуулж байна. Иймд улс төрийн нам, эсвэлд ойр хүмүүсийг нэр дэвшүүлж Цэцийн гишүүн болгохгүй байх

- Үндсэн хуулийн цэцийн гишүүнд эдлүүлэх нийгэм, эдийн засгийн баталгаа болох цалин, бусад материаллаг хэрэгцээг хангах

- Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг тодорхойлсон боловч тэдгээрийн бүрэн эрхийн хугацааны үед эдлүүлэх нийгэм, эдийн засгийн баталгааг дэлгэрэнгүй тодорхойлж, нарийвчлан тусгасан зохицуулалт оруулах

- Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг маш тодорхой тусгасан боловч практикт Цэцийн гишүүнээр томилогдож буй тухайн иргэн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй байх, улс төрийн өндөр мэргэшилтэй байх гэсэн хоёр шаардлагын аль нэг шаардлагыг хангасан тохиолдолд Цэцийн гишүүний албан

тушаалд томилогдох шаардлагыг бүрэн дүүрэн хангаж буй мэтээр тайлбарлаж, улмаар хэрэглэх явдал ажиглагдаж байна. Гэтэл хууль зүйн болон улс төрийн гэх ойлголтууд нь бие даасан агуулга илэрхийлж байгаа төдийгүй аль алийг хангасан хүнийг нэр дэвшүүлэх

- Германд хууль тогтоох танхим-ууд үндсэн хуулийн шүүгчдийг мэргэшсэн олонхийн саналаар томилдог жишгийг томилгооны үе шатанд нэвтрүүлэх боломжтой гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1992 он
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2012 он

2. Ном, гарын авлага, өгүүлэл, судалгаа

1. Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц: өгүүлэл, илтгэлийн эмхтгэл, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2007 он
2. Ж.Амарсанаа. Үндсэн хуулийн хяналт, түүнийг хэрэгжүүлэх арга зам. УБ., 2007 он
3. Н.Жанцан нар, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, УБ, 2017 он
4. Б.Чимид. Шүүх эрх мэдлийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. (өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2007 он

5. Б.Чимид, “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс”, УБ., 2006 он.

6. Б.Чимид. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Ч.Өнөрбаяр, Б.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм. УБ., 2019 он.

7. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. УБ., 2018 он

8. Ч.Өнөрбаяр. Монгол Улс дахь Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. Үндсэн хуулийн цэц., Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (Онол, арга зүй, хэрэгжилт) УБ., 2017 он.

3. Гадаад эх сурвалж

1. The Ways of Federalism in Western Countries and the Horizons of Territorial Autonomy in Spain: Volume 1 (Berlin, Heidelberg: Springer, 2013), pp. 481–500, 492.
2. Constitutional Court's rulings, inter alia, of 6 December 1995 and 14 February 2011.
3. Draft Law No. XII-P-1134 Amending Article 19 of the Law on the Constitutional Court, registered on 25 October 2013.
4. Judicial Independence in European Constitutional Law. <https://www.cambridge.org/core/journals/european-constitutional-law-review/article/judicial-independence-in-european-constitutional>
5. The Fundamentals of Constitutional Courts. <https://www.idea.int/sites/default/files/publications/the-fundamentals-of-constitutional-courts.pdf>

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БҮЙ
АСУУДЛУУД ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**



Шихихутуг их сургуулийн магистрант
Г.БАТМӨНХ

Хураангуй:

Улс орон хөгжихийн хэрээр төрийн худалдан авалт нэмэгдэх бөгөөд тэр дотроо стратегийн бүтээн байгуулалт, төрийн нууцад хамаарах худалдан авалтыг үр дүнтэй, шударга, оновчтой зохион байгуулах нь дутагдалтай байна. Тиймээс дээрх худалдан авалтыг хэрхэн зөв зохион байгуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс сэргийлэх асуудлыг хуульчилж өгөх нь чухал.

Түлхүүр үг:

Төрийн худалдан авах ажиллагаа, төрийн нууцад хамаарах худалдан авалт, ашиг сонирхол, цахим худалдан авалт.

Гарчиг

Судалгааны ажлын зорилго

1. Төрийн худалдан авах тухай хууль тогтоомжийн дутагдалтай

тал, тогтвортой байдал

2. Төрийн худалдан авах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Төрийн нууц болон цахим худалдан авалт)
3. Шийдвэрлэх арга зам

Оршил

Төр үүссэн цагаас эхлэн нийтийн хөрөнгөөр өөрийн хэрэгцээт буюу нийтэд хэрэглэгдэх худалдан авалтыг хийх шаардлага үүссэн бөгөөд төрт улс өөрийн оршин тогтнох үйл ажиллагааг явуулахад тодорхой хариу төлбөртэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хийгдэж эхэлсэн гэж судлаачид үздэг.⁴¹⁶

Төрийн худалдан авах ажиллагаа бол бодлогын хувьд стратегийн ач холбогдол бүхий томоохон арга хэрэгсэл бөгөөд төр бол хамгийн том худалдан авагч юм. Тийм ч учраас төрийн худалдан авалтыг бодлогоор дамжуулан эдийн засгийн зорилтот секторуудыг хөгжүүлэх боломжтой. Тухайлбал: үндэсний үйлдвэрлэл, тодорхой салбарын хөгжлийг дэмжих, тодорхой газар нутаг дахь иргэдийг ажлын байраар хангах, ажилгүйдлийг бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг байна.

⁴¹⁶ Г.Банзрагч “Эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтын нийтийн эрх зүйн үндэс, анхаарах асуудлууд” (2016), 1 дэх тал,

Төрийн худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтаар дамжуулан нийтийн болон хувийн эрх зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах боломжтой байдаг. Төрийн худалдан авалтын хувьд шийдвэр гаргаж буй процесс нь захиргааны эрх зүйн хүрээнд ойлгогдох боловч гэрээтэй холбоотой харилцаа нь хувийн эрх зүйн хүрээнд шийдвэрлэгдэж байна.

Манай улсын эдийн засгийг зохицуулдаг хууль тогтоомжийн хувьд хувийн эрх зүйд хамааралтай нь цөөн бөгөөд дийлэнхдээ нийтийн эрх зүйд хамаарч байна.

Монгол улсын төрийн худалдан авах ажиллагааг харьцангуй хожуу хуульчилсан бөгөөд эдүгээ 2000 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль” батлагдан гарч хагас төвлөрсөн тогтолцоог бий болгож ирсэн. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга 2005 онд батлагдаж 2023 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж 2024 оноос тус хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэн байна.

Хууль, эрх зүйн суурь зарчим нь хууль дээдлэх зарчимд нийцсэн эсэх нь өмнө батлагдсан хуулиудтай зөрчилдөөнгүй байх, эрх зүйн онол, үзэл баримтлалд нийцсэн байдлаар тодорхойлогддог. Тус хууль нь бусад хуультай зөрчилдөж буй байдлыг бусад хуулийн холбогдох зарим

заалттай харьцуулж үзэхэд зарим талаар зөрчилдөж байгаа, төрийн худалдан авалтыг хийдэлгүй, бүрэн зохицуулж чадахгүй байгаа зэрэг нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг юм.

Судалгааны ажлын зорилго

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, тулгамдсан асуудлуудыг тодруулж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд шинэтгэл хийх агуулгыг тодорхойлоход оршино.

I.Төрийн худалдан авах тухай хууль тогтоомжийн дутагдалтай тал, тогтвортой байдал

Монгол Улс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг анх хуульчлан зохицуулснаас хойш 20 жил өнгөрсөн ч төрийн худалдан авах ажиллагааны эрх зүй нь эдийн засгийн эрх зүйн хүрээнд харьцангуй шинэ тутам хөгжиж байгаа салбар эрх зүйн нэг юм.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль нь бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын ашигт ажиллагааг бууруулах, зардлыг өсгөх магадлал өндөр гэж

харж байна. Тухайлбал, тухайн байгууллага үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг нэг төрлийн үйлдвэрийн бүтээгдэхүүнээр дагнан худалдан авалт хийх боломжгүй, үйлдвэрлэгчээс шууд худалдан авалт хийх боломж хязгаарлагдмал байгаа нь хангамжийн бараа материалын нэр төрлийг нэмэгдүүлэх, бусад бүтээгдэхүүнтэй өрсөлдүүлэх, шаардлагад нийцсэн хамгийн бага үнэтэй бүтээгдэхүүнийг авахаас өөр боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа нь бараа бүтээгдэхүүний чанар, эдэлгээ, эвдрэл гэмтлийн асуудлыг цаашид ч үүсгэсээр байна. Өөрөөр хэлбэл худалдан авах ажиллагааны агуулга, эрсдэл, өртөг, нарийн төвөгтэй байдлыг харгалзан тухайн төслийн үр дүн, хөгжлийн зорилтод хүрэхийн тулд стандартын дагуу цаг хугацаанд нь үр ашигтайгаар нөөцийг ашиглах, үр дүнтэй болгох зорилгоор худалдан авах ажиллагааны хэлбэрийг зохион байгуулахад бараа, бүтээгдэхүүний чанарын асуудал чухал шаардлагатай байна.

Мөн тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”, 3.5 дахь хэсэгт “Хууль тогтоомжоор олгосон

эрхийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.” гэх мэт хэд хэдэн харилцааг энэхүү хуулиар зохицуулахгүй гэж заасан боловч хэрхэн зохицуулах чиглэл, баримжаа байдаггүйгээс авлига, ашиг сонирхол үүсэх, албан тушаалаар урвуулан ашиглах, иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хөндөх, хүртээмжтэй өрсөлдөх боломжийг хязгаарласан, чанаргүй бараа, ажил, үйлчилгээг дэмжих нөхцөлийг бүрдүүлдэг.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-иар дээрх асуудлуудыг хуульчлан зохицуулах зохицуулалтуудыг нэмэгдүүлснээс гадна үйлдвэр, түүний сэлбэг хэрэгслийг албан ёсны үйлдвэрлэгчээс шууд худалдан авах зохицуулалт тусгагдсан нь оновчтой боловч бусад төрлийн бараа, материалын худалдан авалтыг шууд худалдан авч болох зохицуулалт тусгах хэрэгцээ шаардлага байсан. Мөн дээрх шинэчилсэн найруулгад хуулийг хэрэгжүүлэхийн тулд төрийн захиргааны төв байгууллагуудаас 17-20 төрлийн дүрэм, журам, эрх зүйн хэм хэмжээний болон хуульчилсан актууд батлан гаргаж дагаж мөрдүүлэхээр заасан бөгөөд хууль

батлагдсан гарснаас хойш 1 жилийн хугацаанд Засгийн газар, Сангийн яам зэрэг нутгийн захиргааны байгууллагаас 10-н дүрэм, журам батлагдсан байгаа нь хуулийн хэрэгжилт, үүргээ гүйцэтгэхэд удаашрал, хүндрэлтэй, ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Монгол Улсын Их Хурал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”- ийг 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталж, 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Өнгөрсөн 17 жилийн хугацаанд тус хуульд 21 удаа нэмэлт, өөрчлөлт орж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа харилцааг зохицуулж байсан нь нэг талаас хууль, эрх зүйн хувьд тогтворгүй байдлыг илэрхийлсэн.⁴¹⁷

II.Төрийн худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Төрийн нууц болон цахим худалдан авалт)

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан болон одоо мөрдөгдөж буй хуулиар төрийн нууцад хамаарах худалдан авалтыг энэхүү хуулиар зохицуулахгүй⁴¹⁸

⁴¹⁷ Монгол Улсын Сангийн яам- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020 он

⁴¹⁸ /2005/ ТБОНӨХБАҮХАмХ 3.4.Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж,

байх мөн төрийн нууцад хамаарах худалдан авалтыг зохион байгуулахдаа эрх бүхий байгууллагаас хуульд нийцүүлэн гаргасан журмын⁴¹⁹ дагуу зохион байгуулахаар хуульчилсан байдаг.

Төрийн нууцад хамаарах худалдан авалт гүйцэтгэдэг байгууллагууд нь тухайн байгууллагын удирдлагын тушаалаар, зарим үндэсний аюулгүй байдлыг хангахуйц үндэсний хэмжээний бүтээн байгуулалтын худалдан авалт, сонгон шалгаруулалтыг тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг шийдвэрлэдэг бөгөөд гэхдээ ямар нэгэн тусгайлан баталсан нэгдсэн хэм хэмжээний актыг баримталдаггүй юм. Үүнээс үзэхэд үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болохуйц асуудал хуулиар бус тухайн худалдан авалтыг зохион байгуулах байгууллагын дотоод хэм хэмжээ, соёлын хүрээнд зохицуулагдах нөхцөл байдал үүсдэг.

Төрийн худалдан авалтыг нууц нэрийн дор тусгайлсан зохицуулалтгүй зохион байгуулснаар аж ахуйн нэгж байгууллагуудын өрсөлдөөнийг хязгаарлах, авлига, ашиг сонирхолд өртөх, мэдээлэлд ойр субъектүүд эрх мэдлээ багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

⁴¹⁹ /2023/ ТБОНӨХБАҮХАмХ 3.4. Энэ хуулийн 3.3.1-д заасан төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг тагнуулын байгууллага боловсруулж, Засгийн газар батална

урвуулан ашиглах нөхцөл бүрдсэн. (Санхүүгийн чадамж, ажиллах хүн хүч, техник, тусгай зөвшөөрөл, байгууллагын түүх г.м орон хүчин зүйлээр шаардлага хангахгүй аж ахуйн нэгж сонгон шалгарч мөнгө угааж байна.)

Төрийн нууцад хамаарах худалдан авалтыг хуулиар бус захиргааны акт⁴²⁰, захиргааны хэм хэмжээний актаар⁴²¹ зохицуулахаар хуульчилсан байгаа нь дээрх зөрчил, асуудлууд үүсэх гол нөхцөл байдалд хүргэж байна. Шинэчилсэн найруулгаар мөрдөгдөж буй “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг тагнуулын байгууллага боловсруулж, Засгийн

газар батална гэж заасан боловч хууль батдагдсанаас хойш 1 жил, мөрдөгдөж эхлээд хагас жил болж байхад энэхүү журам батлагдаагүй байгаа нь хууль хэрэглээ болон тухайн хууль өөрийн зохицуулах харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаатай холбоотой.

Мөн Монгол улсын хувьд төрийн худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай, хэмнэлттэй болгохын тулд цахим худалдан авах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, цахим худалдан авах ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй ногоон худалдан авалтыг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Төрийн худалдан авах ажиллагаанд үр ашигтай, хэмнэлттэй, ил тод болгоход хүний оролцоог багасгах, тендер шалгаруулалт зохион байгуулах үйл явцыг хүнээс хараат бус болгох шаардлага зүй ёсоор урган гарсантай холбогдуулан цахим шилжилтэд үе шаттайгаар шилжиж байна.

Манай улс төрийн худалдан авах ажиллагааг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлэн ажиллах, дунд болон урт хугацааны бодлогын хөтөлбөрт зорилт дэвшүүлэн ажиллаж, цахим хэлбэрээр зохион байгуулахад баримтлах журмыг боловсруулан мөрдүүлж байгаа ч хуулиар цахим хэлбэрээр зохион байгуулах талаар нарийвчилсан зохицуулалт хангалтгүй тул зарим тохиолдолд зөрчилдөх асуудал үүсдэг.

Судлаач Т.Энхжаргал “Засгийн

⁴²⁰ /2015/ ЗЕХ 37.1.Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.

⁴²¹ /2015/ ЗЕХ 59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.Тайлбар: “Гадагш чиглэсэн” гэж иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн үр дагавар үүсгэсэн, тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжийг агуулаагүй байхыг ойлгоно.

газрын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хүрээг өргөтгөх асуудал” илтгэлдээ Монгол улсын засгийн газрын худалдан авах ажиллагааны хуулийн зохицуулалт, түүний хүрээ, тулгамдаж буй асуудал, цаашид зохицуулах асуудлын хүрээг судлан дүгнэсэн байдаг.⁴²²

Хуулийн хэрэгжилт, үр дүнгийн хувьд харвал цахим худалдан авах ажиллагааны системийг сайжруулах хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд байсан.

Тухайлбал: цахим системийг ашиглан гадаадын этгээд тендерт оролцох боломжийг бүрдүүлэх, олон улсын байгууллагын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад системийн хувьд боломжтой байх зэрэг хамрах хүрээг өргөжүүлэн тэлж зах зээлийн өрсөлдөөний зарчмаар чанарыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Мөн түүнчлэн худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал түүнтэй уялдуулан нууцлал, аюулгүй байдлыг хангах шаардлагатай юм.

III. Шийдвэрлэх арга зам

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулж хуулиар зохицуулахгүй орхигдуулсан харилцаануудыг зохицуулах эсвэл

хуульд заасан төрийн нууцад хамаарах худалдан авалтыг зохион байгуулах журмыг боловсруулж мөрдөж эхлэх.

Дээрх журам батлагдан үйлчилж эхэлсэн ч хуулиар зохицуулаагүй энэ төрлийн асуудлыг бүрэн гүйцэд зохицуулж чадах эсэх нь эргэлзээтэй бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн нууцтай холбоотой худалдан авалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд эрх бүхий төрийн байгууллага (Тагнуул, АТГ г.м)-ын хяналтын доор зохион байгуулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, дээрх байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулах (худалдан авах ажиллагаанд оролцсоны урамшууллын системийг бий болгох, гарсан шийдвэрийг тухай бүр эрх бүхий байгууллагад хүргүүлэх) нь зүйтэй.

Өнөөдрийн байдлаар Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжоор худалдан авалтыг гүйцэтгэх байгууллагууд цахим худалдан авалт (цахим дэлгүүр)-ыг гүйцэтгэх бүрэн боломж нээгдсэн нь авууштай боловч худалдан авалтыг зохион байгуулах систем шаардлага хангахгүй буюу ойлгомжгүй мөн ачаалал даах чадвар дутмаг тул сайжруулалтыг зөв зохион байгуулалт, системтэй болгох, мэдээ мэдээллийг аж ахуйн нэгж байгууллагуудад үнэн бодит, нээлттэй түгээх нь зүйтэй.

⁴²² Т.Энхжаргал “Засгийн газрын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хүрээг өргөтгөх асуудал” (2014), 1 дэх мал. Legaldata-аас унших боломжтой: <https://legaldata.mn/b/115>

Дүгнэлт

Эрх зүйн хэм хэмжээ нь нийгэм, эдийн засгийн хөгжилтэй зэрэгцэн боловсронгуй болох шаардлагатай хэдий ч тогтвортой байх шинжийг тодорхой түвшинд агуулах учиртай. Мөн олон удаа нэмэлт, өөрчлөлт орох нь хуулийн системчлэл, логик уялдаа холбоо алдагдах нөхцөлийг бий болгох талтай. Түүнчлэн тухайн харилцааг бүхэлд нь зохицуулж байгаа хуулийг хууль хэрэгжүүлэгчид нэг мөр ойлгож практикт хэрэглэх, хуулийн зохицуулалт тухайн харилцааг зохицуулах зорилго, зарчимд нийцэж байгаа тохиолдолд зохицуулалтын зорилгод нийцсэн гэж дүгнэдэг.

Иймээс хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал нь эрх зүйн суурь зарчим, үзэл санаа, зохицуулалтын зорилгодоо нийцсэн эсэх хүрээнд хийсэн дүн шинжилгээ хийх шаардлагатай юм.

Төрийн худалдан авах ажиллагааг тодорхойлох онолын тодорхойлолт, эрх зүйн зохицуулалтын хүрээ, хуулийн хэрэгжилтийг үнэлж, худалдан авах ажиллагааг судалснаар эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг тодорхойлох ач холбогдолтой юм.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, урилга, тендер шалгаруулалтын үр дүн, гэрээний хэрэгжилт, гэрээний үр дүн ил тод байх, өрсөлдөөнийг дэмжиж тендерт оролцогч нарыг тендерт оролцох тэгш боломжоор хангах, төсвийг

хэмнэсэн, үр ашигтай худалдан авалт хийх, худалдан авалт хийхэд хуульд нийцүүлэх, хариуцлагатай байх зарчмыг баримтлах шаардлагатай хэдий ч хуулийн дагуу захиалагч бүр худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төсөв хэмнэсэн, үр ашигтай худалдан авалт хийх механизм бүрдээгүй байна.

Иймд хуулийн зохицуулалт нь тодорхой, ойлгомжтой, зөрчилдөөнгүй байх шаардлагад нийцсэн байх, хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөөнгүй байх, хэл найруулга, логик зүй тогтлыг хангах болон бүрэн байх шаардлагатай.

Цаашид төрийн худалдан авах ажиллагааг оновчтой төлөвлөж, зохион байгуулах шаардлагатай ба төрийн хариуцлага хүлээх механизм, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, төр болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх эрсдэлийг бууруулах шаардлагатай байна.

Санал

Худалдан авах үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээ нь нийгэм, эдийн засгийн хөгжилтэй зэрэгцэн боловсронгуй болох шаардлагатай хэдий ч тогтвортой байх шинжийг тодорхой түвшинд агуулахын зэрэгцээ төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог нягтаршуулах.

Цахим худалдан авалтыг зохион байгуулах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, цахим дэлгүүрт бараа, ажил, үйлчилгээ үзүүлэх сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангаж өрсөлдөөн, системийн ачаалал даах чадавхыг нэмэгдүүлэх.

Төрийн нууцад хамаарах худалдан авалтыг зохион байгуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох,

Ном зүй, ашигласан материал:

1. Г.Банзрагч “Эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтын нийтийн эрх зүйн үндэс, анхаарах асуудлууд” (2016), 1 дэх тал.

2. Монгол Улсын Сангийн яам- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2020 он.

3. Т.Энхжаргал “Засгийн газрын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хүрээг өргөтгөх асуудал” (2014), 1 дэх тал.

<https://legalinfo.mn/mn>

Legaldata: <https://legaldata.mn/>

www.tender.gov.mn

Ашигласан ном, эх сурвалж

1. Ane Tamayo, H. S. (2017). The Role of Social Capital in Corporations. *Journal of Finance*.

2. Bourdieu, P. (1986). *The forms of capital*.

3. Claridge, T. (2018). *Introduction to social capital theory*.

4. Coleman, J. S. (1988). “Social Capital in the Creation of Human Capital,”. *Sociology*.

5. Coleman, J. S. (1988). The American Journal of Sociology . *Social Capital in the Creation of Human Capital*.

6. Coleman, J. S. (1990). *Foundations of Social Theory*. Harvard University Press.

7. Gittel, R. a. (1998). Building Social Capital as a Development Strategy. *sagepub*.

8. Häuberer, J. (2011). *Concept of Social Capital*.

9. Hongseok Oh, M.-H. C. (2004). Group Social Capital and Group Effectiveness: The Role of Informal Socializing Ties. *jstor*.

10. Humnath Bhandari, K. Y. (2009). What Is Social Capital? A Comprehensive Review of the Concept. *Asian Journal of Social Science*, 3.

11. Leonard, M. (2004). Bonding and bridging social capital. *Sociology* , 38.

12. Management, J. o. (2011). Multilevel Challenges and Opportunities in Social Capital Research. *Journal of Management*.

13. *Market business news*. (2022). marketbusinessnews.com: <https://marketbusinessnews.com/financial-glossary/social-capital/-ээс> Гапрасан

14. Mikiewicz, P. (2021). Social capital and education – An attempt to synthesize conceptualization arising from various theoretical origins. *Cogent Education* , 5.

15. Nahapiet, J. &. (1998). *Academy*

of Management Review. *Social Capital, Intellectual Capital, and the Organizational Advantage*, 243.

16. Putnam, R. D. (1995). Tuning In, Tuning Out: The Strange Disappearance of Social Capital in America. *Political Science and Politics*, 67.

17. Sawhill, I. V. (огноо байхгүй). *Social Capital: Why We Need It and How We Can Create More of It*. 2020.

18. Thibault Coppe, L. T. (2022). The Use of Social Capital in Teacher Research: A Necessary Clarification. *Frontiers in Psychology*.

19. Wacquant, P. B. (1992). *An Invitation to Reflexive Sociology*. Chicago Press.

20. Wu, C. (2021). Social capital and COVID-19: a multidimensional. *CHINESE SOCIOLOGICAL REVIEW*, 30.

КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР



Шихихутуг их сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш
А.ДОРЖГОТОВ

**КОМПАНИЙН ХУУЛИЙН
ТАЙЛБАР: Үргэлжлэл. Түрүүч нь
“Шихихутуг” сэтгүүлийн 2015,
2018, 2019, 2021, 2022, 2023 оны
дугааруудад нийтлэгдсэн болно.**

36 дугаар зүйл. Алтан хувьцаа

36.1. Засгийн газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд энэ хуулийн 36.2-т заасан асуудлаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй алтан хувьцааг гаргахаар зааж болно.

36.2. Алтан хувьцаатай компанийн

хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагаас дор дурдсан асуудлаар гаргасан шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрх ашигт харшилсан тохиолдолд Засгийн газар хориг тавина.

36.2.1. хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;

36.2.2. компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

36.2.3. их хэмжээний хэлцэл байгуулах;

36.2.4. бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох, өөрчлөх.

36.3. Засгийн газар энэ хуулийн 36.2-т заасны дагуу хориг тавих тухай шийдвэртээ хориг тавьж байгаа үндэслэлээ заана.

36.4. Энэ хуулийн 36.2-т заасан асуудлаар компанийн гаргасан шийдвэр Засгийн газрын батламжилснаар хүчин төгөлдөр болно.

36.5. Алтан хувьцааг бусдад шилжүүлэхийг хориглоно.

36.6. Энэ хуулийн 36.1-д заасан тодорхой хугацаа дуусгамагц алтан хувьцаа нь хүчингүй болох бөгөөд хугацааг дахин сунгахгүй.

Тайлбар:

Алтан хувьцааны тухай ойлголтыг эрх зүй, эдийн засгийн агуулгаар нь

дараах байдлаар тайлбарлан бичсэн байна. Засгийн газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, их хэмжээний хэлцэл байгуулах, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох, өөрчлөх тохиолдолд тодорхой хугацаанд компанийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй хувьцаа гаргаж болох бөгөөд үүнийг “алтан хувьцаа” гэдэг байна.

Алтан хувьцаа. Энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцааг эзэмшигчид хөрөнгөө оруулж эзэмшдэг. Харин алтан хувьцаа бол компанийн гаргасан шийдвэрт хориг тавих эрхтэй. Гэхдээ үүнийг ямар нэгэн хөрөнгө оруулалт⁴²³ гэж ойлгож болно. Төрийн өмчийн компаниудыг хувьчлахдаа 10 жилийн хугацаатайгаар алтан хувьцааг төр эзэмшихээр гаргасан энэ нь мөнгө хөрөнгө биш. *Тухайлбал*, МИАТ-ын үйл ажиллагаа тариф нэмэх гэх ч юм уу, асуудалд өөрсдөө хориг тавьж зохицуулна гэсэн үг юм. Шийдвэрт хориг тавина. Алтан хувьцаа гэдэг ойлголт анх англид үүсчээ. Засгийн

⁴²³Хөрөнгө оруулалт бол ирээдүйд ашиг олох зорилгоор мөнгө эсвэл цаг хугацаа, эсвэл нөөц баялгийг ашиглах үйл явц юм. <https://en.wikipedia.org/wiki/Investment>

газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа:

a) хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;

b) компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

c) их хэмжээний хэлцэл байгуулах ;

d) бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох, өөрчлөх тохиолдолд тодорхой хугацаанд компанийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй. Ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй хувьцаа гаргаж болох бөгөөд үүнийг “алтан хувьцаа” гэж тодорхойлсон байна.

Алтан хувьцааны тухай: 1980-аад оны үед Англи улсад М.Thatcher алтан хувьцааны ухагдахууныг хувьчлалд өргөн хэмжээгээр амжилттай ашигласан байдаг. Монгол Улсад энэ ойлголт тодорхой хэмжээгээр байсан хэдий ч хувьчлалд ашиглагдаагүй юм. Гэхдээ Компанийн тухай хуулинд алтан хувьцааны тухай ойлголт ерөнхий байдлаар орсон байдаг. Нэг жижигхэн түүхийг та бүхэнтэй хуваалцъя. 2013-2014 оны үед УИХ-ын эдийн засгийн байнгын хороон дээр төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийг хэлэлцэж байх үед уул уурхайн салбарт ялангуяа стратегийн

орд, газруудад төрийн зүгээс оролцох нэг хэлбэр нь алтан хувьцаагаар дамжуулан оролцож болох юм гэсэн санал гаргаад энэ саналаа тайлбарлаад олонхийн дэмжлэг авч, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр болсон юм. Алтан хувьцаа бол нэг л ширхэг, саналын эрхгүй, аливаа ногдол ашиг авдаггүй, зөвхөн veto буюу хориг тавих эрхтэй хувьцаа бөгөөд үүнийг төр эзэмшээд, стратегийн орд, газруудыг эзэмшиж буй компанийн удирдлагын зөвлөлд энэ алтан хувьцаагаа эзэмшсэн байдлаар оролцож, Монгол улсын эрх ашигтай нийцээгүй шийдвэр гаргасан тохиолдолд veto тавьж, уг шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй байхаар бодож, зохицуулалт хийж өгөх байв. Гэвч чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед би санаачлагчийн хувьд гэнэт уг саналаа татаж авснаар цаашид хэлэлцээгүй билээ.

Тэрээр цааш нь өгүүлэхдээ⁴²⁴ тухайн үедээ Их Хурал дээр нилээн ядаргаатай уур амьсгалтай байсныг ч хэлэх үү, маш олон гишүүд алтан хувьцааны талаар лавлаж асуух нь ойлгомжтой байсан тул яагаад ч юм миний гэдэн хөдлөөд ийнхүү татан авсан нь одоо бодоход их хариуцлагагүй, бодлогогүй алхам байж гэж би одоо боддог. Монгол улсын төр одоо 34 хувь, 51 хувь, 100 хувь гэх мэтээр уул уурхайн салбарт оролцож байгаа бөгөөд сүүлийн үед роялтигоор дамжуулан үр ашиг авах

⁴²⁴ С.Дэмбэрэл. (УИХ-ын дарга, гишүүн асан) Алтан хувьцааны тухай зарим санаа. www.trends.mn (2015.07.15)

гэх мэтээр эрх ашгаа тусгах гэж янз бүрээр оролдож л байна. Үр дүн ямар байгаа талаар, эдгээр хэлбэрүүд нийгмийг яаж хувааж, ямар хэл ам дагуулж, хүн бүр уул уурхайн талаар гайхамшигтай мундаг мэдлэгтэй болж буй талаар яриад хэрэггүй бизээ. Эсвэл Үндсэн хуулийн “газар ...ард түмний мэдэлд, 1072 ширхэг хувьцаа гэх ард түмнээрээ хувьцаа эзэмшдэг нийгмийн тухай бас яриад хэрэггүй биз. Эдгээр хэлбэрүүд цаашид ч байх хандлагатай байгаа бөгөөд нөөцөөр баялаг улс орнуудад тохиолддог баялгийн хараалын нэг шинж тэмдэг ч болж болзошгүй байна. /Хэрэв ерөнхий болон эрдэс баялагийн салбар дахь засаглал өнөөдрийнх шиг суу хэвээр байвал/ Гэтэл алтан хувьцааг дээрх хэлбэрүүд хадгалагдан үлдэх нөхцөлд ч цаашид төрөөс уул уурхайн салбарт оролцох нэг сонголтот хэлбэр болгон хуульчлан хэрэгжүүлж эхэлбэл цаашид ОТ, ТТ, Гачуурт, бусад стратегийн ордуудыг үр ашигтай, ил тод, тогтвортой уул уурхайн зарчмуудын дагуу ашиглахад их ач холбогдолтой болох юм. Учир нь:

1. 34, 51, 100 гэх мэт хэлбэрүүд нь Монгол Улсын эрх ашгийг глилэрхийлэх зорилго бүхий хэлбэрүүд, үүний адил алтан хувьцаа ч тийм зорилготой, хөрөнгө оруулагчдад, бүх эрх чөлөөг нь хангаад Монголын төр өөртөө ямар нэг хариуцлага, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үүрэг хариуцлага авалгүйгээр гагцхүү Монгол Улсын эрх ашигтай харшилсан шийдвэр

гарсан үед л хориг тавих, ингэснээрээ Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжтой.

2. Алтан хувьцааг Монголын тал тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлд сууж буй төлөөллөөрөө дамжуулан хориг тавих эрхийг эдэлснээр нэг талаас хөрөнгө оруулагчийн шийдвэрийг хянах, нөгөө талаас тэднийг Монгол улсын эрх ашгийг харгалзсан шийдвэр гаргахад нөлөөлөх хүчирхэг хэрэгсэл болж чадах юм.

Тэгэхээр цаашид Монгол Улсын Засгийн газар

– Ашигт малтмалын тухай хууль, төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт алтан хувьцааны талаар нэг нэг өгүүлбэр оруулсан нэмэлт өөрчлөлтийг батлуулах.

– Компанийн тухай Монгол улсын хуулинд мөн л алтан хувьцааг уул уурхайн салбарт төдийгүй бусад хувьцаат компаниудын үйл ажиллагаанд хэрэглэх боломжийн тухай бас нэг заалт оруулж өгөх замаар энэ асуудлыг бодитой хэрэгжүүлж болно.

Би тэгвэл хууль тогтоогчийн хувьд яагаад өөрөө болоогүй юм гэсэн асуулт гарч болох юм. Хариулт нь их энгийн. Болно. Гэхдээ удаан procedure-тай (заримдаа залхмаар, залхуу хүрмээр, ... дэгийн тухай хуулийн өөрчлөлт хийж байж арилахаар), Засгийн газар оруулсан нь илүү хурдан, шуурхай хэлэлцэгдээд явж болох defacto нөхцөлтэй байдаг

юм” хэмээн өгүүлжээ.

Алтан хувьцааны тухай зохицуулсан хуулийн 36 дугаар зүйлийн заалтуудын эрх зүйн агуулгыг товч тайлбарлая.

Алтан хувьцаа, давуу эрхийн хувьцаа бол компанийн гаргасан эрх дээр хориг тавих эрхтэй. Гэхдээ үүнийг ямар нэгэн хөрөнгө оруулалт гэж ойлгож болно. Монгол улсын туршлагаас дурдвал, төрийн өмчийн компаниудыг хувьчлахдаа тодорхой жилийн хугацаатайгаар алтан хувьцааг төр эзэмшихээр гаргасан. Энэ нь компанийн удирдлагын шийдвэрт хориг тавих эрх зүйн боломжийг бий болгосон байна.

Компанийн тухай хуулийн 36 дугаар зүйлд “Засгийн газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд зарим асуудлаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй алтан хувьцааг гаргахаар зааж болно.” гэжээ.

Алтан хувьцаатай компанийн шийдвэрт Засгийн газар хориг тавих үндэслэлд:

1. Хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн;
2. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгасан;
3. Их хэмжээний хэлцэл байгуулсан ;

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тариф тогтоох, өөрчлөх тухай шийдвэр гаргасан зэрэг тохиолдолд хориг тавих эрхтэй.

Дээр дурдсан асуудлаар компанийн шийдвэр гарсан тохиолдолд Засгийн газар батламжилснаар хүчин төгөлдөр болно.

Алтан хувьцааны онцлог:

– Алтан хувьцаа бусдад шилжихгүй.

– Тогтоосон хугацаанд үйлчилнэ. Хугацаа дуусмагц хувьцаа хүчингүй болно.

– Тогтоосон хугацааг дахин сунгах, үргэлжлүүлэх боломжгүй байдаг.

36 дугаар зүйл. Хувьцаанд хамаарах үнэт цаас

37.5 Энгийн хувьцааг худалдан авах эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опционыг хувьцаанд хамааруулах бөгөөд тэдгээрийг гаргах, худалдах журмыг компанийн дүрмээр тодорхойлно.

Тайлбар:

Хуулийн 37 дугаар зүйлд хувьцаанд хамаарах үнэт цаасны тухай заажээ.

Хувьцаанд хамаарах үнэт цаасанд:

а) хувьцааг худалдан авах эрхийн бичиг ;

б) хувьцаанд хөрвөх үнэт цаас ;

с) опционыг хамааруулсан байна.

Компани эдгээрийг гаргах

худалдах журмыг компанийн дүрмээр заан тодорхойлогдоно.

Компани хувьцаа эзэмшихэд хамаарал бүхий ойлголтууд байдаг.

Опцион: Компани тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Үүнийг компанийн дүрмээр зөвшөөрсөн тохиолдолд л хэрэгжүүлэх боломжтой.

Өрийн бичиг: Компани өөрийн хөрөнгийн хэмжээнд барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргадаг.

Үнэт цаасны онцлог: Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг (бонд), компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан эсвэл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа зэргийг нийтэд нь үнэт цаас гэж нэрлэдэг.

Өөрөөр хэлбэл, үнэт цаас гэдэг нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн юм уу, зээл олгосон гэдгийг гэрчлэх баримт юм. Үнэт цаас нь банкны хадгаламжийг бодвол ашиг, эрсдлийн түвшин нь харьцангуй өндөр байдаг бөгөөд худалдах, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлэх боломжтой байдгаараа онцлогтой. Манай улсын үнэт цаасны зах зээл дээр бонд болон хувьцаа гэсэн хоёр төрлийн үнэт цаас арилжаалагдаж байна.⁴²⁵

⁴²⁵ Дэлгэрэнгүй ойлголтыг www.news.mn

38 зүйл. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрх

38.1 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

38.2 Энэ хуулийн 62.1.3-т заасны дагуу хувьцааг нэмж гаргах шийдвэр гаргах үед нэмж гаргаж байгаа хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг энгийн хувьцаа эзэмшигч бүрд хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар хүргүүлнэ.

38.3 Хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцааг худалдан авах тухай саналаа хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 30 өдрийн дотор ирүүлнэ.

38.4 Энэ хуулийн 38.1-д заасны дагуу хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах үнэ нь тухайн хувьцааг гаргах үеийн зах зээлийн үнийн 90 хувиас доошгүй байна.

38.5 Энэ хуулийн 38.1-д заасан эрх бүхий хувьцаа эзэмшигч нь тогтоосон хугацаанд нэр, оршин суугаа газрын хаяг, худалдан авах хувьцааны тоо, үнийг төлсөн баримтыг компанид ирүүлснээр тэргүүн ээлжинд хувьцааг

худалдан авсанд тооцно.

38.6 Хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 38.1-д заасан эрхээ бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэгжүүлж болно.

38.7 Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 38.1-д заасан эрхээ бусад этгээдэд бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлж болно.

38.8 Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.

Тайлбар:

Хуулийн 38 дугаар зүйлд компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх, түүнийг хэрэгжүүлэх арга, журмыг тогтоосон байна.

Хувьцаа нэмж гаргах, хувьцаа эзэмшигчид зар хүргэх, хувьцааны төлбөр хийх, тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх боломж, хугацаа, хувьцааны үнэ, уг эрхээ бусад этгээдэд шилжүүлэх, тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх нөхцөл зэргийг тогтоон зохицуулжээ.

Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар зарим компанийн сайтаас бодит жишээ авав. Үүнд: “ТШ” компани энгийн хувьцаа нэмж гаргажээ.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас дараах зүйлийг хувьцаа эзэмшигч нарт зориулсан мэдээлэл гаргаж, ажиллагсдын хурал дээр мэдэгдсэн, улмаар компанийн салбарт ил тодоор байршуулжээ. Тус компанийн хувьцаа эзэмшигч нар бүгд компанидаа ажилладаг ажээ. Мэдэгдэлдээ:

1) Нэмж гаргаж байгаа энгийн хувьцааны тухай;

2) Хувьцаа эзэмшигч нар өөрийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй болох тухай;

3) Хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авах эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд түүний хувьцааг мөн хувь тэнцүүлсэн хэлбэрээр худалдан авч болно гэж үзсэн.

4) Хувьцаа нэмж гаргах тухай шийдвэрт хувьцааны тоо, үнэ, худалдан авч болох болох хувьцаа тоо, төлбөр хийх хугацаа, журмын талаар хэрхэн туссан тухай бичиж, ажлын 30 хоног дотор саналаа ирүүлэхийг заажээ. Мөн самбарт тогтоолыг байрлуулжээ.

5) Тэргүүн ээлжинд хувьцаа худалдаж авах эрх бүхий хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5 дах хэсгийн дагуу овог нэр, оршин суугаа газрын хаяг, худалдан авах хувьцааны тоо, үнэ төлсөн баримтыг компанид ирүүлснээр худалдан авсанд тооцно гэдгийг мэдэгдэлд заажээ.

- Төрийн өмчийн хувьчлалын

хүрээнд “БН” компани нэмж хувьцаа гаргах замаар төрийн мэдлийн хувьцааг 75 хувиа бууруулж, 51 хувь болгожээ.

Компани зах зээл дээр нэмж 9,870,287 ширхэг хувьцаа гаргаж байгаа бөгөөд харин Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид нь (2016.04.11 өдрөөр) дээрх хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй болж байгаа. Өөрөөр хэлбэл, хувьцааг зах зээл дээр санал болгохоос өмнө өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлсэн хэмжээгээр худалдан авах боломжтой болох тухай хувьцаа эзэмшигч нарт мэдэгдсэн байна. Компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдийнхээ тэргүүн ээлжинд худалдан авах хүсэлтийг 2016.05.23-ны өдөр хүртэл авахаар тогтоожээ. Харин хувьцаа худалдан авах үнийг компанийн зүгээс олон нийтэд зарлахгүй, тухайн хувьцаа эзэмшигч нь компаниасаа лавлаж асуух ёстой гэжээ.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 сарын 28-ны өдрийн 70 тоот тогтоолоор “БНС” ХК-ийн хувьцааны тоог 1,000,000 ширхэгээр нэмэгдүүлэн нийт хувьцааны тоог 2,268,320 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр гарсан байна.

Компанийн тухай хуулийн 34.2, 38 дугаар зүйлд заасны дагуу 2014 оны 10 сарын 27-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус

хурлаар тус ХК-ийн хувьцааг эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргаж байгаа хувьцаанаас өөрийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг олгохоор шийдвэрлэжээ. Тус компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх үнийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс 1000 төгрөг байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдах авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн үнэт цааснаас 200,000 ширхэгийг зээлийн төлбөрт өрийг хувьцаагаар сольж эзэмшүүлэх, 300,000 ширхэгийг хаалттай хүрээнд санал болгон арилжих ба үлдсэн үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаа нь Монголын хөрөнгийн биржээр нээлттэй явагдахаар тогтоожээ. Тухайн компанийн мэдэгдэлд компанийн нэр, нийт гаргасан хувьцааны тоо 1,268,320 ширхэг, нэмж гаргаж буй хувь 44 хувь, тэргүүн ээлжинд худалдан авах үнэ 1000 төгрөг, тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр 2014.10.21, тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны тоо нь нэмж гаргаж буй хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцаанаас тоотой хувь тэнцүүлэн авна. Тэргүүн ээлжинд худалдан авах эрх дуусах огноо нь 2015.03.18 гэж тус тус заагаад дэлгэрэнгүй мэдээллийг авах цахим хаягийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын сонинд

нийтэлсэн байна.⁴²⁶

Тэргүүн ээлжинд худалдан авах эрх. Хуульд зааснаар:

а) Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг тухайн компанийн энгийн хувьцаа эзэмшигч эдлэнэ.

б) Тэрээр компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг худалдаж авах эрх нь өөрийн нь эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авах эрхээр хязгаарлагдана.

в) Хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрх компаниас тогтоосон “тодорхой нөхцөлөөр” тодорхойлогдоно. Тодорхой нөхцөлийг 38 дугаар зүйлийг заалтуудаар нарийвчлан тодорхойлсон байна.

Хувьцаа нэмж гаргах. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-д зааснаар компани хувьцаа нэмж гаргах эрхийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсан байдаг. Хувьцаа нэмж гаргах тухай шийдвэрт:

- 1) Нэмж гаргаж байгаа хувьцааны тоо;
- 2) Нэмж гаргаж байгаа хувьцааны үнэ;
- 3) Хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо;
- 4) Хувьцааны төлбөр хийх хугацаа;
- 5) тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах журам, нөхцөл зэрэг

⁴²⁶ Компанийн оноосон нэрийг үсгээр товчилсон байдлаар илэрхийлэв.

шаардлагатай асуудлыг тогтоон заах ёстой.

Компаниас хувьцаа нэмж гаргаж байгаа энгийн хувьцаа эзэмшигч бүрт хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмын дагуу хэрэгжүүлнэ.

Тэргүүн ээлжинд худалдан авах журам. Дээр дурдсан компаниудын туршлага жишээнээс үзэхэд Хувьцаат компани гол төлөв тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журам батлан гаргасны үндсэн дээр тухайн ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Жишээлбэл: “Шарын гол” ХК-ийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журамд хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан нэмж хувьцаа гаргах тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 тоот тогтоолын хэрэгжилтийг

хангах, Компанийн тухай хуулийн дагуу нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд санал болгох, санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан, худалдан авах санал ирүүлээгүй тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан, худалдан авах санал ирүүлээгүй хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулжээ.

Компани нэмж 1,707,404 (нэг сая долоон зуун долоон мянга дөрвөн зуун дөрөв) ширхэг хувьцаа гарган дүрмийн сангаа нэмэгдүүлэх ба хувьцааны хуваарилалт дараах нөхцөлөөр хийгджээ. Тухайн журмын үндсэн зүйлийг дараах хүснэгтэд үзүүлье.

1	№
<i>Хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгон үлдэх хувьцааг олон нийтэд санал болгоно.</i>	Санал болгох
1,707,404 (нийт хувьцааны 16,69 хувь)	Хувьцааны ширхэг, хувь
<i>Компанийн ТУЗ-ийн тогтоолын дагуу санал болгох үнэ 11,117 төгрөг байх ба үлдэх хувьцааг олон нийтэд захиалгын бүртгэлийн аргаар санал болгох үнэ 11,117 төгрөгөөс доошгүй байна.</i>	Үнэ
<i>Энэ журмын 3-р бүлэгт заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлнэ.</i>	Хугацаа

Энэ журамд тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд санал болгохдоо: Нэмж гаргаж буй 1,707,404 ширхэг хувьцааг компанийн энгийн хувьцаа эзэмшигч бүр эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авах эрхтэй ба энэ нь хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны 23,61 хувьтай тэнцэнэ.

Хувьцааг нэмж гаргах хувьцаа эзэмшигчдийн бүртгэх өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, гарсан өдрөөс эхлэн Компанийн тухай хуулийн дагуу “хувьцааг нэмж гаргах шийдвэр гаргах үед энгийн хувьцаа эзэмшигч бүрт гаргаж байгаа хувьцааны тоо, үнэ, хувьцаа, эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар хүргэдэг журмаар хүргүүлэх, хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцааг худалдан авах тухай саналаа шийдвэр гаргаснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлнэ.” гэж заасны дагуу эрхээ хэрэгжүүлж болно гэжээ.

Хуулийн 38.3-д “Хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээр хувьцааг журмын шийдвэр гаргаснаас хойш ажлын 30 өдрийн дотор ирүүлнэ.” гэсэн заалтад нийцсэн байна.⁴²⁷ Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд худалдан авах

эрхээ бүхэлд нь болон хэсэгчлэн хэрэгжүүлнэ гэж дээрх журамд тодорхойлсон. Хуулийн 38.6-д “эрхээ бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэгжүүлж болно.” гэжээ.

Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ бусад этгээдэд бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлэх бол батлагдсан маягтыг Андеррайтерийн болон өөрийн харилцдаг брокер, дилерийн компанидаа хүргүүлнэ гэж хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажиллагааг журамласан байна.

- Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэгдсэн өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигч нь хувьцаа худалдан авах саналаа баталсан хүсэлтийн маягтыг дансанд мөнгө байршуулсан баримтын хамт андеррайтерийн компанид хүргүүлэх.

- Андеррайтерийн компани тэргүүн ээлжинд худалдан авах санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг хүлээн авч, нэгдсэн бүртгэл гарган ажлын 5 (тав) хоног дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх.

- Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах хувьцаа эзэмшигчдийн мэдэгдлийг хүргүүлж, арилжаа явагдах өдрийг товлон ба тухайн арилжаа явагдах өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд худалдан авах хувьцааны үнийн дүн, арилжааны шимтгэлтэй

⁴²⁷ Хуульд “ажлын 30 өдрийн дотор ирүүлнэ” гэж заасан. Харин компанийн журамд “ажлын 30 хоногийн дотор ирүүлнэ” гэжээ. Нарийвчлан үзвэл ялгаа, маргаан гарч болох юм.

тэнцэх хэмжээний мөнгө байршуулах.

- Тухайн арилжаа явагдах өдөр хувьцаа эзэмшигчдийн дансан дахь мөнгөний үлдэгдэл захиалга өгсөн хувьцаа худалдан авахад шаардагдах үнийн дүнд хүрэхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар тус тус тогтоожээ.

Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр аваагүй хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалахаар зохицуулахдаа:

- Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарснаас хойш хувьцаа эзэмшигч нь ажлын 30 хоногт багтаан худалдан авах саналаа ирүүлээгүй нөхцөлд тухайн хувьцаа эзэмшигчийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

- Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгох 1,707,404 ширхэг хувьцаанаас санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн худалдан авах эрхийг хэрэгжүүлэн үлдэгдэл хувьцааг зах зээл дээр олон нийтэд захиалгын бүртгэлийн аргаар санал болгоно.

- Олон нийтэд санал болгох үнэ нь төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор 11,117 төгрөгөөс доошгүй байхаар заасан байна.

Компанийн хувьцааг эргүүлэн авах эрх үүсэх тухай Компанийн тухай хуульд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталсан “Нэмэлт хувьцаа гарган компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх” асуудлаар эсрэг саналтай байсан буюу санал хураалтад оролцоогүй

хувьцаа эзэмшигч нь компани нэмэлт хувьцаа гаргаж буй талаарх мэдээлэл энэ журамд заасны дагуу хүргэгдсэнээс хойш Компанийн тухай хуулийн дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг компаниас эргүүлэн авахыг шаардах эрхтэй болохыг журамд тусгасан байна.

Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн асуудлаар хязгаарлагдмал хариуцлагатай компани болон хувьцаат компанид тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журмын талаар компанийн гаргасан баримт бичгүүдэд тусгажээ. Энд тулгуурлан “ТШ” ХХК, “Шарын гол” ХК, “БН” ХК, “БНС” ХК тус тус Компанийн тухай хуулийн заалт, эрх зүйн зохицуулалтад хэрхэн нийцсэн байдалд дүгнэлт өгөх боломжтой юм.⁴²⁸

Хувьцааны үнэ. Компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах үнэ нь тухайн хувьцааг гаргах үеийн зах зээлийн үнийн 90 хувиас доошгүй байх ёстой. Харин хуулийн 38.4-т заасан энэ хувиас дээш байж болно.

Хувьцааг худалдан авсанд тооцох. Дээр жишээ болгосон компанийн нэмж гаргасан хувьцааг худалдан авсанд тооцох журамд тодорхойлсон. Хуулийн 38.5 дах заалтаар энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас тогтоосон хугацаа болон хуулийн 38.3-т заасан хугацаанд

⁴²⁸ Компаниудын гаргасан баримт бичгийг жишээ болгон тайлбарлахыг хичээсэн болно

дараах баримтуудыг компанид ирүүлсэн тохиолдолд хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авсанд тооцдог. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчийн овог, нэр ;
- оршин суугаа хаяг ;
- худалдан авах хувьцааны тоо ;
- хувьцааны үнийг төлсөн баримт.

Худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх. Хууль тогтоомж болон компанийн дүрэмд заасан үндэслэлээр хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байж болно. Худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай асуудлыг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэгдэнэ.

Хуулийн 38.8-д зааснаар зөвхөн хувьцаат компани (ХК)-д хамаарч байна. Тиймээс хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигчийг тухайн компанийн нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно гэж ойлгож хэрэглэх зохицуулалт

УДИРДАХУЙН УХААНЫ ИЛТГЭЛ



Бизнесийн удирдлагын докторант,
Шихихутуг их сургуулийн Удирдахуйн
ухааны тэнхимийн эрхлэгч
Г.ГАНТӨГС

НИЙГМИЙН КАПИТАЛ

/онолын асуудал/

Хүн бүр нийгмийн харилцаанд ордог ба нийгмийн капитал нь нийгмийн харилцааны салшгүй нэг хэсэг болдог байна. Хүн төрөлхтний түүхийн турш, олон мянган жилийн турш нийгмийн харилцаа маш чухал үүргийг гүйцэтгэж ирсэн ба сүүлийн 30 гаран жил нийгмийн харилцаа нь үнэ цэнийг бий болгох нийгмийн капиталын хэмжээнд илүү өргөн хүрээнд судлагдаж иржээ. Нийгмийн капитал нь олон салбарт, өөр өөр түвшинд, ялгаатай утга санаа, хандлагыг бий болгож байна.

Нийгэм гэдэг нь товчхондоо нийгмийн бүтэц, зохион байгуулалт, сүлжээ харин капитал нь эдийн засгийн эргэлтэнд орж, үр өгөөж өгч үнэ цэнийг бий болгох гэдгээр тайлбарлан бичиж болно.

Эндээс нийгмийн капитал гэдэг нь үр өгөөжтэй байх, нийгэмших боломжийг олгох, нийгэмших чадвар чадавхыг агуулах, ашигтай үнэ цэнтэй байх ойлголт болж байна. Эндээс хүний капиталыг бий болгоход нийгмийн капитал чухал үүрэгтэй юу эсвэл хүний капитал нь өөрөө нийгмийн капиталыг бий болгодог уу гэсэн асуултаас хувь хүний чадамж, нийгмийн харилцааны ур чадварууд хорондоо шүтэлцээтэй болохыг харахаар байна. 1970-1980 онуудад байгалийн капитал, хүний капитал, оюуны капиталуудыг илүү судалж, үнэлж хэмждэг байсан бол улмаар нийгмийн нөлөөлөл, нийгмийн үнэ цэнэ, нийгмийн хөрөнгө оруулалтыг үнэлж капиталжуулах, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах арга замыг олж мэдэх, ач холбогдлыг үнэлэх, бүтээмж өсөх, үнэ цэнээ өсгөх боломжийг судалж иржээ. Аливаа нийгмийн харилцааны үр өгөөж нь өгөх, хуваалцах, туслах, дэмжих, халамжлах дээр суурилах ба үүнээс инновац бий болох улмаар эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй гэдэг талаас хийгдсэн судалгаанууд хэдий их ч нийгмийн капиталын үр дүн бүр эерэг байдаггүй, эрсдэлийг илүү харж аливаа зүйлийг хамтын хүчээр үйлдэх, өөрчлөх нь чухал аж. “Нийгмийн капитал бол шүхэр юм” (Thibault Coppe, 2022),

“Нийгмийн капитал бол тослох материал юм” (Leonard, 2004) гэсэн тодорхойлолтууд нь өөрийн болон байгууллагынхаа нийгмийн капиталын талаар эргэцүүлэх, нийгмийн капиталгүйгээр хүмүүсийн хамтрал гэж үгүй болох, нийгмийн солилцоог илүү боломжтой болгодог нийтлэг үнэт зүйл, хэм хэмжээ, итгэлцэл, харьяалал гэдийг ойлгох болно.

Түлхүүр үгс: Нийгмийн капитал, хэм хэмжээ, нийтийн сайн сайхан, бэлгэдлийн капитал

ҮНДСЭН ХЭСЭГ

НИЙГМИЙН КАПИТАЛЫН СУУРЬ ОЙЛГОЛТ БА ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХУВЬСАЛ

Нийгмийн капиталын үндсэн санаа нь 17-18-р зууны соён гэгээрлийн үеэс эхтэй сонгодог улс төрийн эдийн засгийн нийтлэг сэдэвтэй холбоотой юм. Нийгмийн шинжлэх ухааны сонгодог онолчид Макс Вебер, Карл Маркс, Адам Смит, Эмиль Дюркхайм, Торштейн Веблен, Дэвид Рикардо зэрэг онолчид “нийгмийн” ба “эдийн засгийн” хоорондын уялдаа холбоог эртнээс анхаарч ирсэн.

Эдгээр эрдэмтэд эдийн засгийн хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг онцолж байсан нь нийгмийн капиталын үзэл санаатай шууд холбоотой байдаг байна. Нийгмийн капиталтай холбоотой санаанууд нь Токвилл (холбооны үйл ажиллагаа), Жон Стюарт Милл (иргэдийн

оролцоо), Тоннис (олон нийтийн үнэ цэнэ), Дюркгейм (эв нэгдлийн хэлбэрүүд), Вебер (шатлал ба эрх мэдэл), Локк (иргэний нийгэм), Руссо (харилцааны сүлжээ), Симмел (бүлгийн өвөрмөц байдал), Маркс (нийгмийн анги) зэрэг эрдэмтдийн ажилтай холбоотой байдаг. Нийгмийн капиталын үндсэн зөн совин нь маш эртний социологийн үзэл санаатай холбоотой байдаг бөгөөд нийгмийн капиталтай холбоотой санаа нь шинэ зүйл биш гэж үздэг байна. Нийгмийн капиталд хандах зарим арга барил нь хуучин дарсыг шинэ лонхонд цутгахтай адил гэсэн хандлага байдаг.

“Нийгмийн капитал” гэсэн нэр томъёо 1990-ээд он хүртэл бараг мэдэгддэггүй байсан хэдий ч тэр цагаас нэр хүнд нь хурдацтай нэмэгдэж, олон нийтийн хөгжил, бизнес, улс төрд танил болж, шинжлэх ухааны салбарт хүч түрэн орж ирсэн байна.

“Нийгмийн капитал” гэсэн нэр томъёог аль эрт 1900 онд хэрэглэж байсан. Нийгмийн капитал гэдэг нэр томъёог (одоотой ижил утгатай) 1867 онд Карл Маркс, 1900 онд Жон Дьюи нар хэрэглэж байсан боловч 1980-аад оноос хойш судлагдахуун болжээ. 2000, 2010-аад онуудад уг үзэл баримтлал түгээмэл болж, нийгэм судлал, эдийн засагт нэр хүндтэй байхаас гадна улс төр, бизнес, эрүүл мэнд, байгаль орчны шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх

ухааны бараг бүх салбар, тэр байтугай физикийн шинжлэх ухааны зарим салбарт тархсан байна. (Gittell, 1998)

“Нийгмийн капитал бол дэлхийн хэмжээнд профессор, шинжээч, улс төрчдийн байнга сонсдог бидний хамгийн трэнд болсон нэр томъёоны нэг” болжээ.

Нийгмийн капиталын түүхийг үе шаттайгаар авч үзье.

- 17-р зуунаас 20-р зууны эхэн үе - энэ нэр томъёог анх хэрэглэхээс өмнөх үе, ялангуяа сонгодог улс төрийн эдийн засагт нийгмийн капиталын үндсэн сэдвүүдийг хэлэлцэх үед нийгмийн капитал гэсэн нэр томъёог ашиглаагүй байна.

- Харин энэ томъёоны эхэн үеийн хэрэглээ (20-р зууны эхэн үеэс 1980-аад оны эхэн үе) - энэ нэр томъёог хэд хэдэн өөр өөр судлаачид маш бага ашигладаг байсан үе бөгөөд үзэл баримтлалыг төдийлөн хөгжүүлээгүй.

- Эрт үеийн үзэл баримтлалын хөгжил (1980-аад оны эхэн үеэс 1990-ээд оны эхэн үе) - эрдэмтэд нийгмийн капиталын үзэл баримтлалын үндсийг боловсруулж байсан үе, гэхдээ энэ нэр томъёо нь зарим эрдэмтдийн халааснаас гадуур тодорхойгүй хэвээр байв.

- Түгээмэл хэрэглээ (1990-ээд оны эхэн үеэс өнөөг хүртэл) - энэ нэр томъёо нь түгээмэл хэрэглэгдэж, алдартай болсон үе юм.

Нийгмийн капиталын онолын тодорхойлолт, харьцуулалт

Жеймс Колман (1926-1995) Колман нь (боловсролын социологи, төрийн бодлогын талаар голлон сонирхож байсан Америкийн социологич ба нийгмийн капиталын тодорхойлолтод харьцангуй цөөн тооны иш татсан хэдий ч энэ үзэл баримтлалыг орчин үеийн зохиогчдын нэг гэж нийтээр хүлээн зөвшөөрөгддөг байна. Тэрээр нийгмийн капиталыг бараг бүх нийтээрээ бүтээмжтэй, бүгдэд үнэ цэнэ өгдөг гэж үздэг ба ялгаатай эрх мэдэл, статусыг бий болгодог тэгш бус байдлыг үл тоомсорлосон гэдгээр шүүмжлүүлдэг байна.

Колманы нийтлэг иш татсан тодорхойлолт нь: “Нийгмийн капиталыг чиг үүргээр нь тодорхойлдог. Энэ нь дан нэгдэл биш, харин нийтлэг хоёр шинж чанартай олон янзын нэгжүүд юм. Тэд бүгд нийгмийн бүтцийн зарим талаас бүрддэг бөгөөд тэдгээр нь тухайн бүтэц доторх хувь хүмүүсийн тодорхой үйлдлийг хөнгөвчлөх болно” (Coleman, 1990)

Роберт Путнам Путнам нийгмийн капиталын тухай үзэл баримтлал өргөн шүүмжлэлд өртөж байсан ч 2019 оны түүвэр нийтлэлээс харахад түүний тодорхойлолтууд хамгийн алдартай нь болсон байна. “Харилцан ашиг тусын тулд зохицуулалт, хамтын ажиллагааг хөнгөвчлөх сүлжээ, хэм хэмжээ,

нийгмийн итгэлцэл зэрэг нийгмийн байгууллагын онцлог” (Putnam, 1995)

Пьер Бурдые Бурдыегийн үзэл баримтлалд нийгмийн капиталыг хамтын бус харин хувь хүний өмч гэж үздэг. Бурдыегийн тодорхойлолтод хувь хүнд анхаарал хандуулж байгаа нь илт харагдаж байна. “Харилцан танил болон хүлээн зөвшөөрөгдсөн их эсвэл бага институцичлагдсан харилцааны тогтвортой сүлжээг эзэмшихтэй холбоотой бодит буюу боломжит нөөцийн нийлбэр” (Bourdieu, 1986)

Нан Линий⁴²⁹ нийгмийн капиталын тодорхойлолт нь “Нийгмийн капиталыг сүлжээгээр дамжуулан нөөцийг олж авах боломж” (Häuberer, 2011) гэж ойлгосноор харилцааны болон танин мэдэхүйн хэмжигдэхүүнүүдийн нарийн төвөгтэй байдал, биет бус шинж чанараас зайлсхийдэг. Лин нь нийгмийн капиталын талаарх эдийн засгийн чиг баримжаатай ном зохиолд хамгийн их иш татагддаг бөгөөд үүнийг сүлжээний хандлага гэж нэрлэдэг.

Нахание ба Хошал Энэ хоёр үзэл баримтлалдаа харилцааны болон танин мэдэхүйн хэмжигдэхүүнийг оруулсан хэдий ч тэдний тодорхойлолт нь нийгмийн капиталыг хувь хүний өмч гэж үздэгтэй холбоотой байж болох юм.

“Хувь хүн эсвэл нийгмийн нэгжийн эзэмшиж буй харилцааны сүлжээн

⁴²⁹Тэрээр нийгмийн сүлжээ, нийгмийн капиталын талаархи судалгаа, нийтлэлээрээ хамгийн алдартай.

доторх, дамжуулан олж авах боломжтой болон түүнээс үүдэлтэй бодит болон боломжит нөөцийн нийлбэр” (Nahapiet, 1998) гэж тодорхойлжээ.

Жеймс колман ба бурьеде нарын үзэл баримтлалын харьцуулалт

Жеймс Колман нь нийгмийн хөдөлгөөнийг тайлбарлах гол ойлголт болох нийгмийн капиталын ойлголтыг харьцангуй энгийн бөгөөд ойлгомжтой тайлбарлаж үндэс суурийг тавьжээ. Нийгмийн капитал нь нийгмийн хөдөлгөөнийг тайлбарлах гол ойлголт бөгөөд нэг талаасаа нийгмийн бүтцийн нэг хэсэг, хувь хүмүүст нөхцөл байдлыг сайжруулахад туслах хэрэгсэл юм гэж үзсэн байна. Тиймээс нийгмийн капитал нь олон нийтийн болон хувь хүмүүсийн аль алиных нь хөрөнгө юм.

Колеман нийгмийн капиталыг зорилгоор бус харин чиг үүргээр нь тодорхойлохдоо:

1. Бүтэц дэх үүрэг, хүлээлт, найдвартай байдал
2. Мэдээллийн сувгууд
3. Хэм хэмжээ ба хариуцлага хэмээжээ.

Жеймс Колман хүний капиталын төвлөрсөн үйл ажиллагааг тайлбарлахын тулд нийгмийн капиталын үзэл баримтлалыг боловсруулж, Гари Бекерийн санааг дэлгэрүүлэн боловсруулсан бол Бурдые 1960-аад оноос хойш хөгжиж

ирсэн соёлын болон бэлгэдлийн⁴³⁰ капитал гэсэн ойлголтуудад уг нэр томъёог нэмж оруулсан байна.

Бурдьегийн нэгэн адил Колман янз бүрийн төрлийн капитал, тэдгээрийн харилцан үйлчлэл, тухайлбал хүний, бие махбодын болон нийгмийн капиталыг сонирхож байв. Колеманы нийгмийн капиталын үзэл баримтлалын зорилго нь эдийн засагчид оновчтой үйл ажиллагааны зарчмаар нийгмийн тогтолцоонд дүн шинжилгээ хийх, үйл явцад нийгмийн зохион байгуулалтыг үл тоомсорлосон явдлыг үүдэн Колеман социологи болон хувь хүмүүсийн нийгмийн үйл ажиллагааг эдийн засагчдын оновчтой санаатай холбосон байна. Эхнийх нь нийгмийн бүтцээр тодорхойлогддог нийгмийн үйл ажиллагааны функционалист үзэл бол хоёр дахь нь оновчтой онол бөгөөд зорилго нь хувийн ашиг сонирхлыг дээд зэргээр хангах замаар тодорхойлогддог (Coleman J. S., 1988) Нийгмийн капиталын онолыг Bourdieu (1985) “харилцан танил эсвэл хүлээн зөвшөөрөх их эсвэл бага институцилагдсан харилцааны тогтвортой сүлжээг

⁴³⁰ Бэлгэдлийн капитал нь ихэвчлэн нэр хүнд, статус, зэрэг нэр хүндтэй холбоотой байдаг ба шаанал, өргөмжлөлөөр тодорхойлогддог. Бизнес эрхлэгчдэд бодит үнэ цэнэ нь бусад хүмүүс ийм хөрөнгөд хэрхэн ач холбогдол өгч байгаагаас л хамаарна. Нэр хүнд гэх мэт бэлгэдлийн капиталыг нийгмийн сүлжээ, онцгой боловсролыг олж авах замаар нийгэм, соёлын капитал болгон хувиргаж болно. Бэлгэдлийн нөөц хомс байх нь бизнес эрхлэх үйл явцад сул тал болж, компанийн нэр хүнд, гүйцэтгэлд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байдаг гэж үздэг.

эзэмшихтэй холбоотой бодит болон боломжит нөөцийн нийлбэр” гэж тодорхойлсон ба Бурдьегийн нэгэн адил Колеман нийгмийн капиталыг үндсэндээ хүмүүсийн хоорондын харилцааны нийгмийн бүтцэд оршдог гэж үзсэн. Бурдые эрх мэдэл, статус, нийгмийн капиталыг хувь хүмүүсийн хооронд тэгш бус хуваарилах талаар санаа зовж байсан бол Колеман нийгмийн капиталыг хувь хүмүүсийн үйл ажиллагаа бүхэлдээ ашиг тустай нийтийн сайн сайхан гэж үздэг байв. Иймд Колеман нийгмийн капиталыг бүлгийн хамтын хөрөнгө гэж төсөөлж, эрх мэдэл, статусын ялгааг бий болгодог тэгш бус байдлын талаар бага оруулсан байна.

Эрх мэдэл, зөрчилдөөнийг үл тоомсорлож байгаа нь Колеман нийгмийн капиталыг гол төлөв нийгмийн бүтцийн бүтээгдэхүүн гэж үздэгээс үүдэлтэй байж магадгүй юм. Энэ нь хамтын өмчийн шинж чанарыг соёлын капитал гэдэг нэр томъёоны дор авч үзсэн Бурдюгийн онолоос ихээхэн зөрүүтэй байна.

Энэ нь Бурдые, Колеман нарын нийгмийн капиталын онолууд үндсэндээ ялгаатай бөгөөд энэ нь нийгмийн капитал гэж юу болох, юу биш болох талаар төөрөгдөлд хүргэсэн байна.

Харин Колеманы хувьд хувь хүмүүс үр өгөөжөө хадгалан үлдэхийн хэрээр нийгмийн харилцаа, харилцаа холбоо, сүлжээнд оролцдог. Энэхүү логик нь хүний

зан үйлийг оновчтой байдлаар тайлбарлахыг эрэлхийлдэг оновчтой сонголтын онолоос үүдэлтэй. Эдгээр оновчтой үйлдлүүд нь зөвхөн хувь хүмүүсийн үйл ажиллагаа төдийгүй нийгмийн байгууллагын хөгжлийг харгалзан нийгмийн тодорхой нөхцөл байдалд тохируулагддаг.

Энэ утгаараа нийгмийн капитал нь зөвхөн нийгэмлэг, сүлжээг зохион байгуулахад хөрөнгө оруулалт хийдэг хүмүүст төдийгүй бүлгийн бүх хүмүүст ашиг тустай хувийн болон нийтийн сайн сайхан зүйл юм. Жишээлбэл, орон нутгийн гэмт хэргийн гаралтыг бууруулахад туслах зорилгоор ойр орчмын хяналтын бүлэг байгуулагдвал, тэр байтугай хэзээ ч биечлэн оролцдоггүй хүмүүс ч гэсэн ойр орчмын бүх хүмүүст ашигтай байдаг (Coleman J. S., "Social Capital in the Creation of Human Capital," 1988) байна.

Бурдые нийгмийн капиталыг нийгмийн тэгш бус байдлыг бий болгодог гэж үзсэн бол Колеман нийгмийн капиталыг бараг бүх нийтэд үр ашигтай, бүтээмжтэй гэж үздэг.

НИЙГМИЙН КАПИТАЛ

Нэр томъёоны хувьд авч үзвэл:

Нийгмийн капитал гэдэг нэр томъёо нь өнөө цагт хүмүүсийн харилцан үйлчлэлийн эерэг бүтээгдэхүүнийг хэлдэг. Эерэг үр дүн нь биет болон биет бус байж болох ба давуу тал, ашигтай мэдээлэл, шинэлэг санаа, ирээдүйн

боломжуудыг багтааж болно. Нийгмийн капитал нь хувь хүний эзэмшилд байдаггүй, харин хувь хүмүүсийн хоорондын нийгмийн сүлжээний хоорондын боломжоор илэрдэг байна. Үүнийг байгууллагын амжилтад оруулсан хувь нэмрийг тодорхойлоход ашиглаж болох бөгөөд байгууллагын доторх болон гаднах хувийн харилцаа, сүлжээгээр холбож мөн болно. Мөн ажилчдын дунд итгэлцэл, хүндэтгэлийг бий болгож, компанийн гүйцэтгэлийг сайжруулахад хүргэдэг компани доторх хувийн харилцааг тодорхойлоход ашиглаж болдог. (Humnath Bhandari, 2009)

Нийгмийн капитал гэдэг нь нийтлэг зорилгод үр дүнтэй хүрэхийн тулд бүлэгт хамтран ажиллах боломжийг олгодог нийтлэг үнэт зүйлс буюу нөөцийн багц юм. Нийгмийн капиталыг хувийн холбооноосоо нөөц, ашиг тус, мэдээлэл олж авах боломж гэж үзэж болно. Энэ санааг ерөнхийдөө гишүүд нийгэмд хэрхэн эв найртай амьдрахын тулд нэгдэж чаддагийг тайлбарлахад ашигладаг. (Wacquant, 1992)

Бизнесийн хувьд нийгмийн капитал нь хамтын үнэт зүйлс, харилцан хүндэтгэх мэдрэмжийг бий болгосноор компанийн амжилтанд хувь нэмэр оруулж чадна. Бизнес дэх нийгмийн капитал гэдэг нь бизнесийн орчин дахь харилцаа, сүлжээ, харилцан үйлчлэлээс үүсэх үнэ цэнийг хэлнэ. Энэ нь

бизнес эрхлэгчид, түүний дотор үйлчлүүлэгчид, ажилчид, ханган нийлүүлэгчид, нийт хамт олныхоо хамт олонтойгоо байгуулж буй сайн сайхан, итгэлцэл, харилцан хамаарлын хүрээг хамардаг. (Ane Tamayo, 2017)

Нийгмийн капитал нь бүлэг хүмүүсийг нэг зорилго, зорилгод хүрэхийн тулд үр дүнтэй хамтран ажиллах боломжийг олгодог. Энэ нь корпораци эсвэл ашгийн бус байгууллага гэх мэт нийгэм, байгууллагыг итгэлцэл, нийтлэг шинж чанар, хэм хэмжээ, үнэт зүйлс, харилцан харилцаагаар дамжуулан бүхэлд нь хамтран ажиллах боломжийг олгодог. Энгийнээр хэлбэл, нийгмийн капитал нь нийгмийн харилцаагаар дамжуулан нийгэмд бүхэлдээ ашиг тусаа өгдөг. Иймээс нийгмийн капитал хэрхэн ажилладаг эсвэл ажиллахгүй байгааг судлах нь нийгмийн шинжлэх ухаанд чухал байна. Нийгмийн капитал гэдэг нэр томьёо сүүлийн үед хэрэглэгдэх болсон ч нийгмийн харилцаа нь хувь хүн эсвэл бүлэгт үр бүтээлтэй үр дүнд хүргэдэг гэсэн ойлголтыг нэлээд удаан судалж иржээ. Энэ нь иргэний болон нийгмийн хариуцлагыг тодорхойлох, эсвэл хамтын нийгэмлэгийн гишүүд хэрхэн эв нэгдэлтэй, эв нэгдэлтэй амьдрахын тулд хэрхэн хамтран ажилладгийг тодорхойлоход хэрэглэгддэг. Мөн бизнесийн амжилтад хувь нэмэр оруулах харилцааг тодорхойлоход ихэвчлэн ашигладаг ба санхүүгийн

болон хүний капитал шиг үнэ цэнтэйд тооцогддог. Сүлжээ, интернэтийн хэрэглээ нь нийгмийн капитал бизнесийн утгаар хэрхэн ажилладгийн тод жишээ юм. Эдгээр нь мэргэжилтнүүдэд олон хувилбараар нийгмийн болон ихэнхдээ дэлхийн хэмжээний холболтыг бий болгох боломжийг олгодог. Олон ажлын байрыг ажлын байрны жагсаалтаар бус албан бус сүлжээгээр дүүргэдэг. Энэ бол үйл ажиллагаа явуулж буй нийгмийн капитал юм. (Hongseok Oh, 2004)

Нийгмийн капитал нь нэлээд субъектив байж болох тул хэрхэн хэмжих талаар ерөнхий зөвшилцөлд хүрээгүй байна.

Нийгмийн капиталын үнэ цэн

Нийгмийн капитал бол бүтээмжтэй ашиг тустай нийгмийн харилцаа юм. Нийгмийн капиталыг ойлгох хамгийн сайн арга бол “Та юу мэддэгт биш, харин хэнийг таньдагт” гэсэн үг юм. Нийгмийн капиталыг зарим онолчид нийгмийн бүтцийг тосолж, орчин үеийн эдийн засгийг үр ашигтай ажиллуулах боломжийг олгодог гэж тодорхойлсон байдаг. Энэ нь хүмүүсийн цаг хугацаа, мөнгийг хэмнэж, золгүй явдал, ослоос зайлсхийхэд тусалж, бүх зүйлийг хөнгөвчлөхөд тусалдаг ба боломжгүй байсан шинэ санаануудыг гаргаж, шинэ холбоо тогтоох боломжийг хүмүүст олгоно. Нийгмийн капиталын үнэ цэнийг бус нийгмийн капиталын

үр дагаврын үнэ цэнийн талаар бодох нь хамгийн зөв юм.

Нийгмийн капиталыг тухайн нөхцөл байдалд оролцож буй хүмүүс хамгийн сайн үнэлдэг, учир нь өөр өөр нөхцөл байдалд байгаа хүмүүс нийгмийн капиталын өөр өөр тал дээр өөр өөр үнэт зүйлсийг тусгадаг аа. Жишээлбэл, фермер нь тоног төхөөрөмж, мэдээлэл солилцох гэх мэт харилцан ойлголцлын мэдрэмжээс хамгийн их ашиг хүртдэг бол барилгачин сайн ханган нийлүүлэгчдийг танилцуулахад хүмүүс тусалснаар хамгийн их ашиг тус хүртэх болно. Хүн, бүлэг эсвэл байгууллага өөрт нь ямар хүчин зүйл чухал болохыг тодорхойлж, тэдэнд хамгийн их ашиг тусыг өгөх замаар нийгмийн капиталын үнэ цэнийг тодорхойлж, хэмжиж чадна. (Mikiewicz, 2021)

Нийгмийн капитал нь бүх нийтэд чухал байдаг нь эргэлзээгүй, гэхдээ зарим хүмүүст өөрт байгаа нийгмийн капиталаас илүү их зүйл хэрэгтэй эсвэл илүү их ашиг хүртэх ч боломжтой байдаг. Үнэн хэрэгтээ тодорхой мэргэжил, нийгмийн бүлгийн зарим хүмүүс бусдаасаа илүү нийгмийн капиталтай байдаг. Үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгчийн үүргийг авч үзье. Тэд өөр өөр гарал үүсэлтэй олон зуун хүмүүстэй харилцах боломжтой бөгөөд зүгээр л ажлаа хийснээр эдгээр хүмүүстэй харилцан ойлголцлыг бий болгож, энэ нийгмийн капиталаас ихээхэн

ашиг хүртэх болно.⁴³¹

Нийгмийн капиталын талаар мэдлэгтэй хүн өөрийн нийгмийн капиталыг мэдэгдэхүйц сайжруулж чадах нь ойлгомжтой. Харамсалтай нь зарим хүмүүсийн нийгмийн харилцааны шинж чанараас шалтгаалан тэдний нийгмийн хөрөнгийн үнэ цэнэ бага байдаг.

Танд санал болгох зүйл багатай эсвэл ижил төстэй зүйлтэй хүмүүстэй харилцах нь тодорхой шалтгааны улмаас бага үнэ цэнийг илэрхийлдэг.

Хамгийн ашигтай харилцаа бол нийгмийн янз бүрийн хүрээний хүмүүс, өндөр орлоготой, сайн боловсролтой, нийгэмд сайн холбогдсон хүмүүс, орон нутгийн мэдлэгтэй хүмүүс гэх мэт эерэг зүйлтэй хүмүүстэй харилцах явдал юм. Зарим хүмүүс зөв хүмүүсээ мэддэггүй учраас нийгмийн капитал тийм ч их байдаггүй. Таны нийгмийн капитал бол таны хамгийн дотны таван найзын нийгмийн капиталын үүрэг юм.

Нийгмийн капитал нь асар их ач холбогдолтой бөгөөд зөв барьж, ашигласнаар таны амьдралын чанарт маш том өөрчлөлт авчрах болно. Энэ нь таны мөнгийг хэмнэж, мөнгөтэй болгож, илүү сайн ажил олж, бүх зүйлийг илүү хялбар, аюулгүй болгож, цаг хугацаа, хүчин чармайлтыг хэмнэж, амьдралыг илүү тааламжтай, үр бүтээлтэй болгож чадна. Нийгмийн капиталыг ашиглах

⁴³¹ Хэрэв харилцаа хадгалагдвал

гэхээсээ илүү харилцан үйлчлэлд орж өгөх сэтгэлээр хандаж өөрийн хэргийг бүтээх гэдгээр ойлгох нь нэн чухал. Өгөх нь мэдээлэл хуваалцах эсвэл зарим нэгний асуудлыг сонсохтой адил хялбар байж болно. Хэрэв та харилцаагаа бусдад өгөх, хуваалцах, хөгжүүлэх, урт хугацаанд хадгалахад анхаарлаа төвлөрүүлбэл тэр нийгмийн капиталын үр өгөөж урсах болно. (Claridge, 2018)

Нийгмийн капиталын үнэ цэнэ цаг хугацааны явцад өсөх нь гарцаагүй, гэхдээ тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийлгүйгээр үүнийг хүлээх нь тийм ч сайн үр дүнгүй байдаг байна. Энэ нь харилцааг хадгалах ёстой гэсэн үг бөгөөд хэр олон давтагдах тусам харилцаа илүү сайн, бат бөх болж, бие биедээ итгэх итгэл, харилцан ойлголцлыг төрүүлдэг. Нийгмийн капиталд та ямар нэг нөөцөө “зарцуулж” байж улмаар түүнийг бий болгох боломжтой, учир нь нийгмийн капиталд “зарцуулах” нь нийгмийн харилцан үйлчлэл бөгөөд эерэг туршлага бүхий нийгмийн капиталыг бий болгодог байна. Хэрэв аль нэг тал эсвэл хоёр тал аль аль нь өөрсдийгөө ашигласан, ашиглуулсан гэж үзвэл нийгмийн капитал алдагдах бөгөөд энэ нь эргэлт буцалтгүй хохирол учруулж ч болзошгүй. (Sawhill)

Нийгмийн капиталын олон талт боломж

Нийгмийн харилцаанд олон нийттэй харилцах нь үнэ цэнэ болон нөөц боломжийн хувьд илүү чадамж, түүнийг ашиглах хүрээллийг нэмэгдүүлэх бүхий л салбарын мэдээллийг мэдлэг болгон ашиглах орон зайг бий болгодог учраас нийгмийн томоохон сүлжээ чухал юм. Томоохон сүлжээ нь шаардлагатай үед тэдгээр нөөцөд хандах магадлалыг нэмэгдүүлдэг.⁴³²

Боломж нь нийгмийн капиталыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэрэв та илүү том сүлжээтэй бол тухайн эх сурвалжийн хувьд нэгээс олон харилцагчтай байх магадлал өндөр тул шаардлагатай үед тухайн нөөцөд хандах магадлалыг нэмэгдүүлдэг.

Хүчтэй харилцаа нь цаг хугацааны явцад давтагдах харилцан үйлчлэлээр бий болдог. Гүн гүнзгий холболтыг хөгжүүлэх, хэрэв эерэг байвал илүү үнэ цэнтэй нөөцийг олж авах боломжтой хэм хэмжээг тогтооход цаг хугацаа хэрэгтэй. Итгэлцэл, харилцан хүндэтгэл, сайн санаа, сайн сайхан байдал, үүрэг хариуцлага байдаг газарт нийгмийн капитал оршдог учраас эерэг харилцаа бас чухал. (Market business news, 2022)

⁴³² Тухайлбал: Үе тэнгийнхэн, боломжит түншүүд, салбарын нөлөөлөгчидтэй холбогдохын тулд салбарын хурал, үзэсгэлэн худалдаа, мэргэжлийн сүлжээний арга хэмжээнд идэвхтэй оролцоорой. Эдгээр арга хэмжээ нь харилцаа холбоо тогтоох, санал бодлоо солилцох боломжийг олгодог.

Янз бүрийн албан тушаалын хүмүүстэй харилцах нь бас чухал бөгөөд учир нь бүх хэлхээ холбоо ижил үнэ цэнтэй байдаггүй. Үнэ цэнтэй олон төрлийн нөөц байдаг. Материаллаг бараа, үйлчилгээ нь ойлгомжтой боловч мэдлэг, ур чадвар, мэргэн ухаан зэрэг хүний капитал, мөн “найзын найз”-ын тухай танилцуулга гэх мэт нийгмийн капиталыг багтааж болно. Үүнд хүч чадал, нөлөөлөл, түүнчлэн энэрэн нигүүлсэх, халамжлах, дэмжлэг үзүүлэх гэх мэт сэтгэл хөдлөлийн нөөц багтаж болно.⁴³³

Нийгмийн аливаа бүтэц нь таны харилцааг бий болгож буй нийгмийн нөхцөл байдалтай холбоотой. Жишээлбэл, нийгэм, танай байгууллага, танай гэр бүл эсвэл харилцаанд үндэслэсэн бусад бүлгийн хүрээнд нийгмийн эерэг бүтэц бий болдог. Нийгмийн бүтэц, зохион байгуулалт, түүний доторх нийгмийн хэм хэмжээ нь харилцан үйлчлэлийн суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Тэд хувь хүний зан төлөвт нөлөөлж, бүлгийн гишүүдийн хоорондын нийгмийн харилцааны өнгө аясыг ч тогтоодог.

Нийгмийн капитал нь сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд нийгмийн шинжлэх ухаан маш өргөн хүрээ хамран хэрэглэгдэж ирсэн эрдэм шинжилгээний судлагдахуун болж эхэлсэн. Энэхүү үзэл баримтлал нь шинжлэх ухааны академиас гадна эдийн засаг, олон

⁴³³ Жишээлбэл таны асуудлыг сонсох хүн.

нийтийн хөгжил, улс төр, бизнес, эрүүл мэнд болон бусад олон салбарт тархсан. Харамсалтай нь нийгмийн капитал нь нэгдмэл онол биш юм. Нийгмийн капиталыг өөр өөр өнцгөөс, өөр өөр салбараас авч үзсэний үр дүнд асар олон янзын тодорхойлолт, ойлголт бий болсон. Нийгмийн капитал гэж юу вэ, санал зөрөлдөөн, нийгмийн капиталыг хэрхэн хэмжих, үнэлэх талаар төөрөгдөл, янз бүрийн нэр томьёо ч өргөн хэрэглэгдсээр байгааг дээр дурдсан билээ. Нийгмийн капиталын ихэнх тодорхойлолтуудын нийтлэг тал нь бүтээмжтэй, ашиг тустай нийгмийн бүтцэд төвлөрдөг ба нийгмийн капиталын талаарх янз бүрийн онолын хандлагаас гадна хэд хэдэн түвшинд хуваан авч үздэг. (Management, 2011)

- Хувь хүний түвшинд нийгмийн капитал нь нийгмийн сүлжээ болон эдгээр харилцааны онцлогт анхаарлаа хандуулах хандлагатай байдаг.

- Бүлэг эсвэл байгууллагын түвшинд нийгмийн хэм хэмжээ, үүрэг, дүрэм зэрэг нийгмийн бүтцэд анхаарал хандуулах хандлагатай байдаг.

- Нийгэмлэг эсвэл нийгмийн түвшинд итгэлцэл, итгэл үнэмшил, иргэний хэм хэмжээ, холбооны гишүүнчлэл, сайн дурын үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулах хандлагатай байдаг. Нийгмийн капиталын тухай янз бүрийн шүүмжлэлийг үл харгалзан

уг үзэл баримтлал нь манай нийгэм, эдийн засгийг өөрчлөх асар их нөөц бололцоо гэж үздэг байна.

ДҮГНЭЛТ

Аливаа нийгмийн харилцаа нь хүй нэгдлийн үед ч сүргээрээ амьдрах явцад үр өгөөжөө өгч, олуулаа амьдарснаар эрсдэлээс хамгаалагдах, үр төлөө хамгаалах, хамтын зорилгоор хүнс хоол, нөөцөө бэлтгэх, дулаан амьдрах оромж, байр саваа сонгох, манах, олуулаа нэгдсэнээр санаа ургуулах, бусдын дэмжлэгийг авах, манлайлал, хүлээн зөвшөөрөгдтөл үүсэх, бүтээх оролдлогууд үүсэх, гал гаргах, зэр зэвсэг хийх зэргээр үргэлж эерэг үр дүн, өөрчлөлтөд хөтлөгдөн, улмаар инновацыг бий болгон хөгжүүлснээр өнөөгийн нийгэмд ирсэн, тэнд нэгэн үнэт зүйл, хэм хэмжээгээр зохицуулагдан, бусадтай хуваалцах, туслах, дэмжих, хаа нэг бүлд харьяалагдах, өрсөлдөх, үйлчлэх сэтгэлгээгээр эдийн засгийн үр өгөөж бүхий хамтын нийгмийг бүтээсээр ирсэн. Тэгэхээр нийгмийн капитал гэдэг ойлголт үйлээрээ хүн төрөлхтөнтэй чацуу насжилттай авч шинжлэх ухаанчаар судлагдан, олон салбарыг хамран, эдийн засагт бодитоор хэмжигддэг, үр өгөөж, үнэ цэнийг үнэлж, капиталжуулдаг, энэ нь улс эх орны хөгжилд, байгууллагын хөгжилд, нийгмийн нэгж хүний хөгжилд яаж нөлөөлж

буй эерэг нөлөөллийг хэмжих оролдлогоос “нийгмийн капитал” хэмээн тодотгогдох болжээ. Энэ нь сүүлийн 30 гаран жил судлагдаж буй ч тоймтой хэмжих, үнэлэх загвар алга байна.

Нийгмийн капитал нь нийгмийн сүлжээний үнэ цэнийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, нийгмийн капиталыг илүү үр дүнтэй хөгжүүлж, урт хугацаанд хадгалахад хувь нэмэр оруулах боломжтой байдаг.

Нийгмийн капиталын нөлөөллийг хэрхэн үр дүнтэй бодит үнэлэх вэ гэдэг нэн чухал болж байна. Учир нь орчин үед эдийн засгийн үр ашгийг нийгмийн капиталаар дамжуулж үр өгөөжтэй хүртдэг ба нийгмийг хамтад нь байлгаж, хадгалж, харилцааг тосолж, тордож байж илүү их үр шимд хүрнэ. Нийгэм, эдийн засаг, институци, улс төрийн тогтолцоо нь нийгмийн капиталгүйгээр оршин тогтнох боломжгүй. Нийгмийн капиталыг бий болгохын тулд давтамжтай харилцаа, эерэг үйлдэл, харилцан үйлчлэлээр дамжуулан урт хугацааг шаарддаг байна.

Харин капитал буюу үнэ цэн, өгөөж хэзээ бий болов гэвэл нийтлэг үнэт зүйл, хэм хэмжээ, эерэг үйлдэл, үнэн бодит үр нөлөө, зөв тэмүүлээс ИТГЭЛЦЭЛ бий болж харилцан өгөлцөх, хуваалцах, үйлчлэх, халамжлах, нэгдэхээс үр шимээ өгч инновацаар хөтлөгдөн нийгмийн сайн сайхан, хөгжилд тэмүүлэлд хүрэх боломж үүссэнээр эхэлдэг гэж

ойлголоо. НИЙГМИЙН КАПИТАЛ нь удаан бүтээгддэг авч маш хэврэг шинж чанарыг агуулж байдаг. Харилцаа хамгийн том эрсдэл байдаг тул түүний гол илэрхийлэл нийгмийн капитал нь маш үнэ цэнтэй хөрөнгө болоод байна.

4. Ашигласан ном, эх сурвалж

1. Ane Tamayo, H. S. (2017). The Role of Social Capital in Corporations. *Journal of Finance*.
2. Bourdieu, P. (1986). *The forms of capital*.
3. Claridge, T. (2018). *Introduction to social capital theory*.
4. Coleman, J. S. (1988). "Social Capital in the Creation of Human Capital,". *Sociology*.
5. Coleman, J. S. (1988). The American Journal of Sociology . *Social Capital in the Creation of Human Capital*.
6. Coleman, J. S. (1990). *Foundations of Social Theory*. Harvard University Press.
7. Gittell, R. a. (1998). Building Social Capital as a Development Strategy. *sagepub*.
8. Häuberer, J. (2011). *Concept of Social Capital*.
9. Hongseok Oh, M.-H. C. (2004). Group Social Capital and Group Effectiveness: The Role of Informal Socializing Ties. *jstor*.
10. Humnath Bhandari, K. Y. (2009). What Is Social Capital? A Comprehensive Review of the Concept. *Asian Journal of Social Science*, 3.
11. Leonard, M. (2004). Bonding and bridging social capital. *Sociology* , 38.
12. Management, J. o. (2011). Multilevel Challenges and Opportunities in Social Capital Research. *Journal of Management*.
13. *Market business news*. (2022). [marketbusinessnews.com: https://marketbusinessnews.com/financial-glossary/social-capital/-ээс Гаграсан](https://marketbusinessnews.com/social-capital/-ээс Гаграсан)
14. Mikiewicz, P. (2021). Social capital and education – An attempt to synthesize conceptualization arising from various theoretical origins. *Cogent Education* , 5.
15. Nahapiet, J. &. (1998). Academy

of Management Review. *Social Capital, Intellectual Capital, and the Organizational Advantage*, 243.

16. Putnam, R. D. (1995). Tuning In, Tuning Out: The Strange Disappearance of Social Capital in America. *Political Science and Politics*, 67.

17. Sawhill, I. V. (огноо байхгүй). *Social Capital: Why We Need It and How We Can Create More of It*. 2020.

18. Thibault Coppe, L. T. (2022). The Use of Social Capital in Teacher Research: A Necessary Clarification. *Frontiers in Psychology*.

19. Wacquant, P. B. (1992). *An Invitation to Reflexive Sociology*. Chicago Press.

20. Wu, C. (2021). Social capital and COVID-19: a multidimensional. *CHINESE SOCIOLOGICAL REVIEW*, 30.